ISSN 2226-9185

NATIONAL LEGAL INSTITUTE OF MONGOLIA LAW REVIEW

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

ХУУЛЬ ЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, ПРАКТИКИЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

- Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс
- Монгол Улсын эрх зүйн шинэтгэл, шүүхийн шинэтгэлийн хэрэгжилт, үр дүн, цаашдын асуудал
- Эрх зүй дэх нийтийн ашиг сонирхлын талаарх үндсэн ойлголтын тухайд
- Монгол Улсын гаалийн байгууллагаас барааны тэмдгийн зөрчилтэй дууриамал барааг саатуулах, устгах хууль зүйн үндэслэл, процесс: ДХБ ба ТРИПС-ийн хэлэлцээрийг харгалзсан тайлбар, дүгнэлт
- Эрэн сурвалжлах ажлын тухай хууль зүйн нэр томьёоны тодорхойлолтыг боловсронгуй болгох нь
- Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх эрүүгийн ял ба эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ
- Орчны гэмт явдал судлал
- Үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрхийг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга замын талаар
- Монгол Улсын гэмт хэргийн статистик: Өнөөгийн байдал, түүнийг сайжруулах асуудал
- Баривчлах, цагдан хорих ажиллагаанд шүүхийн хяналтыг хэрэгжүүлэх шаардлага, арга зам
- Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх асуудал: Шүүхийн практикт тулгуурласан шинжилгээ

Цуврал 59 Дугаар 4

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ж.Амарсанаа	*Академич*
Б.Амарсанаа	*Хууль зүйн доктор*
Д.Баярсайхан	*Хууль зүйн доктор*
О.Мөнхсайхан	*Хууль зүйн доктор*
Д.Сүнжид	*Хууль зүйн доктор*
Б.Уранцэцэг	*Хууль зүйн доктор*
Ц.Цогт	*Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч*
С.Энхцэцэг	*Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал*
Х.Эрдэм-Ундрах	*Хууль зүйн доктор*
А.Эрдэнэцогт	*Хууль зүйн доктор*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

-554-

Ерөнхий эрхлэгч
С.Энхцэцэг

Эрхлэгч
Х.Эрдэм-Ундрах

Хариуцлагатай нарийн бичгийн дарга
Б.Гончигсумлаа

Хэвлэлийн эхийг
З.Эрдэнэтөгс

Улсын бүртгэлийн дугаар: 279 ISSN:2226-9185 Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн гаргав. Жилд 5 дугаар гарна.	Хаяг: Улаанбаатар–46, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу /15160/, Хуульчдын гудамж 1, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн байр Утас: +(976)-11-315735 Факс: 315735 Вэб хуудас: www.legalinstitute.mn Цахим хаяг: lawjournal@legalinstitute.mn

EDITORIAL BOARD

J.Amarsanaa	*Academician*
B.Amarsanaa	*(LL.D)*
D.Bayarsaikhan	*(Ph.D)*
O.Munkhsaikhan	*(LL.D)*
D.Sunjid	*(Dr.jur)*
Ts.Tsogt	*Judge of the Administrative Appellate Court*
S.Enkhtsetseg	*Director of National Legal Institute*
Kh.Erdem-Undrakh	*(Dr.jur)*
A.Erdenetsogt	*(Ph.D)*

Editor-in-Chief
S.Enkhtsetseg

Executive Editor–in-Chief
Kh.Erdem-Undrakh

Acting Assistant Editor
B.Gonchigsumlaa

Designed by
Z.Erdenetugs

State Registration Number:279
ISSN: 2226-9185
The National Legal Institute publishes this law review five times per year.

Address: 4th Khoroo of Chingeltei District, Lawyer's Street-1, Ulaanbaatar-15160, Mongolia
Phone:+(976)-11-315735
Fax: 315735
Website: www.legalinstitute.mn
E-mail: lawjournal@legalinstitute.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН www.nli.gov.mn

АГУУЛГА

ХУУЛЬ ТӨРӨХИЙН ӨМНӨ /ОНЦЛОХ ӨГҮҮЛЭЛ, ЯРИЛЦЛАГА/

Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс 9

Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, ардчилсан үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Бяраагийн Чимид

Монгол Улсын эрх зүйн шинэтгэл, шүүхийн шинэтгэлийн хэрэгжилт, үр дүн, цаашдын асуудал 28

БНХАУ-ын Ардын их сургуулийн докторант Б.Энх-Амгалан

ХЗҮХ-ийн Эрдэм шинжилгээний ажилтан Ж.Алтансүх

ЭРХ ЗҮЙ, СЭТГЭЛГЭЭ: ҮЗЭЛ БОДОЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

Эрх зүй дэх нийтийн ашиг сонирхлын талаарх үндсэн ойлголтын тухайд 39

Удирдлагын академийн багш, докторант Р.Мухийт

Монгол Улсын гаалийн байгууллагаас барааны тэмдгийн зөрчилтэй дууриамал барааг саатуулах, устгах хууль зүйн үндэслэл, процесс: ДХБ ба ТРИПС-ийн хэлэлцээрийг харгалзсан тайлбар, дүгнэлт 46

Бельгийн Вант Улсад бүртгэлтэй оюуны өмчийн зөвлөгөө ба хууль зүйн туслан гүйцэтгэх үйлчилгээний бизнес эрхлэгч, Германы Оюуны өмчийн хамгааллын нийгэмлэгийн гишүүн, хуульч (Ph.D) Д.Уянга

Эрэн сурвалжлах ажлын тухай хууль зүйн нэр томьёоны тодорхойлолтыг боловсронгуй болгох нь 66

Үндэсний тагнуулын академийн Эрх зүйн тэнхимийн эрхлэгч, докторант, дэд хурандаа Б.Батхишиг

Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх эрүүгийн ял ба эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ 72

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, (Ph.D) профессор Д.Баярсайхан

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант Ц.Мэргэн

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ, АСУУДАЛ

Орчны гэмт явдал судлал 78

УЕПГ-ын хяналтын прокурор Г.Оюунболд

Үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрхийг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга замын талаар 85

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш (LL.M) Н.Норовсамбуу

Монгол Улсын гэмт хэргийн статистик: Өнөөгийн байдал, түүнийг сайжруулах асуудал 92

ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, математик, хууль зүйн ухааны магистр, цагдаагийн хошууч Б.Мөнхдорж

Баривчлах, цагдан хорих ажиллагаанд шүүхийн хяналтыг хэрэгжүүлэх шаардлага, арга зам 103

МУИС-ын Хууль зүйн сургуулийн магистрант Ж.Болормаа

ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА, ТОЙМ, ҮР ДҮН

Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх асуудал: Шүүхийн практикт тулгуурласан шинжилгээ 111

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Ц.Цогт

Говьсүмбэр аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч З.Ганзориг

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

CONTENT

BEFORE CREATING A LAW
(UNDERLINE ARTICLE AND INTERVIEW)

The Rule of Respecting and Cherishing the Constitution 9
B.Chimid, Professor, Doctor of Juridical Science (S.J.D), Distinguished Statesman, The Keeper and The Drafter of the Original of the Democratic Constitution of Mongolia, Labor Hero of Mongolia, People's Teacher, State Honored Lawyer

Legal Reform in Mongolia: The Implementation Result of Judicial Reform and Issues to Consider Further 28
B.Enkh-Amgalan, Doctoral Student of Renmin University of China
J.Altansukh, Researcher of National Legal Institute

LEGAL THOUGHTS: REFLECTION

The Basic Legal Understanding of the Concept of Public Interest 39
R.Mukhiit, A Doctoral Student, Lecturer of National Academy of Governance

Legal Grounds and Procedure for Suspension and Destruction of Trademark Counterfeit Goods by the Customs Authority in Mongolia: A Case Study in Consideration of the WTO/TRIPS Agreement 46
D.Uyanga, (Dr. jur.), A member of the German Association for the Protection of Intellectual Property (GRUR), Dr D.Uyanga renders intellectual property consulting and legal support services in Belgium

Sophistication of the Legal Terminology of Search 66
B.Batkhishig, Ph.D candidate, Senior Researcher of National Intelligence Academy

Criminal Punishment and Other Measures of Coercion within the Criminal Law of Mongolia 72
D.Bayarsaikhan, (Ph.D), Professor, Head of the Public law Department, School of Law, National University of Mongolia
Ts.Mergen, Master's student at School of Law, National University of Mongolia

IMPLEMENTATION OF LAW, EFFICIENCY AND ISSUES

Environmental Criminology 78
G.Oyunbold, Public prosecutor, Office of the Prosecutor General of Mongolia

Хуулийн үндэсний төв
www.nli.gov.mn

The Ways to Resolve the Problem of Execution of Mortgages 85
N.Norovsambuu, (LL.M.), Lecturer of Private Law Department, School of Law, National University of Mongolia

Crime Statistics in Mongolia: The Current Situation and Ways to Improve 92

B.Munkhdorj, Master in Law and Matematics, Police Colonel, Senior researcher of Police Study Center of the Research and Development Institute of Law Enforcement University

The Importance and Ways to Establish a Court Supervision for Arrest, Detention and Custody 103
J.Bolormaa, Master's student at School of Law, National University of Mongolia

LEGAL RESEARCH OVERVIEW

The Temporary Injunction of Administrative Act: An Analysis of Administrative Court Practice 111

Ts. Tsogt, Judge of Administrative Court of Appeals
Z.Ganzorig, Judge of First Instance Administrative Court in Gobi-Sumber province

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ҮНДСЭН ХУУЛИЙГ ДЭЭДЛЭН ШҮТЭХ ЁС



Үндсэн хуулийн 25 жилийн ойг тохиолдуулан Монгол улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, ардчилсан үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Бяраагийн Чимидийн өгүүллийг уншигч та бүхэнд дахин[1] хүргэж байна.

1. Учирлаж улируулан үзэх нь

Аливаад хэмжээ хязгаар байдаг. Түүнийг дутаах, хэтрүүлэх хоёрын аль нь ч ёс бус.Ардчилсан, эрх зүйт төр, Үндсэн хуульт ёсыг төлөвшүүлэн хөгжүүлэхэд энэ хоёр хязгаарыг баримтлах явдал нэгэн адил хамаатай. Үүнтэй уялдан Монгол овог аймгууд төр улсад нэгдсэн цагаас түүхийн урт аяны турш төр, хууль ёсны талаар чухам юуг туйлын хязгаар болгож, дээдлэн шүтэж ирснийг ул суурьтай улируулан судлах нь өнөөгийн чухал хэрэгцээ болов.

Хууль дээдлэх ёсыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болгон заахын хамт Үндсэн хуулиа бүх нийтээр **"Мэдэгтүн, сахигтун!"** хэмээн зарлан тунхагласан билээ. Гэтэл "төрөө дээдэл" гэж байх болж. Хуулиа **дээдэлж**, төрөө хүндэтгэх нь эрэмбийн ялгаатайг илэрхийлж байгаа бус уу?! Асуудлын гол учир шалтгаан чухам юунд байна вэ?

Сүүлийн жилүүдэд энэ талын судалгаа идэвхжсэнийг дэмжүүштэй. Зөвхөн хууль зүйн хүрээн дэх ойрмогхоны зарим баримтыг дурдахад шинжлэх ухааны доктор Н.Лүндэндорж, доктор Х.Сэлэнгэ нар **монголчуудын** төр, хууль ёсны сэтгэлгээний түүхийг сөхөж тус тусдаа эрдмийн зохиолууд туурвижээ.[2] Бусад салбарын эрдэмтэд жишээлбэл, Чингисийн улс төрийн үзэл, тэнгэрийг шүтэх үзэл гэхчлэн сонирхолтой судалгаа хийх болжээ.[3]

Энэ мэтээс болон эх түүхээс дүгнэн үзвэл монголчуудын төрт ёс, хууль зүйг дээдлэн шүтэх үзэл **гурван их үеийг туулж уу** гэлтэй.

Нэгд: Монгол аймгууд нэгдэж тулгар төрийнхөө тулгын чулууг тавьснаас хойш 720-иод жил гагцхүү хаан төрд нэгдэн оршсоны учир мөнх тэнгэрийг дээдлэн, "тэнгэрийн хүү"[4] гэх нэрээр хаант ёсыг шүтэж өнгөрөөсөн ажгуу.

Хоёрт: 1924 онд Оройн дээд Очир дарь Богд ламтан таалал төгссөний хойно хаант ёсыг халж, нэг намт Бүгд найрамдах ёсыг тогтоосон цагаас "нам засаг" нэрийн доор **улс төрийн дээд удирдагчдыг** шүтэн биширч, үг сургаалийг нь сүсэглэн дагасаар

[1] Б.Чимид "Үндсэн хуулийн үзэл баримтлал. Нийтлэг асуудал" нэгдүгээр дэвтрийн 167-196 дахь тал.

[2] Н.Лүндэндорж, "Төр эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага", УБ., 2002 он; Х.Сэлэнгэ, "XVII зууны үеийн Монголын төр, эрх зүйн сэтгэлгээ" (докторын зэрэг горилсон диссертаци), УБ., 2003 он

[3] Ч.Жүгдэр, "Монголын феодализм тогтох үеийн нийгэм улс төр, гүн ухааны сэтгэлгээ", УБ., 1987 он, С.Дулам "Мөнх тэнгэрийн шүтлэг хийгээд ...", Улаан-Уд, 1996 он; МУИС-ын хамтын бүтээл, "Монгол төр ёс, сэтгэлгээний зарим асуудал", УБ., 2002 он

[4] Ч.Жүгдэр "Чингисийн төрийн үзэл, цэргийн урлаг". ШУА-ийн хэвлэх үйлдвэр, 1990 он, 26 дахь тал

Хууль зүйн үндэсний сургууль www.nls.edu.mn

буюу нэг удирдагчийн санаа зоригийн бус харин төр, нийгмийн хөгжлийн жам ёсыг тусган тухайн улсын Үндсэн хуульд нийцэн бодит чанарыг олж эхэлсэн байна. Хуулийн ийм утга чанар нь түүнийг дээдлэх ёсыг нийтээрээ баримтлахад хүргэжээ. Энэ нь угтаа дур зоргын хандлагыг хууль ёсоор халсан хэрэг болсон юм.

Францын эрдэмтэн Жан-Луи Бержель: "Эрх зүй бол байгаа хууль нь, харин хууль нь ямар байх ёстой вэ? гэдэг нь эрх зүйн гүн ухаан болно"[9] гэж өгүүлжээ. Үүнийг ургуулан бодоход зоргоор томьёолсон "болох, болохгүй" заалт зааврыг бус, зүй зохисыг үзэж, жам ёсыг тусган боловсруулсан бодит хуулийг дээдлэн хүндлэх нь гарцаагүй мэт. Үүнийг л хууль дээдлэх, хууль хүлээн зөвшөөрөгдөхгүйн үндэс хэмээн үзэж болно. Ийм чанарын хуулийг төр, иргэний нийгмийн бүх байгууллага, албан тушаалтан, хувь хүн нийтээр хүндэтгэн сахиж, нийгмийн бүх хэм хэмжээнээс дээгүүр тавьж сахин биелүүлэх нөхцөл бүрэлдэнэ.

Хуулийн бодит чанарыг дүүрэн хангасан байх нь төр хийгээд түүний хууль тогтоогчдоос ард түмнийхээ өмнө хүлээсэн гол хариуцлага юм. Түүний гол шалгуур, алсын (дээд) хязгаар нь Үндсэн хууль мөн билээ. Үндсэн хууль жам ёсны байх, түүнийгээ бусад хууль батлан гаргах хийгээд гүйцэтгэлийг нь хангах, хэрэглэхдээ нарийн чанд баримтлах нь ардчилсан эрх зүйт төр байгаагийн гол илрэл мөн гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрдөг билээ.

Ардчиллын үнэт зүйлүүдийг бэхжүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд төрийн үйл ажиллагааны нэг үндсэн зарчим нь "Хууль дээдлэх ёс"[10] мөн гэж заажээ. Хууль дээдлэх ёс нь өөрийн бодит агуулга, хэмжээ хязгаартай. Бидний ойлгож байгаагаар:

• Эрх зүйн хэм хэмжээгээр тохируулбал зохих алив харилцааг элдэв дэд акт, зааврааар биш хуулиар буюу хууль тогтоомжийн актаар зохицуулах;

• Аливаа хууль нь Үндсэн хуульд, эрх зүйн бусад (дэд) бүх акт нь хуульд нийцсэн буюу захирагдмал байх;

• Хүний жам ёсны эрх, эрх чөлөө, хууль зүйн тэгш байдлыг хүлээн зөвшөөрч хуулиар бэхжүүлэн хангах;

• Үндсэн хууль болон түүнд нийцсэн хууль тогтоомжийн аливаа актыг Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр хүчин төгөлдөр дагаж мөрдөх;

• Парламент нь Үндсэн хуулиа, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага нь Үндсэн хууль ба бусад хуулийг гуйвалтгүй биелүүлэх, зөв хэрэглэх;

• Хууль зөрчсөн гэм буруутай хэн боловч (олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчим, Монгол Улсын гэрээгээр дипломат эрх ямба, дархан эрх эдлэхээс бусад) хууль зүйн зохих хариуцлага хүлээх;

• Хүний эрх, эрх чөлөө нь шударга, алагчлалгүй шүүхээр хамгаалагдсан байх;

• Үндсэн хууль зөрчсөнийг нотолсон Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, ердийн хууль зөрчсөнийг тогтоосон бусад шүүхийн шийдвэр хүчин төгөлдөрт тооцсон өдрөөс эхлэн холбогдох бүх этгээдэд заавал биелүүлэх хүчинтэй байх, хууль зүйн үндэстэй бол түүнийг албадан биелүүлэх;

• Шударга ёс, зүй ёсны хийгээд нийгмийн бусад хэм хэмжээ Үндсэн хуулийн хүрээнд багтсан байх зэрэг гол шинж бүрдсэн байвал хууль дээдлэх ёс хэрэгжиж байгаа нь тэр.

Түүнийг ойролцоо бусад ойлголт, зарчмаас ялгах нь бас чухал. "Хууль дээдлэх", "хууль сахин биелүүлэх", "хууль ёсны байх" ("Верховенство

[9] Жан-Луи Бержель, "Общая теория права", Перевод с французского, М., 2001 г.

[10] Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он, Нэг дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

нэгэн жарныг элээсэн билээ. Энэ үед төрийн дээр нам, намын дээр удирдагч, хуулийн дээр намын шийдвэр оршиж, ард түмнийг дагуулж байлаа. "Цаг цагаараа" гэдгийн учир энэ буюу.

Гуравт: 1980-аад оны дундуураас хууль дээдэлсэн ардчилсан ёсны жишгээр "өөрчлөлт, шинэчлэлт" гэсэн лоозонгийн доор төр улсаа тэгшлэн засах хөдөлгөөнд нэгдэж 1992 онд ардчилсан Үндсэн хуулийг батлан гаргаснаар Монгол түмний тэрхүү дээдлэн шүтэх ёсон үндсээрээ өөрчлөгдөв.

Тэрхүү дээдлэх ёс нь удирдагчийг, засаг төр баригчдыг бус, харин төр хийгээд иргэний нийгмийн аль алиных нь оршин тогтнолын үндсийг бэхжүүлсэн гол хууль Монгол Улсын **Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс** төлөвшиж эхэлсэн буй. Яагаад ийм болсон тухайд олон учир шалтгаан буй.

2. Хууль дээдлэх ёсны учир

Эзэн Чингис "Бүх улсын доторх өмчийг хувааж, заргыг шийтгэж түүнийгээ хөх дэвтэрт бичиггүн.[5] Надтай зөвлөж, Шигихутугийн шийтгээд цагаан цаасан дээр хөх бичиг бичиж дэвтэрлэснийг ургийн урагт хүртэл үүрд хэн ч бүү өөрчил" гэж нэгэнтээ зарлиг буулгасан байдаг.[6]

Тэр зарлиг Их Монголыг (тулгар төрийг) төдийгүй эзэнт гүрнийг (империйг) дагуулсан аж.[7] Үүнээс улбаалан хууль дагаж шийтгүүлэх ёсон нэвтэрч, түүхийн нугачаанд янз янзын өнгөөр хувьсан өөрчлөгдсөн гэх түүхэн баримтууд бий. Тэр бүхэн нь үзэл бодлын хувьд **орчин цагийн хууль дээдлэх ёс (Rule of Law) зарчмын агуулгатай** яг адилгүй, харин "хуулийн аргаар дарангуйлах ёс"-ыг бататгасан шинжтэй байсныг тэмдэглэвэл зохино. Манжийн төрөөс Монголд хүчээр дагуулсан "Гадаад монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг" хэмээх олон зарлиг хуулийг монголчуудад тулган "үг дуугүй" гүйцэтгүүлж байсныг хууль дээдлэх ёсон хэмээн үзвэл харалган санаа болох буй заа. "Бүхын хүзүү бүдүүн боловч буулган дор, хүний хүзүү бүдүүн боловч хуулийн доор" гэсэн сэтгэлгээ үүнээс үүдэлтэй байж ч мэднэ.

Хууль дээдлэх үзэл Баруун Европод XVIII зуунд хэмжээгүй эрхт хаант ёсны эсрэг тэмцлийн нэг лоозон болон гарч ирсэн байна. Тухайлбал, засаг төрийн бүх эрх мэдлийг хаан ганцаар атгаж, дур зоргын шийдвэр гарган дарангуйлдаг ёсыг халж, "засаг төрийг үндсэн хуулийн хязгаарлалтад оруулахын төлөө" тэмцэл XVIII-XIX зуунд эх газрын орнуудад өрнөж улмаар ялсан түүхтэй.[8]

Тэр цагаас хууль тогтооход ард түмний шууд ба шууд бус (төлөөлүүлэн) оролцоо, үүний тул бүх нийтийн санал асуулга (референдум), сонгууль, парламент, эрх мэдэл хуваарилах зарчим мэтийг санаачлан бүтээжээ. Үүний үр дүнд хууль, зарлигийг нэгэн их тушаалтан зоргоор гаргаж хүссэнээрээ хүчлэн дагуулахыг хязгаарлан, засаг төрийн салаадын харилцан хяналт тэнцэл тогтоож, иргэний нийгмийн хяналт, хязгаарлалтад оруулж, түүнийгээ Үндсэн хууль ("конституция") гэх төрийн гол хуулиар бэхжүүлж авсан аж. Анхны бичмэл үндсэн хууль нь 1787 онд АНУ-д гарч дараа нь бусад улс оронд дэлгэрчээ.

Ингэснээр хууль бол дур зоргын

[5] Улсын дээд заргач Их хаантай зөвлөн шийдэж, бичиж дэвтэрлэсэн нь өөрчлөгдөшгүйн учир өнөөгийн ойлголтоор хэвшүүлсэн (заншлын) хууль болж байсан гэх үндэстэй. -Б.Ч.

[6] "Монголын нууц товчоо", дөрөв дэх хэвлэл, редактор Ш.Гаадамба, 1990 он, 203-р зүйл (Чингисийн зарлиг хийгээд түүний Шигихутугтай зөвлөж шийтгэсэн хэргийн данс хараа нь орчин цагийн хэллэгээр бол "прецендент" буюу хэвшүүлсэн заншлын хууль болж байсан бололтой байдаг. - Б.Ч.)

[7] Чингисийн зарлигуудыг нэгтгэсэн "Их засгийн хууль"-ийг монгол хийгээд түүний эзэмшилд орсон орны дэвсгэр даяар удтал дагаж мөрдөж байсан гэж түүхэнд олонтаа өгүүлдэг. Энэ тухай "Монгол Улсын түүх", дэд боть, МУШУА-ийн Түүхийн хүрээлэн, 2003 он, 102 дугаар тал, "Богд Чингис хааны Их засаг хууль", МУИС, 1995 он, 14 дэх тал.

[8] "Общее административное право", Мюнхен Брюль, Серия Р, Том 4, 2000 г., С.26-29.

нөгөөтэйгүүр уул шинэтгэлийг дагалдан төр нийгмийн оршин, бэхжихэд Үндсэн хуулийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдол эрс өөрчлөгдөж, өссөн нэмэгдсэнээс шалтгаалав.

Монголын нийгмийн байгууллын үндэс шинэчлэгдсэн тухайд гэвэл:

• Нийгэм бүхэлдээ нэг төрлийн өмч, эдийн засгийн тогтолцоо, нийгэмшлийн нэгэн төрлийн бүтцэд үндэслэж байснаас өмч, аж ахуйн олон янзын төрөл хэлбэр, хэвшил, өөр өөрийн сонирхол бүхий бүлэг давхраанд суурилсан шинэ тогтолцоонд шилжиж орсон. Өөрөөр хэлбэл, Монголын нийгмийн байгуулалтын эдийн засаг, нийгэмшлийн суурь үндсээрээ шинэчлэгдэж эхэлсэн;

• Нэг нам дангаар ноёрхсон тоталитари дэглэмтэй улс төрийн тогтолцооноос хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрч хамгаалсан, парламентат ёсны харилцаанд үндэслэсэн ардчилсан дэглэмтэй, олон намт улс төрийн тогтолцоонд шилжсэн;

• Нийтийн засаг буюу эрх мэдэл, удирдах, удирдуулах (үйлчлэх, үйлчлүүлэх) ёсны үүднээс **нийгмийг засаг төр, иргэний нийгэм** гэж хуваан үзэх болсон;

• Засаг төр буюу хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн тогтолцоо нь ард түмнээс эх үндсээ авч "тэдний ашиг сонирхлын нэгдэл, оршихуй" нь болох иргэний нийгэмд үйлчлэх болсон, өөрөөр хэлбэл, иргэний нийгмээ захиргааддаг тогтолцооноос түүнд үйлчилдэг ардчилсан тогтолцоонд шилжсэн;

• Ард түмэн нэг үзэл суртлын хүлээснээс нийтээр хөндийрч олон ургалч үзлийг нийгмийн оюун санааны үндэс болгосон зэргийг хэлж болно. Шинэ Үндсэн хуулиар Монгол Улс оршин хөгжихүйн эдгээр жам ёсны үндсийг зангидаж бэхжүүлсэнд түүнийг нийтээр дээдлэн шүтэх ёс төлөвших болсны нэгэн шалтгаан оршино;

• Дээдлэн шүтэхийн зайлшгүйд хүргэсэн хоёр дахь шалтгаан гэвэл Үндсэн хуулийн нийгэм, эрх зүйн чиг үүрэг юм. Тухайлбал:

Нэгдүгээрт, Үндсэн хууль нийгмийн **улс төрийн харилцааны үндсийг** бэхжүүлж, хамгаална.[14] Хураангуйлбал, төр, ард түмний бүрэн эрхт байдал, нийгэмд хүний эзлэх байрыг тодорхойлж төр ба нам, улс төр-нийгмийн бүлэглэлүүд засгийн салаадын хоорондын харилцааны үндсэн зарчмууд, төрийн байгуулал, байгууламж, нутгийн удирдлагын ардчилсан тогтолцоог бэхжүүлэн хамгаалах явдал энэ чиг үүрэгт хамаарна. Ер нь нийгмийн улс төрийн хүчнүүдийн харьцааг оновчтой тодорхойлж бэхжүүлсэн бол тэр нь бодит үндсэн хууль болно. Энэ тухайд Германы социалист Ф.Лассаль (1825-1864) "... бичмэл үндсэн хууль нь нийгмийн хүчнүүдийн бодит харьцааг яв цав илэрхийлэх аваас бат бөх, ач холбогдолтой байна"[15] гэсэн санааг дэвшүүлсэн байдаг.

Хоёрдугаарт, Үндсэн хуулийн **эдийн засгийн чиг үүрэг** нь Монголын нийгмийн эдийн засгийн харилцааны үндсийг хуульчлан бэхжүүлж, хамгаалахад оршино:

• уг харилцааны суурь болсон өмчийн бүх төрөл, хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хамгаалах;

• аж ахуйн (эдийн засгийн) олон хэвшилд тулгуурласан зах зээлийн харилцааг бэхжүүлэх;

• эдийн засагт төрийн оролцоог хязгаарлан чиглэлийг нь тогтоох;

• төрийн өмч, байгаль, түүний

[14] Энэ талаар 2004.01.12-нд "Өдрийн сонин"-ны сурвалжлагчийн тавьсан асуултанд миний утсаар өгсөн хариуг мөнөөх сурвалжлагч бүсгүй товчхон өөрийнхөөрөө найруулснаас утга гажигтай болсныг дашрамд залруулав ("Өдрийн сонин", 2003.01.13-ны дугаарт үзнэ үү).

[15] Б.А.Страшун нар, "Конституционное (государственное) право зарубежных стран", Том1, Часть общая, Из-во БЕК, М., 1993 г. номоос дам ишлэв.

закона", "соблюдение закона", "законность") гэсэн орос үг хэллэгээр дамжиж Монголын эрх зүйд хэдий нь нэвтэрсэн ойлголт зарчмууд бий. МУИС-ийн ХЗС-ийн багш, докторант Х.Тэмүүжин эдгээр зарчмыг "... манай зарим хуульч, судлаачид ... давхардсан буюу нэг утгатай үзэгдэл тул өөр өөр хэлбэрээр томьёолох шаардлагагүй гэж үзэх явдал байгааг" тэмдэглээд "... хоорондох ялгаа заагийг нь гаргахыг хичээнгүйлэн зорьж" хүлээн зөвшөөрөхүйц оновчтой санаа, дүгнэлтүүд дэвшүүлэн илэрхийлжээ.[11] Миний бодоход (Би ч гэсэн "самуураад" хаа нэгэнтээ хольж хутгасан байж магадгүй л дээ?) эдгээр ойлголт "хууль" гэсэн язгуур нэгтэйгээрээ "төрөлхийн" холбоотой ч гэсэн тус тусын агуулга, "үүрэгтэй" бөгөөд түүнийг нь ялгахгүй бол "хууль дээдлэх" ёсны онцгой чанарыг олж харахгүйд хүрэх бус уу. Утгачилбал: **"Хууль ёс"-ны байх** гэдэг нь хууль ба түүнд үндэслэсэн **эрх зүйн бусад** алив актыг холбогдох бүх этгээд нэг мөр ойлгож, биелүүлэх, хэрэглэх зарчмыг; **"хууль сахин биелүүлэх"** гэж бүх нийтээс **"хууль хэрэгжүүлэх"** үйл ажиллагааны нийтээр хэрэглэдэг нэг гол шаардлага арга замыг илэрхийлдэг. Тэгвэл **"хууль дээдлэх"** нь тэр бүхнээс өндөр дээд түвшний үнэлэмж бүхий түгээмэл зарчим мөн. Энэ нь энгийн хэлбэл, элдэв актыг үл оролцуулан зөвхөн хуулийг эрх зүйн болон нийгмийн бусад хэм хэмжээнээс дээгүүрт тавьж ухамсарласан дотоод итгэлийн үндсэн дээр нийтээр, юуны өмнө засаг төр өөрөө сахин биелүүлэх, хэрэглэх, хамгаалах ёсыг хэлж, ойлгож байна. Төрийн үйл ажиллагааны Үндсэн хуулийн зарчим болгосны учир шалтгаан энэ буюу.

Хууль дээдлэх үзэл эцсийн дүнд эрх зүйн ухамсар, түүгээр дэмжигдсэн ёс суртахууны үнэлэмж мөн гэвэл ойлгоход илүү дөхөмтэй болов уу. "Мэдээж дээдлэх гэдэг нь үзэгдэл өөрөө тухайн субьект өөрийн болон бусдын оршихуй, мөн чанарт ашиг тустай хэмээн уг зүйлд итгэн үнэлж, түүний хүчин чадалд бишрэх, хайрлах, хүндэтгэх байдлаар хандах төдийгүй энэ хандлага нь уг хүний дотоодод өөрийн хүлээн зөвшөөрсөн уг зүйлтэй зөрчилдөхөөс эмээх сэтгэцээр дэмжигдсэн ёс суртахуун, сэтгэл зүйн нөлөөллийг агуулсан байдаг"[12] гэснийг дэмжиж болох. Энэ бүх шаардлагын манлайд нь Үндсэн хууль "заларч" түүнийг "мэдэгтүн", "сахигтун" гэсэн уриа буюу зарлиглал "цуурайтаж" байгаа шүү дээ. Иймд, хууль дээдлэхэд тавигдах бүх шаардлагуудыг ойлгож, тууштай хангаж амьдруулахад **Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс** хууль зүйн хийгээд үзэл баримтлалын гол суурь болно. Монгол Улсын өмнөх Ерөнхийлөгч нар *"Сайн төрийн толгойд хууль, муу төрийн толгойд удирдагч"* (Н.Багабанди); *"Үндсэн хууль бол ... Монгол төрийн үзэл баримтлалын тулгуур баримт бичиг мөн"*[13] (П.Очирбат) гэж хэлцгээснийг онч үг хэмээн ишлэх нь зүйн хэрэг болов уу.

3. Үндсэн хуулиа дээдлэн шүтэхийн учир:

Хууль дээдлэх зарчмын суурь нь **Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс** гэж болно. Энэ бол ямар нэгэн мухар сүсгийн тухай таамаглаж байгаа хэрэг огтхон ч биш билээ. Харин оршин буй улс нийгэмд бодитойгоор үйлчилж буй эрхэм дээд үзэл санаа, зарчмын тухай асуудал юм. **Үндсэн хуулийг дээдлэн шүтэх нь хууль дээдлэх ёсны суурь** хэмээн тооцоход наанадаж хоёр гол шалгуур буюу учир шалтгаан байна.

Юуны өмнө Монголын нийгмийн улс төр, эдийн засаг, нийгэмшил, соёл оюуны үндсүүдийн шинэчлэгдсэн нь,

[11] Х.Тэмүүжин, "Jus frast буюу Ёст үг", УБ., 2004 он, 17-20 дахь тал..

[12] Х.Тэмүүжин, "Jus frast буюу Ёст үг", УБ., 2004 он, 19 дэх тал.

[13] Н.Багабанди, "Би Монгол төрийн толгойд хууль байхыг хүсч байна", "Өдрийн сонин", 2004.01.02, №1(1504); П.Очирбат, "БНМАУ-ын АИХ-ын 1992.10.07-ны өдрийн II хуралдаанд тавьсан илтгэл" ("Алдаж болохгүй агшин", УБ., 1997 он, 254 дэх тал)..

зүйн үндэс суурь нь Үндсэн хууль бөгөөд **"Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино"** гэж ...Үндсэн хуулийн сүүлийн зүйлд тунхаглан зааснаас асуудал тодорхой билээ. Үндсэн хууль бол хууль зүйн хамгийн дээд хүчин чадалтай акт гэдэг нь өгүүлэн буй чиг үүрэгтэй холбоотой.

Тавдугаарт, бас нэгэн эздрээтэй, маргаантай боловч бодитоор илэрч буй чиг үүрэг бий. Энэ бол төрийн үзэл суртал буюу ард түмний туйлын "хүслэн" (идеал) гэж байх уу, үгүй юу? гэдэгтэй холбоотой. "Идеология" гэдгийг монголчууд үзэл суртал, "идеал" гэдгийг туйлын зорилго гэж хэлж, ойлгож иржээ. Энэ хос ойлголтыг тайлбарлахыг азнаад нэг намын буюу коммунист үзэл суртлын ноёрхлоос татгалзан (олон) ургалч үзлийг хүлээн зөвшөөрсөн нөхцөлд Монголын ард түмнийг нэгэн зүгт нийтээр тэмүүлэхэд хөтлөн дагуулах үзэл байх ёстой юу? Эцсийн дүнд бидний урагшлахад уриалан дуудах **туйлын хүслэн** (ideal) байна уу үгүй юу гэдэг утгаар энэ асуудлыг авч үзье.

Улс төрийн плюрализм буюу ургалч үзэл гэдэг бол хүмүүс, нийгэмшлийн бүлгүүд өөрсдийн итгэл үнэмшилтэй байж, түүнийгээ чөлөөтэй илэрхийлж хамгаалахыг хүлээн зөвшөөрсөн ардчилсан ёсны нэгэн үндсэн шинж мөн. Гэвч иргэний нийгмийг бүрдүүлж буй бүх **ард түмнийг** нэгтгэж нэгэн бүхэл болохуйц оюун санаа, хүсэл зориг, ашиг сонирхлын хүчин зүйл байхгүй бол тэр ард түмэн зүг бүр зүтгэсэн хэсэг бусаг бүлэглэл болон хувирах магадлал бий. Ард түмний язгуур ашиг сонирхолд үндэслэсэн эрхэм зорилгыг илэрхийлсэн оюун санааны сэтгэл зүйн хүчин зүйлсийг бид туйлын хүслэн гэж үзэж байгаа юм. Монголын ард түмэн бол улс орныхоо өнө удаан оршин тогтнолын төлөө гэх сэтгэл оюунд нэгдсэн, бүрэн эрхт тусгаар улсын нийгэмшлийн үндэс бөгөөд түүхэн ёсоор тогтсон хэл соёлын нийтлэг хийгээд улс төр, эдийн засгийн язгуур ашиг сонирхол бүхий биеэ даасан үндэстэн, иргэний нийгмийн цогц мөн. Энэ хувьдаа нэгдмэл нэг туйлын хүслэнтэй байдаг.

4. Үндсэн хуульд ард түмний туйлын хүслэнг тодорхойлсон нь

Грек гаралтай "IDEAL" гэдэг үг монголоор "хүслэн", "туйлын зорилго", "орь хүслэн", "эрмэлзэл", "өв тэгш зүйл", "туйл" гэсэнтэй дүйх аж. Энэ үг алив хүн, хамт олон, нийгмийн амьдрал, тэмцлийн эрхэм дээд зорилго, нийтээр сүсэглэн тэмүүлэх чин эрмэлзэл гэх утгыг илэрхийлнэ. Гадаад хэлний тайлбар тольд "төгс байдал", үйл ажиллагаанд тэмүүлэх "дээд зорилго" гэх утгаар тайлжээ. Энэ сүүлчийн утгаар үзвэл:[17] Монголын ард түмний туйлын хүслэн нь буюу эрхэм дээд зорилго тэмүүлэл нь чухам юу юм бэ? Үүнийг хэн, хаанаас юугаар, хэрхэн тодорхойлдог вэ? гэдэг бодит шалгууртай ойлголт юм. Өмнөх дэглэмийн үед нэг нам ноёрхсоны учир монгол түмний хэтийн зорилгыг тодорхойлж байв. Тэр нь "коммунизмын гэрэлт ирээдүй" билээ. Гэтэл өдгөө өөр өөрийн үзэл бодолтой (либераль, радикал, консерватив баруун, зүүн, социалист, коммунист төв үзэл гэх зэрэг), улс төрийн өвөрмөц сонирхол бүхий олон нам байгаа учир ганц нам ард түмнийг бүхэлд нь төлөөлөн хүн амыг нийтэд нь алсын алсад дагуулах боломжгүй юм. Түүнчлэн хүн бүр шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй, өөр өөр шашин оршин буй учир нэг нь бүгдийг дагуулах чадваргүй. Эл нөхцөлд Монголын ард түмний язгуур ашиг сонирхлыг чухамхүү төрийн гол баримт бичгээр хуульчлан томьёолж, дагуулахаас өөр зам одоогоор нээгдээгүй гэж хэлж болно. Аль нэг ердийн хуулиар ч үүнийг орлуулах боломжгүй билээ. Иймээс өгүүлэн буй туйлын хүслэнг

[17] Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв, "Орос-Монгол толь", 1982 он, 182 дахь тал.

баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх харилцааны үндсийг тодорхойлон зохицуулах нь энэхүү чиг үүргийн гол агуулга болно.

Эдгээр үндэслэл Монгол Улсын Үндсэн хуулийн 5-7 дугаар зүйл, 16 дугаар зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 7, 8 дахь хэсэг болон 38 дугаар зүйлийн 2-4 дэх хэсэгт тусгалаа олсон байна.

Гуравдугаарт, Үндсэн хуулийн **нийгэмшлийн чиг үүрэг** нэн олон талтай юм. Түүний агуулга нь ард түмний засаг төрийн үндэс байх бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ хүний нийгэм соёлын эрх, эрх чөлөөг бататгаж, түүнийг хангах баталгаа, нийтийн үйлчилгээ, нийгмийн хамгааллын талаарх засаг төрийн байгууллагын үндсэн үүргийг тогтоон бэхжүүлэхэд оршино. Энэ нь Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 2, 4-8, 11, 15 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 7 дахь заалт, 55 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 1 дэх хэсэг зэрэг бусад зүйлд тусгалаа олж томьёологдсон байгаа. Гэхдээ энэ бүхэн зөвхөн үг үсгэндээ биш хуулийн үзэл баримтлалд агуулагдана.

Дөрөвдүгээрт, Үндсэн хуулийн **"хууль зүйн чиг үүрэг"** гэж чихэнд бараг хоногшоогүй томьёолол байдаг. "Үндсэн хууль бол хууль биш" гэж манай зарим улс төрч маргадгийг үзвэл энэ нь шинжлэх ухааны зохих тайлбар нотолгоо хэрэгтэй бололтой.

Нэрт шог зохиолч, АИХ-ын депутат асган Ж.Барамсай эрдмийн зэрэг горилсон зохиолын хэлбэрдлийг шоглон бичихдээ "Үхэр" диссертацийн дүгнэлт болгон "Үхэр бол амьтан мөн, амьтан амьтандаа бүр амьд амьтан мөн" гэж бичсэн шиг "Үндсэн хууль бол хууль мөн, хууль хуульдаа бүр гол хууль мөн"гэж хэлүүштэй.

Монголчууд бид үнэнийг гаднаас л олж "бэлэнчлэх" гээд байдаг, өөрсдийгөө үл зөвшөөрсөн хүмүүс болохоор Францын харьцуулсан эрх зүйн дэлхийд нэрд гарсан эрдэмтэн агсан Рене Давидын бичсэнийг иш татахад илүүдэхгүй байхаа. Тэрээр нийтлэг эрх зүйн (common law) хэм хэмжээ, бусад хуультай АНУ-ын Үндсэн хуулийг харьцуулан үзээд "Холбооны хуулиудын дотор Үндсэн хууль, өөрөөр хэлбэл АНУ-ын Үндсэн хууль онцгой байр эзэлнэ ... . Тэр бол нийгмийн чухамхүү тулгуурыг нь тодорхойлсон үндсэн хууль"[16] гэхчлэн юутай ч хууль мөнийг нотлон өгүүлжээ.

Чухамхүү нийгмийн бүх харилцааны үндсүүдийг бэхжүүлэн оршин хөгжих суурийг хамгаалдаг тэрхүү онцгой чанарт нь түүний **хууль зүйн чиг үүрэг** төвлөрдөг бөгөөд энэ нь дараах байдлаар илэрнэ. Тухайлбал, Үндсэн хууль нь:

• Төрийн хууль тогтоомжийн бүх акт (үндсэн хуульчилсан болон ердийн материаллаг хийгээд процессын хууль, УИХ-ын тогтоол, хөтөлбөр зэрэг);

• Хуулийн бүх дэд акт (Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, сайд, агентлагийн дарга, бүх шатны засаг дарга нарын тушаал, захирамж зэрэг);

• Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээг дагаж мөрдөхгүй гэж Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 4-т заасан ёсоор Монгол Улсын олон улсын бүх гэрээ;

• Нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн үйлдвэр, албан газрын захиргааны бүх акт;

• Аливаа байгууллага, албан тушаалтан, иргэний өдөр тутмын үйл ажиллагаа тус тус Үндсэн хуульд нийцсэн байх ёстой.

Өөрөөр хэлбэл, энэ бүхний хууль

[16] Рене Давид, Камилла Жоффре-Спинози,"Основные правовые системы современности", "Международные отношения", М., 1990 г., С. 397, 399.

хүчин зүтгэх жам ёсны үүрэгтэй. Үүнийг ардчилсан Үндсэн хуульт байгуулал иш үндэс болгоно. Засаг захиргааны түшмэл, мэргэжлийн хянан шалгагч, цагдаа, шүүгч хэн боловч "би хүмүүсийг захирч байна" гэж ойлгож ихэмсэг, дээрэлхүү, "цэвдэг хүйтэн" хандах биш, харин "тэдэнд үйлчилж, тусалж байна" гэж өгөөмрөөр сэтгэж дадахыг, өөрөөр хэлбэл урьдын захиргаадалтын арга барилаа үндсээр нь эргүүлэн энэрэнгүйжүүлэх буюу хүмүүнлэгжүүлэх нь төрийн албаны ёс зүй нийгмийн сэтгэл зүйн шинэтгэл болох ёстой. Үүнд бас "хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм" гэсний уг чанар оршино. Мэдээж хүн "хязгааргүй эрх чөлөөтэй" гэж андуурч "балмадлан явах" бус. Харин Үндсэн хуулиар бататгасан:

1) Эрх, эрх чөлөөгөө "... үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг" гажуудуулахгүйгээр эдэлж;

2) "... шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн ..." нийгэмд хүлээсэн үндсэн хийгээд журамт үүргээ ёсчлон биелүүлэх[18] нь мөн л Үндсэн хууль дээдлэн шүтэх ёс биелж байгаа нь болно.

Иргэн хүний үүргийн тухай сая дурдсан үндэслэлүүд нь:

"Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусдын эрх чөлөөг эрх зүйн дагуу зөвшөөрөн хүндлэх, ёс суртахууны шударга шаардлагыг биелүүлэх, ардчилсан нийгэмд байдаг хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосон зохих хязгаарлалтад л захирагдана"[19] гэсэн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын заалтад ч нийцэж байгаа билээ.

5. Үндсэн хуулийг дээдлэн сахих үзлийг төлөвшүүлэн бэхжүүлэх алхмууд

Ёс зарчим, үзэл баримтлалыг тунхаглах, лоозондох нь хагас алхам. Харин гүйцэд алхах буюу бодит үр дүнд хүргэхийн тулд ихээхэн хүчин чармайлт шаардана.

Шинэ Үндсэн хуулийг дагаж мөрдсөн 10 гаруйхан жилийн хугацаанд Монгол орон улс төрийн ардчилсан тогтолцоо, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн нь үнэнхүү том амжилт мөн. Үүгээрээ бахархаж болно, гэлээ ч сэтгэл цадаж, санаа сагаж болохгүй. Бид чинь улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, оюуны "өөрчлөлт, шинэчлэлт"-ийг эхэлж, гүнзгийрүүлэхдээ бүхнийг нэгэн их татах хүчинд зангидаж, тухайлбал, "Үндсэн хуулийн шинэтгэл" гэсэн дээдлэх ёс зарчимд нийт ард түмний хүч анхаарлыг төвлөрүүлж зангидах замаар хийж гүйцэтгэсэн билүү, эсвэл хэсэг бусаг шийдвэр, төслөөр амжуулав уу гэвэл байдал арай өөрөөр ойлгогдож байгааг нуух юун.

Тоймолж үзэхэд хууль тогтоохоос бусад хүрээнд төрийн гол хуулийнхаа заалт, үзэл баримтлал,түүгээр тунхагласан ард түмний туйлын хүслэнг өргөн олонд тайлбарлан таниулах, улс төрийн ажилтан төрийн болон орон нутгийн албан хаагчдад зааж сургах талаар тухайлж хөтөлбөржүүлэн нэгдсэн урт хугацааны ажил улс даяар зохиосонгүй юу даа гэж үзэхээр байна.

Үндсэн хууль баталсны дараа түүнийг хэрэгжүүлж эхлэх нэн анхны арга хэмжээг 1992 онд халаагаа өгөх нь тодорхой болоод байсан Улсын Бага Хурал, Засгийн газар төлөвлөн баталж зарим эхлэл тавьсан. Түүнээс уламжлан:

- Хуучин хуулиудыг үндсэнд нь шинэчилсэн;

- Нийгмийн шинэ харилцааг тусгасан хууль олныг гаргасан;

- "Өөрчлөлт, шинэчлэлт"-ийн зарим салбар үзэл баримтлал, цөөнгүй хөтөлбөр гаргасан;

[18] Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он, 19 дүгээр зүйл.

[19] Хүний эрхийн олон улсын гэрээ хэлэлцээрийн эмхтгэл, НҮББШУСБ, УБ., 1993 он, 8 дахь тал.

тодорхойлон хуульчлах үүргийг чухамхүү Үндсэн хууль гүйцэтгэж байгаа юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн оршилд манай ард түмний туйлын хүслэнг дараах томьёоллоор илэрхийлэн бататгажээ. Үүнд:

“Монголын ард түмэн бид:

- Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,

- Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,

-Төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,

- Хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна.” гэсэн байдаг.

Ард түмний нэрийн доор тунхагласан эдгээр үндэслэл өөр өөрийн өргөн агуулга, гүн утга бүхий дээд эрмэлзэл тул тус тусын нухацтай тайлбар шаардана. Тэдгээрээс хүмүүс олон янзаар төсөөлөөд байна уу даа гэж ажиглагддаг иргэний нийгмийн талаарх заалтын учрыг цухас дурдья.

“Иргэний ардчилсан нийгэм” (ИАН) гэдгийн тухайд бол Үндсэн хуульд түүнийг “байгуулах” тухай биш, “төлөвшүүлэн хөгжүүлэх”-ийг эрхэм зорилго болгон тунхагласан байна. Гэтэл энэ үндэслэлд “социализм байгуулна” гэдгийн урьдын загварчилсан сэтгэлгээгээр хандаж Монгол оронд өдгөө ИАН байгуулж байгаа мэтээр ярих, бичих нь улиг болжээ.

Иргэний нийгэм бол амьдралын гүнд байсаар ирсэн төр, нийгмийн зөв оршихуйн үндэс аж. Гэтэл өмнөх үед түүнийг жинхэнэ утгаар нь тухайлбал, засаг төрийг төрүүлэн гаргаад хянаж нөлөөлөх үндсэн дээр өөрсөддөө үйлчлүүлдэг тийм ардчилсан тогтолцоо бүхий нийгэмшлийн зохион байгуулалт болгож, байр суурийг нь эзлүүлэн хөгжүүлэх ойлголт, зарчим байсангүй. Зөвхөн засаг төр л ард түмнийг удирдан захирч төр, нийгмийн төлөө ажиллуулдаг гэсэн үзэл зарчмаар иргэний нийгэмд хандаж ирсэн байна. Энэ хандлагаас ангижран иргэний нийгэм нь засаг төрийн байгууллагын эх үүсвэр байж, үйл ажиллагаанд хяналт тавьж, түүнийг өөрсөддөө үйлчилдэг “зарц” болгож чадсан тийм ардчилсан цогц тогтолцоо болгон төлөвшүүлж бэхжүүлэхийг л “цогцлуулан хөгжүүлэх” гэсэн томьёоллоор ард түмэн эрхэм зорилгоо болгожээ. “Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна” гэсэн Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн үндэслэл бол зөвхөн сонгох ёсыг хэлж байгаа нь бус, засаг төр ИАН-д үйлчилнэ гэсэн зарчмыг тусган илэрхийлжээ гэж болно.

ИАН ба засаг төр хоёрын хоорондын харилцааны язгуур зарчмын үүднээс авч үзвэл:

- Парламент (гишүүд) нь ард түмнээс бүрэн эрх (мандат) авч гараад тэднийг эргэн захирч давамгайлж байх бус, харин төрийн мэргэшсэн аппаратын болзошгүй дарамтаас нийт иргэний нийтлэг ашиг сонирхлыг хууль журамд тусган хамгаалж хянаж байх;

- Гүйцэтгэх (захиргааны) төв, орон нутаг, салбар хүрээний байгууллага, аппарат нь хуулийг биелүүлэн, төрөөс үзүүлэх нийтийн үйлчилгээ, нийгмийн (халамж, хангамж) хамгааллыг зохих ёсоор зохион байгуулж хүн амд үйлчлэх;

- Шүүх эрх мэдлийн байгууллагууд нь шударга ёс, эрх зүйн үндсэн дээр гүйцэтгэх болон хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг засаг төрийн дур зоргын ажиллагаа, **“хуульд дуулгаваргүй этгээд”**-ийн халдлагаас хамгаалах гэхчлэн иргэний нийгэмдээ

явах нь бий. Энэ бол албаны хэлээр өгүүлбэл, Үндсэн хуулийн нэр барьж өргөмжлөгдөөд эрх тушаал эзэлмэгц эргээд дайрч буй хэрэг, энгийнээр хэлбэл "Амар байна уу гэсэн биш, гай болов" гэдэгтэй агаар нэгэн. Хуулийг сайжруулах тухай нийтэд хандан ярьж бололгүй яахав. Гэвч энэ нь иргэдийн эрх болохоос, уг хуулийг биелүүлэхээ тангараглаж, үүрэг хүлээсэн төрийн албан хаагчийн хашгирч явдаг үг бишсэн билээ. Юм бүхэн хэмжээ хязгаартайн нэг нь энэ.

Үндсэн хуулийн нэрээр өөрчлөлт шинэчлэлтийн үйл явцыг албан ёсоор нэгтгэн дүгнэж, алдаа оноог нягтлан тодорхойлсон төрийн дээд түвшний шийдвэр гарсангүй. Цэцийн шийдвэрийг Улсын Их Хурал ойшоон үзэхгүй алгуурладаг муу зуршил сүүлийн 8 жилд мэр сэр үзэгдээд цаашдаа архагших янзтай.

Хуулийн бус дээд сургуульд Үндсэн хуулийн сургалт үгүйлэгдэж, заримд нь нэр төдий зүйл болж байгааг судалгаа харуулжээ. Өдгөө Соросын сангийн явуулсан бэлтгэл, туршилтын хөтөлбөр хийгээд сурах бичгүүд 8-9 дүгээр ангид Үндсэн хуулийн зарим сэдвийг орж буй нь сайшаалтай боловч эргэж харууштай зүйл байна. Хэнтий аймгийн Өндөр хаан дахь дунд сургуулиудын нийгмийн ухааны багш нартай хийсэн уулзалт ярилцлагаас үзэхэд аймагт Үндсэн хуулийн боловсролд санаа тавьдаг хүн нь цөөн тооны багш нар л байдаг бололтой.

Энэ мэтийг болон бусад орны жишгээс үзвэл **Үндсэн хууль дээдлэх үзэл дадлыг нийт иргэн, төрийн албан хаагч, улс төрчид, ялангуяа залуу үеийнхэнд итгэл үнэмшил, дадал зуршил болон төлөвшүүлэхэд зориуд анхаарал тавьж** төрийн бодлогын түвшинд зохих шийдвэр гарган хэрэгжүүлбэл ардчиллын үнэт зүйлсүүдийг ард түмний хүртээл болгож шинэтгэлийг гүнзгийрүүлэхэд чухал тус үзүүлнэ. Үүний тул:

- Үндсэн хуулийн агуулга, заалт, ач холбогдол иргэд, төрийн албан хаагч, сурагч оюутан залууст тайлбарлан таниулах, сургалт явуулах агуулга бүхий "Үндсэн хуулийн албан, албан бус сургалтын хөтөлбөр"-ийг Засгийн газрын хэмжээнд төлөвлөн санхүүжүүлж, тодорхой хугацааны давтамжтайгаар явуулах;

-Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагыг Үндсэн хуулиар хангаж, "төрийн хэрэг" хөтлөх журамд хүндэтгэл, хариуцлагатай байр эзлүүлэх;

-Төрийн ба нутгийн албан хаагчдын "Үндсэн хууль" сургалт семинарыг жил бүр сум, дүүргийн Засаг даргын болон яам, агентлагийн шугамаар зохион явуулж, шалгаж дүгнэж байх;

-Үндсэн хуулийн өмнө андгай, тангараг өргөх ёс журмыг хянан үзэж, нэр хүндийг нь дээшлүүлэхүйц хэлбэр журамд оруулах, ёс болгох хандлагаас ангижрах;

-Төрийн шүтээний зан үйлийг дэмжиж зөв хэвшүүлэх (сүлд залах, төрийн туг, далбаа мандуулах тахих, Үндсэн хуулийн өмнө тангараг, андгай өргөх, сүлд дуулал эгшиглүүлэх, УИХ-ын чуулган, нутгийн Хурлын хуралдаан эхлэхэд Үндсэн хуулийн өмнө хүндэтгэлийн ёслол үйлдэх гэх зэрэг);

-Үндсэн хуулийг зөв тайлбарлах замаар Цэцийн эрх, үүргийг үндсэн хуульчилсан актаар дэлгэрүүлэн тогтоож, түүний үйл ажиллагааны цар хүрээ, онолын түвшин, практик үндэслэлийг дээшлүүлэх;

-Үндсэн хуулийг хүн амын янз бүрийн давхраанд зориулан уншиж судлах, залж "тахих"-д дөхөмтэй хэлбэр хэмжээгээр хэвлэн нийтлэх, болж өгвөл үнэгүй түгээх (Жишээ нь: Шинээр гэрлэгчдэд зориулан баринтаглан хэвлэж гэрлэх ёслолын ордонд тавьж түгээх нь "бөгжнөөс" яахин дутах билээ. Түүнтэй зүйрлэх ч аргагүй мэт.);

-Ном товхимол, гарын авлага боловсруулах, энэ чиглэлээр эрдэм

- Үндсэн хуулийг 3 удаа хэвлэн нийтэлсэн;

- Судлаач багш нар зарим ном зохиол санаачлан нийтлүүлсэн;

- Хуульч бэлтгэхдээ зааж зөвлөж, судлуулж ирсэн;

- Жил бүр Үндсэн хуулийн өдрийг тэмдэглэх үеэр хэвлэл мэдээллийн хэрэгслээр ганц хоёр өдөр "сурталчилж" заримдаа хурал цуглаан зохиож дадсан;

- Төв музейд 2001 оны 1 дүгээр сард Үндсэн хуулийн булан нээж үзмэр дэлгэсэн (саяхан буулгачихсан харагдсан) гэх зэргээр түүгээд байвал нэрлэх ажил нэлээдгүй.

Гэсэн хэдий ч өнгөрсөн 12 жилд Үндсэн хуулиа сурталчилж, түүнд сурган хэвшүүлэх ажлыг баг хороо, айл өрх хүртэлх улсын хэмжээний өргөн цартай, улирал жил дамнасан "урт" хугацаатай, шахаж шаардаж, шалган дүгнэдэг эзэн шалгууртай тогтмол ажил хараахан болгосонгүй алгуурлажээ гэхэд хилсдэхгүй.

Улс төр, эдийн засаг, нийгэмшлийн хүрээнд **"Үндсэн хуулийн шинэтгэл"** гэх хөтөлбөр бүхий мэргэжлийн удирдлага зохицуулалттай нэгдсэн арга хэмжээ ийнхүү үгүйлэгдэж билээ. Үүнийг харгалзан үзээд Улсын Ерөнхийлөгчөөс 1996 онд дэвшүүлсэн санал болон 1997 онд өргөн мэдүүлсэн төслийг УИХ анхаарч хүлээн аваагүйгээр үл барам харин ч сүрхий үгүйсгээд хэсэг бусаг арга хэмжээгээр орлуулсан нь хоорондоо зөрчилдөхөд хүрсэн үзэгдэнэ.

Төрийн ба нутгийн байгууллага, албан хаагчдыг Үндсэн хуулиар хангах, тэднийг энэ талаар зохих хэмжээний мэдлэгтэй болгоход тухайлж анхаарсангүй. Бидний хэсэгчилсэн судалгаанаас үзэхэд төв, орон нутгийн олонхи албан хаагч тэр дундаа өрх бүрд хүрдэг багийн засаг даргад, бас сумдын захиргааны сан хөмрөгт Үндсэн хууль байхгүй нь судлах бүү хэл "үзээгүй" өдий хүрсэн нь цөөнгүй тохиолдов. Үндсэн хуулийг хэвлэн баг, хорооныхоо Засаг даргад үнэгүй тараачих соёл, нүнжиг дутагдаа юу гэлтэй. Тэдэнд зориулан аймгаас гаргасан ажлын дэвтэрт юм уу, төвөөс гаргасан эмхтгэлд "Үндсэн хуулиас" гэсэн гарчгийн дор ганц хоёрхон (Засаг даргын ба иргэний үүргийн тухай) зүйл, сайндаа л "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" бүлгийг нийтэлсэн байх жишээтэй.[20]

Төрийн албанд хүмүүсийг шалгаруулан шилж авах, улс төрийн ажилтан бэлтгэхэд энэ асуудлыг тодорхой болзол, шалгуур болгож анхаардаггүй байна. Үндсэн хуульд үнэнч байх нь албан хаагчийг төрийн хүн болгож буй ухамсрын гол хүчин зүйл, онцлох шалгуур, засаг төр нь нэг бодлого журамтай ажиллахын зайлшгүй нөхцөл мөн билээ. Энэ нь төрийн хүн эрх зүйт төрөөс зүтгэх жам ёсны шаардлагаас урган гарч буй хэрэг. Тиймээс ч манайд бол Үндсэн хуулийг гуйвалтгүй биелүүлэхээ тангарагладаг бөгөөд ардчилсан зарим орон иргэнийг Төрийн албанд ороход нь Үндсэн хуульд үнэнч эсэхийг тусгайлан шалгадаг хуультай байдаг.[21]

Манай улс төрч болон төрийн албанд горилогч зарим хүн энгийн байхдаа Үндсэн хуулиа сайтар судлаагүй байж "зад муулчихаад", дараа нь түүнийг магтаж үндэслэл заалтын нөмрөгт нь сонгууль, шалгаруулалтад орж элдвийг амладаг. Тэгээд ялангуут Үндсэн хуульдаа үнэнч байхыг тангараглаж гарын үсэг зурснаар эрх мэдэл олж авдаг. Тэгснээ удалгүй өөрчлөх ухааны юм яриад, ингэснээрээ бусдад зохисгүй нөлөөлөөд

[20] "Багийн Засаг дарга нарын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн эмхтгэл", Засгийн газрын хэрэг эрхлэх газар, УБ., 2002 гэсэн гарын авлага гаргасан нь сайшаалтай. Гэвч "хууль тогтоомж"-д ордоггүй олон акт, сайд нарын том том тушаал зааврыг оруулсан атлаа 70 зүйлтэй Үндсэн хуулиас зөвхөн 6 зүйлийг нийтэлжээ. Багийн засаг даргад чинь хүний эрх, эрх чөлөө, Монголын төрийн байгуулалт, Үндсэн хуулийг сахин биелүүлэх тухай заалтууд хамаагүй гэж үү? ... гэмээр.- Б.Ч.

[21] ХБНГУ-ын Бавари муж улсын "Үндсэн хуулийг хамгаалах тухай" хуулийн 3-р зүйлийн 1 дэх хэсэг.

шинжилгээний чанарлаг ажлыг хөхиүлэн дэмжих;

-Аймаг, сум, багийн засаг захиргааны газруудыг Үндсэн хуулийн мэдээллийн булан, сантай болгох, нийслэлд олон нийтэд зориулсан "Танхим" бий болгож иргэдэд үйлчлэх зэргээр уг ажлыг шинэ хөдөлгөөнд оруулж эрчимжүүлэн тогтмолжуулах нь чухал.

-Радио, телевизийн нэвтрүүлэгт тайлбар, үзүүлбэрээс гадна Засгийн газраас санхүүжүүлж өглөө, оройн "уншлага" оруулах нь юуны буруу байхав.

Зарчмын шийдэл шаардсан өөр нэг зүйл байна. Тухайлбал, Үндсэн хуулийн байгууллыг сахин хамгаалж буй байдалд төрийн тусгай албаны хяналт тогтоох асуудлыг улс орны аюулгүй байдлыг хангах түвшинд авч үзэх нь төр, нийгмийн хөгжилд амин чухал учир холбогдолтой болов уу.

Улсын Их Хурал өөрөө Үндсэн хуулиа, Засгийн газар, шүүх эрх мэдлийн байгууллагууд Үндсэн хууль, түүнд нийцсэн хууль, олон улсын гэрээг ёсчлон биелүүлж хяналт тавьж зөрчил гаргасанд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох зэргийн олон хэлбэрийн үр нөлөөтэй ажил зохиомоор. Ер нь ердийн хууль зөрчсөний учир гэм буруутныг тогтоож хариуцлага оногдуулдаг атал Үндсэн хууль зөрчсөний учир энэ талаар чимээ ч гаралгүй өнгөрдөг хачирхалтай явдлыг халах цаг болсон буй заа. Чингэх нь Монголын ард түмэнд хууль дээдлэх үзэл, дадал төлөвшүүлэхэд хамгийн үр нөлөөтэй байх билээ.

Сахилга хариуцлага гэгч дээрээсээ эхэлж тэндээс үлгэр жишээ, "цочрол" авдгийг төрт ёсны түүхэн уламжлал харуулдаг байжээ. "Зэм ирвэл ахад, зуд ирвэл хуцанд" гэдэг нь талаар үг биш болов уу.

Доор дээргүй судалж, дээрээсээ үлгэр үзүүлэх нь: Миний бие бодон бодон явсаар нэгэнтээ хэдэн багш, хэсэг хуульчийн хамт Берлин дэх Чөлөөт их сургуулийн Үндсэн хуулийн профессоруудтай уулзахдаа *"Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх... эрхтэй. Урлаг, шинжлэх ухаан, шинжлэл судлал, багшлахуй нь чөлөөтэй. Багшлах эрх чөлөө нь Үндсэн хуульд үнэнч байхаас чөлөөлөгдөхгүй"*[22] гэж танай улсын Үндсэн хуульд заасан нь ямар учир утгатай юм бэ? гэж асуулаа. Тэд:

-Үндсэн хууль төрийн гол хууль, ХБНГУ-ын үндсэн хуулийн байгууллын үндэс учир түүнийг гуйвуулсан дуу хоолой их сургуулийн хананаас гарах ёсгүй гэсэн утгатай гэхчлэн тайлбарлаж өгсөн билээ. Нээрээ л тиймдээ гэлтэй. Ард түмний дээдлэн шүтэж явах нэгэн гол шүтээн байхгүйгээр үндэсний эв нэгдэл, тусгаар улс оршин тогтноход бэрхтэй юм.

Тийм шүтээн бол солигдоод байдаг удирдагч, гурван салаанд хуваагдсан засаг төрийн дээд газрууд, өөр өөр үзэлтэй намууд, янз янзын номлол бүхий шашны аль нь ч биш, гагцхүү Үндсэн хууль бөгөөд түүнийгээ "бут аваад" байвал улс гүрэн хямарч тогтворгүйтэх магадлал их. Иймд, гол хуулиа нийтээр сүсэглэн дагуулахын тул Үндсэн хуулийг тайлбарлан таниулах хийгээд сургалт зохион явуулахад **шинжлэх ухааны үнэн зөв хандлага онцгой чухал ач холбогдолтойг эрх зүйт төрийг төлөвшүүлсэн улс** орнууд нотолсон аж.

Коммунист үзэл, социализм бүхэлдээ мухардалд орсонтой уялдсан гүнзгий хямрал хууль зүйн амьдрал, эрх зүйн талаарх нийгмийн сэтгэл зүйг тойрч өнгөрөөгүй. Өөрөөр хэлбэл, хоёр зууны заагаар улс төр, эдийн засагт нүүрлэсэн хямрал нь хууль зүйн хямралыг дагуулсан билээ. Энэ нь эрх

[22] ХБНГУ-ын Үндсэн хууль, 1949 он, 5 дугаар зүйлийн 1, Здахь хэсэг: "Every person shall have the right freely to express ... his opinions... . Arts and sciences, research and teaching shall be free. The freedom of teaching shall not release any person from allegiance to the constitution".

зүйн социалист тогтолцоог ардчилсан тогтолцоогоор шинэтгэн буйтай шууд холбоотойг гүнээ ухаарах учиртай. Уул хямрал нь бас хууль хийгээд эрх зүйг үгүйсгэх, туйлшруулах (бүхнийг хуульчлах гэх) буюу эрх зүйн нигилизм, абсолютизм хоёрыг үзэж, туулж өнгөрөөхөд хүргэсэн байна.

Нөгөөтэйгүүр хүмүүс ардчиллын ачаар олж авсан итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөгөө хэрэг дээр эдлэх болсноор хууль зүйн амьдралд олон түмний өгөх үнэлэмж ил тод болжээ.

Энэ үйл явцыг судалгааны зорилгоор ажиглахад Үндсэн хуулийн утга санааг гуйвуулан "тайлбарлах", үгүйсгэх хандлага ч илэрдэг. Хууль дээдлэх, Үндсэн хууль дээдлэн шүтэх гэдэг бол Монгол төр, иргэний нийгэм, ард түмнийг нэгдмэлээр авч үзсэн, үндэсний эв нэгдэл, язгуур ашиг сонирхол, туйлын зорилгын үүднээс эрхэмлэсэн ойлголт бөгөөд харин зарим хүн зарим асуудлаар хувийн үзэл бодлоо илэрхийлэхийг хориглоно гэсэн агуулгатай бишийг тэмдэглэх нь зүйтэй. Үүний хамт учрыг үл ухан үгүйсгэх, зориуд гуйвуулах хандлага төслийг хэлэлцэх үеэс эхэлж, өнөөг хүртэл цухалзсаар буй нь Үндсэн хуулийг дээдлэн шүтэх, сахин биелүүлэх явдалтай зөрчилдөж байна. Тэр дундаа шинжлэх ухааны нэр барьж Үндсэн хуулийг мушгин гуйвуулах хандлагаар түүний зарим заалт, үндэслэлийг бүдүүлгээр дайрч үгүйсгэх явдал мэр сэр үзэгддэгийг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлж буйн илрэл хэмээн хүндэтгэн үзэж болох хэдий ч **төрийн эрх зүйн онолын үүднээс хүлээн зөвшөөрсөн мэт хүлцэнгүй суух боломжгүй**.

ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгээс гадны байгууллагын санхүүжилтээр боловсруулж гаргасан "Монгол Улсын төрийн байгууллагуудын чадавхи: Ардчилсан засаглалыг төгөлдөржүүлэх шаардлага боломж" (УБ., 1998 он) хэмээх номын зарим санааг жишээ болгон хэлж болно. Энэ номонд төрийн байгууллагуудын талаарх хуулиудыг сайжруулахад хэрэг болохоор, эгэл жирийн санаанууд нилээд байгааг үгүйсгээд яахав. Гэхдээ түүний хуудсанд Үндсэн хуулийг "Зээлдэх, дуурайх, хуулбарлах оролдлогын нэгэн том жишээ...", "бусад улс гүрний Үндсэн хуулиас түүвэрлэн авч, ур дүй муутайхан шиг эвцэлдүүлэн зохиомжилсон ..." [23] гэх зэргээр басамжлан гуйвуулж, үгүйсгэхийг оролдсон хийгээд үндэслэл, заалтыг нь хазгай ухаарсан санаа цөөнгүй тохиолдоно. Хамгийн хачирхалтай нь түүнийг зохиогч нь эхлээд Үндсэн хуулийг (төрийн хэлбэрийн хувьд ерөнхийлөгчийн засаг тогтоох, нам нь УИХ-ыг тараах, гишүүнийг эгүүлэн татах, гишүүн нь императив мандаттай байх[24] гэх зэргээр хуучин зарчмыг эргүүлэн) өөрчлөх гэхдээ хувийнхаа бодол санааг эхлээд дугаарлан жагсаагаад[25] түүнийгээ "нотлох"-ын тулд элдэв хоёроор хэлжээ. Хувьд бодогдсоноо нотлохыг биш харин шинжлэн судлаад арга буюу хүрсэн дүгнэлтийг санал болгох нь шинжлэх ухааны арга зүйн гол шаардлага болов уу. Жагсаасан саналын ихэнх нь хууль зүй, жам ёсонд үл нийцэх, хуучнаа сэргээхийг эрмэлзсэнээс гадна уг хуулийн төслийг боловсруулахад оролцсон болон хэлэлцэн батлалцсан хууль тогтоогчдыг "боловсрол ч үгүй, туршлага ч үгүй" хүмүүс гэх өнгөөр дургүйцлээ илэрхийлсэн мөрүүд уг номонд орсон нь гайхалтай ("Зэмлэсэн" өгүүлбэрүүдийг уншаад байхад шинжлэх ухааны хандлагатай биш, харин улс төрийн тодорхой бүлгийн

[23] ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэн, "Монгол Улсын Төрийн байгууллагуудын чадавхи: Ардчилсан засаглалыг төгөлдөржүүлэх шаардлага боломж", УБ., 1998 он, 13, 14 дэх тал.

[24] "Сонгосон иргэд нь гишүүнийг эгүүлэн татах эрхээр хангагдах" гэсэн нь императив мандаттай болгох гэсэн утгатай.

[25] Мөн тэнд, 24 дэх тал.

дордуулсан биш, сайжруулсан л байх ёстой. Тэгэхдээ улс, улсын жишгийг тусгана гэж тал тал руу савлаж болохгүй билээ. 2000 оны өөрчлөлтийг хийхдээ парламентын хаант засагт[27] Англиин хийгээд холбооны улс болох хоёр танхимт парламенттай Германы жишгийг харгалзсан гэж маргадаг. Тэгээд бас Америк маягаар Ерөнхийлөгчийн Бүгд Найрамдах Улс болно гэцгээх.[28] Нэг улсад төрийн удирдлагын хоёр, гурван хэлбэрийг зэрэгцүүлэн хэрэглэж болохгүй шүү дээ. Олонхиор шийдэж нэгэнт тогтсон, сонгосноо л туйлд нь хүргэх хэрэгтэй болно. Гэтэл өөрсдийн сонирхолд нийцүүлэн өөрчлөх гэсэн тодорхой бүлгийн санаархал оршсоор буйн улмаас Үндсэн хуульд тэр бүр ил тод бус гэнэтийн цочмог, нэмэлт өөрчлөлт оруулсан явдал ч нэгэнтээ тохиолдов. Одоо ч тийм эрмэлзэл байна гэлцэх болсон нь сэжигтэй. 1996-2000 оны сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд Парламентад суудалтай (олонхи цөөнх) гурван намын бүлэг "үгсэн" Үндсэн хуульд оруулсан "нэмэлт, өөрчлөлт"-ийг Цэцээс хүчингүй болгосон. Гэтэл хэсэгхэн хугацааны дараа дахин сэргээсэн нь дэндүү болхи санагдана. **Уг нэмэлт, өөрчлөлт "сайжруулсан" бол ч яриад байх юм юу байх вэ, магтах л хэрэг гарна.** Гэтэл хүний эрхийг хангах гол баталгаа, өөрөөр хэлбэл, засаг төрийн байгууллагын зүгээс хүний эрх зөрчихөөс сэргийлэх гол үндэслэл болсон **төрийн эрх мэдэл хуваарилах** зарчимд нийцэхгүй байгааг одоо хүлээн зөвшөөрөхөөс аргагүй болжээ. Ялангуяа Парламент, Засгийн газар хоёрын бүрэлдэхүүнийг "үнээ, тугал нийлүүлсний" адил хольж хутгасан нь цөөн гишүүнтэй парламент, харьцангуй олон гишүүнтэй Засгийн газар хоёрын харилцан хяналт тавьж, сөрөн зогсож, тэнцвэржих зарчимд үнэхээр харшилжээ. Түүний дээр хуулийг УИХ-ын гишүүдийн бараг дөрөвний нэгийн бүрэлдэхүүнтэй (20 гишүүн) батлах[29] болгож ардчиллын нэг гол шинж гэгддэг "мажоритари" зарчмыг үгүйсгэсэн, Засгийн газрын бүрэлдэхүүний талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг үл хэрэгсэн эцсийн дүнд нам шийдэх болсон, хүн үзэл бодол, хүсэл зоригоо хамгийн чөлөөтэй илэрхийлэх арга болсон нууц санал хураалтыг Парламентын түвшинд хаалттай болгосон, Парламент байнга ажиллах (чуулах) хугацааг 1/3-ээр богиносгосон зэргийг даруйхан эргэж харууштай. Иймд, дүгнэлтэд үндуцах бус, улс орныхоо төлөө уян хатан, ухаалаг байх нь түүхийн өмнө нэр бүтэн үлдэх төдийгүй, төрд зүтгэж буйн утга учир оршино. Алдаж магадгүй, засах нь зайлшгүй гэж нэмүүштэй. "Хүн хэдий сайн ч хэлэхээс нааш санахгүй, цаас хэдий нимгэн ч чичихээс нааш салмарахгүй" гэдэг.

Төрийн эрх мэдлийг засгийн гурван салаанд хуваарилах онолыг үндэслэгч Монтескье ***"Парламент, Засгийн газар хоёрыг нийлүүлбэл эрх чөлөөний тухай ярилтгүй, ... нэгэнт эрх чөлөөгүй нөхцөлд шударга шүүх оршихгүй"***[30] гэж бичсэн буй. Түүний төрөлх эх орны Үндсэн хуульд засгийн газрын гишүүний чиг үүрэг нь парламентын мандаттай, улс үндэсний хэмжээний ажил мэргэжлийн төлөөлөх албан тушаалтай, төрийн аливаа албаны болон мэргэшлийн үйл ажиллагаатай хавсармал байж болохгүй[31] хэмээн тунхагласан байдгийг дурдахад илүүдэхгүй. Гэтэл энэ зарчимд сөрөг өөрчлөлтийг улс төрийн

[27] В.Е.Чиркин, "Конституционное право зарубежных стран", "Юрист", М., 1997 г., с.142.

[28] ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэн, "Монгол Улсын Төрийн байгууллагуудын чадавхи: Ардчилсан засаглалыг төгөлдөржүүлэх шаардлага боломж", УБ., 1998 он, 24 дэх тал.

[29] Хэрэв ингэх л байсан юм бол тэр үлдсэн 50 гаруй гишүүнийг цалинжуулж, илүүдсэн юм бол сонгохын хэрэг юун гэлтэй. Тэд бол урьдынх шиг тойрогт ажиллах орон нутгийн байгууллагуудын ажлыг орлон хийх гэж сонгогдсон бус, чухамхүү хууль тогтоох албан тушаалтан, Улсын Их Хуралд байнга суух үүрэгтэй ард түмний элч. – Б.Ч.

[30] Монгол Улсын шүүгчийн ном, 1998 он, 9 дэх талд иш татсанаар авав.

[31] БНФУ-ын 1958 оны Үндсэн хууль, 23-р зүйл.

өмнөөс донгодож шийтгэх нь үү дээ гэмээр өнгө аяс мэдрэгдээд байдгийг хэлэх юун). Эрдэм шинжилгээний бүтээлээс гадна энгийн зарим өгүүлэл, мэдээнд Үндсэн хуулийн үзэл баримтлалыг андуурч тайлбарласан нь бас бий. Цөөн баримтыг дурдвал:

"Өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй" гэснийг "шүүмжлэх" нэрээр Үндсэн хуулийг бүхэлд нь "хар бичээс", "... хүний эрхийг хөсөрт хаясан харгис цааз" ("Нүгэл буян", "Улаанбаатарын үдэш", 1996 оны 6 дугаар сар, Д.Энхбат)" гэх буюу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийг нутаг дэвсгэрийн зарчмаар нэг мөр болгон тогтоож, хотуудын тухай жич заасны үл ажиглан "хотгүй улс" ("ЗГМ" сонин, 1998 он, Цэвлээ), Үндсэн хуулийн зохицуулах зүйл, үүргийг дутуу төсөөлснөөс ч тэр үү "Хот тохижуулалтын асуудал Үндсэн хуульд хасагдсан нь "ажил хэрэгт их бэрхшээл учруулж байна" ("Үнэн" сонин, 1999 он, №127) гэх зэргээр гуйвуулсан, үгүйсгэсэн явдал үзэгдэнэ.

Энэ мэт нь Үндсэн хуулийн эрх зүйн талаарх хувь хүний ухамсрын түвшинтэй холбоотой байхаа.[26] Гэхдээ энэ нь Үндсэн хууль хэлэлцэх, батлан гаргах явцад зарчмын зарим асуудлаар өөр саналтай цөөнх болж үлдсэн улс төрийн зарим зүтгэлтний ялагдлаа хүлээн зөвшөөрөхгүй байсаар үе үе цухалзуулдагтай ч холбоо, сүлбээтэй нь мэдрэгддэг. Ийм хандлагыг хүний эрхийн талаас нь хүндэтгэн үзэх хэдий ч **Үндсэн хуулийг дээдлэн шүтэх үндэсний нийтлэг язгуур ашиг сонирхлын үүднээс** дэмжих аргагүй юм.

Учир нь энэ бол Монголын төр, нийгмийн суурийг бэхжүүлж нэгэнт баталсан төрийн хүчин төгөлдөр гол хууль мөн бөгөөд Монголчууд бид түүнийгээ баримтлан **улс орноо ардчилсан хэмээн нотолж, хөтөлж** яваа билээ. Ер нь бид Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёсыг эрхэмлэхдээ түүнийг төрийн тусгаар тогтнол, хүний эрх, эрх чөлөө, тэгш байдал, шударга ёсыг бататгасан ардчилсан төрийн гол хууль мөн, бүх хуулийн манлай, манай нийгмийн суурь баримт бичиг гэсэн үнэлэмжийг иш үндэс болгосноос биш, бүхнээс төгөлдөр, мөнхөд өөрчлөгдөшгүй хэмээн даваадуулж хөөрөгдөөгүй. Нөгөөтэйгүүр түүнд байгаа зарим бүдэг бүрхэг, мэргэжлийн бус хүрээнд төдийлөн ойлгомжтой биш үг хэллэг байдгийг далимдуулан бүхэлд нь үгүйсгэн "доош нь хийх", тэгснээрээ засаг төрийн хэлбэр, тогтолцооны зарчмын өөр хувилбарыг оруулж ирэх, өнгөрөн төгссөн хуучныг сэргээх оролдлогыг бид эсэргүүцэж байгаагаа ил тод хэлэх нь зүйтэй. Үндсэн хуулийн бүрхэг мэт зарчмын суурь үндэслэлүүдийн эргэлзээг тайлах арга зам нь шууд л Үндсэн хуулиа дайрч давшлаад байх биш, Улсын Их Хурлын, Ерөнхийлөгчийн, Засгийн газрын, Цэцийн, Шүүхийн, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн, Нутгийн удирдлагын, Сонгуулийн зэрэг "хуулиар тодорхойлно", "зохицуулна" гэхчлэн өөрт нь бичсэн бөгөөд шинжлэх ухаанд "үндсэн хуульчилсан" гэх хуулиуд, түүнчлэн бусад ердийн хуулиар нарийвчлан тодруулах нь маш чухал. Энэ бол жам ёс мөн. Чингээд хүч үл хүрэлцэх аваас гол хуулийнхаа үзэл баримтлалаас гажихгүй, улс төрийн аль нэг нам, бүлгийн явцуу сонирхол, албан тушаалын төлөөх шохоорхолд автахгүйгээр онол-мэргэжлийн өндөр түвшинд боловсруулсан, ард түмний олонхийн санаа бодол, олон намын зүй ёсны нийтлэг сонирхолд буюу ашиг сонирхлын огтлолцолд тохирсон зайлшгүй нэмэлт тодруулалт хийж болох нь мэдээж. Харин эцсийн дүнд

[26] Төрийн "эрх мэдэл хуваарилах зарчим", "байнгын парламент", "императив мандат", "мажоритари зарчим", "хараат бус шүүгч" гэх мэт хэлэхэд хялбар ч хэрэг дээрээ эрх биш мэргэжил шаардах, оношлоход хялбар бус ухагдахуунууд бий. Иймд мэргэжлийн бус хүмүүстэй маргах нь илүүц мэт бодогдоно. –Б.Ч.

гэлтэй биш дээ. Юутай ч гэсэн энэ асуудлыг Үндсэн хуулиа дээдлэх эрх зүйн ухамсрын үндсэн дээр шийдвэрлэхийн оронд зоргоор хандах арга барилд автсаныг харуулжээ. Ийм асуудлыг цаашдаа нарийн журамлана гэвэл Үндсэн хуульдаа огт халдахгүйгээр УИХ, Засгийн газрын хуулинд төдийгүй, Улсын Их Хурлын чуулганы **дэгэд** л холбогдох журмыг нэмээд оруулчихадл болох шүү дээ. Гэтэл маргааш яахыгаа сайтар товлоогүйгээр Засгийн газраа огцруулсны улмаас шинэ бүрэлдэхүүнийг томилох ажил бүтэлгүйтэн ужгирсны бурууг Үндсэн хуульд түлхэцгээн, "улс төрийн хариуцлагаас мултарч", түүнийгээ "алтан боломж"-ийг алдалгүй ашигласан гавьяа мэт дөвийлгөж ярьсаар ирсэн.

Парламент, Засгийн газар хоёрын бүрэлдэхүүнийг хольж, улмаар нам, төрийн ажил үйлсийг хутгах үндсийг тавьсан, мажоритари зарчмыг үгүйсгэсэн, парламентын тасралтгүй, байнгын ажиллагааг сулруулсан зэргийн өөрчлөлтийн сөрөг тал нь өдгөө нэлээд мэдрэгдэж байгаа бололтой. "Газрын ойр, гайны бага дээр нь" гэдэгчлэн засаж залруулаасай, дахин ийм юм бүү тохиолдог гэж л залбирахаас өөр яах билээ.

Парламент хууль тогтоохдоо Үндсэн хуулиа ягштал баримтлах нь эрх зүйт төрийн эрхэм шинж болохоор энэ нь бас **Улс Их Хурлын эрхэм гишүүдийн хууль зүйн болон ёс зүйн үүрэг, хариуцлагын гол шалгуур** болно. Сахилга, хариуцлага дээрээс эхэлж, доош үлгэрлэдэг, хууль журам нь дээдэст хатуу, доодост нигүүлсэнгүй байх нь төрт ёсны эрхэм чанар, нэгэн зүйл урлаг гэж үздэг тийм уламжлал ч бий. Их дээр үеэс нэхэн үзвэл суут богд Чингис хаан "ажил үүргээ биелүүлж чадахгүй, хууль зөрчсөн" ноёд, жанжингуудыг хатуугаар зэмлэн цээрлүүлэх зарлиг буулгаж мөрдүүлж байсныг судлаачид тэмдэглэжээ.[34] Үүнийг тэр цагт хууль дээдлэн төр барих нэгэн арга болгосон гэж болно.

6. Үндсэн хуулийг дээдлэн шүтэх нийгэм-сэтгэл зүйн үндэс

Монгол Улсын Үндсэн хууль нь бол ард түмний сонголт, хамтын бүтээл мөн. Өөрөөр хэлбэл, түүнийг төрийн (ордны) эргэлтийн аргаар гэнэт батлаагүй. Түүнийг боловсруулж баталсан үйл явцын голыг тоймловол:

-Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг төрийн хийгээд улс төрийн олон намын төлөөлөгч оролцсон улсын комисс зохион байгуулж, хянаж чиглүүлсэн;

-Монгол төрийн хуримтлуулсан туршлага, бусад орны жишиг болон ардчилсан хөдөлгөөний явцаар бэлтгэгдсэн үзэл баримтлалд суурилсан;

-Энэ бүх үе шатны ажилд Монголынхоо хууль зүй, түүх, улс төр, эдийн засаг, хэл шинжлэл, урлаг утга зохиол, гадаад харилцааны болон бусад мэргэшлийн цөөнгүй эрдэмтэн, мэргэжилтнийг янз бүрийн үүрэгтэйгээр татан оролцуулсан;

-Ард түмэн 3 сар хэлэлцсэнийг нэгтгэн дүгнэж, зарчмын маргаантай асуудлыг тэдний олонхийн саналыг эш үндэс болгон шийдвэрлэсэн;

-Ардын Их Хурлын депутат, нийт аймаг, сумын эрх баригчдын 6 газар бүсчлэн хийсэн зөвлөгөөнөөр урьдчилан хэлэлцүүлж санаа бодлыг нь авсан;

-НҮБ-ын Хууль зүйн комиссын шинжээчидтэй болон 1991 оны 9 дүгээр сард Улаанбаатарт зохиосон **"Монгол Улс ардчилалд шилжихэд шинэ Үндсэн хуулийн гүйцэтгэх үүрэг, байр суурь"** сэдэвт Олон улсын бага хуралд оролцсон 10 гаруй орны эрдэмтэд,олон

[34] Гарольд Лэмб, "Дэлхийн эзэн Чингис хаан" (Harold Lamb,"Genghis Khan: The Emperor of All Men"), Цуврал-10, Төр засгийн ҮААЭГ-ын хэвлэх үйлдвэр, УБ., 2003 он, 168-169 дэх тал.

бусад олон нам, ард түмэнд урьдчилан таниулж, санаа бодлыг нь авалгүйгээр гэнэт өөрчилсөн нь яав ч зөвтгөх аргагүй. Түүнчлэн, уг өөрчлөлтийг Цэц нэгэнтээ хүчингүй болгосны дараа дахин тэр чигээр нь сэргээж, мөн л гэнэт баталснаа "нийгмийн захиалга" гэж зарласан нь дааНч үнэмшилгүй. Засаг төр нь ард түмнээ залилан мэхэлж болохгүй шүү дээ! Уул өөрчлөлтийн төсөлд УИХ-ын гишүүдийн дийлэнх олонхийн буюу 60 гаруй гишүүний гарын үсгийг "зөвшөөрнө" гэж зуруулсныг **чуулганы бус аргаар** хууль батлуулсан буюу намаар далайлгаж ам тангаргийг нь авсан гэхээс өөр дүгнэлт гарахгүй бөгөөд эл нөхцөлд үнэн хэрэгтээ гишүүд үгээ хэлж, шүүн хэлэлцэх боломжтой байсан гэх үндэслэл олдомгүй. Дараа нь энэ чинь буруу байна шүү гэсэн Улсын Ерөнхийлөгчийн үндэслэл бүхий хоригийг Улсын Их Хурал хэлэлцээд хүлээж аваагүй, Цэцээс хянан үзэх эрхгүүр байсан ч "Үндсэн хууль бол хууль биш", "түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт бол Үндсэн хууль" гээд тэгж гавьж амыг нь тагласан. Үндсэн хуульд **зөвхөн хуулиар** нэмэлт, өөрчлөлт оруулдаг Монголын парламентын уламжилсан заншил, бусад орны хууль зүйн жишгийг ч хайхарсангүй. Эрх зүйн анхдагч нэг актын нэр өгөлгүй "нэмэлт өөрчлөлт" гээд л гаргачихсан. Цэргийн албаны тухай хуульд "Нэргүй өндөрлөг" гэдэг шиг л битүүлэг. Хэрэв зохих журмаар боловсруулж, ард түмний болон улс төрийн хүчнүүдийн санаа бодлыг сонсож харгалзан тусгаж, хуулиа гаргаж ирсэн төртэйгээр хүчин төгөлдөр болгосон бол дараа нь тийм "хүчинтэй" гэх нь зөв л дөө. Үдийн завсарлагыг эс тооцвол 2-3-хан цагт "маналзуулсан" нэргүй цактыг сар, жилээр боловсруулж 6 сар дамжуулан хэлэлцэж, баталсны хойно 1 сарын дараа хүчин төгөлдөр болгон мөрдсөн Үндсэн хуультай адилтгана гэдэг арай дэндсэн шалтаг.

Гэнэтийн энэ өөрчлөлтөө "төрийг гацаанаас гаргасан" мэргэн арга мэтээр тайлбарлацгаадаг. Үнэндээ бол Үндсэн хууль гацаасан биш, ард түмэн шаардсан, "захиалсан"[32] ч биш, төрийн томчуудын үзэл бодол, арга ухаан нь гацаасан хэрэг. Тэд огцорсон Ерөнхий сайдын оронд нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхийлөгч зөвшөөрсөнгүй, тийм байтал Улсын Их Хурал дахь олонхи суудалтай нам (эвсэл) өөр хүнийг биш өмнөхөө л дахин дахин дэвшүүлэн, буцааснаас огцорсон Засгийн газар хэдэн сар "үүрэг гүйцэтгэгч"-ээр ажилласныг "Үндсэн хуулийн гацаа" гэдэг. Хэрэв намаас(эвслээс) нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхийлөгч цаг тухайд дэмжсэн бол; Эвсэл зөвшөөрөгдөхүйц өөр хүний нэрийг тэр дор нь дэвшүүлсэн бол; **хамгийн гол нь Засгийн газрыг огцруулахдаа Үндсэн хуулийн холбогдох заалтыг ёсчлон баримталсан бол** "гацаа" гэх зохиомол шалтаг буюу санамсаргүй гай тохиолдохгүй байсан билээ. Юу гэвэл тухайн тохиолдолд Засгийн газрыг шууд л огцруулчих ёсгүй байсан. Харин түүнд итгэл үзүүлэх эсэх талаар ("вотум доверия") УИХ-ын тогтоолын төсөл оруулж санал хураах, эсхүл Ерөнхий сайдыг огцруулах үндэслэл байгаа эсэхийн талаар Үндсэн хуулийн цэцэд хандаж дүгнэлт гаргуулах зэрэг бусад заалтыг[33] хэрэглэх учиртай, боломжтой байв. Хэрэв итгэл үзүүлэх эсэх талаар санал хураахад, оролцсон гишүүдийн олонхи нь "итгэл үзүүлэхгүй" гэвэл Засгийн газар огцрох нь гарцаагүй болж, энэ тухай хууль гаргах л үлдэж байгаа нь мэдээж болно. Чингэвээс Засгийн газрын залгамжлах бүрэлдэхүүнийг яаралтай товлосны дараа хуучнаа "огцруулсугай" гэж шийдвэрлээд шинэ бүрэлдэхүүнээ ёстой л "бариа зөрөөн дээр" томилж болохсон билээ. Үндсэн хуульд ийм заалт байтал түүнийг хэрэгсээгүйг мэдлэг дадлага дутсан

[32] "Зууны мэдээ" сонин, 2000.09.13, №292 (559).

[33] Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он, 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт; 43 дугаар зүйлийн 1-4 дэх хэсэг; 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4 дэх заалт.

улсын байгууллагуудын төлөөлөгч нартай төслөөр санал солилцож, санаа бодлыг нь тандсан зэргээр нягтлан боловсруулсан.

Төслийг боловсруулах дунд болон эцсийн шатанд Монгол Улсын Бага Хурал (1, 2 дугаар хэлэлцүүлгийг нэмээд) 4 удаа, Ардын Их Хурлын 420 гаруй депутат 70 шахам хоног 2 удаа хэлэлцэж, 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн өглөөнөөс цэг, таслалыг хүртэл хэлж, үг бүрийг дуудан уншуулж сонсоод 1-ээс бусад нь санал нэгтэй баталсан төрийн гол хууль мөн билээ. П.Очирбат төрийн тэргүүн, Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын даргын хувиар **"Монгол Улсын их цаазын[35] төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүн, шинэ төслийн тухай"** Ардын Их Хурлын 2 дугаар хуралдаанд 1992 оны 10 дугаар сарын 7-ны өдөр тавьсан илтгэлдээ: "Монгол Улсын их цаазын тухай төсөл бол Монгол Улсын оюуны чадавхийг бүхэлд нь дайчилсан Монголын хөдөлмөрчид, эрдэмтэн, мэргэжилтэн, та бидний хамтын бүтээл" гэж тэмдэглэсэн[36] юм.

Шинэ Үндсэн хууль нь бүтээн туурвигдсан эш үндэс, арга замын хувьд "социалист орнуудын зохицуулсан бодлого", "нэг үзэл суртал" нэрийн доор Зөвлөлт маягийг даган дуурайсан (түүнд захирагдсан) өмнөх хуулиас ялгаатай бөгөөд манай ард түмний өөрсдийн бие даасан бүтээл гэх бүрэн үндэстэйг дээрх баримтууд нотолно. Энэхүү "төрөлх" чанараараа Монгол Улсын Үндсэн хууль бол манай ард түмэн нийтээрээ дээдлэн шүтэж, ёсчлон сахих **нийгэм, сэтгэл зүйн гүн үндэстэй** байна. Иймд, түүнийг үеэс үед залгамжлан дээдэлж хэвшүүлвээс нэгэн зүйл **үндэсний бахархал** болно. Энэ нь түүний ихэд хураангуйлсан зарим томьёоллыг **Үндсэн хуульчилсан** болон ердийн хуулиар үзэл зарчмыг нь гуйвуулахгүйгээр нарийвчлан тодруулах шаардлагыг огт үгүйсгэхгүйг өмнө дурдсан. Тийм ч шаардлага бий.

Монгол Улсын хууль тогтоох, гүйцэтгэх дээд байгууллагууд Үндсэн хуулиа дээдлэн шүтэх ёсыг "дээр, дооргүй", "хот, хөдөөгүй" нийтээр хэвшүүлэхэд онцгой анхаарал тавьж, бүх талаас нь онц анхааралтай хандаж, энэ үйлсийг байнга чиглүүлж байх нь төрт ёс, хууль дээдлэх ёсны анхдагч шаардлага мөн болов уу хэмээн үзнэ. Чингис хаан "Засаг хууль"-ийн хамгаалагчаар өөрийн ууган хүү Цагаадайг томилж, биелэлтийг нь ноёдын чуулганаар жил бүр хэлэлцүүлдэг байсан гэдэг.[37] "Засаг хууль"-ийн заалт гэсэн түүвэрт "Засаг хуулийн биелэлтэд хяналт тавьж байхыг хүү Цагаадайдаа тэрээр зарлиг болгосон байна"[38] гэснээс үзэхүл энэ хамгаалалтыг "амаар" биш хуулиар бэхжүүлсэн байжээ. Хэдийгээр нийгэм, төрийн, хуулийн мөн чанар "танигдашгүй болтлоо" өөрчлөгдөн хувьссан ч хууль дээдлэх төрт ёсны уламжлалаа сэргээж буй шинэ цаг үед үндэсний ухамсар, сэтгэл зүйн хувьд өв уламжлалын учиг бийг энэ мэтээс харж ухамсарлаж болно.

Өдгөө Үндсэн хуулиа дээдлэн сахих үйлсийг Монгол Улсын Их Хурал хянан чиглүүлж, биелэлтийг зохион байгуулж хангах үүргийг Засгийн газрын тэргүүн хариуцаж, зөрчил гажуудлаас **хамгаалах** үйлсийг Үндсэн хуулийн цэц эрхэлж байгаа нь дам утгаараа түүхэн уламжлалтай төстэй бус уу.

-Яагаад Улсын Их Хурал хянан чиглүүлнэ гэсэн хэмээвээс: **"Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах"** явдлыг

[35] Үндсэн хуулийн төслийг Ардын Их Хуралд ийм нэртэй өргөн мэдүүлсэн бөгөөд түүнийг тус Их Хурал хэлэлцэн өөрчилсөн юм (П.Очирбат, "Алдаж болохгүй агшин", УБ., 1997 он, 254 дэх тал).

[36] П.Очирбат, "Алдаж болохгүй агшин", УБ., 1997 он, 259 дэх тал.

[37] Эзэн богд Чингисийн "Их засаг", МУИС-ийн ХЗДС, УБ., 1997 он, 31 дэх тал.

[38] Эрэнджен Хара-Даван, "Сод жанжин Чингис хаан, түүний үлдээсэн өв","Мон судар" хэвлэлийн газар, УБ., 2003 он, 175 дахь тал.

Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 8-д Улсын Их Хурлын **онцгой бүрэн эрхийн** нэг болгон заасныг;

-Яагаад Засгийн газрын тэргүүн биелэлтийг хариуцна гэж хэлэв гэвэл: **"Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж,төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна"** гэж Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг;

-Яагаад Цэц хамгаална гэвэл "Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг хянан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн" гэж Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус эш үндэс болгов.

Хууль дээдлэх ёсон бол засаг төр барих урлаг, хүн зон амар жимэр амьдрахуйн арга юм. "Чингис хааны од гялалзаж тэр хүмүүс тушаал зарлигийг дагах болсноор хатуу тогтоосон засаг ёсын[39] тусламжаар тэрээр хүмүүсийг удирдан захирах болов" гэснийг санахад илүүдэхгүй. Чингисийн билэг сургаалд "хатуу чанд, яв цав байдалтай бол хамаг улс бат бэх болой"[40] гэж бий. Энэ бүхнээс үүдэн төр барьж, түмэнд үйлчлэх урлагт суралцахад **Үндсэн хууль судлал, тэр дундаа түүхэн хийгээд харьцуулсан судлалыг хөгжүүлэн түшиглэх шаардлага** өссөөр буйг харгалзан нэгийг бодох цаг болжээ гэдгийг эцэст нь онцлон тэмдэглэхийг хүсч байна.

2006 он

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГ
www.nli.gov.mn

[39] Хууль гэсэн утга юм.-Б.Ч.

[40] Эрэнджен Хара-Даван, "Сод жанжин Чингис хаан, түүний үлдэсэсэн ев","Мон сударˮ хэвлэлийн газар, УБ., 2003 он, 266-267 дахь тал.

дагуу төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтнаас хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж, улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшлийг хангах эрх зүйн үндэс, таатай орчинг бүрдүүлэхэд оршино гэж тус хөтөлбөрт заасан юм.

Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр 1998 онд батлагдсанаас хойш 18 жил өнгөрсөн. 2008 он хүртэл Эрх зүйн шинэтгэлийн Хөтөлбөр, түүнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаар өмнө нь тусгайлсан судалгаа, үнэлгээ өгөх ажил хийгдэж байгаагүй. Хөтөлбөрт тусгагдсан хуулиуд батлагдан гарч буй эсэхийг хянаж, эдгээр хуулийн жагсаалтыг шинэчлэх асуудлыг голлон анхаарч иржээ. Иймээс хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар иж бүрэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг явуулах шаардлагыг харгалзан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2007 оны 36 дугаар тушаалаар "Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлын удирдамж", "Хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлын ерөнхий график"-ийг батлаж, Хууль зүй дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2007 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 42 тоот тушаалаар Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлын хэсэг, 8 дэд хэсгийг байгуулан ажиллуулж[4] тус хөтөлбөрийн 2008 он хүртэлх хэрэгжилтийн талаар тайлан гаргасан байдаг.

Энэхүү илтгэлээр 2008 оноос хойших эрх зүйн шинэтгэлийн үр дүнг судалж буй "Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь" судалгааны тухай товч танилцуулж, тус судалгааны хүрээнд хийгдсэн "Шүүхийн шинэтгэлийн хэрэгжилт, үр дүн, цаашдын асуудал" сэдэвт дэд хэсгийн судалгааны үр дүнг түүвэрлэн авч үзье.

[4] Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан, ХЗҮХ, 2008, Уб., 6 дахь тал

"Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь" сэдэвт судалгааны тухай

Энэхүү судалгаагаар, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн судалгааны захиалгад тусгасан асуудал[5] -ыг судалж эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх хүрээнд, Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн 2008 оноос хойших хэрэгжилтийг дүгнэн, зарим хүрээний эрх зүйн шинэтгэлийн үр дүн, цаашдын асуудлыг тодруулж, олон улсын чиг хандлага, гадаад орнуудын туршлагыг судлан, Монгол Улсын хэрэгцээ, шаардлагад үндэслэн эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх үндэсний бодлого тодорхойлоход харгалзан үзэх зарим асуудлаар санал, зөвлөмж боловсруулж байна.

Судалгааг Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хэрэгжилт; Зарим хүрээний эрх зүйн шинэтгэл, хүрсэн үр дүн, цаашдын асуудал; Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх зарим асуудал гэсэн 3 үндсэн бүлэгт хуваан гүйцэтгэсэн бөгөөд бүлэг тус бүрийн хүрээнд дэд хэсгийн дэлгэрэнгүй тайлан бэлтгэсэн болно.

Судалгааны нэгдүгээр бүлэгт, Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр, түүхэн үүрэг, 2008 он хүртэлх хэрэгжилтийн үнэлгээ ба хөтөлбөрийн Монгол Улсын бүрэн эрхт байдлыг хангах эрх зүйн үндсийг төгөлдөржүүлэх; Эдийн засгийн харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох; Хүний эрх, эрх чөлөө, түүний хууль зүйн баталгааг хангах; Төрийн байгууллын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох; Эрх зүйн шинэтгэлийн орчин бүрдүүлэх; Хууль зүйн мэргэжлийн боловсон хүчний сургалтын тогтолцоог боловсронгуй болгох; Олон улсын эрх зүйн

[5] Хууль зүйн яамны 2016 оны 4/487 дугаартай албан бичгээр судалгаа хийх хэрэгцээ, шаардлагатай хэмээн тодорхойлж ирүүлсэн асуудлуудыг судалгаанд хамруулсан.

МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ: ШҮҮХИЙН ШИНЭТГЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ЦААШДЫН АСУУДАЛ[1]



БНХАУ-ын Ардын их сургуулийн докторант Б.Энх-Амгалан



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан Ж.Алтансүх

1990 оноос хойших Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөгжлийн асуудлыг шинэ Үндсэн хууль батлагдах хүртэл үе /1990-1992/, эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр батлагдах хүртэл үе /1992-1998/, өнөө үе /1998 оноос хойш/ хэмээн үечлэн авч үздэг. 1992 оны шинэ Үндсэн хууль, түүний үзэл баримтлалд нийцсэн ардчилсан нийгэм, зах зээлийн эдийн засгийн эрх зүйн үндэс бүрэлдэж эхэлсэн боловч эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, нийгэмд шинээр үүсч буй харилцааг хуульчлан зохицуулах, тэдгээрийг олон улсын жишиг, загварт нийцүүлэх, хуулийг дээдлэх, хүндэтгэн хэрэгжүүлэх нийгмийн ухамсрыг төлөвшүүлэх шаардлага хэвээр байв. Иймээс эрх зүйн шинэтгэлийн зорилго, зарчим, арга зүйн үндсийг нарийвчлан тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, төлөвлөгөө тогтоох зорилгоор Эрх зүйн шинэтгэлийн Хөтөлбөрийг 1998 онд боловсруулсан[2] ба "Монгол Улсын хууль тогтоомжийг 2000 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл", "Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г хамтад нь баталжээ.[3]

1998 оны Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт эрх зүйн шинэтгэлийн зорилго, зарчим, арга зүйн үндсийг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх 7 үндсэн чиглэлийн нийт 56 зорилтот арга хэмжээг төлөвлөсөн. Эрх зүйн шинэтгэлийн зорилго нь тус улсад хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх зорилгыг хэрэгжүүлэх үүднээс Үндсэн хуульд тунхагласан зарчим, үзэл санаанаа

[1] Энэхүү илтгэл нь ХЗДХЯ-ны захиалгаар, ГОУХАН / GIZ/-ийн "Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах төсөл" –ийн дэмжлэгтэйгээр мэргэжилтэн, судлаач, олон нийтийн оролцоог хангах хандлага баримтлан гүйцэтгэсэн "Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь" сэдэвт судалгааны эхний шатны тайланд суурилсан болно. Судалгааны тайланг эцэслэх, редакцийн хяналт хийх үе шат үргэлжилж байна. Тус илтгэлийг 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан "Солонгос-Монгол Улсын эрх зүйн өөрчлөлт шинэчлэл, түүний үнэлэлт дүгнэлт, цаашдын чиг хандлага" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн.

[2] "Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээ" Тайлан, /УБ: 2003/, 7.

[3] "Хөтөлбөр, үндсэн чиглэл, төлөвлөгөө батлах тухай" УИХ-ын 1998 оны 18 дугаар тогтоолоор баталсан.

Хүний үндэсний хүрээлэн www.nhri.gov.mn

дүнд харьцангуй ахиц, дэвшилд хүрчээ.

Эрх зүйн шинэтгэлийн үйл явцаас үзвэл эрх зүйн шинэтгэлийн дээрх 5 тусагдахууны үр дүн харилцан адилгүй байна. Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд 2008 онд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлангийн "Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр үндсэндээ хэрэгжиж, эрх зүйн шинэтгэлийн зорилт хууль тогтоомжийн төвшинд биелэгдсэн байна... Харин хууль дээдлэх зарчмыг төрийн үйл ажиллагаанд хэвшүүлэх, хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх талаарх нийгмийн ухамсарыг бүрдүүлэх зорилт зохих хэмжээнд хангагдсангүй" гэсэн дүгнэлт өнөөгийн нөхцөлд мөн хүчинтэй хэвээр байгаагаас үзэхэд хууль тогтоомжийн шинэтгэлийг түлхүү хийж, нийгэмд эрх зүйн шинэ ухамсар төлөвшүүлэх чиглэлээр хангалттай үр дүнд хүрээгүй болно. Хууль тогтоох, хуулийн гүйцэтгэлийг хангах, хууль хэрэглэх тогтолцоо, арга ажиллагааг шинэтгэх, хууль зүйн мэргэжлийн боловсролыг шинэтгэх чиглэлд анхаарч тодорхой үйл явц өрнөж байгаа бол хууль зүйн эрдэм шинжилгээний ажлын зохион байгуулалт, арга зүйг шинэтгэх чиглэл ухралтад орсныг анхаарах хэрэгцээ, шаардлага хүлээгдэж байна.

"Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлж буй шинэтгэлийн тусагдахуун, чиглэлүүд нь.. хоорондоо уялдаатай, зэрэглэж дугаарлах боломжгүй, нэг нь нөгөөгөөсөө хамаарч байгаа цогцолбор арга хэмжээ юм." хэмээсэн академич Ж.Амарсанаагийн хандлагаар эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэх үйл явц бүрэн өрнөөгүй байна гэж үзэж болох юм.

Эрх зүйн шинэтгэлийн 5 тусагдахуунаар эрх зүйн шинэтгэлийн үйл явц, үр дүнг илэрхийлсэн доктор, професор Н.Лүндэндорж /2003 онд/, доктор Б.Гүнбилэг /2011 онд/ нарын дүгнэлт, санал, зөвлөмжид тусгагдсан асуудлууд өнөөгийн нийгэмд шийдвэрлэгдээгүй хэвээр байгааг хүлээн зөвшөөрөх ёстой.

Судалгааны сэдвийн цар хүрээ өргөн бөгөөд ажлын нэгдсэн тайлан эцэслэн гараагүй байгаа тул тус судалгааны томоохон хэсэг болох "Шүүхийн шинэтгэл, хүрсэн үр дүн, цаашдын асуудал" дэд хэсгийн үр дүнг илтгэе.

Шүүхийн шинэтгэлийн хэрэгжилт, үр дүн, цаашдын асуудал

Шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хангах нь хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг тогтоох үндэс суурь билээ. Шүүх бие даасан, шүүгч хараат бус байх нь иргэний эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг бодитой хамгаалах хүчирхэг механизм, шүүх эрх мэдлийн эрх зүйн баталгаа мөн. Тийм учраас бие даасан, хараат бус шүүхийг тогтоох нь эрх зүйт төрийн нэг гол зорилт, шалгуур болдог. Монгол Улс 1992 оны шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш Үндсэн хуулийн зарчим, агуулгад нийцүүлж шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг эрх зүйт төрийн үзэл баримтлалд нийцүүлж төлөвшүүлэх талаар шинэтгэл хийсэн.

Уг шинэтгэлээр хийгдсэн ажлуудыг он дарааллын хувьд дараах мөчлөгт хамааруулан түүхчлэн шинжлэн судлав. Үүнд: 1/ 1993 - 2002 он; 2/ 2002-2012 он; 3/ 2012 онд шүүхийн тухай багц хуулиуд хэрэгжиж эхэлснээс хойших үе гэж авч үзнэ. Ийн судлахдаа 1993-2002, 2002-2012 онуудад хэрэгжүүлсэн шүүхийн шинэтгэлийн үр дүнг товч үнэлж, 2012 онд батлагдсан шүүхийн тухай багц хуулиуд хэрэгжиж эхэлснээс хойш хийгдсэн шинэтгэлийг дэлгэрэнгүй судаллаа.

"Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр" нь "Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр"; Монгол Улсын Их хурлын 2008 оны 35 дугаар тогтоолоор баталсан "Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр"; мөн Монгол Улсын Их хурлын 2009 оны 38 дугаар

зохицуулалтад Монгол Улсын оролцоог өргөтгөх хэмээх 7 үндсэн чиглэл, 56 зорилтот арга хэмжээ тус бүрээр 2008 оноос хойших хэрэгжилтийг авч үзэв. Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх түвшин, гарах үр дүн болон үнэлэх шалгуурыг нарийвчлан тодорхойлоогүй орхигдуулсан тул судалгаа хийхэд бэрхшээлтэй байсан боловч 2008 онд тус хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын арга зүй болон тухайн үед өгсөн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмжийг баримжаа болгож ашигласан. Гэхдээ энэ дэд хэсгийн судалгаа нь 2008 онд хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний ажлаас ялгаатай бөгөөд хөтөлбөрийн 2008 оноос хойших хэрэгжилтийг ерөнхийд нь дүгнэхийн зэрэгцээ 2008 онд хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлсэний үндсэн дээр гаргасан санал, зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, цаашид эрх зүйн шинэтгэлийн чиглэлээр анхаарах асуудлыг түүвэрлэхэд төвлөрсөн болно.

Судалгааны хоёрдугаар бүлэгт, эрх зүйн шинэтгэлийн арга хэмжээ тус бүрийг гүнзгий судлахад хүний нөөц хангалтгүй, цаг хугацаа хомс байсныг харгалзан, ХЗДХЯ-ны захиалгад дурдсан болон судалгааны багийн зүгээс дэлгэрэнгүй судлах нь зүйтэй гэж үзсэн “Эдийн засгийн хүрээний эрх зүйн шинэчлэл: Жижиг, дунд үйлдвэр, бизнесийн эрх зүйн өнөөгийн орчин”, “Захиргааны эрх зүйн шинэчлэл, үр дүн”, “Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн бодлого, хэрэгжилт, үр дүн”, “Шүүхийн шинэтгэлийн хэрэгжилт, үр дүн, цаашдын асуудал” сэдвүүдээр тусгай тайлан боловсруулав. Бизнесийн хүрээний эрх зүйн шинэтгэлийн хэрэгцээ, шаардлагыг тандах хүрээнд бизнес, жижиг, дунд үйлдвэр эрхлэх эрх зүйн орчны өнөөгийн байдлын талаар асуулга боловсруулж, иргэд, аж ахуйн нэгжээс судалгаа авах ажлыг “Ойлт” судалгааны төвд захиалан гүйцэтгүүлж, үр дүнг тусгав.

Судалгааны гуравдугаар бүлэгт, эрх зүйн шинэтгэлийн бодлогын талаарх олон улсын чиг хандлага, зарим орны туршлагыг тандан, Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал /2016-2030/-ыг нарийвчлан, эрх зүйн шинэтгэлд хамаарах зорилт, зорилгыг тодорхойлж, Монгол Улсын өнөөгийн хэрэгцээ, шаардлага, хүрээ, зорилт, чиглэлийн талаар асуудал хөндсөн олон улсын ба дотоодын эрдэм шинжилгээний бага хурал, уулзалт, хэлэлцүүлгийн үр дүн, түүнчлэн тус судалгааны хүрээнд олон нийтийн оролцоог хангах хандлагаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг түүвэрлэн, цаашид зөвлөлдөх ажиллагааны арга зүй, анхаарах зарим асуудлыг онцлох байдлаар эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэхийг зорьсон.

Судалгаагаар 1998 онд батлагдсан Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр анх дэвшүүлсэн зорилтдоо ерөнхийдөө хүрсэн хэмээн дүгнэв.

Нэрт эрдэмтэн Б. Чимидийн бүтээл[6] -д тусгасан эрх зүйн шинэтгэлийн тусагдахууны талаар баримтлах ёстой 5 үндсэн чиглэл буюу эрх зүйн шинэтгэл зөвхөн хууль тогтоомжийг шинэтгэх бус хууль тогтоох, хуулийн гүйцэтгэлийг хангах, хууль хэрэглэх тогтолцоо, арга ажиллагааг шинэтгэх, хууль зүйн мэргэжлийн боловсролыг шинэтгэх, хууль зүйн эрдэм шинжилгээний ажлын зохион байгуулалт, арга зүйг шинэтгэх, нийгэмд эрх зүйн ухамсар төлөвшүүлэх чиглэлүүдийг хамтад нь авч явах талаас дүгнэвэл ЭЗШХ-т дэвшүүлсэн зарим зорилт хангалттай хэмжээнд хэрэгжээгүй байна. Гэхдээ энэ байдал 2008 оны үнэлгээ хийсэн үетэй харьцуулахад тодорхой арга хэмжээ авч, хүчин чармайлт гаргасны

[6] Б. Чимид, Төр, нам, эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал. Хоёрдугаар дэвтэр. /УБ: 2008/, 15-16.

шүүх, шүүгчийг мэргэшүүлэх, мэргэшсэн шүүгчээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх эрх зүйн үндэс бүрдэх ач холбогдолтой. Иймд цаашид шүүхийн дагнасан тогтолцооноос ухрахгүй байх, одоогийн хүрсэн амжилтаа ахиулж, цаашид шүүхийг хэрэг маргааны төрлөөр дагнан мэргэшүүлэх асуудлыг аль болох хөгжүүлэхэд анхаарах шаардлагатай;

• Шүүхийн тогтолцоо өөрчлөгдсөнтэй холбогдуулан дээр дурдсан хүндрэл бэрхшээлүүдийг цаашид давтахгүйн үүднээс хууль тогтоогчоос хууль тогтоомжийн төслийг боловсруулахдаа судалгаатай хандах буюу онолын суурь болон хавсарга судалгааг хийх, түүнчлэн хууль тогтоомжийн үр нөлөөний судалгааг ул суурьтай хийж хэвшүүлэх санал багтаж байна.

2.Шүүхийн бие даасан байдлын тухайд

Шүүхийн бие даасан байдлыг хувь хүний болон институцийн талаас нь авч үздэг.[10] Шүүхийн /институцийн/ бие даасан байдлыг хангах гэдэг нь хоёр үндсэн утгыг илэрхийлдэг. Үүнд нэг талаас шүүх эрх мэдлийг төрийн бусад эрх мэдэл болох хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлээс харьцангуй бие даалгах[11], нөгөө талаас шүүх эрх мэдлийг шүүх бүр бие даан [тусгаар] хэрэгжүүлэх агуулга багтдаг.[12] Үүнийг энгийнээр илэрхийлвэл шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг хангахад шүүхийг гаднаас буюу төрийн эрх мэдлийн бусад субьектээс хамгаалах, нөгөө талаар шүүхийг шүүхийн өөрийн удирдлага, захиргаанаас хамгаалах гэж ойлгож болох юм. Энэ талаар Доктор Г.Совд "шүүхийн бие даасан байдал гэж шүүхийн Үндсэн хуулийн статусыг хангахыг...,"[13] хэлнэ гэж товчхон тодорхойлжээ.[14]

Монгол Улсын шүүхийн шинэтгэлээр дэвшүүлсэн томоохон зоритуудын нэг бол шүүхийг бие даан үйл ажиллагаагаа явуулах хэмжээний төсвөөр хангах, шүүхийн эдийн засгийн баталгааг сайжруулах зорилт байсан. 2012 оноос хойш хийгдсэн шүүхийн шинэтгэлээр шүүхийн бие даасан байдал тэр дундаа шүүхийн эдийн засгийн баталгаа сайжирсан талаар судалгааны дүн гарчээ. Энэ нь шүүхийн бие даасан байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий Үндсэн хуулийн байгууллага болох Шүүхийн ерөнхий зөвлөлийг байгуулсан, мөн шүүхийн тухай багц хуулиудад шүүхийн эдийн засгийн баталгааг хангах талаарх зохицуулалтууд өмнөх хуулиудтай харьцуулахад харьцангуй сайн тусгагдаж, хуульчлагдсан зэрэгтэй холбоотой.

Судалгаагаар шүүхийн эдийн засгийн баталгаа хангагдах эрх зүйн зохицуулалт сайжирсан гэж гарсан боловч хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлээс шүүхийн төсвийг бууруулах ёстой гэсэн хандлага хэвээр байна. Тухайлбал, шүүхийн эдийн засгийн баталгааны гол амин сүнс болсон заалтууд болох ШтХ-ийн 28.5-д "шүүхийн үйл ажиллагааны төсвийг өмнөх жилийн хэмжээнээс бууруулахыг хориглоно", ШЭЗБтХ-ийн 23.5-д заасан "Шүүхийн төсвийг батлахдаа

[10] Vicki C. Jackson, "Judicial Independence: Structure, Context, Attitude," in Judicial Independence in Transition, ed. Anja Seibert-Fohr /Springer Science & Business Media, 2012/, 22–23.

[11] О.Мөнхсайхан нар, Монгол Улс дахь шүүхийн захиргааны загвар: тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам,/УБ: Нээлттэй нийгэм форум, 2015 он/, 28.

[12] Б.Чимид, "Шүүх эрх мэдлийн талаархи Үндсэн хуулийн үзэл баримтлалын тухайд", илтгэл, /"Шүүх эрх мэдэл-Шинэ зуун" олон улсын онол-практикийн бага хурал, УБ, 2001 он/, 56.

[13] Г.Совд, "Шүүх, шүүгчдийн хараат бус байдлыг хангах асуудалд", Монголын төр, эрх зүй, Дугаар 02, /УБ, 1997/, 1.

[14] Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1-д "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ"; 47.3-т "Шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулна"; 48.2-т "Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно"; 48.3-т "Шүүх улсын төсвөөс санхүүжинэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана"; 49.3-т "Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана" гэх зэргээр шүүхийн бие даасан байдлыг хангах эрх зүйн үндсийг тогтоож өгчээ.

тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл"; Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 69 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр"-т тодорхойлсон зорилтуудад нийцүүлэн батлагдсан шүүх эрх мэдлийн шинэтгэлийн стратегийн гол баримт бичгүүдийн нэг юм.

Дээр дурдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 39 дүгээр захирамжаар батлагдсан "Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөрийг шүүхэд хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх үндсэн чиглэл", Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2014-2020 онд шүүхийн хөгжлийн стратегийг тодорхойлсон 5 дэд хөтөлбөрийг 2014 онд тус тус баталсан. Уг хөтөлбөрт а/ Шүүхийн шинэ менежмент хөтөлбөр; б/ Шүүхийн хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх хөтөлбөр; в/ Шүүгч, ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр; г/ Шүүхийн хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөр; д/ Шүүх ба олон нийт гэсэн хөтөлбөрүүд батлагдсан.

Дээрх хөтөлбөрт заагдсан шалгуур үзүүлэлтэд тулгуурлан шүүхийн шинэтгэлийг 1/ Шүүхийн тогтолцоо; 2/ Шүүхийн бие даасан байдал; 3/ Шүүгчийн хараат бус байдал; 4/ Шүүхийн хүний нөөц, сонгон шалгаруулалт; 5/ Шүүхийн ил тод, нээлттэй байдал; 6/ Шүүх эрх мэдлийн хүрээний бусад байгууллага гэсэн дэд хэсгүүдэд хуваан авч судалсан ба судалгааны дүгнэлт, санал хэсгийг тоймлон[7] энэхүү илтгэлээр хүргэе.

1.Шүүхийн тогтолцооны тухайд

Шүүх эрх мэдлийн бие даасан, хараат бус байдал нэмэгдэх нь тухайн улсын эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхийн сацуу авлига, хээл хахуулийн гэмт хэрэг буурах нэг хүчин зүйл болдог.[8] Судлаачдын үзэж байгаагаар шүүхийн тогтолцоо сул, шүүхийн үйлчилгээ иргэдэд хүртээмжгүй, чанаргүй бол нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ болон хөрөнгө оруулалтыг 10 хүртэл хувиар бууруулдаг байна.[9] Ийм учраас дэлхийн улс орнууд хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг хангаж ажиллах бие даасан шүүх эрх мэдлийг төлөвшүүлэх, институтын хувьд чадавхийг нь бэхжүүлэх талаар анхаарч шүүхийн улс төр, эдийн засаг, хууль зүйн баталгааг хангаж ажиллаж ирсэн.

Монгол Улсын шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдсэн томоохон өөрчлөлтийн нэг болох шүүхийн тогтолцооны өөрчлөлтөд дүн шинжилгээ хийхэд шүүхийн тогтолцоо өөрчлөгдсөнөөр буюу шүүхийг дагнан байгуулснаар шүүгч илүү мэргэших, энэ нь шийдвэрийн чанарт нөлөөлөн улмаар ажлын ачаалал буурах эерэг үзүүлэлттэй судалгааны дүн гарсан боловч хууль санаачлагчийн зүгээс шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдлийг гаргахдаа хууль тогтоомжийн онолын буюу суурь судалгаа хангалттай хийгээгүй, түүнчлэн хууль тогтоомжийн үр нөлөөний судалгааг хийгээгүйгээс болж шинэтгэлийн томоохон ажлуудын нэг болох дагнасан шүүхийн тогтолцооны хэрэгжилтэд хүндрэл учирсан болох нь тогтоогдсон. Үүнтэй уялдуулан дараах саналыг гаргаж байна. Үүнд:

- Шүүхийн тогтолцоонд "тойргийн" зарчим нэвтрүүлснээр буюу шүүхийг хэрэг маргааны төрлөөр дагнан байгуулснаар шүүхийн харилцан адилгүй ачаалыг бууруулах,

[7] Судалгааны дүгнэлт, санал гаргасан үндэслэл, иш татсан эх сурвалжийн мэдээллийг энэхүү илтгэлд дурдаагүй тул судалгааны үндсэн тайлангаас үзнэ үү.

[8] Wittrup, Jesper. "Budgeting in the Era of Judicial Independence." International Journal for Court Administration, April 2010. http://www.iaca.ws/files/Jesper_Wittrup4-2010.pdf.

[9] 2012 онд УИХ-д өргөн баригдсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн төсөл болон түүнтэй холбогдох бусад хуулийн төслийн танилцуулга. www.parliament.mn.

шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг бууруулж болохгүй" гэсэн заалтуудыг тус тус хүчингүй болгосон нь шинэтгэлээр хийж хэрэгжүүлсэн ажлаасаа ухарсан алхам болжээ.

Эдгээр заалтуудыг хүчингүй болгосон нь шүүхийн төсвийг хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлээс бууруулах замаар шүүхийн төсвөөр дамжуулан шүүхийн хараат бус байдалд халдах эрсдлийг бий болгож болзошгүй. Иймд дээрх заалтуудыг сэргээн хуульчлах, мөн шүүхийн төсвийн хэмжээг улсын нэгдсэн төсөвт эзлэх хувийн доод хэмжээг хуульчлах, "Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх" хөтөлбөрт тусгасан шүүхийн төсвийн хэмжээ улсын нэгдсэн төсвийн 1.5 хувьд хүргэх зорилтыг хангаж ажиллахад анхаарах шаардлагатай.

ШЗтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1.1 болон ШтХ-ийн 28.5 дахь хэсэгт байгаа "Ерөнхий зөвлөл бүх шатны шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Улсын Их Хуралд шууд өргөн мэдүүлэх" гэсэн заалт нь Үндсэн хууль болон холбогдох хуулиудтай зөрчил үүсгэж болзошгүй байдалд анхаарч, шүүхийн төсвийг үндэслэлгүйгээр бууруулах байдлаас сэргийлэх хуулийн зохицуулалтыг бий болгох шаардлагатай. /Энэ талаар хууль тогтоомжийг хэрхэн өөрчлөх боломжтой талаар бодлогын хувилбар дэвшүүлснийг судалгааны "Шүүхийн бие даасан байдал" хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү/ Түүнчлэн, шүүх хэвийн үйл ажиллагаагаа явуулах зохих байраар хангагдаагүй, шүүхийн байранд шүүхээс бусад байгууллагууд /прокурорын байгууллага/ хамт байршиж байгаа явдалд анхаарал хандуулж Монгол Улсын ШтХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалтад заагдсан "Шүүх өөрийн байртай байна" гэсэн заалтыг мөрдөх хүрээнд шүүхийн төсвийн хөрөнгө оруулалтын төсвийг хангалттай хэмжээгээр батлах шаардлагатай. Үүнтэй уялдуулан дараах саналыг гаргаж байна. Үүнд:

•Шүүхийн төсвийн хэмжээний улсын нэгдсэн төсөвт эзлэх хувийн доод хэмжээг нэг хувиас дээш хэмжээтэй болгож хуульчлах;

•ШЗтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1.1 болон ШтХ-ийн 28.5 дахь хэсэгт "Ерөнхий зөвлөл бүх шатны шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Улсын Их Хуралд шууд өргөн мэдүүлэх" гэсэн заалт нь холбогдох хуулиудтай зөрчил үүсгэж болзошгүй байдалд анхаарч шүүхийн төсвийн хэмжээг үндэслэлгүйгээр бууруулахаас сэргийлэх зохицуулалтыг хууль тогтоомжид тусгах;

•ШтХ-ийн 28.5-д "шүүхийн үйл ажиллагааны төсвийг өмнөх жилийн хэмжээнээс бууруулахыг хориглоно", ШЭЗБтХ-ийн 23.5-д заасан "Шүүхийн төсвийг батлахдаа шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг бууруулж болохгүй" гэсэн заалтуудыг хүчингүй болгосныг сэргээн хуульчлах;

•Шүүхийн ерөнхий зөвлөлд хэт өргөн эрх хэмжээ олгогдсонтой холбогдуулан ШЕЗ-ийн гишүүний ёс зүйн дүрмийг батлах, нөгөө талаар шүүхийн захиргааны зарим чиг үүргийг хороодоор дамжуулан хэрэгжүүлэх талаар судлах санал багтаж байна.

3.Шүүгчийн хараат бус байдлын тухайд

Шүүгч гэдэг бол хэргийн оролцогчид түүнд хамааралтай, сонирхолтой этгээдүүдийн олон эрх ашгийн уулзвар, огтлолцол, зөрчилдөөнтэй асуудлаар хамгийн дээд эрх ашиг буюу хуулийн дагуу шийдвэр гаргах үүрэгтэй онцгой субьект. Шүүгч шударгаар ажиллаж, хуулийн дагуу шийдвэр гаргахын тулд бусад эрх мэдэлтэй, хөрөнгөтэй хүмүүсээс хамгаалагдсан байх ёстой. Шүүх эрх мэдлийн хараат бус байдлын нэг гол тулгуур зарчим бол шүүх биеэ даасан байхын зэрэгцээгээр шүүгчийн

хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах чадварыг хангах явдал. Энэ талаар Доктор Н.Лүндэндорж "... шүүх бие даасан байвал гадны аливаа хууль бус нөлөө шүүгч рүү чиглэх юм. Харин шүүх бие даасан бус байвал хууль бус нөлөө шүүгч рүү бус, тэдний үйл ажиллагаанд хяналт тавьдаг институц рүү чиглэдэг"[15] хэмээн дүгнэсэн байдаг.

Монгол Улсын шүүхийн шинэтгэлээр хийгдсэн томоохон өөрчлөлтүүдийн нэг бол ШЭЗБтХ-ийн 22 дугаар зүйлд заасны дагуу "нөлөөллийн мэдүүлэг" хөтлөх болсон явдал. Энэ нь шүүгчийн хараат бус байдлыг хангахад тодорхой ахиц дэвшил бий болгосон бөгөөд нөлөөллийн мэдүүлгийн ач холбогдлыг цаашид сурталчлан таниулах, хуулийн хүрээнд хөтөлж явуулах нь шүүгчийн хараат бус байдлыг хангахад чухал ач холбогдолтой. Түүнчлэн ШЭЗБтХ-ийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт "Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ нь шүүгч эдийн засгийн хувьд хараат бусаар ажиллаж, амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байна." гэж заасны дагуу шүүгчийн цалинг шат дараатай нэмэгдүүлсэн нь шүүгчийн хараат бус байдлыг хангахад ахиц дэвшил гаржээ. Үүнтэй уялдуулан дараах саналыг гаргаж байна. Үүнд:

- Шүүгчийн цалинг хууль тогтоогч бодит тооцоо, судалгаанд тулгуурлаж тогтооход, шүүгчийн цалинг инфляцийн түвшинтэй уялдуулж тогтоодог байх зэрэг асуудлыг анхаарах;

- ШЭЗБтХ-ийн 23.5-д "Шүүхийн төсвийг батлахдаа шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг бууруулж болохгүй" гэсэн заалтыг хүчингүй болгосныг сэргээн хуульчлах;

- Шүүгчийн хариуцлагын тогтолцоог сайжруулах үүднээс шүүгчийн ёс зүйн болон мэргэжлийн хариуцлагын асуудлыг Шүүхийн ёс зүйн хороо болон Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хороо шийдвэрлэдэг чиг үүргийн давхардлыг арилгах, шүүгчийн мэргэжлийн ёс зүйн алдааг нэг байгууллага буюу Шүүхийн ёс зүйн хороо шийдвэрлэх талаар хууль зүйн давхардлыг арилгах санал байна.

4. Шүүхийн хүний нөөц, сонгон шалгаруулалтын тухайд

Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 3-т "шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана." гэж тусгажээ. Энэ байгууллага 1993-2012 он хүртэл УДШ болон Хууль зүйн яамны дэргэд хавсарга байдлаар орон тооны бус гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байсан нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахад үр нөлөө муутай байв. Иймд 2012 онд батлагдсан Шүүхийн багц хуулиудын хүрээнд Үндсэн хуульд заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагыг байгуулсан явдал шүүхийн шинэтгэлд чухал ач холбогдолтой болсон. Энэ байгууллага байгуулагдсанаар шүүхийн шинэтгэлийг дагнан хэрэгжүүлэх олон арга хэмжээ авч байгаагийн дотор шүүхийн хүний нөөц, сонгон шалгаруулалт чухал байр суурийг эзэлнэ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүрэг, эрх хэмжээг өргөтгөснөөр шүүгчийн сонгон шалгаруулах ажиллагаа шинэ шатанд гарсан. Үүнд: 1/ 2012 оны Шүүхийн тухай хуулиар Шүүхийн мэргэшлийн хороог шинэчилэн байгуулсан. 2/ 2012 оноос өмнөх үетэй харьцуулахад шүүхийн хүний нөөц нэмэгдсэн 3/ Шүүгчид нэр дэвшигчийн бүрэлдэхүүнийг өргөтгөсөн буюу шүүхийн захиргааны ажилтнуудаас бусад өөр өөр төрлийн ажил эрхэлж байсан туршлагатай хүмүүс анхан шатны шүүхэд нэр дэвшиж шүүгчээр томилогдсон. 4/Шүүгчийн сонгон шалгаруулалт, шалгалтын талаарх

[15] Н.Лүндэндорж нар, Монгол Улсад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь Бодлогын тойм судалгаа, /УБ: Нээлттэй нийгэм форум, 2010/, 39.

мэдээлэл илүү ил тод болсон. Шүүгчийн сул орон тоонд шалгаруулалт зарласан зар, шалгалтын болон ярилцлагын хуваарийг ШЕЗ-ийн цахим хуудсанд тухай бүр мэдээлдэг болсон зэрэг дэвшилттэй зүйлүүд бий болсон.

Шүүхийн тухай багц хуулийг баталснаар шүүгчийн сонгон шалгаруулах ажиллагаанд дээр дурдсан дэвшилттэй зүйлүүд гарч байгаа боловч судлаачид шүүгчийн сонгон шалгаруулалт, шүүгчийн томилгоо шударга явагдахгүй байгаа талаар шүүмжлэлтэй хандсаар байна. Тухайлбал, шүүгчийн сонгон шалгаруулалтаар хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигч шүүгчээр сонгогдож чадахгүй байгаа мөн шүүхийн тогтолцоог өөрчлөн байгуулсантай холбогдуулан зарим шүүгчийг буцаан томилоогүй явдал гарсан талаар судлаачид шүүмжлэлтэй хандаж байна. Түүнчлэн шүүгчийн сонгон шалгаруулах ажиллагааны журам тодорхой бус, шүүгчид нэр дэвшигчийн талаарх дүгнэлт хэлбэр төдий явагддаг зэрэг асуудлууд гарч байна.

Иймд шүүгчийн хараат бус байдлын баталгааны нэг үндсэн шалгуур үзүүлэлт болох шүүгчийн сонгон шалгаруулалт, шүүгчийн томилгоогоор дамжуулан Монгол Улсын Ерөнхийлөгч болон Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчийн хараат бус байдалд халдаж болзошгүй байгаа байдалд анхаарал хандуулж шүүгчийн хараат бус байдлыг хангах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай. Үүнтэй уялдуулан дараах саналыг гаргаж байна. Үүнд:

• Шүүгчийн сонгон шалгаруулах чиг үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөл-өөс тусдаа бие даасан Мэргэшлийн хороо хэрэгжүүлэх;

• Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчийн сонгон шалгаруулалтыг явуулахдаа Шүүхийн мэргэшлийн хорооны шалгалтад тэнцсэн хүмүүсээс нэр дэвшүүлэхдээ шалгалтын онооны эрэмбийг гол шалгуур үзүүлэлт болгон авч үзэх, Мэргэшлийн хорооноос хамгийн өндөр үнэлгээ авсан нэр дэвшигчийг шүүгчээр томилох;

• Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчийн сонгон шалгаруулах ажиллагааг явуулахдаа шүүгчид нэр дэвшигчийг ямар үндэслэлээр Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсэн болох мөн нэр дэвшигчийг шүүгчээр томилуулахгүй болсон бол үндэслэлээ бичиж, тодорхой тайлбар хийх талаар хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгох;

• Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхийн хүрээнд шүүхийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор шүүгчдийг томилохдоо шүүгчийг дахин томилохоос татгалзах, шүүгчийг өөрчлөн зохион байгуулагдсан шүүхэд нь бус өөр шүүхэд, мөн дээд шатны шүүхийн шүүгчийг доод шатны шүүхийн шүүгчээр шилжүүлэн томилсон зэрэг асуудалд ямар үндэслэлээр, яагаад буцаан томилохгүй байгаа үндэслэлээ тайлбарладаг байх шаардлагатай байх;

• Шүүхийн хүний нөөцийн бодлогыг сайжруулах үүднээс шүүгч бэлтгэх сургалтын тогтолцоог сайжруулах, энэ үүднээс шүүгч бэлтгэх дагнасан сургалттай сургууль нээх боломжийг судлах, түүнчлэн шүүгчийг бүх насаар нь томилохоос өмнө "туршилтын хугацааны шүүгч"-ээр 3-5 жилийн хугацаагаар ажиллуулсны дараа шүүгчийг бүх насаар нь томилох зэрэг гадаад орнуудын туршлагыг судлах санал багтаж байна.

5. Шүүхийн ил тод, нээлттэй байдлын тухайд

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин дөрөвдүгээр зүйлд "Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүх хэргийг ил таслан шийдвэрлэнэ" гэж заасан ба 2012 оны Монгол Улсын Шүүхийн тухай хуульд шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй,

ил тод байна гэж тусгажээ.[16] Энэ нь шүүх хуралдаан хориглосноос бусад тохиолдолд нээлттэй явагдах, шүүхийн шийдвэр нээлттэй байх гэсэн утгыг илэрхийлж байна.

"Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах хөтөлбөр батлан хэрэгжүүлж байгаа нь дэвшилттэй алхам болжээ. Иймд шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийг цаашид гүнзгийрүүлэх, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх, судалгааны эргэлтэнд оруулах нь хууль зүйн шинжлэх ухааны цаашдын хөгжилд чухал ач холбогдолтой. Үүнтэй уялдуулан дараах саналыг гаргаж байна. Үүнд:

• Шүүхийн шийдвэрийн ил тод байдалд анхаарч хувь хүн, байгууллагын нууцтай холбоотой шийдвэрийн нууцлал, ялангуяа гэр бүлийн хүрээний маргаан зэрэг хувь хүний нууцтай холбоотой шийдвэрүүдийг олон нийтэд нээлттэй, ил тод байрлуулах нь зохистой эсэхэд анхаарах;

• Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ тогтмол хийж, судалгааны эргэлтэнд оруулахад анхаарах санал багтаж байна.

6. Шүүх эрх мэдлийн хүрээний бусад /оролцогч/ байгууллагын тухайд

Монгол Улсын Үндсэн хуулийн "Шүүх эрх мэдэл" гэсэн Дөрөвдүгээр бүлэгт шүүх, прокурорын байгууллагын тогтолцоо, үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын дээд шүүхийн бүрэн эрх, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн зохион байгуулалт, бүрэн эрхийн асуудлыг хуульчилжээ. Мөн шүүх хэвийн үйл ажиллагаа явуулахад туслах, дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй Цагдаагийн байгууллага, Өмгөөллийн байгууллага, Тахар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зэрэг байгууллагуудын эрх зүйн үндсийг холбогдох хуулиар зохицуулсан.

Шүүхийн шинэтгэл хэрэгжиж эхэлснээс хойш буюу шүүхийн тухай багц хуулиуд батлагдсантай холбогдуулан шүүх эрх мэдлийн хүрээний байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоог сайжруулах чиглэлээр олон ажлууд хийгдсэний дотор Шүүх, хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн цахим нэгдсэн сүлжээ бүрдүүлсэн нь шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдсэн томоохон ажлуудын нэг болжээ. Шүүхийг тойргийн тогтолцоогоор шинэчлэн зохион байгуулахтай уялдуулан прокурор, цагдаа, мөрдөх албаны зохион байгуулалт, үйл ажиллагааг шинэчлэх, эдгээр байгууллагуудын болон хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээний ажлын ачаалал нэмэгдсэн зэрэг хүндрэл бэрхшээлүүд гарч байна.

Мөн шүүх эрх мэдлийн хүрээний бусад байгууллагуудын эдийн засгийн баталгаа хангагдахгүй байгаа байдалд анхаарч эдгээр байгууллагуудад шаардлагатай хэмжээний төсвийг батлах шаардлагатай. Иймд эдгээр байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, мөн дээрх байгууллагуудын эдийн засгийн баталгаа, цалин хангамжийг шүүгчийн цалинг нэмэгдүүлсэнтэй дүйцүүлэх хэмжээгээр сайжруулахад анхаарах хэрэгтэй. Үүнтэй уялдуулан дараах саналыг гаргаж байна. Үүнд:

• Шүүхийн шинэтгэл хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шүүх, хууль сахиулах байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулахад анхаарах;

• Шүүх эрх мэдлийн хүрээний бусад байгууллагуудын эдийн засаг, нийгмийн баталгааг хангах, эдгээр байгууллагуудын ажилчдын цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулахад

[16] Монгол Улсын Шүүхийн тухай хууль (2012)-ийн 8 дугаар зүйлийн 8.2.

анхаарах;

• Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авах, түүнчлэн улс төрөөс хамаарахгүйгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал багтаж байна.

Ийнхүү тус илтгэлд Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь" судалгааны талаар товч танилцуулж, тус судалгааны "Шүүхийн шинэтгэлийн хэрэгжилт, үр дүн, цаашдын асуудал" дэд хэсгийн дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг тухайлан авч үзлээ.

Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь" судалгаа цаашид эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичгийг шинээр боловсруулан гаргах ажилд нэмэлт мэдээлэл болно хэмээн найдахын зэрэгцээ цаашдын бодлого тодорхойлоход харгалзах боломжтой үндэслэлүүд гаргахыг зорьсон гэдгийг дахин тэмдэглэн хэлье.

1998 оны Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг албан ёсоор хааж, дараагийн баримт бичиг батлагдаж гараагүй ч эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх хэрэгцээ, шаардлага, шинэтгэлийн бодлогын цаашдын зорилт, чиглэл болон бодлогын баримт бичиг боловсруулах талаар хөндсөн уулзалт, хэлэлцүүлэг, зөвлөлдөх үйл ажиллагаа багагүй хийгджээ. Эдгээр үйл ажиллагаагаар хэлэлцүүлсэн илтгэл, зөвлөмжүүдийн эмхэтгэлийг судалж үзэхэд өнөө хэр нийгэмд тулгамдсан асуудлыг тухайн үед хөндөж дэвшүүлсэн; эрх зүйн шинэтгэлийн зохион байгуулалтын болон арга зүйн зэрэг тал бүрийн харилцааны гарцыг эрэлхийлсэн чухал эх сурвалж хэвээр байна. Тэдгээрт дэвшүүлсэн тодорхой санал зөвлөмжүүдийг эрх зүйн шинэтгэлийн цаашдын бодлого, зорилт, чиглэлийг онол, практикийн үндэслэлтэй боловсруулахад түлхэц болгон ашиглах нь зүйтэй.

Эрх зүйн шинэтгэлийн бодлого тодорхойлоход эрдэмтэн судлаач, мэргэжилтэн, иргэд, олон нийтийн оролцоог хангах, тэдгээрийн санал, зөвлөмжийг тусгах, хэлэлцэж зөвлөлдөх арга ажиллагаа цаашид ч нэн чухал болохыг дахин онцолъё. Үүнийг төрийн болон төрийн бус байгууллага, Монголын Хуульчдын холбоо, хууль зүйн их, дээд сургууль, Монгол Улсын эрх зүйн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын болон гадаад улсын байгууллага, төсөл, хөтөлбөрөөр дамжуулан үндэсний хэмжээнд өргөтгөн зохион байгуулах нь тохиромжтой юм. Монгол Улсад эрх зүйн шинэтгэлийг амжилттай хэрэгжүүлэхэд бусад улс орон, олон улсын байгууллага өргөн хүрээнд туслалцаа дэмжлэг үзүүлж ирснийг тэмдэглэхийн зэрэгцээ цаашид хамтын ажиллагааг системтэй, үр дүнтэй ашиглах тал дээр нэгдсэн бодлого шаардагдаж байгааг илэрхийлье.

Эрх зүйн шинэтгэлийн дараагийн шатны бодлогын баримт бичиг баталж хэрэгжүүлэхийг зөвлөмж болгохын зэрэгцээ тухайн баримт бичиг ямар байх талаар судлаач, мэргэжилтнүүдээс гаргасан саналыг тоймлон хүргэвэл эрх зүйн шинэтгэлийн хүрээнд авч хэрэгжүүлэх үндсэн зорилго, зорилт, арга хэмжээ, баримтлах зарчим, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, биелэлтийг үнэлэх/хэмжих шалгуур үзүүлэлтийг цогц тусгасан байхыг чухалчилж үзсэн байна.

Судалгаагаар тогтоогдсон үр дүн, судалгааны хэсгүүдэд томьёолсон нарийвчилсан саналуудад үндэслэн эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх ерөнхий санал, зөвлөмжийг судалгааны нэгдсэн тайланд тусгах болно.

---o0o---

ЭРХ ЗҮЙ ДЭХ НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫН ТАЛААРХ ҮНДСЭН ОЙЛГОЛТЫН ТУХАЙД



Удирдлагын академийн багш, докторант Р.Мухийт

2000 оноос хойш Монгол Улсад батлагдсан тэр дундаа захиргааны эрх зүйн эх сурвалж болох хуулиудад “нийтийн ашиг сонирхол” гэсэн нэр томьёо хууль зүйн ач холбогдол бүхий байдлаар хэрэглэгдэх болсон.

Тухайлбал 2002 онд батлагдсан (одоо хүчингүй болсон) Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1.1-т ”захиргааны байгууллага” гэж **нийтийн ашиг сонирхлыг** илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг ... байгууллагыг ойлгоно гэж заасан.

Харин 2012 онд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг батлахдаа “энэ хуулийн зорилт нь нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, хянах замаар нийтийн албаны үйл ажиллагааг **нийтийн ашиг сонирхолд** нийцүүлэх нөхцөлийг баталгаажуулж төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангахад оршино” гээд тус хуулийн 3.1.1-т **"нийтийн ашиг сонирхол"** гэж нийтийн албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоосоо ангид тэгш, шударгаар хэрэгжүүлнэ гэх олон нийтийн итгэлийг ойлгоно гэж тодорхойлжээ.

Улмаар 2015 онд Захиргааны ерөнхий хууль болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг батлан гаргасан. Эдгээр хуульд нийтийн ашиг сонирхол нь шийдвэр гаргахад хэрхэн нөлөөтэй байх талаар тусгасан байна.

Жишээлбэл, Захиргааны ерөнхий хуулийн 5.1-д **Нийтийн ашиг сонирхлыг** илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно; 10.4.2-т **нийтийн ашиг сонирхолд** ноцтой хохирол учруулахаар бол; 28.1.1-д **нийтийн ашиг сонирхолд** сөргөөр нөлөөлөхөөр бол; 28.1.2-т гарцаагүй байдлын улмаас, эсхүл **нийтийн ашиг сонирхлын** үүднээс хойшлуулшгүй ажиллагаа явуулах шаардлагатай бол; 48.2.2-т бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, эсхүл **нийтийн ашиг сонирхолд** сөргөөр нөлөөлсөн; 49.3.3-т шинэ нөхцөл байдал бий болсноор **нийтийн ашиг сонирхол** зөрчигдөхөөр бол; 49.3.5-д **нийтийн ашиг сонирхолд** ноцтой сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх, эсхүл түүнийг зайлуулахын тулд; 56.3-т Захиргааны байгууллага нийтийн ашиг сонирхолд ноцтой хор уршиг учруулахаар бол түүнээс урьдчилан сэргийлэх, эсхүл арилгах үүднээс захиргааны гэрээг дангаар цуцалж болно; 62.2-т нийтийн ашиг сонирхол,

www.nlsoyol.mn

хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөх тохиолдолд захиргааны хэм хэмжээний актын төсөлд нийтийн санаа бодлыг тусгах зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцох боломжоор хангах бөгөөд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг заавал хийнэ; 73.1.7-д хуульд өөрөөр заасан нийтийн ашиг сонирхлыг хөндөх бусад асуудал; 79.3-т Холбогдох захиргааны байгууллага нийтийн ашиг сонирхлыг хангахын тулд, эсхүл гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлж болохуйц сөрөг нөлөөг арилгах арга хэмжээг авах үүрэгтэй; 81.2-т Төлөвлөгөөг хэрэгжүүлснээр нийтийн ашиг сонирхлыг ноцтой хохироох тохиолдолд тухайн захиргааны актыг хүчингүй болгож болно гэжээ.

Түүнчлэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилгыг хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэж тодорхойлсон.

Эндээс нийтийн ашиг сонирхол өөрөө хууль зүйн ач холбогдолтой учир түүнийг шүүх зайлшгүй харгалзан үзэх, улмаар шүүхийн журмаар хамгаалах шаардлага гарч байгаа бөгөөд нийтийн ашиг сонирхлыг хууль зүйн хувьд хэрхэн тодорхойлох нь чухал болоод байгаа юм.

Иймд нийтийн ашиг сонирхол гэх хууль зүйн үзэгдлийн мөн чанарын талаар судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Ингэхдээ түүнийг эрх зүйн үзэгдэл болох талаас нь анхаарлаа хандуулж байгааг тэмдэглэх нь зүйтэй болов уу.

1. Эрх зүй дэх ашиг сонирхлын тухай

Монгол Улсын Үндсэн хуульд “ашиг сонирхол”[1] гэсэн ойлголт нийт 6 удаа дурдагдсан байна. Тухайлбал:

6.4. Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно.

16.10/ нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно;

16.11/ улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;

17.2/ хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

23.1. Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.

46.2. Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх

[1] Зарим тохиолдолд манай зарим судлаач, хуульч “эрх ашиг” хэмээн бас бичсэн байдаг. Эдгээр нэр томьёог Үндсэн хуулийн ойлголтоор жигдлэх нь зүйтэй.

бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана.

Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалтаас үзэхэд "ашиг сонирхол" гэдэг нь "хүн амын эрүүл мэндийн ашиг сонирхол", "байгаль хамгааллын ашиг сонирхол", "үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол", "нийгмийн ашиг сонирхол", "хувь хүний ашиг сонирхол", "гэр бүлийн ашиг сонирхол", "эх нялхсын ашиг сонирхол", "хүүхдийн ашиг сонирхол", "нийт иргэн, улсын ашиг сонирхол", "төрийн ашиг сонирхол" гэсэн олон төрлөөр тодорхойлогджээ.

Мөн Үндсэн хуулийн 17.2-т "хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх" нь нийт иргэдийн үндсэн үүрэг гэж тодорхойлсон. Энд хувийн ашиг сонирхлыг тээгч бол хувь хүн өөрөө гэдэг нь тодорхой байна. Харин олон нийтэд хамаатай ашиг сонирхлыг тээгч нь хэн байх вэ гэдэг асуудал нэлээд маргаантай байх нь бий. Манай Үндсэн хуульд ч улсын ашиг сонирхол, төрийн ашиг сонирхол гэх мэтээр ялгамжтай туссан байгааг дурдсан. Эндээс улсын буюу төрийн ашиг сонирхол гэж ард түмнийхээс ангид зүйл байх уу? эсвэл нэг зүйл үү? Эдгээр нь хувь хүнд хамаатай юу, нийтэд хамаатай юу гэх мэт онолын асуултууд хөвөрнө.

Төр ашиг сонирхлыг тээгч байх тухай асуудал эртний Аристотель, Платон, Полиби, Цицерон нарын бүтээлд туссан. Тэдний гол санаа нь полис буюу төрийн ашиг сонирхол бол нийтийн буюу бүх иргэдийн ашиг сонирхол мөн. Харин хувийн ашиг сонирхол нь нийтийн ашиг сонирхолтой уялдаатай байна гэдэг.

Дундад зуунд төрийн ашиг сонирхол гэдгийг теологийн шинжтэй болгосон. Гэгээн Августин, Фома Аквинский, Марсилий Падуанский нар төрийн ашиг сонирхол гэдэгт сүм хийдийн дээд үнэт зүйлсийг ойлгож байлаа. Сүүлд Макиавелли, Боден нарын бүтээлд төр болон сүм хийдийг салгаж, төр бүх иргэдийн сайн сайхны төлөө зөвхөн удирдлагын үүрэг гүйцэтгэнэ гэж үзэх болсон.

Шинэ үед төрийн ашиг сонирхлын талаар Т.Гоббс, Гегель, Бисмарк нар, хувьсгалаас өмнөх Оросын эрдэмтэд Н.Н.Алексеев, В.М.Гессен, Н.М.Коркунов, орчин цагийн эрдэмтэд П.В.Анохин, С.Н.Бабурин, А.М.Величко, В.Е.Чиркин, В.С.Шевцов, С.В.Степашин нар судалсан байна.

Үүнтэй холбоотойгоор төрийн мөн чанарын асуудал шийдвэрлэх ач холбогдол бүхий байдлаар гарч ирдэг. В.М.Корельскийн үзснээр "энэ бол төрийн эрх мэдэл хэнд байна вэ, түүнийг хэний ашиг сонирхлын төлөө, хэн хэрэгжүүлж байна вэ гэдэгтэй холбоотой асуудал" юм. Эндээс үзвэл төрийн мөн чанарыг тодорхойлох асуудалд хариулт өгөх нэг хүчин зүйл бол төрийн ашиг сонирхлын тухай асуулт бөгөөд төр хэний ашиг сонирхлын төлөө үйлчилж байна вэ гэдгээр тодорхойлогдоно.

Төрийн мөн чанарын талаар үндсэн хоёр хандлага бий. Эхний хандлагад "элитийн онол", "технократ онол", "ангийн онол" зэрэг тодорхой бүлгийн ашиг сонирхол давамгай нөлөө үзүүлдэг тухай сургаалиуд багтана. Энд төрийн ашиг сонирхол гэдэг нь эдийн засгийн хувьд ноёрхогч анги давхаргын ашиг сонирхолтой ижил гэж ойлгогддог. Хувийн ашиг сонирхлыг "гаргуунд нь хаядаг" марксизм мөн энэ хандлагад хамаарна.

Хоёр дахь хандлага нь төрийн нийгмийн зориулалтад тулгуурладаг ба төр бол нийгмийн ашиг сонирхлын илэрхийлэл гэж үздэг. Төр "нийтийн баялаг"-т үйлчлэх ёстой. Америкийн улс төр судлаач В.Остромын бичснээр "нийтийн баялаг" гэдэгт тухайн улс орон буюу нийгмийн нийтлэгт ашиг тустай үйл ажиллагааг ойлгоно. Нийтийн баялаг бол нийтийн ашиг сонирхол гэж үзэх нь түгээмэл бөгөөд үүний

Учир нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1-д "Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах хэлбэрээр мэдүүлэх эрхтэй" гэж, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1.7-д "нэхэмжлэл гэж иргэн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус актын улмаас зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар захиргааны хэргийн шүүхэд хандаж гаргасан өргөдлийг ойлгоно" гэж хуульчилсан.

Эндээс зөвхөн хууль ёсны ашиг сонирхлыг л шүүхээр хамгаалах эрх зүйн зохицуулалт урган гарч байгаа юм.

Хууль ёсны ашиг сонирхол бол эрх зүйн хэм хэмжээ, дэг журамтай харшлаагүй ашиг сонирхол байна. Нэг үгээр хэлбэл "хориглогдоогүй байдал" гэж ойлгож болох юм. Ингэснээр "хуулиар хориглосноос бусдыг зөвшөөрнө" гэсэн томьёолол хэрэгждэг. Иймээс хууль ёсны ашиг сонирхол ихэнхдээ хууль тогтоомжид формаль байдлаар бэхжээгүй, тодорхой хууль зүйн үүрэг хүлээгээгүй байна. Харин эрх зүйн харилцаанд оролцогч бусад субьектээс түүний хүсэл зоригт саад болохгүй байх ерөнхий үүрэг оршдог. Ялангуяа хууль ёсны ашиг сонирхол эрх зүйн зарчимд суурилдаг гэдгийг ойлгох нь чухал. Иймээс хууль ёсны ашиг сонирхол бол эрх зүйн зохицуулалтын хүрээнд байдгийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй бөгөөд заримдаа субьектив эрхтэй адил хамгаалагдах боломжтой болдог. "Заримдаа" гэдгийн учир бол албан тушаалтны үзэмжээр шийдэх асуудлыг бүрэн үгүйсгэх боломжгүйд байгаа юм.[3]

Хууль зүйн шинжлэх ухаанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг ялгах оролдлого хийгээд удаж байна. Нийтийн, хувийн ашиг сонирхлын аль нь байхаас үл хамаарч эдгээр ашиг сонирхол хуульд нийцсэн эсэх нь чухал үзүүлэлт юм. Жишээлбэл, 2014 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр Испанийн Каталони мужийн иргэдийн 80 орчим хувь нь Испани улсаас тусгаарлагдах санал асуулга явуулсан боловч Испани улсын хууль зүйн сайд Рафаэль Катала энэ санал асуулга Хууль зүйн ямар ч үр дагавар үүсгэхгүй гэж, тус улсын Ерөнхий сайд Мариано Рах энэ бол Испани улсын Үндсэн хуульт ай харшилж байгаа бөгөөд бүх испаничуудын эрхийг зөрчиж байна гэж мэдэгдсэн байдаг. Улмаар Испанийн Үндсэн хуулийн шүүхээс Үндсэн хуульт ай харшилж байна гэдгийг тогтоосон.[4] Иймд хууль ёсны нийтийн ашиг сонирхлын тухай авч үзэх нь зүйтэй болж байгаа юм.

Нэг талаас хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах процесс хууль тогтоомжоор нарийн зохицуулагдаагүй учраас хамгаалалтын гол механизм субьектив эрх рүү чиглэсэн. Өөрөөр хэлбэл "зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхол" гэдэг холбоо үг төдий ойлгогдох нь элбэг. Нөгөө талаас хууль ёсны ашиг сонирхол мөн эсэх дээр аль аль талдаа бүрхэг ойлголттой байх явдал түгээмэл байна.

ОХУ-ын Иргэний процессын хуулийн 3 дугаар зүйл, Арбитрийн процессын хуулийн 4 дүгээр зүйлд шүүхэд зөрчигдсөн эсхүл маргаж буй эрх болон хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалуулахаар сонирхогч этгээд хандах боломжийг хуульчилсан байгаа нь зөвхөн эрх нь зөрчигдсөн тал хандахаас гадна сонирхогч этгээд хандаж болохыг илтгэж байна. Ингэснээр хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад түлхэц үзүүлж байна гэж үзэж болно.

[3] М.С.Матейкович, В.А.Горбунов. Законные интересы в конституционном праве.-М.: Норма: ИНФРА-М, 2011. С.28-29, 48, 57.

[4] http://www.forbes.ru/news/272813-kataloniya-vyska-zalas-za-otdelenie-ot-ispanii

шалгуур нь нийтийн болон хувийн ашиг сонирхлын тэнцвэр (баланс) байна.

ОХУ-ын эрдэмтэн Ю.А.Тихомиров төрийн ашиг сонирхол бол зөвхөн "үндэсний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний ашиг сонирхлыг хэрэгжүүлэх үед яригдана" гэвч "нийтийн ашиг сонирхол төрөөс иргэний нийгэмд үйлчлэх, тэдгээрийн ашиг сонирхлыг хамгаалах байдлаар илэрнэ. Ийм байдлаар төр нийтийн ашиг сонирхлыг (иргэний нийгмийн ашиг сонирхол) дотооддоо хамгаалдаг бол олон улсын харилцаанд өөрийн ард түмний үндэсний ашиг сонирхлыг хамгаалдаг" гэжээ.

Энд мэдээж тухайн улс оронд оршин буй улс төрийн дэглэм ихээхэн нөлөө үзүүлнэ. Тухайлбал, улс төрийн тоталитар дэглэмтэй улсын хувьд хувь хүн, нийгмийн ашиг сонирхлыг мэдэгдэхүйц хязгаарлах буюу бүхэлд нь үгүйсгэдэг. Харин төрийн ашиг сонирхол нэрийн дор тодорхой хүмүүсийн хувийн ашиг сонирхол нуугддаг байна. Улс төрийн ардчилсан дэглэм бүхий улсад эсрэгээрээ төр бол хувь хүний сонирхлыг илэрхийлэх бөгөөд эдгээр нь бүхэлдээ хамтын буюу нийгмийн ашиг сонирхол болдог. Ийм учраас төрийн байгууллага, албан тушаалтныг сонгуулийн үндсэн дээр бүрдүүлнэ.[2]

Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлд "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ. Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно" гэж заасан. Иймээс ард түмний ашиг сонирхол төрийн үйл ажиллагааны чиглүүлэгч болох ба иргэний эрх төрийн үйл ажиллагааны агуулгыг тодорхойлно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна". Мөн зүйлийн 3 дахь хэсэгт "Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй" гэж заасан. Дээрх харилцаанд төр өөрийн чиг үүргээ гүйцэтгэнгээ нийгмийн ашиг сонирхлыг хамгаалагч болж байна.

Нөгөө талаас нийгэм өөрийн олон янзын илрэл болох ард түмэн, хүн ам, бүлгээрээ өөрийн ашиг сонирхолтой байна. Эдгээр субьектийг нийгмийн том бүлэг буюу иргэний нийгэм гэж хэлж болно. ОХУ-ын эрдэмтэн М.В.Баглай, В.А.Туманов нар "иргэний нийгэм бол тухайн нийгэм дэх улс төрийн бус харилцааны нийлбэр цогц бөгөөд түүний гол зориулалт бол хувийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэх явдал юм" гэжээ.

Эндээс ардчилсан улсад иргэний нийгмээс эрх зүйт төрд өөрийн ашиг сонирхлыг тулгасны үндсэн дээр тэр нь төрийн ашиг сонирхол гэсэн нэр томьёонд хувирч байгаа гэж тайлбарласан тохиолдолд төрийн ашиг сонирхол гэдэг ойлголтыг хэрэглэх боломжтой болно гэж үзэж байна.

Л.А.Морозова "нийгмийн ашиг сонирхол гэдэг бол нийтийн шинжтэй ашиг сонирхол юм. Гэхдээ энэ бол зөвхөн төрийн ашиг сонирхол гэсэн үг биш. Харин бүх нийгэмд буюу нийгмийн зарим нийтлэгт ашиг тустай байдаг" гэснийг зайлшгүй харгалзан үзэх ёстой.

2. Ашиг сонирхол хууль ёсны байх буюу хууль ёсны ашиг сонирхлын тухай

Нийтийн ашиг сонирхлыг албан ёсоор хамгаалахад энэ нь хууль ёсны ашиг сонирхол байх шаардлагатай.

[2] М.С.Матейкович, В.А.Горбунов. Законные интересы в конституционном праве.-М.: Норма: ИНФРА-М, 2011. С.63-66.

шалгах шаардлагатай байвал 10 хоногт багтаан шийдэх учиртай. Үүнээс гадна нэр дэвшигчийг бүртгэх сонгуулийн хорооны шийдвэрт, санал асуулгын дүнгийн талаарх гомдлыг шүүх гомдол гаргаснаас хойш 2 сарын дотор шийднэ" гэж заасан.

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх 2004 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 3 дугаар дүгнэлтэд хувьцаат компанийн аж ахуйн үйл ажиллагаа нь олон тооны хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлыг хөнддөг тул нийтийн ашиг сонирхол болно гэж тогтоосон.

Эндээс нийтийн ашиг сонирхол бол нийгэм, түүний гишүүд өөрсдийн материаллаг, оюун санааны, гоо зүйн болон бусад хэрэгцээгээ хангахад нөлөөлж буй үнэт зүйл гэж үзэж болно.

Ашиг сонирхлын нийтийн байх шинж чанар агуулгын болон тоон бүрдүүлбэртэй. Эхнийхэд олон этгээдийн хувьд ач холбогдол бүхий үнэ цэнэтэй байхыг ойлгоно. Жишээлбэл, үндэсний эрүүл мэндийн асуудал нь олон хүн тамхи татахыг хүсч байгаа эсэхээс үл хамааран хамгаалагддаг. Энд хувь хүний тамхи татах хувийн ашиг сонирхолтой зөрчилдөх боловч амин чухал ашиг сонирхлыг хамгаалах хэрэг гарна.[6] Өмнө дурдсантай холбоотойгоор тоон бүрдүүлбэрийг ердийн арифметик тоогоор тооцох боломж байхгүй. Гол нь ганц нэг хүнд хамаатай хувийн ашиг сонирхол биш байх нь чухал.

Гэвч төрийн аппарат өөрсдийн байгууллагын ашиг сонирхлыг нийтийн ашиг сонирхол мэтээр ашиглах явдал цөөнгүй тохиолддог. Нийтийн гэх нэрийн дор төрийн албан хаагчид өөрсдийн ашиг сонирхлыг илэрхийлэх тохиолдол бас гардаг. Иймээс жинхэнэ нийтийн ашиг сонирхол болон төрийн байгууллагаас тунхаглаж буй ашиг сонирхлыг адилтгах боломжгүй нөхцөл үүсдэг. Үүнийг квази-нийтийн ашиг сонирхол гэж нэрлэх нь бий. Үүнд байгууллагад илүү орон тоог нэмэх зэрэг ойлголтыг хамруулдаг. Ийм тохиолдолд мөн нийтийн ашиг сонирхлыг хамгаалах хэрэг гарна.[7]

Иймээс ашиг сонирхлуудын тэнцвэрийг олох гол зарчмуудыг эрх зүйн хүрээнд бий болгох шаардлага гарч байна.

---o0o---

[6] М.С.Матейкович, В.А.Горбунов. Законные интересы в конституционном праве.-М.: Норма: ИНФРА-М, 2011. С.117, 120, 140.

[7] М.С.Матейкович, В.А.Горбунов. Законные интересы в конституционном праве.-М.: Норма: ИНФРА-М, 2011. С.152, 159.

3. Нийтийн ашиг сонирхлын мөн чанарын тухайд

Нийтийн ашиг сонирхлыг тодорхойлох явдал зөвхөн тоон хэмжүүрээр илэрхийлэгдэхгүй. Жишээлбэл, архи, тамхины хэрэглээг авч үзвэл манай улсын нийт хүн амын цөөнгүй хэсэг хэрэглэдэг. Хэрэв бид нийтийн ашиг сонирхол гэдгийг зөвхөн тоогоор илэрхийлж үзвэл төрөөс олонхи хүн амын сэтгэл зүйд нийцүүлж архи, тамхины хэрэглээг дээд хэмжээнд дэмжсэн хууль батлах байсан байж ч болох. Гэтэл архидан согтуурахтай тэмцэх, тамхины хууль энэ олонхийн сэтгэл зүйн эсрэг чиглэсэн. Энд үндэсний хүн амын эрүүл мэндийн ашиг сонирхлыг дээгүүрт тавьж байгаа нь харагдаж байна.

Эндээс төрөөс хүлээн зөвшөөрсөн, эрх зүйн зохицуулалт бүхий нийгмийн ашиг сонирхол бол нийтийн ашиг сонирхол байна гэж үзэж болох юм.[5]

Өгүүллийн эхэнд дурдсан хуулиудад нийтийн ашиг сонирхлын талаар зохицуулсан байдлаас харахад захиргааны эрх зүйд нийтийн ашиг сонирхлын концепц хэр их чухал болохыг олж харахад төвөггүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 6.4-т "Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно" гэж заасан. Эндээс үзэхэд тодорхой тохиолдолд нийтийн ашиг сонирхолд харшилсан бол субьектив эрхийг хязгаарлах боломжийг хуульчилсныг харж болох юм.

Нийтийн ашиг сонирхлыг тодорхойлох, түүнийг албан ёсоор хамгаалахад Үндсэн хуулийн шүүхийн үүрэг, нөлөө их байна. Учир Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр бол тухайн улсын эрх зүйн тогтолцоонд шийдвэрлэгч үүрэг гүйцэтгэж жишиг тогтоож болдог байна. Үүнийг бид ОХУ-ын хэдэн жишээнээс харж болох юм. Үүнд:

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх 2005 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 9 дүгээр тогтоолдоо "татвар төлөх үндсэн хуулийн үүрэг татварын үүргийн хүрээнд оршдог. Татвар төлөгчийн Үндсэн хуулийн үүрэг нь нийгмийн бүх гишүүдэд хамаатай нийтийн ашиг сонирхол болохын хувьд төрөөс татвар төлөгчийн болоод нийгмийн бусад гишүүдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор татварын эрх зүйн харилцааг зохицуулах арга хэмжээ авах эрхтэй байгаад зогсохгүй үүрэгтэй юм" гэжээ. Түүнчлэн 2004 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 379-О тогтоолд "цэргийн алба бол улс орны аюулгүй байдал, батлан хамгаалахтай нягт холбоотой нийтийн ашиг сонирхлын төлөө хэрэгжүүлж буй үүрэг" гэж тодорхойлсон байна. Мөн 2004 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 4 дүгээр тогтоолд "сонгох, сонгогдох эрхтэй холбоотой асуудлаар шүүхэд хандаж байгаа нь мөн чанарын хувьд нийтийн эрх зүйн харилцаанаас үүдэлтэй шаардлага мөн. Энэ үүднээс олон тооны иргэдийн ашиг сонирхлыг хөнддөгөөрөө нийгэмд үлэмж ач холбогдолтой. Иймээс энэ төрлийн маргааныг сонгуулийн процессын хүрээнд аль болох түргэн хугацаанд шийдэх шаардлагатай" гэсэн байна.

Энэ дагуу ОХУ-ын иргэдийн сонгуулийн эрхийн болон ард нийтийн санал асуулгын үндсэн баталгааны тухай хуулийн 78 дугаар зүйлд "сонгуулийн компанит ажлын явцад гомдлыг ерөнхий журмын дагуу санал авах өдрийн өмнөх өдрөөс хойш 5 хоногийн дотор, санал авах өдөр буюу санал авсны дараагийн өдөр бол нэн даруй шийдвэрлэнэ. Хэрэв гомдолд дурдсан фактыг нягтлан

[5] М.С.Матейкович, В.А.Горбунов. Законные интересы в конституционном праве.-М.: Норма: ИНФРА-М, 2011. С.67-68, 83, 89, 91-92.

МОНГОЛ УЛСЫН ГААЛИЙН БАЙГУУЛЛАГААС БАРААНЫ ТЭМДГИЙН ЗӨРЧИЛТЭЙ ДУУРАЙМАЛ БАРААГ САТУУЛАХ, УСТГАХ ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ, ПРОЦЕСС: ДХБ БА ТРИПС-ИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ХАРГАЛЗСАН ТАЙЛБАР, ДҮГНЭЛТ



Бельгийн Вант Улсад бүртгэлтэй оюуны өмчийн зөвлөгөө ба хууль зүйн туслан гүйцэтгэх үйлчилгээний бизнес эрхлэгч, Германы Оюуны өмчийн хамгааллын нийгэмлэгийн гишүүн, хуульч (Ph.D) Д.Уянга

А. Удиртгал буюу жишээ тохиолдол

"Ө" өмгөөллийн нөхөрлөлийн үйлчлүүлэгч Польш улсын компани "П" Монгол улсын Шадар Сайдын Х оны Х тоот тушаалын дагуу "Х" барааны тэмдгийг (барааны шошго, нэр, trademark) хүүхдийн тоглоомын бүтээгдэхүүний хувьд эзэмших барааны тэмдэг эзэмшигчийн онцгой эрхтэй. Монгол улсын "М" ХХК барааны тэмдэг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр "Х" барааны тэмдэг бүхий дуураймал тоглоомыг (trademark counterfeit goods) их хэмжээгээр оруулж ирж худалдаалж байсан. "П" компани барааны тэмдгийн зөрчилтэй тоглоомыг ачсан чингэлэг МОНГОЛ УЛСын хилээр нэвтрэх гэж байгааг олж мэдсэн тул "П"-ийн итгэмжлэлээр "Оюуны өмчийн зөрчилтэй бараа саатуулах" өргөдөл, хүсэлтийг "Ө" өмгөөллийн нөхөрлөлийн өмгөөлөгчид Гаалийн Ерөнхий газарт гаргажээ. Энэ өргөдөл, хүсэлтийн дагуу Гаалийн Ерөнхий Газрын шийдвэрээр Замын-Үүд дахь Гаалийн газар барааг хилээр нэвтрүүлэхгүй саатуулсан байна.

"П"-ийн зүгээс барааг худалдсан Унгарын компанид барааг буцааж илгээх эсвэл устгалд оруулж зөрчлийг арилгах шаардлага тавьжээ.

(1) "П"-ийн зүгээс барааг саатуулах өргөдөл, хүсэлт гаргах хууль зүйн үндэслэл, үүнтэй холбоотой Гаалийн байгууллагын эрх хэмжээг хуулиар хэрхэн тодорхойлсон бэ?

(2) "П" нь "М"-с буюу Гаалийн байгууллагаас барааг буцааж гаргахыг шаардах хууль зүйн үндэслэл юу вэ?

(3) "М" нь "П"-ийн шаардлагыг биелүүлэхгүй бол "П" ямар арга хэмжээ авахыг шаардах эрхтэй вэ?

(4) Олон улсад нийтлэг байдаг жишгээр барааны тэмдгийн зөрчил гаргагч зөрчлөө сайн дураараа арилгаагүй, барааны тэмдгийн зөрчил гаргаагүй гэж маргаагүй бөгөөд барааг устгалд оруулахыг өөрөө зөвшөөрсөн эсвэл шүүхийн шийдвэрээр барааны тэмдгийн зөрчилтэй гэж үзэж устгалд оруулахаар шийдсэн бол барааг устгалд оруулж, худалдааны эргэлтээс бүр мөсөн зайлуулдаг. Харин Монгол Улсын хуулиар барааг устгалд оруулах хууль зүйн үндэслэл, процедур ямар байх вэ?

Оюуны өмчийн худалдааны асуудлаарх хэлэлцээр (The Agreement

on Trade-Related Aspects of Intellectual Property Rights (TRIPS), цаашид ТРИПС-ийн хэлэлцээр гэнэ) бол Дэлхийн худалдааны байгууллагыг (цаашид ДХБ гэнэ) байгуулах тухай 1994 оны хэлэлцээрийн салшгүй хэсэг бөгөөд ДХБ-ын гишүүн бүр ТРИПС-ийн гишүүн байдаг.[1] Монгол Улс ба Польш Улс нь ДХБ-ын гишүүд тул Польшийн компаниуд Монгол Улсад ТРИПС-ийн стандартад нийцсэн хамгаалалттай байх зарчимтай. Иймээс ТРИПС-ийн хэлэлцээрийг шууд хэрэглэх асуудал, ТРИПС-ийн хэлэлцээрийн стандартын талаар доорх (A) хэсэгт авч үзэв.

Нийтлэлийн (B) хэсэгт гаалийн байгууллагаас оюуны өмчийн зөрчилтэй барааг саатуулах хууль зүйн үндэслэл, процедур, (C) хэсэгт барааг буцаах шаардлага тавих барааны тэмдэг эзэмшигч, гаалийн байгууллагын эрх, хууль зүйн үндэслэл, (D) хэсэгт саатуулсан барааг устгах өргөдөл, хүсэлт гаргах хууль зүйн үндэслэл, процессыг тус тус тайлбарлаж, эцэст нь хураангуй дүгнэлтийг (E) хэсэгт багтаав.

Хавсралт (F) хэсэгт оюуны өмчийн хэрэгжилтийг хил дээр хангахад холбогдох ТРИПС-ийн хэлэлцээрийн холбогдох заалтуудыг орчуулж, хавсаргасан.

B. Оюуны өмчийн худалдааны асуудлаарх хэлэлцээр (ТРИПС)

I. Хэлэлцээрийг Монгол улсын шүүх, гаалийн байгууллага, оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шууд хэрэглэх асуудал

1. Хэлэлцээрийн давуу хүчинтэй байдал

ТРИПС-ийн хэлэлцээр нь урьд өмнө үйлчилж байсан олон талт оюуны өмчийн олон улсын хэлэлцээрийг өөрийн салшгүй хэсэг болгож нэгтгэсэн.[2] Иймээс барааны тэмдгийн хувьд Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах Парисийн 1967 оны хэлэлцээрийн (Paris Convention for the Protection of Industrial Property) гишүүд мөн дагаж мөрддөг.

Монгол Улсад олон улсын гэрээний зүйл, заалт дотоодын хуулиас давуу хүчинтэй байх, дотоодын хууль олон улсын гэрээтэй зөрчилдсөн үед олон улсын гэрээний заалтыг хэрэглэх ерөнхий зарчим үйлчилж ирсэн уламжлал бий. Энэ зарчмыг Барааны тэмдгийн хамгаалалттай холбогдох дараах хуулиудад шууд зааж өгсөн байдаг.

-Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 2-р зүйлийн 2.2-р заалт

-Гаалийн тухай хуулийн 2-р зүйлийн 2.2-р заалт;

-Иргэний хуулийн 2-р зүйлийн 2.2-р заалт;

-Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 2-р зүйлийн 2.2-р заалт;

-Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2-р зүйлийн 2.2-р заалт.

2. Хэлэлцээрийг Монгол Улсын шүүх, гаалийн байгууллага шууд хэрэглэх асуудал

Дотоодын хуулиар Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэхээр зааж өгсөн нь ийнхүү ТРИПС-ийн хэлэлцээрийг шууд хэрэглэнэ гэсэн үг хараахан биш юм. Учир нь олон улсын гэрээ өөрийн мөн чанарын хувьд хувь хүн, хуулийн этгээдэд холбогдсон субъектив эрх, үүрэг үүсгэхгүй зөвхөн олон улсын эрх зүйн субъект болох гэрээний талуудад (улс гүрнүүдэд, олон улсын байгууллагад) эрх, үүрэг үүсгэсэн чанартай байж болно.[3] Нөгөө талаас, хэдийгээр утга агуулгынхаа хувьд хувь хүн, хуулийн этгээдийн

[1] Art. 2 Para 2 of the Agreement Establishing the World Trade Organisation and Annex IC.

[2] Art. 3 Para 3 TRIPS Agreement.

[3] Mathias Herdegen, Vulkerrecht, 8 Auflage, Mьnchen 2009, S. 158, Rn. 5.

өгч байсан.[7] Оюуны өмчийн хуулиуд, үүний дотор Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, Гаалийн тухай хуулийг ТРИПС-ийн хэлэлцээрт нийцүүлэхийн тулд өөрчилж байсан. Ингэхээр барааны тэмдгийн эрхийн хэрэгжилттэй холбоотой дотоодын хууль тогтоомжийг аль болох ТРИПС-ийн хэлэлцээрт ойртуулж ойлгож, тайлбарлах нь дотоодын хуулийг анхдагч эх сурвалжид нь дөхүүлж зөв ойлгоход тустай гэсэн үг юм. Үүний дээр хуулийг олон улсын хэлэлцээрт нийцүүлж тайлбарлах нь олон улсын нийтлэг стандартыг дагаж, хэрэгжүүлж, улсынхаа олон улсын өрсөлдөх чадварт хуульчид, шүүгчид өөрийн хувь нэмрээ оруулж байна гэсэн үг билээ.

Дотоодын хуулийг ТРИПС-ийн хэлэлцээрт нийцүүлж тайлбарлахыг эрмэлзсэн хэдий ч хуулийн заалт шууд утгаараа, ерөнхий логикоороо хэлэлцээрийн заалттай шууд зөрчилдөж байвал дараагийн шатанд ТРИПС-ийн хэлэлцээрийг шууд хэрэглэх буюу ТРИПС-ийн хэлэлцээр дотоодын хуулиас давуу хүчтэй байх тухай асуудал яригдана.

II. ТРИПС-ийн хэлэлцээрийн хэрэглэх хүрээ, хэлэлцээрийн дагуу эрх эдлэх субьект

Оюуны өмчийн олон улсын эрх зүйн салбарын үндсэн суурь зарчим бол “газар нутгийн зарчим”(territoriality principle) юм. Энэ зарчмын дагуу оюуны өмчийн эрхийн агуулга, хүрээ, хязгаар, хэрэгжүүлэх арга замыг тухайн улс өөрийн хилийн дотор өөрийн дотоодын хуулиараа зохицуулна. Дэлхий даяар нэгдсэн нэг оюуны өмчийн эрх гэж байхгүй. Өөрөөр хэлбэл, LOUIS VUITTON, OMEGA, NIKE гэж дэлхий даяар үйлчилдэг нэг барааны тэмдэг гэж байхгүй. Энэ нь дэлхийн улс тус бүрд бүртгэлд үндэслэж үүссэн олон багц хамгаалалт юм.

Дан ганц газар нутгийн зарчим үйлчилсэн орчинд улс орнууд оюуны өмчийн хуулиараа гадаад иргэд, компанийг ялгаварлан гадуурхаж, тэдний эрхийг дотоодын иргэд, компаниас дордуулж хамгаалах нөхцөл бий болдог. Олон улсын олон талт хэлэлцээрүүд нь юуны өмнө ийнхүү ялгаварлан гадуурхахыг зогсоож, гадаадын зохиогчид, зохион бүтээгчид, барааны тэмдгийн эрх эзэмшигч компанийн эрхийг дотоодынхтой ижил байлгах зорилготой байдаг(“үндэсний тааламжтай нөхцөл”, “national treatment”). ТРИПС-ийн хэлэлцээр мөн адил энэхүү үндэсний тааламжтай нөхцөлийг бий болгох зорилттой учир ТРИПС-ийн хэлэлцээрийн 3-р зүйлийн 1-р заалтын дагуу ДХБ-ын гишүүн орны харьяат хувь хүн, хуулийн этгээд Монгол Улсад тус улсын хувь хүн, хуулийн этгээдийн адил эрх эдэлнэ.

ТРИПС-ийн хэлэлцээрээр үндэсний тааламжтай нөхцөлийг баталгаажуулаад зогсохгүй үүн дээр нэмж ДХБ-ын гишүүн улсын гадаадын иргэд, хуулийн этгээд Монгол Улсад эдлэх “наад захын эрхийг”(minimum standards of protection) зааж өгсөн.[8] Энэхүү эрхийг Монгол Улсад тус улсын харьяат иргэд, хуулийн этгээд эдлэхгүй, харин үндсэн зарчмын хувьд ДХБ-ын гишүүн улсын харьяат гадаадын иргэд, хуулийн этгээд эдэлнэ.[9] Хэлэлцээрийн үндсэн зорилго нь дэлхий нийтийн стандартыг гадаад этгээдийн эрхийг хамгаалснаар тогтоох явдал. Үүний цаад санаа нь ямар ч улс өөрийн улсын харьяатын эрхийг гадаадын иргэдийнхээс дордуулахгүй байх эрмэлзэлтэй байх тул дотоодын хуулиа хэлэлцээрийн стандартад хүргэж өөрчлөлт, шинэчлэл хийх нь зайлшгүй гэсэн гаргалгаа юм.

[7] World Trade Organisation, IP/Q/MNG/1; IP/Q2/MNG/1; IP/Q3/MNG/1; IP/Q4/MNG/1 (26 March 1999): Review of Legislation, Mongolia; IP/Q3/112/Add.2 (10 December 1998); IP/C/W/115 (12 December 1998) https://docs.wto.org/, last view on 10 November 2016.

[8] Art. 1 Para 1 TRIPS Agreement; ТРИПС-ийн хэлэлцээрийн 1-р зүйлийн 1-р заалтын 2 дахь өгүүлбэр.

[9] Art. 1 Para 3 TRIPS Agreement; ТРИПС-ийн хэлэлцээрийн 1-р зүйлийн 3-р заалт.

эрхийг хангахад чиглэсэн ч гэсэн олон улсын гэрээ нь үг, өгүүлбэр найруулга, ерөнхий агуулгын хувьд ийм субъектив эрх үүсгэхэд чиглээгүй, шүүх шууд хэрэглэх боломжгүй, ойлгомжгүй эсвэл агуулгаараа зөвхөн олон улсын гэрээний талуудад үүрэг, даалгавар өгсөн утгатай байж болно.[4]

Аливаа олон улсын гэрээгээр ямар субьектэд зориулж эрх, үүрэг үүсгэж байна вэ? гэсэн асуултад тухайн олон улсын гэрээг тайлбарлах замаар буюу гэрээний талуудын хүсэл зоригийг илрүүлэх замаар хариулна. Олон улсын гэрээг тайлбарлах дэлхий нийтийн жишиг, стандартыг Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцийн 31-33-р зүйлүүдээр тогтоосон.[5] Монгол Улс нь тус конвенцийн гишүүн юм.

ТРИПС-ийн хэлэлцээрээр барааны тэмдэг эзэмшигч, зөрчил гаргагч, гуравдагч этгээд ДХБ-ын нэг гишүүн улсын хил хязгаарын дотор шууд эдлэх эрхийг зааж өгөөгүй. Харин энэ асуудлыг тухайн улс орны олон улсын гэрээг хэрэглэх тухай дотоодын хуулиар шийднэ.

Жишээ нь:

Европын 25 улсыг нэгтгэсэн, хил гаалиа нэгтгэж, дотоодын нэг том зах зээлийг бий болгосон Европын холбоо нь ДХБ/ТРИПС-ийн хэлэлцээрийн гишүүн юм. Европын Шударга Ёсны Шүүх (European Court of Justice) буюу Европын холбооны Дээд шүүх Hermes, Parfums Dior, Shievering-Nijstad гэсэн шийдвэрүүдээр Европын Холбооны гишүүн улсуудын хууль ТРИПС-ийн хэлэлцээрт нийцэж байна уу, ТРИПС-ийн хэлэлцээрээр хувь хүн, хуулийн этгээд шууд эдлэх субьектив эрх үүсгэсэн үү? өөрөөр хэлбэл ТРИПС-ийн хэлэлцээрийг шүүх шууд хэрэглэх эрхтэй юу? боломжтой юу? гэсэн асуултад зарим талаар хариулсан.[6] Hermes шийдвэрт Европын Холбооны Шударга Ёсны Шүүх ТРИПС-ийн хэлэлцээрийн 50-р зүйлийн 6-дахь заалтад заасан хугацаа шууд дуусахгүй, холбогдох хэргийн хариуцагч ийнхүү саатуулах арга хэмжээг дуусгавар болгох хүсэлт өөрөө гаргах ёстой гэж заасан. Parfums Dior шийдвэрт Европын Холбооны шүүх ТРИПС-ийн хэлэлцээрээр хувь хүн, хуулийн этгээд шууд эдлэх эрх, үүрэг үүсгэсэн үү? гэсэн асуултад энэ нь Холбооны холбогдох улсын дотоодын хуулийн асуудал, Европын холбооны хуулиар ингэж шууд хэрэглэх шаардлага тавихгүй гэж хариулсан байдаг.

Монгол Улсын Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль ба барааны тэмдгийн эрхийн хэрэгжилттэй холбоотой холбогдох бусад хуулиудад дээр дурдсанчлан дотоодын хуулийн заалт ТРИПС-ийн хэлэлцээрт нийцэхгүй бол хэлэлцээрийг баримтална гэж заажээ. ТРИПС-ийн хэлэлцээрийн аливаа заалт нь хувь хүн, хуулийн этгээдэд эрх үүсгэж, агуулгын хувьд шүүх, төрийн байгууллага шууд хэрэглэхүйц тодорхой бол түүнийг шууд хэрэглэнэ гэсэн гаргалгаа үүнээс гарч байна.

3. Дотоодын хуулийг хэлэлцээрт нийцүүлж тайлбарлах

ТРИПС-ийн хэлэлцээрийг шууд хэрэглэхээс ялгаатай өөр нэг асуудал бол дотоодын хуулийг ТРИПС-ийн хэлэлцээрт нийцүүлж тайлбарлахыг эрмэлзэх явдал юм. Монгол Улс ДХБ-д нэгдэж орсны дараа 1999, 2000 онуудад ТРИПС-ийн хэлэлцээрийн биелэлтийг дотоодын хуулиар хангах талаар ДХБ-д илтгэл, мэдээлэл, асуулгын хариулт

[4] Mathias Herdegen, Vulkerrecht, 8.Auflage, Mьnchen 2009, S. 158, Rn. 5.

[5] Vienna Convention on the Law of Treaties.

[6] Case C-53/96 Hermes International v FHT Marketing Choise BV 1998 ECR I-3603; Case C-300/98 & C-392/98 Parfumes Christian Dior SA v Tuk Consultancy BV, Asso Gerьste GmbH 2000 ECR I-11307; Case C-89/99 Schievering-Nijstad VOF v Robert Groeneveld 2001 ECR I-5851.

(д) бараа саатуулах хүсэлтэд барааны тэмдэг эзэмшигчийн эрх зөрчигдөхөөр байна гэсэн нотолгоог хавсаргасан байх (52-р зүйл),

(е) бараа саатуулах хүсэлтэд гаалийн байгууллагаас барааг таних боломжтой барааны тодорхойлолтыг хавсаргасан байх (52-р зүйл),

(ё) Эрх эзэмшигчээр мөнгөн барьцаа эсвэл түүнд дүйцэх баталгааг гаргуулсан байх (53-р зүйл)

ТРИПС-ийн хэлэлцээрийн 53-р зүйлд заасан мөнгөн барьцаа, баталгааны зорилго нь барааны тэмдгийн зөрчилтэй бараа орж ирж байна гэсэн мэдээлэл нь буруу байснаас Гаалийн байгууллага аливаа гуравдагч импортлогчид хохирол учруулсан бол тэр хохирлыг Барааны тэмдэг эзэмшигчээр (бараа саатуулах хүсэлтийг Гаалийн байгууллагад гаргасан этгээдээр) өөрөөр нь төлүүлэх баталгаа болгож авдаг. Ингэхдээ заавал барьцаа, баталгаа авч байж бараа саатуулах үйл ажиллагаа эхэлнэ гэсэн үг биш юм.[11] Жишээ нь: Европт шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтаар импортоор орж ирж байгаа бараа нь эрхийн зөрчилтэй нь хангалттай нотлогдож байвал шүүхээс ийм барьцаа, баталгаа гаргахыг шаарддаггүй.[12] Нөгөө талаар гуравдагч этгээдэд учирч болзошгүй хохирлын хэмжээнээс хамаарч шүүхээс барьцаа, баталгааны мөнгөн дүнг янз бүрээр тогтоодог практик Европт байдаг ба энэ мөнгөн дүн нь монголын практикт байдаг шиг тогтсон мөнгөн дүн биш, харин тухайн нөхцөл байдлаас хамаарч зөрчил гаргасан гэгдэх импортлогчийн эрх ашгийг хамгаалахуйц хэмжээний өндөр барьцаа ч байж болно (үүнийг шүүгч нөхцөл байдлыг үнэлж шийддэг).

Дүгнэвэл, ТРИПС-ийн хэлэлцээрийн 51, 52-р зүйлд заасны дагуу буюу дээрх I-ийн (а)-(е)-д заасан урьдчилсан нөхцөлийг хангасан үед бараа саатуулах хүсэлтийг шүүх эсвэл холбогдох эрх бүхий байгууллага (монголын хувьд Гаалийн Ерөнхий Газар (ГЕГ) хүлээн авна. Барьцаа, баталгаа буюу дээр (ё)-д заасан нөхцөлийг тухайн нөхцөл байдлаас хамааралтайгаар хангахыг шаардаж болно.

2. Бараа саатуулсан хүсэлтийг хүлээж авсан эсэхийг мэдэгдэх

Бараа саатуулах ажиллагааг явуулах үндсэн шаардлагуудыг хангаж байгаа үед шүүх эсвэл холбогдох эрх бүхий байгууллага (Монгол улсын хувьд ГЕГ) хүсэлтийг хүлээж авсан эсэх тухай буюу бараа саатуулах болсон тухай шийдвэрийг хүсэлт гаргагчид мэдэгдэх үүрэгтэй (ТРИПС-ийн хэлэлцээрийн 52-р зүйл).[13] Ингэхдээ мэдэгдлийг "нөхцөл байдлыг ухаалгаар шинжилж үзсэний үндсэн дээр анхаарах ёстой хугацааны" дотор хүсэлт гаргагчид танилцуулах ёстой. Энэ нь богино хугацааны тухай буюу хэдэн өдрийн дотор мэдэгдэх үүрэг үүснэ гэсэн утгатай.[14]

Дүгнэвэл, манай жишээ тохиолдлын хувьд ГЕГ нь "П"-ийн гаргасан бараа саатуулах өргөдөл, хүсэлтийг хүлээж авсан эсэх тухай "П"-д бичгээр мэдэгддэг байвал Монгол улсын ГЕГ олон улсын стандартын дагуу ажиллажээ гэж үзнэ. Хүсэлтийг хүлээж авахгүй бол ГЕГ нь ТРИПС-ийн хэлэлцээрийн 41-р зүйлийн 3-р заалтын дагуу үндэслэлийг зааж, Барааны тэмдэг эзэмшигч "П"-д бичгээр мэдэгдэнэ. Түүнчлэн саатуулах арга хэмжээг авах хугацааг арга хэмжээ авах тухай шийдвэрт зааж өгсөн бол ГЕГ бараа саатуулах арга хэмжээ хэдийд авах талаар мэдээллийг "П" өгөх үүрэгтэй.

3. Барааг саатуулсан тухай мэдэгдэх үүрэг

54-р зүйлийн дагуу ДХБ-ын гишүүн

[11] ibid. p. 63, Para 3.43.

[12] ibid. p. 63, Para 3.44.

[13] ibid. p. 63, Para 3.44.

[14] ibid. p. 62, Para 3.39.

Дүгнэвэл, манай жишээ тохиолдлын хувьд Польш Улс нь ДХБ-ын гишүүн улс юм. "ТАТАТА" барааны тэмдгийг "газар нутгийн зарчмын" дагуу Монгол Улсад бүртгүүлж, Монгол Улсын барааны тэмдгийн эрх олж авсан Польш улсын "П" компани нь Монгол Улсад бүртгэлтэй дотоодын компаниудын адил Монгол Улсын хуулийн хамгааллыг эдэлж, "үндэсний тааламжтай нөхцөлөөр" эрхээ хамгаалуулна. Улмаар "П" компани Монгол улсын нутаг дэвсгэрт ТРИПС-ийн хэлэлцээрийн дагуу "наад захын эрхийг" ТРИПС-ийн хэлэлцээрийн 1-р зүйлийн 3-р заалтын дагуу эдэлнэ. Өөрөөр хэлбэл, Монголын төрийн эрх бүхий байгууллагууд "П"-ийн эрхэд холбогдож ТРИПС-ийн стандартыг биелүүлж хангах, олон улсын үүрэгтэй. Ингэхдээ юуны өмнө дотоодын хууль тогтоомжийг ТРИПС-ийн стандартад нийцүүлж, ойртуулж тайлбарлахыг эрмэлзэх хэрэгтэй. Иймхүү хүчин чармайлт гаргасан хэдий ч дотоодын хууль тогтоомж ТРИПС-ийн стандартыг хангахгүй бол ТРИПС-ийн хамгаалалтыг "П" шууд эдлэхийг шаардах эрхтэй. Гэвч ТРИПС-ийн холбогдох зүйл, заалт нь агуулгын хувьд шууд хэрэглэх хэмжээний тодорхой эсэхээс энэ нь хамааралтай гэдгийг анхаарах чухал. Нөгөө талаас нэн ялангуяа Улсын Дээд шүүх нь европын дээд шүүхүүдийн нэгэн адил хэрэг маргааныг хууль тайлбарлах замаар шийдвэрлэж, хуулийг нэг мөр хэрэглэх улсын доторх нэгдсэн практик тогтоодоггүй монголын нөхцөлд дотоодын хууль тогтоомж байхгүй нь эрх зүйн тодорхой бус байдлыг бий болгож, олон улсын гэрээний үүргийг биелүүлэхгүй байсаар байх нөхцөл байдлыг бий болно гэдэгтэй эвлэрэхээс өөр аргагүй болно.

III. ТРИПС-ийн хэлэлцээрийн дагуу барааны тэмдгийн зөрчилтэй барааг хил дээр саатуулах үндсэн нөхцөл, стандарт

Бидний жишээ тохиолдлын хувьд "П" компани барааны тэмдгийн зөрчилтэй гэж үзэж, "М" компанийн оруулж ирэх тоглоомыг хил дээр саатуулж, улсын хилээр оруулахгүй байхыг хүсэж Гаалийн байгууллагад ханджээ. ТРИПС-ийн хэлэлцээрийн дагуу ийм хүсэлт, гомдлыг тухайн улсын холбогдох эрх бүхий байгууллага хүлээж авч, ажиллагаа явуулахад холбогдох наад захын стандартыг тогтоосон байдаг.[10]

1. Бараа саатуулах ажиллагааг явуулах ерөнхий нөхцөл, стандарт

ТРИПС-ийн хэлэлцээрийн 51-р зүйлийн дагуу ДХБ-ын гишүүд өөрийн шүүх эсвэл холбогдох захиргааны байгууллагад барааны тэмдгийн зөрчилтэй барааг саатуулах эрхийг олгоно. Үүний дагуу шүүх, захиргааны байгууллага дараах бүх нөхцөлүүд биелсэн үед Гаалиас бараа саатуулах арга хэмжээг авах эрхтэй буюу үүрэгтэй:

(а) Холбогдох улсад хүчин төгөлдөр бүртгэлтэй барааны тэмдгийн эрхийг зөрчсөн байх (51-р зүйл). Энэ нөхцөлийн дагуу Монгол Улсын хувьд эхлээд Оюуны өмчийн газраас барааны тэмдгийн гэрчилгээ олгосон эсэхийг шалгана.

(б) ижил бараанд ижил барааны тэмдгийг хэрэглэсэн байх буюу ижил эсвэл төсөөтэй бараанд үндсэн шинжээрээ ялгагдахгүй ижил эсвэл төсөөтэй барааны тэмдгийг хэрэглэсэн байх бөгөөд энэ нь Монгол Улсын хуулийн дагуу барааны тэмдэг эзэмшигчийн эрхийг зөрчсөн байх (51-р зүйл),

(в) дээр (а), (б)-д заасан барааны тэмдгийн зөрчилтэй бараа импортоор орж ирэх гэж байна гэсэн үндэслэл бүхий таамаглал байх(51-р зүйл),

(г) барааны тэмдэг эзэмшигч бичгээр хүсэлт гаргасан байх(51-р зүйл),

[10] Olivier, Vrigins/Marius Schneider (ed.), Enforcement of intellectual property rights through border measures – Law and Practice in the EU, Oxford University Press 2012, p. 55

орны шүүх ба холбогдох байгууллага (Монгол улсын тухайд Гаалийн Ерөнхий газар) Барааны тэмдгийн зөрчилтэй байж болох барааг барааны тэмдэг эзэмшигчийн хүсэлтийн дагуу саатуулсан тохиолдолд ингэж саатуулсан тухай импортлогч ба хүсэлт гаргасан барааны тэмдэг эзэмшигчид нэн даруй мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдэхдээ болж өгвөл бичгээр мэдэгдэх ба ямар ч тохиолдолд нэн даруй мэдэгдэх үүрэг үүснэ.[15]

Оюуны өмчийн эрхийн тухайд төрөөс хүний хувийн өмчийн эрхийг хамгаалахад шууд оролцож байгаа юм. Иймээс Гаалийн байгууллагаас оюуны өмчийн эрхийн зөрчилтэй барааг саатуулах үед энэ талаар эрх эзэмшигчид тухай бүр мэдэгдэх ёстой байдаг. Хэрэв эрх эзэмшигч өөрөө барааг саатуулах шаардлагагүй гэж мэдэгдвэл эсвэл хуульд заасан хугацааны дотор эрх эзэмшигч ямар нэг хариу өгөөгүй бол саатуулсан барааг шууд суллаж өгдөг хууль, журам жнь: Европт үйлчилдэг.

Дүгнэвэл, манай жишээ тохиолдлын хувьд Монгол улсын ГЕГ нь эхлээд "П"-ын бараа саатуулах, өргөдөл хүсэлтийг хүлээж авсан бол энэ тухай ТРИПС-ийн хэлэлцээрийн 52-р зүйлийн дагуу бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Ингэж мэдэгдсэнээс хойш барааг саатуулах ажиллагааг явуулж, барааг саатуулсан бол хоёр дахь мэдэгдлийг "П"-д илгээх ба энэ хоёр дахь мэдэгдэлд ямар тоо, хэмжээний барааг, хэдний өдөр, хэрхэн саатуулсан тухай "П"-д ТРИПС-ийн хэлэлцээрийн 54-р зүйлийн дагуу мэдэгдэх үүрэгтэй.

4. Бараа саатуулах хугацаа

ТРИПС-ийн хэлэлцээрийн 55-р зүйлд эрх бүхий байгууллага барааны тэмдгийн эрхийн зөрчилтэй бараа саатуулах хугацааг зааж өгсөн.[16] Үүний дагуу барааг саатуулсан тухай мэдэгдлийг барааны тэмдгийн эзэмшигчид буюу өргөдөл, хүсэлт гаргагчид өгснөөс хойш 10 хоногоос илүү хугацаагаар барааг саатуулж болохгүй гэсэн зарчим үйлчилнэ.[17] Үндэслэл бүхий шалтгаан байвал барааг саатуулах шийдвэрийг анх гаргасан эрх бүхий байгууллага барааг дахин 10 хоногоор сунгаж саатуулж болно.[18] Барааг үүнээс илүү хугацаагаар саатуулах эрх анх гаргасан эрх бүхий байгууллагад байхгүй ба

(а) өргөдөл, хүсэлт гаргагч өөрөө эсвэл хариуцагчаас бусад өөр нэг процессын тал хянан шийдвэрлэх ажиллагаагаа эхлүүлсэн гэж шүүхээс эсвэл холбогдох захиргааны байгууллагаас анх саатуулсан байгууллагад мэдэгдсэн бол эсвэл

(б) саатуулах хугацааг гарах шийдвэрийг урьдчилан баталгаажуулах эрх бүхий байгууллагын шийдвэрээр сунгасан бол барааг цааш үргэлжлүүлэн саатуулж болно.

Дүгнэвэл, манай жишээ тохиолдлын хувьд 54-р зүйлийн дагуу бараа саатуулсан тухай Монгол улсын ГЕГ-ийн мэдэгдлийг "П" хүлээж авснаас хойш ГЕГ нь "П"-ын барааны тэмдгийн эрхийг зөрчсөн "М"-ийн хүүхдийн тоглоомын барааг 10-аас дээш өдрөөр хил дээр саатуулах эрхгүй байна. ГЕГ үндэслэл бүхий шалтгаан байгаа бол (ихэнхи тохиолдолд "П"-ийн өмгөөлөгчдийн үндэслэл бүхий хүсэлтийг хүлээж авснаар) барааг дахин 10 өдөр саатуулж болно. ТРИПС-ийн логик, системээр авч үзвэл саатуулах хүсэлт гаргагч "П"-ийн өмгөөлөгчид энэ хугацааны дотор зөрчил таслан зогсоох, хохирол нөхөн төлүүлэх гэх мэт нэхэмжлэлийг иргэний хэргийн шүүхэд хандаж гаргасан эсвэл саатуулсан барааг хэрхэх талаар шүүгчийн захирамж гаргуулж авсан гэж 10 буюу цаад тал нь 20 хоногийн дотор ГЕГ-д мэдэгдээгүй бол ГЕГ барааг "М"-д суллаж өгөх үүрэгтэй.

[15] ibid. p. 62, Para 3.39.

[16] ibid. p. 65, Para 3.51.

[17] ibid. p. 65, Para 3.51.

[18] ibid. p. 65, Para 3.51.

5. Импортлогч буюу хариуцагчид өөрийгөө өмгөөлөх боломж олгох

Барааг саатуулсны дараа саатуулсан барааг хэрхэх талаарх шийдвэрийг гаргах процессыг эхлүүлсэн бол импортлогч буюу хариуцагчид өөрийгөө өмгөөлөх боломжийг олгож, түүний хүсэлтээр барааг саатуулах арга хэмжээг өөрчилж, хүчингүй болгож эсвэл хүчин төгөлдөр үлдээх талаар үйл ажиллагаанд тохирсон хугацааны дотор шийдвэр гаргах үүргийг ТРИПС-ийн гишүүн улсын шүүх эсвэл холбогдох захиргааны байгууллага 55-р зүйлийн дагуу хүлээдэг.

Дүгнэвэл, манай жишээ тохиолдлын хувьд "М"-д өөрийгөө өмгөөлөх боломжийг олгох үүрэгтэй. Энд анхаарах зүйл бол ТРИПС-ийн хэлэлцээрийн цаад логик, систем нь монголд байдаг шиг шүүхийн хяналтгүй захиргааны ажиллагаа бус харин шүүхийн хяналтад байх ажиллагаанд оршдог. Иймээс өөрийгөө өмгөөлөх эрхийг Иргэний хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаагаар хангадаг ба Гаалийн байгууллага шүүхийг орлож, хэрэг маргаан шийдэхгүй гэсэн сэтгэлгээ, зарчмын үндсэн дээр ТРИПС-ийн хэлэлцээрийн текст боловсруулагдсан гэдгийг энд анхаарна уу.

6. Саатуулсан бараатай танилцах боломжийг олгох үүрэг

Өргөдөл, хүсэлт гаргагч өөрийн гомдол, шаардлагыг үндэслэх зорилгоор Гаалиас саатуулсан бараатай танилцах эрхтэй.[19] Ийм эрхийг импортлогч өргөдөл, хүсэлт гаргагчийн нэгэн адил ТРИПС-ийн хэлэлцээрийн 57-р зүйлийн дагуу эдлэх эрхтэй байдаг.[20]

Дүгнэвэл, манай жишээ тохиолдлын хувьд Монгол улсын ГЕГ нь "П" ба "М"-ийн аль алинд нь саатуулсан барааг үзэж танилцаж, барааны тэмдгийн зөрчилтэй эсэх буюу зөрчилгүй эсэх талаар үндэслэл, нотолгоо гаргах боломжийг олгоно.

IV. ТРИПС-ийн хэлэлцээрийн дагуу барааны тэмдгийн зөрчилтэй барааг саатуулсны дараах процессын зохицуулалт

Манай жишээ тохиолдлын хувьд Гаалийн байгууллага барааны тэмдгийн зөрчилтэй гэгдэх тоглоомыг "М" компани хилээр оруулж ирэх үед Монгол улсын ГЕГ барааг хилээр нэвтрүүлэхгүй, саатуулсны дараа ГЕГ ямар процессын алхам хийх вэ?

ТРИПС-ийн хэлэлцээрийн текстийг Европт болон өрнөдийн хөгжсөн орнуудад байдаг оюуны өмчийн хэрэгжилтийн ерөнхий жишиг, стандартад тулгуурласан ойлголт, зарчимд үндэслэж боловсруулсан. ТРИПС-ийн хэлэлцээрийн агуулгыг ойлгохын тулд юуны өмнө Европын холбооны процессыг жишээ болгож танилцуулья.

1. Европын жишээ

Европын холбооны хувьд оюуны өмчийн эрхийг Гаалийн байгууллагын шугамаар хэрэгжүүлэхтэй холбоотой нэгдсэн журам байдаг (EU Regulation No 608/2013).[21] Энэ журмын дагуу дараах 3-н нөхцөлийг зэрэг хангасан үед Гаалийн байгууллага холбогдох процедурын дагуу барааны тэмдгийн зөрчилтэй барааг устгадаг:[22]

Нэгдүгээрт, Гаалиас барааг саатуулсан тухай мэдэгдлийг авсны дараа 10 хоногийн дотор эрх эзэмшигч буюу бараа саатуулах өргөдөл, хүсэлт гаргагч саатуулсан бараа нь өөрийнх нь оюуны өмчийн эрхийг зөрчсөн гэж үзэж байгаагаа Гаалийн байгууллагад бичгээр мэдэгдсэн,

Хоёрдугаарт, Гаалиас барааг

[19] ibid. p. 66, Para 3.59.

[20] ibid. p. 66, Para 3.59

[21] EU Regulation No 608/2013, http://eur-lex.europa.eu/LexUriServ/LexUriServ.do?uri=OJ:L:2013:181:0015:0034:en:PDF, last view on 11 Nov. 2016

[22] Art. 23 EU Regulation No 608/2013; Olivier, Vrigins/Marius Schneider (ed.), Enforcement of intellectual property rights through border measures – Law and Practice in the EU, Oxford University Press 2012, p. 202, Para 5.444.

гаргана. Ингэхдээ 46-р зүйлд зааснаар барааны тэмдгийн зөрчлийн үед зөвхөн онцгой тохиолдолд л бараан дээрх барааны тэмдгийг хуулж авах замаар барааг чөлөөт эргэлтэд оруулж болно гэсэн хэлэлцээрийн үүргийг анхаарах ёстой байдаг.

Барааны тэмдгийн зөрчлийг таслан зогсоох буюу зөрчилтэй барааг устгах процессыг шүүхийн шугамаар хангахаас гадна захиргааны журмаар хангах эрх чөлөөг улс орнууд ТРИПС-ийн хэлэлцээрийн 49-р зүйлийн дагуу эдэлдэг. Ингэхдээ холбогдох захиргааны процесс нь өөрөө ТРИПС-ийн хэлэлцээрт нийцэж байх ёстой байдаг.

Дүгнэвэл, Манай жишээ тохиолдлын хувьд "М" нь "П"-ийн барааны тэмдгийн эрхийг зөрчсөн бөгөөд ийнхүү зөрчөөгүй гэж маргаагүй бол ТРИПС-ийн хэлэлцээрийн дагуу барааг устгалд оруулна. Ингэхдээ "М" ба "П" нь харилцан тохиролцож барааг Монгол улсын хилээр оруулахгүйгээр буцааж болох талаар ТРИПС-ийн хэлэлцээрт шууд заагаагүй бөгөөд, ийм боломжийг ТРИПС-ийн хэлэлцээрээр хаагаагүй. ТРИПС-ийн хэлэлцээрийн дагуу барааг зарчмын хувьд Гаалийн байгууллага 10 хоног л хадгалах үүрэгтэй бөгөөд энэ хугацаанд "М" амжиж "П"-ийн эрхийг зөрчөөгүй гэж гомдол, нэхэмжлэл гаргах үүрэгтэй. Европын Холбооны жишиг, стандартаар "М" нь 10 хоногийн дотор ямар нэг гомдол, нэхэмжлэл гаргаагүй бол барааны тэмдгийн зөрчилтэй барааг устгалд оруулдаг. Манай улсын тухайд ТРИПС-ийн хэлэлцээрт холбогдож ийм нарийн процессын зохицуулалт байхгүй байгааг доор (С) хэсгээс харна уу.

3. Шүүхээс гарах шийдвэрийн баталгаажуулах процедур

ТРИПС-ийн хэлэлцээрийн төслийг хөгжсөн орнуудын оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх стандарт, практикт үндэслэж боловсруулсан. Европт оюуны өмчийн зөрчлийг - хэрэв талууд хоорондоо асуудлаа зохицуулж чадахгүй бол - эрх эзэмшигч шүүхэд нэхэмжлэл гаргаж, шүүхийн шийдвэрээр зөрчил таслан зогсоох үйл ажиллагаа явагддаг. Гаалиас саатуулсан барааны тухайд -хэрэв саатуулсан бараа нь муудах бараа байвал мөн эрхийн маргаан гарсан бол - Монгол улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69-р зүйлтэй дүйцэх процедураар асуудлыг шийдвэрлэдэг. Энэ уламжлалд тулгуурлан ТРИПС-ийн хэлэлцээрт шүүхээс гарах шийдвэрийг урьдчилан баталгаажуулах процедурын стандартыг дэлхий даяар тогтоосон. Холбогдох заалтын буюу хэлэлцээрийн 50-р зүйлийн орчуулгыг хавсралт (F) хэсгээс харна уу.

V. ТРИПС-ийн хэлэлцээрт заасан процедурын бусад шаардлагууд

ТРИПС-ийн хэлэлцээрээр Оюуны өмчийн буюу барааны тэмдгийн хэрэгжилтийг хангах шүүхийн ба захиргааны процедурт тавих ерөнхий шаардлага, стандартыг зааж өгсөн. Эдгээр нь:

-чөлөөт, шударга өрсөлдөөнийг хангах шаардлага буюу оюуны өмчийн хэрэгжилтийг хангах процедур нь өөрөө зүй ёсны худалдаанд саад учруулж болохгүй бөгөөд оюуны өмчийн эрхийг буруугаар ашиглах нөхцөлийг бүрдүүлж болохгүй (41-р зүйл, 1-р заалт).

-оюуны өмчийг хэрэгжүүлэх процедур нь шударга байх ёстой ба тэгш байдлыг хангах ёстой. Энэ нь зайлшгүй шаардлагатай биш байхад төвөгтэй, өртөгтэй байж болохгүй ба гүйцэтгэх боломжгүйгээр хугацаа хязгаарласан ба шударга бусаар хугацаа хойшлуулсан байдал бий болгож болохгүй (41-р зүйл, 2-р заалт),

-аливаа хэргийн холбогдолтой шийдвэрийг бичгээр гаргаж, үндэслэлийг зааж өгсөн байх ёстой. Холбогдох шийдвэрийг процессын талуудад тухайн нөхцөл байдалд тохирсон байдлаар нэн даруй хүргүүлэх

саатуулсан тухай мэдэгдлийг авсны дараа 10 хоногийн дотор эрх эзэмшигч буюу бараа саатуулах өргөдөл, хүсэлт гаргагч саатуулсан барааг устгалд оруулахыг хүлээн зөвшөөрч байгаагаа бичгээр мэдэгдсэн,

Гуравдугаарт, Барааны эзэн буюу гаалийн мэдүүлэг гаргагч (ө.х. оюуны өмчийн зөрчилтэй барааг импортлогч) Гаалиас барааг саатуулсан тухай мэдэгдлийг авсны дараа 10 хоногийн дотор барааг устгахыг хүлээн зөвшөөрч байгаагаа бичгээр илэрхийлсэн бол. Хэрэв заасан 10 хоногийн хугацаанд барааг устгах талаар зөвшөөрлөө ирүүлээгүй бол барааны эзнийг ийнхүү зөвшөөрлөө өгсөн гэж үзнэ.

Энэ гурван нөхцөл гурвуулаа биелсэн үед барааг Гаалийн байгууллага устгадаг (гэхдээ энд анхаарах зүйл бол Европын Холбооны энэ журам паралел худалдаа, гэрээний зөрчил, зорчигчийн бараа гэх мэт тохиолдлуудад үйлчлэхгүй).[23]

Барааны эзэн буюу гаалийн мэдүүлэг гаргагч оюуны өмчийн зөрчлийг хүлээн зөвшөөрөөгүй үед эрх эзэмшигч барааны тэмдгийн зөрчил мөн эсэхийг тогтоохын тулд шүүхэд нэхэмжлэл гаргана. Эсвэл эрүүгийн хуулийн журмаар эрүүгийн хэрэг үүсгэх гомдол гаргана. Холбогдох, гомдол нэхэмжлэл гаргасан нь Гаалиас эцсийн шийдвэр гартал барааг цааш саатуулсаар байх үндэслэл болдог. Иргэний журмаар нэхэмжлэл гаргасан үед эрх эзэмшигч барааны тэмдгийн зөрчил таслан зогсоох шаардлага тавих бөгөөд энэ шаардлагаа гаалиас саатуулсан барааг устгуулах замаар хангуулах хүсэлтийг шүүхэд тавьж болно.

Европын Холбооны энэхүү журмаар хэрэв холбогдох талууд зөвшөөрлөө өгсөн буюу зөрчил гаргагчийг зөвшөөрлөө өгсөн гэж үзэх хуулийн хугацаа өнгөрсөн бол заавал шүүхийн шийдвэр гаргуулах шаардлагагүйгээр Гаалийн байгууллага барааг устгах хялбарчилсан журмыг тогтоож өгсөн. Энэ нь оюуны өмчийн хамгааллын асуудал манай монголын эдийн засгаас бүтцийн хувьд маш их ялгаатай европын эдийн засгийн хувьд макро эдийн засгийн чухал асуудал байдаггүй холбоотой[24] бөгөөд Гаалиас бараа саатуулах, устгах хүсэлтийн тоо сүүлийн хорин жилд маш их өссөнтэй бас холбоотой (Жнь: германд 1994 онд 56 хүсэлт Гаалийн байгууллагад гаргаж байсан бол энэ тоо 2010 онд 23713 болж өссөн бөгөөд энэ тоо нь нийт Европын Холбооны хэмжээнд гаргасан бараа саатуулах хүсэлтийн 5 хүрэхгүй хувь нь юм).[25] Ийм хялбарчилсан журам байдаггүй байсан үед зөрчилтэй барааг иргэний, эрүүгийн шүүхийн шийдвэрээр устгаж байсан. Муудах бараа эсвэл яаралтай шийдвэрлэх шаардлагатай үед шүүхээс гарах шийдвэрийг урьдчилан баталгаажуулах замаар барааг устгах эсэх талаар шийдвэр гаргаж байсан.

2. Зөрчилтэй барааг устгах тухай ТРИПС-ийн хэлэлцээрийн заалт

ТРИПС-ийн хэлэлцээр иргэний журмаар Барааны тэмдгийн эрхийн зөрчлийг таслан зогсоох нэхэмжлэлийн шаардлагыг шүүхийн журмаар тавих эрхийг Барааны тэмдэг эзэмшигчид 44-р зүйлд заасны дагуу олгодог. Үүний дээр барааны тэмдгийн зөрчлийг дахин гаргаж болохгүйг үр дүнтэйгээр, хатуугаар сануулах зорилгоор шүүхээс зөрчилтэй гэж үзсэн барааг аливаа нөхөн төлбөр төлөхгүйгээр худалдааны сүлжээнээс устгал хийх замаар гаргахыг шүүх захирамжилж болно гэж ТРИПС-ийн хэлэлцээрийн 46-р зүйлд заасан байдаг. Устгал хийх захирамж гаргахдаа шүүхээс зөрчлийн хүнд, хөнгөн байдал, гуравдагч этгээдийн сонирхлыг харьцуулан үзэж байж

[23] Art. 1 Para 4, 5 EU Regulation No 608/2013.

[24] Olivier, Vrigins/Marius Schneider (ed.), Enforcement of intellectual property rights through border measures – Law and Practice in the EU, Oxford University Press 2012, p. 102, Para 4.105.

[25] Ibid. p. 547

ёстой. Аливаа хэргийн холбогдолтой шийдвэрийг талуудад мэтгэлцэх боломжийг олгож, тэднээс гаргаж өгсөн нотлох баримтад тулгуурлан гаргана (41-р зүйл, 3-р заалт),

-аливаа захиргааны журмаар гарсан эцсийн шийдвэрийг шүүх хянах боломжтой байх бөгөөд тухайн гишүүн улсын шүүхийн харьяаллын тухай дотоодын хуулийг хүндэтгэн үзсэний үндсэн дээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хууль зүйн асуудлаар шүүх дахин хянах боломжтой байна. Гэвч эрүүгийн хэргийн хувьд гэм буруугүй гэж үзсэн шийдвэрийг дахин хянах үүрэг энэ хэлэлцээрээр үүсэхгүй (41-р зүйл, 3-р заалт),

-шударга ба тэгш процедурын зарчим (42-р зүйл): Хэргийн хариуцагч нь нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлийг агуулсан, хэргийн талаар нарийвчилсан мэдээллийг хангалттай хэмжээнд агуулсан мэдэгдлийг түүнд цаг тухайд нь бичгээр хүргүүлэхийг шаардах эрхтэй байна. Талууд хараат бус хуульчаар төлөөлүүлэх эрхтэй байх ба процедурын явцад заавал биечлэн байх хэт хүндрэлтэй шаардлагыг тавьж болохгүй. Процессын бүх талууд өөрсдийн шаардлагаа үндэслэх, холбогдох нотлох баримтыг гаргаж өгөх эрхтэй. Тухайн улсын Үндсэн хуульд үл харшлах тохиолдолд мэдээллийг тодорхойлох, хамгаалах боломжийг процессоор олгох ёстой.

С. Барааны тэмдгийн зөрчилд холбогдох монголын хууль тогтоомж

I. Барааны тэмдгийн зөрчилтэй барааг саатуулах хууль зүйн үндэслэл

Монгол улсын Гаалийн тухай хуулийн 262-р зүйлийн 262.1 зүйлд барааны тэмдэг бүхий буюу “оюуны өмчид хамаарах” барааг Гаалийн тухай хуулийн 264-р зүйлд заасан “өргөдлийг ирүүлснээс бусад тохиолдолд Гаалийн байгууллага гаалийн хилээр нэвтрүүлнэ” гэж, Гаалийн байгууллага нь “оюуны өмчийн эрхэд хамаарах бөгөөд гаалийн хяналтад байгаа барааг оюуны өмчийн эрх эзэмшигчийн өргөдлийг үндэслэн гаалийн хилээр нэвтрүүлэхгүй байх арга хэмжээ авна” гэж тус тус заажээ.

Гаалийн тухай хуулийн 264-р зүйлийн 264.1-ийн дагуу гаалийн байгууллага барааг дараах нөхцөл бүрдсэн үед саатуулна:

(а) Монгол Улсад хамгаалсан, оюуны өмчийн эрх хүчинтэй байх. Гаалийн Ерөнхий газар, Оюуны өмчийн газрын даргын хамтарсан 2009 оны тушаалын 298/41-р тушаалын хавсралт болох “Оюуны өмчийн эрхэд хамаарах барааг гаалийн хилээр нэвтрүүлэх журам” (цаашид “Бараа саатуулах журам“ гэх)-ийн 1.3-ийн дагуу “оюуны өмчийн эрхэд хамаарах бараа” гэдэгт “бүртгэгдсэн барааны тэмдэг бүхий барааг” бас хамруулж ойлгоно .

(б) Барааг хилээр нэвтрүүлж байгаа үйлдэл нь Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 12, 13-р зүйлд заасан барааны тэмдэг “эзэмшигчийн онцгой эрх”, “барааны тэмдгийг ашиглах” ойлголтуудын хүрээнд байх. (жич: үүнтэй холбогдуулан цэвэр хувийн хэрэглээнд зориулсан, гар ачаанд хийсэн барааг хилээр нэвтрүүлэх явдал нь Оюуны өмчийн зөрчил болохгүй гэж гишүүд өөрийн хуульдаа зааж өгч болно гэж ТРИПС-ийн хэлэлцээрийн 60-р зүйлд заасан байдаг.)

(в) Барааг гаалийн хилээр нэвтрүүлж Монгол улсын нутаг дэвсгэрийн хүрээнд худалдаанд гаргахаар гаалийн бүрдүүлэлт хийх мэдүүлэг гаргасан байх,

эсвэл

(с) бараа нь гаалийн хяналтад байх. Бараа саатуулах журмын 4.4.1-т гаалийн хяналтад байх гэдэгт гаалийн бүрдүүлэлтийн дараа шалгалт хийх, гаалийн хяналтад байгаа барааг

хууль.mn

ойлгоно.

II. Гаалиас барааны тэмдгийн зөрчилтэй бараг саатуулах процесс

1. Бараа саатуулах өргөдөл

Гаалийн тухай хуулийн 264-р зүйлийн 264.1.-т зааснаар ГЕГ нь барааны тэмдгийн зөрчилтэй бараг барааны тэмдэг эзэмшигчийн өргөдөл, хүсэлтээр саатуулна. Тус хуулийн заалт ба Бараа саатуулах журмын 4.4-т заасны дагуу өргөдөл, хүсэлтийг барааны тэмдгийг эрх эзэмшигч дараах бүрдүүлбэртэйгээр гаргана:

-эрх эзэмшигчээс бөглөж өгсөн холбогдох өргөдлийн маягт,

-эрх эзэмшигчийн талаарх мэдээлэл,

-оюуны өмчийн обьектын талаарх мэдээлэл,

-өргөдөл гаргагчийн тодорхойлсноор хууль бусаар нэвтрүүлсэн байж болох барааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл,

-Барааны тэмдгийн гэрчилгээний хуулбар,

-Бараг саатуулах болсон үндэслэл, хугацаа,

-Бараг "Оюуны өмчийн эрхэд хамаарах барааны гаалийн бүртгэл"-д бүртгүүлсэн бол түүний дугаар,

-Мөнгөн барьцааг холбогдох дансанд байршуулсан байх.

2. Бараа саатуулах шийдвэр, шийдвэр гаргах хугацаа

Бараа саатуулах журмын 4.6-д Гаалийн байгууллага "Бараа саатуулах" өргөдөл, хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 30 хоногийн дотор холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэнэ гэжээ.

Гаалийн байгууллага Гаалийн тухай хуулийн 264-р зүйлийн 264.1 дэх хэсэг, Бараа саатуулах журмын 4.4-т заасан шаардлагыг хангасан өргөдөл, хүсэлтийг хүлээн авах үүрэгтэй бөгөөд Бараа саатуулах журмын 4.8.2-т Гаалийн байгууллага өргөдөл гаргагчаас гаргаж өгсөн мэдээллийг үнэн эсэхэд хяналт хийж, ийм эргэлзээ байхгүй бол бараа саатуулах шийдвэрийг гаргахаар зааж өгсөн байна.

III. Бараг буцаах шаардлага тавих барааны тэмдэг эзэмшигч, гаалийн байгууллагын эрх, хууль зүйн үндэслэл

Гаалийн тухай хууль болон бараа саатуулах журамд бараг саатуулсны дараа өргөдөл, хүсэлт гаргагч эсвэл барааны тэмдгийн зөрчилтэй бараг импортлогч ямар алхам хийх ёстойг зааж өгөөгүй байна.

Барааны тэмдэг эзэмшигчийн эрх нь хувийн өмчийн эрх бөгөөд бараг буцаах шаардлагыг тэрээр Иргэний хуулийн 106-р зүйлийн 106.3-ийн дагуу гаргаж болох юм. Энэ зүйлийн дагуу Гаалийн байгууллагаас саатуулсан бараг буцааж, илгээсэн улс уруу гаргах замаар зөрчлийг арилгахыг барааны тэмдэг эзэмшигч импорлогчоос шаардах боломжтой.

Гэвч энэхүү хувийн өмчийн эрхийн хэрэгжилтийг бараг буцаахыг шаардах замаар шууд хангах хуулийн эрх хэмжээ Гаалийн байгууллагад байхгүй.

IV. Саатуулсан бараг устгах өргөдөл, хүсэлт гаргах хууль зүйн үндэслэл, процесс

1. Гаалийн байгууллагын эрх хэмжээ

Гаалийн тухай хуульд Гаалийн байгууллагаас оюуны өмчийн эрхийн зөрчилтэй бараг саатуулах эрхтэй гэж заасан. Харин саатуулсан бараг устгах эрх хэмжээг Гаалийн тухай хуулиар Гаалийн байгууллагад олгоогүй.

Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 34-р зүйлийн 34.3-т "Барааны тэмдгийг хууль бусаар ашигласны улмаас хураан авсан зөрчилтэй бараа, бүтээгдэхүүнийг борлуулах, хэрэглээнд буцаан гаргах нь барааны тэмдэг эзэмшигчийн эрхийг зөрчиж болзошгүй гэж үзвэл шүүх болон

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nlc.mn

төрийн захиргааны байгууллага түүнийг устгах тухай шийдвэрийг" гаргана гэжээ.

34-р зүйлийн 34.3-т заасан "төрийн захиргааны байгууллага" гэсэн ойлголтод Гаалийн байгууллага багтах боловч барааг устгахтай холбогдсон болон эрх эзэмшигч, зөрчил гарагч хоёрын хоорондох маргааныг мэтгэлцэх зарчмыг хангаж шийдэх процессын зохицуулалт байхгүй байна. Иймээс хууль тогтоогч Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийг батлах үед "төрийн захиргааны байгууллага" гэдэгт Гаалийн байгууллагыг шууд хамруулж ойлгож байсан эсэх нь тодорхойгүй байна.

2. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх хэмжээ, холбогдох процесс

Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 34-р зүйлийн 34.3-т заасан "төрийн захиргааны байгууллага" гэдэгт оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг ойлгож ирсэн бөгөөд Оюуны өмчийн газар оюуны өмчийн зөрчлийг шүүхээс гадуур, захиргааны журмаар таслан зогсоож, цөөн тохиолдолд оюуны өмчийн зөрчилтэй барааг устгалд оруулж ирсэн билээ. Оюуны өмчийн зөрчил таслан зогсоох процессыг зохицуулсан хоёр журам (ЗГ-ийн 1999 оны 220-р тогтоолын хавсралт болох "Оюуны өмчийн хяналтын дүрэм", Хууль зүйн сайдын 2000 оны 111-р тушаалын хавсралт "Оюуны өмчийн байцаагчийн ажиллах журам") байдаг ч энэ нь агуулга, зорилго, мэтгэлцэх зарчмыг хангасан байдал, хэрэг маргааныг шийдвэрлэгч этгээдийн хараат бус байдлыг хангах механизмын хувьд шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай харьцуулшгүй юм.

Манай жишээ тохиолдлын хувьд "М" ХХК-ийн оруулж ирсэн тоглоом нь гаалийн хяналтад байгаа бараа юм. Хэдийгээр Оюуны өмчийн газар "гаалийн баталгаат бүс"-т байгаа барааг Барааны тэмдгийн хуулийн 34-р зүйлийн 34.1 хэсгийн дагуу устгах шийдвэр гаргаж болох боловч Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг ГЕГ биелүүлэх ёстой гэсэн үүрэг хүлээсэн хуулийн заалт байхгүй.

3. Шүүхийн эрх хэмжээ, холбогдох процесс

Монгол улсын Иргэний хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх тухай хууль мэтгэлцэх зарчмыг хангах, хараат бус шүүхээр шүүлгэх гэх мэт ардчилсан төр дэх хүний наад захын эрхийг хангасан, ТРИПС-ийн хэлэлцээрийн ерөнхий стандартад нийцсэн процессыг бий болгосон. Үүний дээр, Монгол улсад шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх зарчим үйлчлэх бөгөөд үүнд холбогдох субьект нь Гаалийн байгууллага мөн. Гэвч одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Гаалийн ерөнхий хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль ба холбогдох журмууд болон монголын практикт оюуны өмчийн хэрэгжилтийг шүүхийн оролцоогүй хангасаар ирсэн. Нөгөө талаас Оюуны өмчийн эрхийн хэрэгжилтийг Монгол улсын Иргэний хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу хангахын тулд Гаалийн тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, холбогдох журмуудад өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай.

4. Захиргааны ерөнхий хууль

2016 оны 7-р сарын 1-нээс эхлэн үйлчилж байгаа Захиргааны ерөнхий хууль нь захиргааны актыг бичгээр гаргах шаардлага, баримт бичигтэй танилцах эрх, захиргааны актыг мэдэгдэх гэх мэт ТРИПС-ийн ерөнхий стандартад нийцсэн процессын ерөнхий шаардлагыг тавьж байгааг энд дурдах хэрэгтэй. Гэвч Захиргааны ерөнхий хууль нь барааны тэмдгийн зөрчилд холбогдож процедурын үе шат бүрийг тодорхойлсон маргаан шийдвэрлэх, албадан хэрэгжүүлэх, бараа устгах гэх мэтэд холбогдох тусгай зохицуулалт

биш юм.

D. ДҮГНЭЛТ

"М" ХХК-ийн оруулж ирсэн хүүхдийн тоглоом Гаалийн тухай хуулийн 264-р зүйлийн 264.1 дэх хэсэг, Гаалийн Ерөнхий газрын дарга, Оюуны өмчийн газрын даргын хамтарсан 2009 оны 298/41 дугаартай тушаалын хавсралтаар баталсан "Оюуны өмчийн эрхэд хамаарах барааг Гаалийн хилээр нэвтрүүлэх" журмын 4.1-т заасан нөхцөл бүрдсэн үед ГЕГ барааны тэмдгийн зөрчилтэй барааг саатуулах эрхтэй.

ГЕГ барааг саатуулсны дараа анхаарах хугацаа буюу Гаалиас бараа саатуулж болох цаад хугацаа, түүнчлэн Гаалийн агуулах, савыг суллаж өгөхтэй холбогдон барааны тэмдэг эзэмшигч, зөрчил гаргагчаас (импортлогч) авах ёстой арга хэмжээний талаар Монгол улсын холбогдох хууль тогтоомжид тодорхой зааж өгөөгүй байна.

"П" нь ДХБ-ийн гишүүн улс болох БН Польш улсын компани болохын хувьд ТРИПС-ийн хэлэлцээрийн дагуу Монгол Улсын иргэн, оюуны өмчийн эзэмшигчийн нэгэн адил эрх эдэлнэ. Үүний дээр хэрэв холбогдох хэлэлцээрийн зүйл, заалтыг Гаалийн байгууллага, Оюуны өмчийн газар, шүүх шууд хэрэглэх боломжтой бол тэрээр тус хэлэлцээрт заасан наад захын эрхийг эдэлнэ.

Барааны тэмдэг эзэмшигч түүний эрхийг зөрчиж импортолсон барааг илгээгч улс уруу буцаах шаардлага тавих эрхтэй гэсэн заалт Монгол Улсын Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд байхгүй. Ийм шаардлагыг Иргэний хуулийн 106-р зүйлийн 106.2 заасан өмчлөгчийн эрхийн хүрээнд тавих боломжтой. Гэвч Гаалийн байгууллагад саатуулсан барааг буцаахыг зөрчил гаргагчаас шаардах эрх хэмжээг хуулиар олгоогүй.

"П" нь Барааны тэмдгийн хуулийн дагуу Гаалиас саатуулсан барааг устгах замаар түүний эрхийн зөрчлийг арилгуулахын шаардах эрхтэй. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 34-р зүйлд зааснаар барааг устгах шийдвэрийг улсын байцаагч, шүүгч буюу "төрийн захиргааны байгууллага", "шүүх" гаргана. Энэ зүйлд заасан "төрийн байгууллага", "улсын байцаагч" гэдэгт гаалийн байгууллага, гаалийн байцаагч багтах эсэх нь эргэлзээтэй байна.

"М" ХХК-ийн оруулж ирсэн тоглоом нь гаалийн хяналтад байгаа бараа юм. Хэдийгээр Оюуны өмчийн газар гаалийн хяналтад байгаа барааг Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 34-р зүйлийн 34.1 хэсгийн дагуу устгах шийдвэр гаргаж болох боловч Оюуны өмчийн газрын шийдвэрийг ГЕГ биелүүлэх ёстой гэсэн үүрэг хүлээсэн хуулийн заалт байхгүй.

Барааг устгах нэхэмжлэлийг иргэний шүүхийн журмаар гаргаж болох боловч монголд ийм практик байдаггүй.

Монголын одоо үйлчилж байгаа дотоодын хууль, тогтоомж нь ТРИПС-ийн наад захын стандартыг хангахгүй байна. "П" компанийн өргөдөл, хүсэлтээр ГЕГ барааг саатуулах эрхтэй боловч ГЕГ нь "П" ба "М"-ийн өмнө хүлээх үүрэг нь бүрхэг тодорхойгүй байна. Үүний дээр ГЕГ-ийн үүргийг шүүхийн шийдвэрээр албадан хангуулах хууль зүйн бодит боломж ч байхгүй байна.

ТРИПС-ийн хэлэлцээр нь Барааны тэмдгийн зөрчлийг хил дээр таслан зогсооход холбогдож нэлээд нарийн стандарт, процессыг зааж өгсөн. Энэхүү стандарт, процессыг дотоодын хуулиар хангаж өгөх зайлшгүй шаардлагатай. Энэхүү стандарт, процессыг хангасан дотоодын процессыг хуулиар бий болгож өгөөгүй цагт Монгол улсыг ТРИПС-ийн хэлэлцээрийн дагуух үүргээ гүйцэтгэсэн гэж үзэхгүй.

Олон улсын стандартыг хангасан оюуны өмчийн хамгаалал нь улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх,

I ХЭСЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ БА ҮНДСЭН ЗАРЧМУУД

1-р зүйл. Үүргийн мөн чанар, хүрээ

1. Гишүүд энэхүү хэлэлцээрийн заалтуудыг хэрэглэнэ. Гишүүд энэхүү хэлэлцээрт шаардсан хамгаалалтаас илүү өндөр хэмжээнд өөрсдийн хуульдаа хамгаалалт хийх үүрэг хүлээхгүй, гэвч холбогдох хамгаалалт нь энэхүү хэлэлцээрийн зохицуулалтад нийцэж байх ёстой. Гишүүд энэхүү хэлэлцээрийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд тохиромжтой арга замыг өөрийн хуулийн систем, практикийн хүрээнд сонгох эрх чөлөөг хадгална.

2. Энэхүү хэлэлцээрийн хүрээнд “оюуны өмч” гэсэн ойлголтод 2-р хэсгийн 1-7-р бүлэгт заасан бүх төрлийн оюуны өмч багтана.

3. Гишүүд энэхүү хэлэлцээрээр олгосон эрхийг бусад гишүүдийн харьяатад олгоно. Холбогдох оюуны өмчийн эрхийн хувьд гишүүдийн харьяат гэж эрх эдлэх шалгуурыг дараах конвенцуудын дагуу хангасан хувь ба хуулийн этгээдийг ойлгоно: Парисийн конвенц (1967), Бернийн конвенц (1971), Ромын конвенц ба Интеграл зургийн оюуны өмчийг хамгаалах гэрээ...

2-р зүйл. Оюуны өмчийн конвенциуд

1. Энэхүү хэлэлцээрийн II, III, IV хэсгийн хувьд гишүүд Парисийн конвенцийн 1-12-р зүйлүүд 19-р зүйлийг дагаж мөрдөх үүрэгтэй.

3-р зүйл. Үндэсний тааламжтай нөхцөл

1. Гишүүд бусад гишүүдийн харьяатад хандахдаа өөрийн улсын харьяаттай ижил байдлаар хандана. Энэ нь оюуны өмчийн эрхийг хамгаалах бүх нөхцөлийн хувьд үйлчилнэ. Хэлэлцээрээр ийм нөхцөл үйлчлэхгүй байхаар Парисийн конвенц, Бернийн конвенц, Ромын конвенц, Интеграл бүдүүвчид холбогдох оюуны өмчийн хэлэлцээрийн заалтууд цаашид хүчин төгөлдөр үйлчилнэ.

II ХЭСЭГ. ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХ БИЙ БОЛОХ, ЭРХИЙН ХҮРЭЭ, ЭРХ АШИГЛАХАД ХОЛБОГДСОН СТАНДАРТУУД

2-р БҮЛЭГ. БАРААНЫ ТЭМДЭГ

15-р зүйл. Хамгаалалтын зүйл

1. Аливаа бараа эсвэл үйлчилгээг өөр нэг этгээдийн бараа үйлчилгээнээс ялгах чадвартай тэмдэг ба тэмдгийн хослол нь барааны тэмдэг байна. Хүний нэр, үсэг, тоо, дүрс хэлбэр, өнгөний хослол болон аливаа тэмдгийн хослолыг барааны тэмдгээр бүртгэнэ. Хэрэв тэмдэг нь тухайн бараа, үйлчилгээг ялгах чадваргүй бол гишүүд хэрэглээний явцад олж авсан ялгарах чадвараас хамааруулж бүртгэл хийж болно. Гишүүд нүдэнд харагдах тэмдгийг л барааны тэмдгээр бүртгэх шаардлага тавьж болно.

5. Гишүүд барааны тэмдгийг бүртгэхээс өмнө эсвэл бүртгэсний дараа нэн даруй хэвлэх үүрэгтэй.

16-р зүйл. Холбогдох эрх

1. Бүртгүүлсэн барааны тэмдгийн эзэмшигч нь аливаа гуравдагч этгээдийг төөрөгдөлд оруулж болох, өөрөөс нь урьдчилж зөвшөөрөл аваагүй ижил эсвэл ойролцоо тэмдгийг ижил эсвэл ойролцоо бараа, үйлчилгээнд хэрэглэхийг хориглох онцгой эрхтэй. Ижил бараа үйлчилгээнд ижил тэмдэг хэрэглэж байгаа үед төөрөгдөлд орох нөхцөл байдал үүссэн гэж үзнэ.

III ХЭСЭГ. ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

1-р БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮҮРЭГ

41-р зүйл.

1. Энэхүү хэлэлцээрээр хамгаалсан оюуны өмчийн аливаа зөрчлийн эсрэг үр дүнтэй үйл ажиллагаа явуулах боломжийг бий болгох, үүний дотор зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх шуурхай арга хэмжээ буюу зөрчил давтагдахгүй байх баталгааг бий болгох зорилго бүхий энэхүү бүлэгт

гадаадын хөрөнгө оруулалтыг татах нэг үгтвар нөхцөл болох тул оюуны өмчийн салбарт тогтолцооны, хуулийн жинтэй шинэчлэл хийх шаардлагатай байгаа нь ТРИПС-ийн хэлэлцээрийн агуулга, дотоодын хууль тогтоомж, практикийн бодит байдлыг харуулсан дээрх харьцуулалтаас тодорхой харагдаж байна.

Хуучин социалист тогтолцооноос эхтэй захиргааны байгууллага шүүхийн үүргийг орлож гүйцэтгэдэг тогтолцоо нь ихээхэн хэмжээний мөнгөн дүн ба зах зээлийн хяналтад холбогдох асуудалд тохирохгүй байгааг дээрх харьцуулалт илтгэж байна. Иймээс ТРИПС ба олон улсын нийтлэг стандартад тулгуурласан, иргэний эрх зүй ба иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх эрх зүйд суурилсан барааны тэмдгийн хэрэгжилтийн тогтолцоог бий болгох шаардлагатай бөгөөд үүний тулд шат дараатай шинэчлэлийг нэлээд хэдэн жилийн туршид хийж, албан хаагч, өмгөөлөгч, хуульч, шүүгчдийг бэлтгэх шаардлага урган гарч байна.

Барааны тэмдгийн хэрэгжилтийг зохистойгоор хангах нь хүн амын хүнсний болон бусад аюулгүй байдалд жинтэй нөлөөтэй болохыг энд зориуд дурдах ёстой. Учир нь худалдааны сүлжээний талаар нарийн мэдээлэлтэй бизнес эрхлэгчид өөрсдөө барааны тэмдгийн эрхээрээ дамжуулж бүтээгдэхүүн, зах зээлээ хянадаг. Хувийн санаачилгад үндэслэсэн хяналтын тогтолцоо нь ямар ч төрийн сайн зохион байгуулалтаас илүү уян хатан, хурдан мэдээлэл авах чадвартай байх болно. Энэ хүчийг ашиглаж нийтийн ашиг сонирхлын хамгаалахын тулд барааны тэмдгийн эрх зүйн шинэчлэл зайлшгүй чухал.

Е. Хавсралт: ТРИПС-ийн хэлэлцээрийн холбогдох заалтуудын орчуулга

ОЮУНЫ ӨМЧИЙН ХУДАЛДААНЫ АСУУДЛААРХ ХЭЛЭЛЦЭЭР (ТРИПС-ийн хэлэлцээр)

ТРИПС-ийн хэлэлцээр бол Дэлхийн Худалдааны Байгууллагыг байгуулах тухай 1994 оны 4-р сарын 15-ны өдөр Марокко Улсын Марракеш хотод гарын үсэг зурсан гэрээний 1С хавсралт юм.

УДИРТГАЛ

Олон улсын худалдаа гажуудуулах болон олон улсын худалдаанд саад учруулахыг багасгах эрмэлзэлтэйгээр оюуны өмчийн эрхийг үр дүнтэй, тохиромжтойгоор хамгаалахыг дэмжих хэрэгтэй байгаа төдийгүй оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх арга хэмжээ болон процесс нь өөрөө зүй ёсны худалдаанд саад болохгүй байхыг хангах ёстойг анхааран үзэж, гишүүд үүгээр дараахыг хамарсан шинэ зохицуулалт ба журам хэрэгтэйг хүлээн зөвшөөрч байна:

(а) ГАТТ 1994-ийн үндсэн зарчмууд, түүнчлэн холбогдох оюуны өмчийн эрхийн олон улсын гэрээ, конвенцуудыг цаашид дагаж мөрдөх;

(б) худалдаанд холбогдох оюуны өмчийн эрхийг олгох, эрхийн хүрээг тодорхойлох ба эрхийг ашиглахад тохиромжтой стандарт, зарчмуудыг бий болгох;

(в) худалдаанд холбогдох оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх үр дүнтэй, тохиромжтой зохицуулалтыг улс орны эрх зүйн системийн ялгааг харгалзан үзэж бий болгох;

(г) засгийн газар хоорондын маргааныг үр дүнтэй, зардал багатай шийдвэрлэх зохицуулалтыг бий болгох;

(е) хэлэлцээрийн үр дүнд бүрэн оролцохыг хангасан шилжилтийн зохицуулалт хийх;

Гишүүд дуураймал барааг олон улсад худалдаалахтай холбоотой олон талаас зөвшөөрсөн зарчим, зохицуулалт ба тогтолцоо хэрэгтэй байгааг хүлээн зөвшөөрч байна;

Гишүүд оюуны өмчийг хувийн өмчийн эрх болохыг хүлээн зөвшөөрч байна;

заасан процедурыг гишүүд хууль тогтоомжоороо бий болгох үүрэгтэй. Холбогдох процедурыг зүй ёсны худалдаанд саад учруулахгүй ба эрх буруугаар ашиглахгүй байх баталгааг хангах замаар хэрэглэнэ.

2. Оюуны өмчийг хэрэгжүүлэх процедур нь шударга, тэгш байх ёстой. Энэ нь зайлшгүй шаардлагатай биш байхад төвөгтэй, өртөгтэй болгосон эсвэл зүй бусаар хугацаа хязгаарласан ба хойшлуулсан байдал бий болгож болохгүй.

3. Аливаа хэргийн холбогдолтой шийдвэрийг бичгээр гаргаж, үндэслэлийг зааж өгсөн байна. Холбогдох шийдвэрийг процесийн талуудад тухайн нөхцөл байдалд тохирсон байдлаар нэн даруй хүргүүлэх ёстой. Аливаа хэргийн холбогдолтой шийдвэрийг талуудад мэтгэлцэх боломжийг олгож, тэднээс гаргаж өгсөн нотлох баримтад тулгуурлан гаргана.

4. Аливаа захиргааны журмаар гарсан эцсийн шийдвэрийг шүүх хянах боломжтой байх бөгөөд тухайн гишүүн улсын шүүхийн харьяаллын тухай дотоодын хуулийг хүндэтгэн үзсэний үндсэн дээр анхан шатны шүүхийн шийдвэрийн хууль зүйн асуудлыг шүүх дахин хянах боломжтой байна. Гэвч эрүүгийн хэргийн хувьд гэм буруугүй гэж үзсэн шийдвэрийг дахин хянах үүрэг энэ хэлэлцээрээр үүсэхгүй.

5. Хуулийн хэрэгжилтийг хангах ерөнхий тогтолцооноос тусдаа байх оюуны өмчийн хэрэгжилтийг хангах тусгай шүүхийн тогтолцоог бий болгох үүрэг энэ хэсгийн дагуу үүсэхгүй бөгөөд гишүүн улсын хуулийн хэрэгжилтийг хангах хүчин чадлыг энэхүү хэлэлцээр хөндөхгүй. Хуулийн хэрэгжилтийг хангах эх үүсвэрээ хувааж, оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх тусгай зохион байгуулалт хийх үүрэг энэхүү хэсгээр үүсэхгүй.

2-Р БҮЛЭГ. ИРГЭНИЙ БА ЗАХИРГААНЫ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА НЭХЭМЖЛЭЛ, ГОМДЛЫН ШААРДЛАГУУД

42-р зүйл. Шударга ба тэгш процедур

Гишүүд эрх эзэмшигчдийг иргэний шүүхийн процедураар энэхүү хэлэлцээрийн хүрээн дэх оюуны өмчийн эрхийн хэрэгжилтийн хувьд хангаж өгнө. Хэргийн хариуцагч нь нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлийг агуулсан, хэргийн талаар нарийвчилсан мэдээллийг хангалттай хэмжээнд агуулсан мэдэгдлийг түүнд цаг тухайд нь бичгээр хүргүүлэхийг шаардах эрхтэй. Талууд хараат бус хуульчаар төлөөлүүлэх эрхтэй байх ба процедурын явцад заавал биечлэн байх хэт хүндрэлтэй шаардлагыг тавьж болохгүй. Процессын бүх талууд өөрсдийн шаардлагаа үндэслэх, холбогдох нотлох баримтыг гаргаж өгөх эрхтэй. Тухайн улсын Үндсэн хуульд үл харшлах тохиолдолд нууцлах мэдээллийг тодорхойлох, хамгаалах боломжийг процессоор олгох ёстой.

43-р зүйл. Нотлох баримт

1. Хэрэгт холбогдох нэг тал өөрийн шаардлагад холбогдох, түүний үндэслэлийг хангалттай гаргаж чадахуйц нотлох баримтыг тухайн нөхцөл байдалдаа таарахуйц хангалттай хэмжээнд гаргаж, өөрийн шаардлагын үндэслэлийг гаргахад эрх зүйн ач холбогдолтой нотлох баримтыг эсрэг талд байгаа гэж зааж өгсөн тохиолдолд шүүх эсрэг талаас нотлох баримтыг гаргуулахыг нууцлах мэдээллийг хамгаалах арга хэмжээг авч захирамжлах эрхтэй байна.

2. Процессын нэг талаас сайн дурааараа буюу ямар нэг хүндэтгэн үзэх үндэслэлгүйгээр шаардлагатай мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзсан эсвэл түүнийг тохиромжтой хугацааны дотор гаргаж өгөхгүй байгаа эсвэл эрх хэрэгжүүлэх хянан шийдвэрлэх ажиллагаанд ноцтойгоор саад учруулсан бөгөөд талуудад гаргасан

мэдэгдэл, нотолгоонд өөрийн байр сууриа илэрхийлэх боломжийг олгосон байсан бол нэхэмжлэл, мэдээлэл гаргаж өгөөгүйн улмаас үндэслэлээ гаргахад нь саад болж байгаа талын мэдэгдлийг оролцуулан гарт байгаа мэдээлэл дээр үндэслэн зөвшөөрсөн эсвэл татгалзсан урьдчилсан ба эцсийн шийдвэрийг гаргах эрхийг гишүүн өөрийн улсын шүүхэд өгч болно.

44-р зүйл. Таслан зогсоох

1. Шүүх нэн ялангуяа импортоор орж ирж буй оюуны өмчийн зөрчилтэй барааг гаалийн бүртгэлд орсны дараа өөрийн харьяа нутаг дэвсгэрийн худалдааны сүлжээнд орохыг зогсоохын тулд оюуны өмчийн зөрчлөө таслан зогсоохыг нэг этгээдээс шаардах эрхтэй байна. Хэрэв тухайн этгээд барааг оюуны өмчийн зөрчилтэй болохыг мэдээгүй буюу нөхцөл байдлыг ухаалгаар дүгнэж үзвэл ийнхүү мэдэх боломжгүй байсан бол гишүүд тухайн этгээдийн худалдаж авсан буюу захиалсан эрхийг хамгаалалтын зүйлийн хувьд энэ эрх хэмжээг хэрэгжүүлэх үүрэг хүлээхгүй.

46-р зүйл. Бусад нэхэмжлэлийн шаардлагууд

Зөрчил дахин гаргаж болохгүйг үр дүнтэйгээр, хатуугаар сануулах зорилгоор шүүхийн байгууллага зөрчилтэй гэж үзсэн барааг аливаа нөхөн төлбөр төлөхгүйгээр худалдааны сүлжээнээс устгал хийх замаар гаргахыг захирамжилж болно. Энэ үйл ажиллагаа нь эрх эзэмшигчид хохирол учруулах нөхцөлийг арилгах зорилготой бөгөөд тухайн улсын үндсэн хуулийн хүрээнд явагдах ёстой. ... Холбогдох хүсэлтийг хангахдаа зөрчлийн хүнд, хөнгөн байдал ба гуравдагч этгээдийн сонирхлыг харьцуулан үзэх шаардлагыг анхааран үзэх ёстой. Барааны тэмдгийн зөрчилтэй барааны хувьд зөвхөн онцгой тохиолдолд л бараан дээр хууль бусаар зүүж, наасан барааны тэмдгийг авч хаяж барааг чөлөөт эргэлтэд оруулахыг зөвшөөрч болно.

3-Р БҮЛЭГ. ГАРАХ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙГ УРЬДЧИЛАН БАТАЛГААЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

50-р зүйл.

1. Шүүх гарах шийдвэрийн биелэлтийг урьдчилан баталгаажуулах арга хэмжээг хурдан, үр дүнтэйгээр дараах тохиолдолд авна.

(а) оюуны өмчийн зөрчлийг гарахад хаалт хийх, аливаа барааг, үүний дотор импортоор орж ирж буй барааг гаалийн бүртгэлд орсных нь дараа харьяа нутаг дэвсгэрийн худалдааны сүлжээнд орохоос урьдчилан сэргийлж, нэн даруй хориг тавих;

(б) буруутгаж буй зөрчилтэй холбоотой нотлох баримтыг баталгаажуулах.

2. Шүүх эсрэг талын байр суурийг урьдчилан сонсолгүйгээр гарах шийдвэрийн биелэлтийг урьдчилан баталгаажуулах арга хэмжээг нэн ялангуяа хэрэв цаг алдвал эрх эзэмшигчид дахин сэргээж болохгүй хохирөл учрах боломжтой үед эсвэл нотлох баримтыг устгаж болох эрсдэл бодитойгоор бий болсон үед авна.

3. Нэхэмжлэгч өөрөө эрх эзэмшигч мөн гэдгийг, түүний эрх зөрчигдсөн гэдгийг эсвэл ийнхүү эрх зөрчигдөх бодит нөхцөл бий болсон гэдгийг хангалттай хэмжээнд мэдэж авахын тулд шүүх нэхэмжлэгчээс нөхцөл байдлыг ухаалгаар шинжилж үзэхэд түүний гар дээр байх ёстой аливаа нотлох баримтыг гаргаж өгөхийг шаардах эрхтэй бөгөөд шүүх хариуцагчийг хамгаалахын тулд ба эрх буруугаар ашиглахын эсрэг баталгаа болгож мөнгөн баталгаа эсвэл түүнтэй дүйцэх аливаа баталгааг гаргахыг нэхэмжлэгчид захирамжлах эрхтэй.

4. Гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг эсрэг талын байр суурийг урьдчилан сонсолгүйгээр авах үед холбогдох талд энэ талаар үйл ажиллагааг явуулсны

заасан процедурыг гишүүд хууль тогтоомжоороо бий болгох үүрэгтэй. Холбогдох процедурыг зүй ёсны худалдаанд саад учруулахгүй ба эрх бууруугаар ашиглахгүй байх баталгааг хангах замаар хэрэглэнэ.

2. Оюуны өмчийг хэрэгжүүлэх процедур нь шударга, тэгш байх ёстой. Энэ нь зайлшгүй шаардлагатай биш байхад төвөгтэй, өртөгтэй болгосон эсвэл зүй бусаар хугацаа хязгаарласан ба хойшлуулсан байдал бий болгож болохгүй.

3. Аливаа хэргийн холбогдолтой шийдвэрийг бичгээр гаргаж, үндэслэлийг зааж өгсөн байна. Холбогдох шийдвэрийг процесийн талуудад тухайн нөхцөл байдалд тохирсон байдлаар нэн даруй хүргүүлэх ёстой. Аливаа хэргийн холбогдолтой шийдвэрийг талуудад мэтгэлцэх боломжийг олгож, тэднээс гаргаж өгсөн нотлох баримтад тулгуурлан гаргана.

4. Аливаа захиргааны журмаар гарсан эцсийн шийдвэрийг шүүх хянах боломжтой байх бөгөөд тухайн гишүүн улсын шүүхийн харьяаллын тухай дотоодын хуулийг хүндэтгэн үзсэний үндсэн дээр анхан шатны шүүхийн шийдвэрийн хууль зүйн асуудлыг шүүх дахин хянах боломжтой байна. Гэвч эрүүгийн хэргийн хувьд гэм бууруугүй гэж үзсэн шийдвэрийг дахин хянах үүрэг энэ хэлэлцээрээр үүсэхгүй.

5. Хуулийн хэрэгжилтийг хангах ерөнхий тогтолцооноос тусдаа байх оюуны өмчийн хэрэгжилтийг хангах тусгай шүүхийн тогтолцоог бий болгох үүрэг энэ хэсгийн дагуу үүсэхгүй бөгөөд гишүүн улсын хуулийн хэрэгжилтийг хангах хүчин чадлыг энэхүү хэлэлцээр хөндөхгүй. Хуулийн хэрэгжилтийг хангах эх үүсвэрээ хувааж, оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх тусгай зохион байгуулалт хийх үүрэг энэхүү хэсгээр үүсэхгүй.

2-Р БҮЛЭГ. ИРГЭНИЙ БА ЗАХИРГААНЫ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА НЭХЭМЖЛЭЛ, ГОМДЛЫН ШААРДЛАГУУД

42-р зүйл. Шударга ба тэгш процедур

Гишүүд эрх эзэмшигчдийг иргэний шүүхийн процедураар энэхүү хэлэлцээрийн хүрээн дэх оюуны өмчийн эрхийн хэрэгжилтийн хувьд хангаж өгнө. Хэргийн хариуцагч нь нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлийг агуулсан, хэргийн талаар нарийвчилсан мэдээллийг хангалттай хэмжээнд агуулсан мэдэгдлийг түүнд цаг тухайд нь бичгээр хүргүүлэхийг шаардах эрхтэй. Талууд хараат бус хуульчаар төлөөлүүлэх эрхтэй байх ба процедурын явцад заавал биечлэн байх хэт хүндрэлтэй шаардлагыг тавьж болохгүй. Процессын бүх талууд өөрсдийн шаардлагаа үндэслэх, холбогдох нотлох баримтыг гаргаж өгөх эрхтэй. Тухайн улсын Үндсэн хуульд үл харшлах тохиолдолд нууцлах мэдээллийг тодорхойлох, хамгаалах боломжийг процессоор олгох ёстой.

43-р зүйл. Нотлох баримт

1. Хэрэгт холбогдох нэг тал өөрийн шаардлагад холбогдох, түүний үндэслэлийг хангалттай гаргаж чадахуйц нотлох баримтыг тухайн нөхцөл байдалдаа таарахуйц хангалттай хэмжээнд гаргаж, өөрийн шаардлагын үндэслэлийг гаргахад эрх зүйн ач холбогдолтой нотлох баримтыг эсрэг талд байгаа гэж зааж өгсөн тохиолдолд шүүх эсрэг талаас нотлох баримтыг гаргуулахыг нууцлах мэдээллийг хамгаалах арга хэмжээг авч захирамжлах эрхтэй байна.

2. Процессын нэг талаас сайн дурааараа буюу ямар нэг хүндэтгэн үзэх үндэслэлгүйгээр шаардлагатай мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзсан эсвэл түүнийг тохиромжтой хугацааны дотор гаргаж өгөхгүй байгаа эсвэл эрх хэрэгжүүлэх хянан шийдвэрлэх ажиллагаанд ноцтойгоор саад учруулсан бөгөөд талуудад гаргасан

мэдэгдэл, нотолгоонд өөрийн байр сууриа илэрхийлэх боломжийг олгосон байсан бол нэхэмжлэл, мэдээлэл гаргаж өгөөгүйн улмаас үндэслэлээ гаргахад нь саад болж байгаа талын мэдэгдлийг оролцуулан гарт байгаа мэдээлэл дээр үндэслэн зөвшөөрсөн эсвэл татгалзсан урьдчилсан ба эцсийн шийдвэрийг гаргах эрхийг гишүүн өөрийн улсын шүүхэд өгч болно.

44-р зүйл. Таслан зогсоох

1. Шүүх нэн ялангуяа импортоор орж ирж буй оюуны өмчийн зөрчилтэй барааг гаалийн бүртгэлд орсны дараа өөрийн харьяа нутаг дэвсгэрийн худалдааны сүлжээнд орохыг зогсоохын тулд оюуны өмчийн зөрчлөө таслан зогсоохыг нэг этгээдээс шаардах эрхтэй байна. Хэрэв тухайн этгээд барааг оюуны өмчийн зөрчилтэй болохыг мэдээгүй буюу нөхцөл байдлыг ухаалгаар дүгнэж үзвэл ийнхүү мэдэх боломжгүй байсан бол гишүүд тухайн этгээдийн худалдаж авсан буюу захиалсан эрхийг хамгаалалтын зүйлийн хувьд энэ эрх хэмжээг хэрэгжүүлэх үүрэг хүлээхгүй.

46-р зүйл. Бусад нэхэмжлэлийн шаардлагууд

Зөрчил дахин гаргаж болохгүйг үр дүнтэйгээр, хатуугаар сануулах зорилгоор шүүхийн байгууллага зөрчилтэй гэж үзсэн барааг аливаа нөхөн төлбөр төлөхгүйгээр худалдааны сүлжээнээс устгал хийх замаар гаргахыг захирамжилж болно. Энэ үйл ажиллагаа нь эрх эзэмшигчид хохирол учруулах нөхцөлийг арилгах зорилготой бөгөөд тухайн улсын үндсэн хуулийн хүрээнд явагдах ёстой. ... Холбогдох хүсэлтийг хангахдаа зөрчлийн хүнд, хөнгөн байдал ба гуравдагч этгээдийн сонирхлыг харьцуулан үзэх шаардлагыг анхааран үзэх ёстой. Барааны тэмдгийн зөрчилтэй барааны хувьд зөвхөн онцгой тохиолдолд л бараан дээр хууль бусаар зүүж, наасан барааны тэмдгийг авч хаяж барааг чөлөөт эргэлтэд оруулахыг зөвшөөрч болно.

3-Р БҮЛЭГ. ГАРАХ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙГ УРЬДЧИЛАН БАТАЛГААЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

50-р зүйл.

1. Шүүх гарах шийдвэрийн биелэлтийг урьдчилан баталгаажуулах арга хэмжээг хурдан, үр дүнтэйгээр дараах тохиолдолд авна.

(а) оюуны өмчийн зөрчлийг гарахад хаалт хийх, аливаа барааг, үүний дотор импортоор орж ирж буй барааг гаалийн бүртгэлд орсных нь дараа харьяа нутаг дэвсгэрийн худалдааны сүлжээнд орохоос урьдчилан сэргийлж, нэн даруй хориг тавих;

(б) буруутгаж буй зөрчилтэй холбоотой нотлох баримтыг баталгаажуулах.

2. Шүүх эсрэг талын байр суурийг урьдчилан сонсолгүйгээр гарах шийдвэрийн биелэлтийг урьдчилан баталгаажуулах арга хэмжээг нэн ялангуяа хэрэв цаг алдвал эрх эзэмшигчид дахин сэргээж болохгүй хохирол учрах боломжтой үед эсвэл нотлох баримтыг устгаж болох эрсдэл бодитойгоор бий болсон үед авна.

3. Нэхэмжлэгч өөрөө эрх эзэмшигч мөн гэдгийг, түүний эрх зөрчигдсөн гэдгийг эсвэл ийнхүү эрх зөрчигдөх бодит нөхцөл бий болсон гэдгийг хангалттай хэмжээнд мэдэж авахын тулд шүүх нэхэмжлэгчээс нөхцөл байдлыг ухаалгаар шинжилж үзэхэд түүний гар дээр байх ёстой аливаа нотлох баримтыг гаргаж өгөхийг шаардах эрхтэй бөгөөд шүүх хариуцагчийг хамгаалахын тулд ба эрх буруугаар ашиглахын эсрэг баталгаа болгож мөнгөн баталгаа эсвэл түүнтэй дүйцэх аливаа баталгааг гаргахыг нэхэмжлэгчид захирамжлах эрхтэй.

4. Гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг эсрэг талын байр суурийг урьдчилан сонсолгүйгээр авах үед холбогдох талд энэ талаар үйл ажиллагааг явуулсны

www.ni.gov.mn

эрх эзэмшигч холбогдох хугацааны дотор нэхэмжлэл, шаардлага гаргах эрхээ хэрэгжүүлээгүй бол баталгааг суллаж өгнө.

54-р зүйл. Барааг саатуулсан тухай мэдэгдэл

51-р зүйлийн дагуу барааг саатуулсан бол энэ тухай импортлогч, хүсэлт гаргагчид нэн даруй мэдэгдэнэ.

55-р зүйл. Бараа саатуулах хугацаа

Барааг саатуулсан тухай мэдэгдлийг хүсэлт гаргагч хүлээж авснаас хойш ажлын 10 хоногийн дотор хариуцагчаас бусад өөр нэг талын санаачилгаар холбогдох асуудлыг шийдвэрлэх процессыг эхлүүлсэн гэж гаалийн байгууллага мэдэгдэл аваагүй бол эсвэл эрх бүхий байгууллага гарах шийдвэрийн биелэлтийг урьдчилан баталгаажуулах замаар барааг саатуулах хугацааг сунгасан тухай мэдээллийг гаалийн байгууллагад өгөөгүй бол барааг импортлох, экспортлох нөхцөлүүд биелсэн үед барааг чөлөөлж өгнө; шаардлагатай нөхцөлд энэ хугацааг дахин 10 хоногоор сунгаж болно. Хэрэв холбогдох асуудлыг шийдвэрлэх процессыг эхлүүлсэн бол өөрийгөө өмгөөлөх боломжийг хариуцагчид олгож хариуцагчийн хүсэлтээр холбогдох арга хэмжээг өөрчилж, хүчингүй болгож эсвэл хүчин төгөлдөр үлдээх талаар үйл ажиллагаанд тохирсон хугацааны дотор шийдвэр гаргана. Дээрх заалтуудыг үл харгалзан барааг саатуулах арга хэмжээг шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах замаар авч байгаа үед 50-р зүйлийн 6-р заалтыг хэрэглэнэ.

56-р зүйл. Импортлогч ба барааны эзэнд учирсан хохирлыг нөхөн төлөх

Барааг хууль ёсны эрхгүйгээр саатуулснаас эсвэл 55-р зүйлийн дагуу чөлөөлсөн барааг саатуулснаас улбаалж барааны импортлогч, хүлээн авагч, өмчлөгчид учирсан хохирлыг хүсэлт гаргагчаар төлүүлэхийг захирамжлах эрхийг харьяалах байгууллага эдэлнэ.

57-р зүйл. Танилцах, мэдээлэл авах эрх

Эрх эзэмшигч тавьсан шаардлагадаа үндэслэл гаргахад зориулж саатуулсан бараатай танилцах боломжийг хангалттай хэмжээгээр олгох эрхийг гишүүд нууцлах мэдээллийг хамгаалсны үндсэн дээр харьяалах байгууллагад олгоно. Харьяалах байгууллага нь бараатай танилцах боломжийг мөн адил хэмжээгээр импортлогчид олгох эрх хэмжээтэй байна. Харьяалах байгууллагын шийдвэр хүсэлт гаргагчийн талд гарсан үед гишүүд барааг илгээгч, импортлогч ба хүлээн авагчийн нэр, хаяг ба холбогдох барааны хэмжээг эрх эзэмшигчид мэдээлэх эрхийг харьяалах байгууллагад олгоно.

---o0o---

дараа нэн даруй бичгээр мэдэгдэх ёстой. Хариуцагчийн хүсэлтээр өөрийгөө өмгөөлөх боломжийг хариуцагчид Мэдэгдэл хүлээж авснаас хойш тодорхой хугацааны дотор олгох бөгөөд ингэснээр

холбогдох арга хэмжээг өөрчилж, хүчингүй болгох боломжтой байх ёстой.

5. Нэхэмжлэгчээс урьдчилан баталгаажуулах арга хэмжээг авах барааг тодорхойлоход шаардлагатай бусад мэдээллийг өгөхийг шаардаж болно.

6. Хэргийн талаар шийдвэр гаргах хянан шийдвэрлэх ажиллагаа тухайн нөхцөл байдлаас үзэхэд анхаарах ёстой, гишүүний хуульд заасны дагуу шүүхээс тогтоосон хугацааны дотор эсвэл ийм хугацаа зааж өгөөгүй бол ажлын 20 өдөр буюу календарын 31 өдрийн дотор буюу эдгээрийн аль сүүлд дууссан өдрөөр тооцсон хугацааны дотор эхлээгүй бол 4-р зүйлийг анхааран үзэж, түүний 1, 2-р заалтуудад заасан арга хэмжээг хариуцагчийн хүсэлтээр хүчингүй болгож эсвэл өөр ямар нэг замаар үйлчлэлийг нь зогсоож болно.

7. Гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг хүчингүй болгосон эсвэл нэхэмжлэгчийн үйлдэл, эс үйлдлээр ийм шаардлага байхгүй болсон эсвэл оюуны өмчийн зөрчил гараагүй буюу ийм зөрчил гарах бодит нөхцөл бий болоогүй байсан нь тодорхой бол шүүх хариуцагчийн хүсэлтээр түүнд арга хэмжээнээс болж үүссэн хохирлыг тохирсон хэмжээгээр нөхөн төлүүлэхийг нэхэмжлэгчид захирамжлах эрхтэй.

8. Захиргааны журмаар аливаа урьдчилан баталгаажуулах арга хэмжээг авах үед ийм арга хэмжээ нь энэ бүлэгт заасан зарчмуудад нийцэж байх ёстой.

4-Р БҮЛЭГ. ХИЛ ДЭЭР ХИЙХ ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ШААРДЛАГА

51-р зүйл. Гаалийн байгууллагаас барааг чөлөөлөхгүй байх

Гишүүд доор заасан заалтуудад нийцүүлэн барааны тэмдгийг дуурайлгасан... барааг импортоор орж ирэх гэж байна гэсэн үндэслэл бүхий сэжиг байгаа үед харьяалах шүүх, захиргааны байгууллагад барааг гаалийн байгууллагаас чөлөөт эргэлтэд оруулахыг зогсоох хүсэлтийг бичгээр гаргах боломжийг эрх эзэмшигчид олгоно...

52-р зүйл. Хүсэлт

51-р зүйлийн дагуух процедурыг эхлүүлэх хүсэлт гаргасан аливаа эрх эзэмшигч импортлох улсын хуулийн дагуу оюуны өмчийн эрх эзэмшигчийн эрх зөрчигдөхөөр байгаа гэж гэрчлэх нотолгоог, түүнчлэн гаалийн байгууллагаас барааг хялбар таних боломжтой барааны нарийн тодорхойлолтыг харьяалагдах байгууллагад гаргаж өгөх үүрэгтэй. Харьяалагдах байгууллага нөхцөл байдлыг ухаалгаар шинжилж үзсэний үндсэн дээр анхаарах ёстой хугацааны дотор хүсэлтийг нь хүлээж авсан эсэхийг хүсэлт гаргагчид мэдэгдэх ба хэрэв гаалийн байгууллага авах арга хэмжээний хугацааг урьдчилан тогтоосон бол холбогдох хугацааг хүсэлт гаргагчид мөн мэдэгдэнэ.

53-р зүйл. Мөнгөн барьцаа ба дүйцэх баталгаа

1. Хариуцагчийг ба эрх бүхий байгууллагыг хамгаалах болон эрх буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хүсэлт гаргагчаас мөнгөн барьцаа гаргах эсвэл түүнд дүйцэх баталгаа гаргахыг харьяалах байгууллага шаардах эрхтэй. Ийм мөнгөн барьцаа ба түүнд дүйцэх баталгаа нь арга хэмжээг авахгүй байх нөхцөлийг ухаалаг бусаар бүрдүүлж болохгүй.

2. ... Ийм баталгааны төлбөр нь хуулийн дагуух бусад шаардлага, нэхэмжлэл тавих эрх эзэмшигчийн эрхийг хязгаарлаж болохгүй ба хэрэв

байна. Үүнээс үзвэл, эрэн сурвалжлах ажил нь гэмт хэргийг илрүүлэх, гэмт этгээдийг олж тогтоох ажиллагаа болох эсэх нь эргэлзээтэй болно.

Монгол хэлний тайлбар тольд "эрэн сурвалжлах" гэдэг үгийн үндэс болох **"эрэх"** гэдэг нь "мэдье ольё гэж хайх, сурвалжлах;, эрэх сурах, эрэх хайх, эрэх сурвалжлах"[3] гэсэн утгатай, **"илрүүлэх"** нь "ил болгох"[4];, **"тогтоох"** гэдэг нь "алив юмыг үүсгэх, бий болгох, байгуулах"[5] гэсэн утгатай гэж тайлбарлажээ. Эндээс үзвэл, эрэн сурвалжлах болоод илрүүлэх, тогтоох зэрэг нэр томьёо нь агуулгын хувьд өөр өөр утгатай аж.

Тэгвэл хууль зүйн хувьд эрэн сурвалжлах гэдэгт юуг ойлгох бэ?

Манай улсын хууль зүйн салбарын бүтээлүүдээс үзэхэд, эрэн сурвалжлах ажлын тухай онолын тодорхойлолт нэн хомс юм. Гүйцэтгэх ажил судлаачдын ил бүтээлүүдэд ч эрэн сурвалжлах ажлын тухай онолын тайлбар байхгүй, ихэвчлэн Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан нэр томьёоны тодорхойлолтыг иш татсан нь ажиглагдаж байна.[6]

Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн салбарын эрдэмтэн, судлаачид хамтран бичсэн "Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар"-т "Эрэн сурвалжлах арга хэмжээ гэдэг нь оргон зайлсан сэжигтэн, яллагдагчийг олж баривчлахад эрлийн сэжиг таамаглал дэвшүүлэх, мөрдөн мөшгих болон тодорхой ЭБШ ажиллагаа явуулахыг хэлнэ" гэж тодорхойлжээ.[7] Энэ тодорхойлолтын дагуу эрэн сурвалжлах арга хэмжээ нь үндсэндээ оргон зайлсан сэжигтэн, яллагдагчийг олж баривчлахад чиглэсэн ажиллагаанууд болж байна. Харин тус тайлбарт, **"Гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх** гэдэг нь гэмт хэрэг гарсан байдлыг боломжтой хамгийн богино хугацаанд бодитойгоор сэргээн тогтоох явдал юм", **"Гэмт этгээдийг олж тогтоох** гэдэгт гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж, түүний гэм бурууг үндэслэл бүхий эргэлзээгүйгээр нотлохыг ойлгоно"[8] гэж тодорхойлсон нь эрэн сурвалжлахаас эрс өөр агуулгатайг харуулдаг.

Академич С.Нарангэрэл "Эрх зүйн эх толь бичиг" бүтээлдээ,"Эрэн сурвалжлах (англ. search; ор.розыск) -мөрдөлт ба шүүхээс оргон зайлсан яллагдагчийг илрүүлэх, байгаа газрыг тогтоох, ял эдлэхээс оргон зайлсан шүүгдэгч буюу хорих газраас оргосон ялтныг олоход чиглэгдсэн төрийн эрх хэмжээ бүхий (хэрэг бүртгэх, мөрдөн байцаах зэрэг) байгууллагын үйл ажиллагаа. Хэрэв гэмт этгээд тодорхой бус бол түүнийг тогтоох арга хэмжээ эрэн сурвалжлах ойлголтод хамаарахгүй бөгөөд гэмт хэргийг мөрдөх ба илрүүлэх агуулгатай болно." гэж тайлбарлажээ.[9]Энэ тайлбар үндсэндээ оргон зайлсан яллагдагч, шүүгдэгч, ялтныг олоход чиглэсэн үйл ажиллагаа гэдэг утгыг нэгэн адил агуулж байна. Гэхдээ академич С.Нарангэрэл гэмт этгээд тодорхой бус бол түүнийг тогтоох арга хэмжээ нь эрэн сурвалжлах бус, гэмт хэргийг мөрдөх, илрүүлэх ажиллагаанд хамаарна гэснээрээ эрэн сурвалжлах болон гэмт хэрэг үйлдсэн этгээдийг илрүүлэх ажиллагаа ялгаатай гэсэн зарчмын чухал санааг хөндсөн.

Гадаад орнуудын, тухайлбал, манай улстай адил гүйцэтгэх ажлын тухай төрөлжсөн хуультай ОХУ болон ТУХН-ийн бусад орнуудад эрэн сурвалжлах ажлыг гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа, эсхүл үйлдэж байгаа болон

[3] Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.,1966 он. 889 дүгээр талд.

[4] Мөн тэнд. 303 дугаар талд.

[5] Мөн тэнд. 434 дүгээр талд.

[6] Ц.Доржням, М.Цогтоо, С.Эрдэнэ. Аюулгүй байдлын нэр томьёоны тайлбартоль. УБ.,2016гэх мэт.

[7] Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар. УБ.,2003 он. 290 дүгээр талд.

[8] Мөн тэнд. 11 дүгээр талд.

[9] С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ.,2008, 623 дугаар талд.

ЭРЭН СУРВАЛЖЛАХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ЗҮЙН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ



Үндэсний тагнуулын академийн Эрх зүйн тэнхимийн эрхлэгч, докторант, дэд хурандаа Б.Батхишиг

Хураангуй. Эл өгүүлэл нь эрэн сурвалжлах ажлын тухай үндэсний болон бусад орны онолын болон хууль зүйн ойлголтыг судлан шинжилсний үндсэн дээр Гүйцэтгэх ажлын тухай Монгол Улсын хуульд заасан эрэн сурвалжлах ажлын тухай нэр томьёоны тодорхойлолт, холбогдох хэм хэмжээг боловсронгуй болгоход чиглэсэн болно.

Түлхүүр үг: Гүйцэтгэх ажил, эрэн сурвалжлах ажил, эрэн сурвалжлах обьект, эрэн сурвалжлах үндэслэл.

Хууль сахиулах байгууллагын, түүний дотор гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын үйл ажиллагааны нэг чухал чиглэл бол эрэн сурвалжлах ажил юм.

Тодорхой хүн, эд зүйлийг эрэн сурвалжлахтай холбоотой хэм хэмжээ Монгол Улсын олон хууль тогтоомжид тусгагдсан байдаг ч зөвхөн Гүйцэтгэх ажлын тухай хууль[1]-д нэр томьёоны хууль зүйн тодорхойлолт өгсөн. Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Эрэн сурвалжлах ажил" гэж Тагнуулын байгууллага цагдаа, хорих ял эдлүүлэх байгууллагад Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад хууль тогтоомжоор харьяалуулсан эрүүгийн хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох чиглэлээр хийх нууц ажиллагааг хэлнэ." хэмээн тодорхойлжээ. Гэхдээ тухайн нэр томьёоны гол агуулга нь "хуулиар харьяалуулсан эрүүгийн хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох чиглэлээр хийх" гэдэгт төвлөрч байгаа нь гүйцэтгэх ажил болон Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 6 дугаар зүйлд заасан "... аливаа гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлж, гэмт этгээдийг олж тогтоох..." эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилтыг шийдвэрлэхэд чиглэсэн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанаас эрэн сурвалжлах ажил нь үндсэндээ ялгаагүй болжээ.

Гэтэл Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль[2] -ийн 65.4-т,"... оргосон этгээдийг эрэн сурвалжлах", 99.1.3-т "хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурор, шүүхээс оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг эрэн сурвалжлах", 206.1-д "Сэжигтэн, яллагдагч оргон зайлсан бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрэн сурвалжлах арга хэмжээг авна" гэж зааснаас үзэхэд, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд эрэн сурвалжлах ажил нь гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг тогтоох бус, мөрдөн шалгагдаж байгаа тодорхой этгээд оргон зайлсантай холбоотой авч үзсэн

[1] Гүйцэтгэх ажлын тухай тухай Монгол Улсын хууль – ТМ., УБ., 1999., №3

[2] Эрүүгийн байцаан шийтгэх хууль – ТМ., УБ.,2002., №6

хуулийн үндэсний хэрэгжилт www.nlo.gov.mn

үйлдсэн этгээдийг илрүүлэх, тогтоох зорилтоос тусад нь гүйцэтгэх ажлын бие даасан зорилт болгож нийтлэг хуульчилсан байна. Ингэхдээ эрэн сурвалжлах зорилтын хүрээнд гол төлөв хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, шүүхээс оргон зайлсан болон хорих байгууллагаас оргосон, түүнчлэн сураггүй алга болсон хүнийг эрэн сурвалжлах явдлыг авч үзжээ. Тухайлбал, ОХУ-ын Гүйцэтгэх ажлын тухай хууль[10]-ийн 2-р зүйлд эрэн сурвалжлах обьект нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, шүүхээс оргон зайлсан, эрүүгийн хариуцлагаас зайлсхийсэн, түүнчлэн сураггүй алга болсон этгээд байхаар заасан нь бусад оронд нийтлэг шинжтэй юм. Гэхдээ зарим оронд эрэн сурвалжлах обьектыг илүү өргөн хүрээнд хуульчилсан байна. Тухайлбал, Казахстан, Узбекстаны хууль[11]-д дээрх обьектуудаас гадна хэн болох нь тодорхойгүй цогцос болон холбогдох хуулиар эрэн сурвалжлахаар заасан бусад этгээдийг, Молдав Улс хууль бус үйл ажиллагаанаас олсон хөрөнгө мөнгийг илрүүлэх болон тухайн хөрөнгийн гарал үүсэлтэй холбоотой нотлох баримт цуглуулахыг нэмж заажээ.

Дээр дурдсан орнуудын гэмт хэргийг илрүүлэх ажиллагаанаас эрэн сурвалжлах ажлыг ялгаж, тодорхой обьектыг эрж олох явдлаар түүний агуулга, хүрээг хязгаарласан хууль тогтоомжийн үзэл баримтлал нь судлаач, эрдэмтдийнх нь ном бүтээлд тусгалаа олсон байна. Тухайлбал, ОХУ-ын гүйцэтгэх ажил судлалын салбарын нэрт эрдэмтэн, хууль зүйн ухааны доктор, профессор А.Шумилов "Эрэн сурвалжлах нь эрэн сурвалжлагдаж буй этгээдийн байгаа газрыг тогтоож баривчлах зорилгоор явуулж байгаа гүйцэтгэх ажлын арга хэмжээ, эрэн сурвалжлах арга хэмжээ болон бусад арга ажиллагаа (эрүүгийн процессын ажиллагаа багтана)-ны цогц юм" гэж тодорхойлоод, эрэн сурвалжлах ажлыг үндсэндээ мөрдөн шалгах байгууллага болон гүйцэтгэх салбар нэгж хамтран явуулна гэж онцолжээ.[12] А.Ю.Шумилов өөр нэг бүтээлдээ эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны болон гүйцэтгэх ажлын хүрээнд явуулах эрэн сурвалжлах ажлыг ялгаж, "Эрэн сурвалжлах үйл ажиллагаа нь эрүүгийн процессын үйл ажиллагааны нэг хэсэг болохын хувьд эрүүгийн процессын хууль тогтоомжоор зохицуулагдана. Тэр нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага болон шүүхээс (яллагдагч г.м) оргон зугтсан этгээдийн байгаа газрыг тогтооход чиглэсэн эрх бүхий субьектүүд (хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэх байгууллага)-ийн явуулж буй ажиллагааны цогц юм.

Эрэн сурвалжлах үйл ажиллагаа нь гүйцэтгэх ажлын бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд гүйцэтгэх ажлын салбарын хууль тогтоомжоор зохицуулагдах бөгөөд тэр нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, шүүхээс оргон зугтсан этгээд(яллагдагч г.м), эрүүгийн ял шийтгэл эдлэхээс зайлсхийсэн этгээд (эрүүгийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон бусад байгууллагаас оргосон ялтан г.м), сураггүй алга болсон болон бусад этгээдийн байгаа газрыг тогтооход чиглэсэн эрх бүхий субьектүүд (гүйцэтгэх ажилтан г.м)-ээс гүйцэтгэх ажлын арга хэмжээ явуулах замаар тухайн үйл ажиллагаа(эрэн сурвалжлах)-ны зорилтыг шийдвэрлэхэд оршино." гэж тус тус тодорхойлжээ.[13]

ОХУ-ын гавьяат хуульч, хууль зүйн ухааны доктор, профессор А.Е.Чечетин "Эрэн сурвалжлах ажлыг гэмт хэргийг илрүүлэх иж бүрэн үйл ажиллагаанаас ялгах нь зүйтэй. Хэрэв эрэн сурвалжлах ажлын үндсэн зорилт нь өмнө аль

[10] Федеральный закон РФ "Об оперативно-розыскной деятельности. 12.08.1995, №144-ФЗ

[11] Закон Республики Узбекстан "Об оперативно-розыскной деятельности. 25.12.2012, №ЗРУ-344

[12] А.Ю.Шумилов. Курс основ оперативно-розыскнойдеятельности: Учебник. М..2007, С.318

[13] А.Ю.Шумилов. Оперативно-розыскнаяэнциклопедия. М.,2004. С.67

хэдийн тодорхой болсон, эрүүгийн хариуцлагад татах зайлшгүй эрх зүйн үндэслэлтэй болох нь тогтоогдсон этгээдийг олж илрүүлэх явдал байдаг бол, гэмт хэргийг илрүүлэх үндсэн зорилго нь гэмт хэрэг үйлдсэн, тодорхой бус этгээдийг тогтоох, түүний гэм бурууг нотлох баримтыг цуглуулах явдал болно" гэж эдгээрийн гол ялгааг тайлбарлажээ.[14] Тэрээр бас "Эрэн сурвалжлах ажил нь гүйцэтгэх болон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг цогцоор нь явуулахад үндэслэгддэг хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны нэг төрөл болохын хувьд нэгэн зэрэг гүйцэтгэх ажлын ч, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны ч бүрэлдэхүүн хэсэг болно" гэж онцлон тэмдэглэсэн байна.

Хууль зүйн ухааны доктор, профессор Е.С.Дубоносов "Эрэн сурвалжлах ажил нь тодорхой этгээд эрүүгийн хариуцлагад татагдах, хүлээсэн үүргээ гүйцэтгэх, ял эдлэхээс зайлсхийх, сураггүй алга болохоос урьдчилан сэргийлэх,хэн болох нь тодорхойгүй хүнийг тогтоох болон эрэн сурвалжлагдаж буй этгээдийг хуульд заасан арга ажиллагаа явуулах замаар олж илрүүлэхэд чиглэсэн хууль сахиулах байгууллагын эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдсан үйл ажиллагаа" гэж тодорхойлжээ.

Хууль зүйн ухааны дэд эрдэмтэн Е.С.Лапин "Эрэн сурвалжлах ажил нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, сураггүй болсон болон эрэн сурвалжлагдаж байгаа бусад этгээдийн байгаа газрыг тогтоох, түүнчлэн эрэн сурвалжлагдагч, сураггүй болсон этгээд удаан хугацаанд нуугдаж орогноход нөлөөлж байсан шалтгаан нөхцөлийг илрүүлж арилгахад чиглэсэн, эрх бүхий, эсхүл эрх олгосон албан тушаалтнуудаас Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль болон бусад эрх зүйн хэм хэмжээний актад заасан журмын дагуу тусгай хэрэг шалгах ажиллагааны хүрээнд гүйцэтгэх ажил, эрүүгийн процессын, мэдээлэл-лавлагааны болон бусад арга хэмжээнүүдийг иж бүрэн авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм" гэж тодорхойлжээ.[15]

Дээр дурдсан үндэсний болон гадаад орнуудын хууль тогтоомжийн холбогдох хэм хэмжээ, эрдэмтэн судлаачдын үзэл санаанд нэгтгэн шинжлэхэд гүйцэтгэх ажлын эрэн сурвалжлах ажил нь дараах онцлог шинжтэй юм. Үүнд:

1.Эрэн сурвалжлах болон гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа эсхүл үйлдэж байгаа болон үйлдсэн этгээдийг илрүүлэх, тогтоох ажиллагаа нь харилцан адилгүй ойлголт төдийгүй гүйцэтгэх ажлын тус тусдаа бие даасан зорилт болж байна.

2.Эрэн сурвалжлах ажил нь өргөн агуулгаараа эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудаас тодорхой обьектыг эрж олоход чиглэсэн гүйцэтгэх ажил, эрүүгийн процессын болон бусад арга хэмжээний цогц болох боловч гүйцэтгэх ажлын талаас нь гүйцэтгэх байгууллага, албан тушаалтнаас хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлэх гүйцэтгэх ажлын арга хэмжээ, ажиллагаанууд болох онцлогоор нь тодорхойлох боломжтой юм.

3.Эрэн сурвалжлах ажил нь гол төлөв мөрдөн шалгах байгууллага, гүйцэтгэх байгууллагын хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагаа болохын хувьд гүйцэтгэх ажлын ч, эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжоор ч зохицуулагдана.

4.Гэмт хэргийг илрүүлэх, гэмт этгээдийг тогтооход чиглэсэн гүйцэтгэх ажлын болон эрүүгийн мөрдөн шалгах ажиллагааны обьект нь хэн болох нь тодорхой бус байдаг бол гүйцэтгэх

[14] Под.ред. Горяинов К.К., Овчинский В.С., Синилов Г.К. Теорияоперативно-розыскнойдеятельности: Учебник. М.,2007. С.509

[15] Лапин Е.С., Михайлов Ю.Н. Краткий курс теоретических основ оперативно-розыскной деятельности: Учеб. пособ. Саратов.,2006 С 94

ажлын эрэн сурвалжлах ажлын обьект нь нэгэнт тодорхой болсон этгээд (сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан) этгээд болно.

5.Эрүүгийн процессод эрэн сурвалжлах обьект нь зөвхөн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч байх бол гүйцэтгэх ажилд эрэн сурвалжлах обьект нь эдгээрээс гадна сураггүй болсон этгээд, оргосон ялтан, холбогдох хуулиар эрэн сурвалжлахаар заасан хүн, бусад зүйл болдгоороо илүү өргөн хүрээтэй юм.

Энэ бүхнээс үзвэл, эрэн сурвалжлах ажил нь Гүйцэтгэх ажлын тухай Монгол Улсын хуульд тодорхойлсончлон хуулиар харьяалуулсан эрүүгийн хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох чиглэлээр хийх ажиллагаа биш болох нь тодорхой харагдана. Түүнээс гадна дээрх шинжүүдийн дагуу бол Гүйцэтгэх ажлын тухай Монгол Улсын хуульд заасан эрэн сурвалжлах ажил явуулахтай холбоотой олон хэм хэмжээ тухайн үйл ажиллагааны агуулгад нийцэхгүй байгаа нь илэрхий байна. Тухайлбал, Гүйцэтгэх ажлын тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т,цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ажил явуулах үндэслэл нь:

-Хуулиар харьяалуулсан гэмт хэргийг далд аргаар үйлдсэн буюу үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай үндэслэл бүхий мэдээллийг ердийн арга хэрэгслээр шалгах боломжгүй;

-Хуулиар харьяалуулсан гэмт хэрэг үйлдсэн этгээдийг өөр арга, хэрэгслээр олж тогтоох боломжгүй;

-Эрүүгийн хэргийн нотолгоог бүрэн гүйцэд шалгах зорилгоор шүүх, прокурор, мөрдөн байцаагчаас даалгавар ирүүлсэн;

-Барьцаанд байгаа хүнийг суллах, сураггүй алга болсон хүнийг эрж олох талаар байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлт буюу өөрт байгаа баримтыг үндэслэн;

-Энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д заасан баримт бичиг, эд зүйлийг эрж олох талаар байгууллага, иргэдээс хүсэлт ирүүлсэн;

-эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээг Монгол Улстай байгуулсан гадаад улс, олон улсын байгууллагаас хүсэлт ирүүлсэн.” зэрэг байхаар заасан, мөн хуулийн 11.4-т “Хорих ял эдлүүлэх байгууллага тус хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасан зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хоригдлын дунд, түүнчлэн оргосон ялтныг баривчлах зорилгоор эрэн сурвалжлах ажил явуулна.” гэж заасан нь илт зөрчилтэй болсон.

Эдгээр заалтад цагдаагийн байгууллагын хувьд барьцаанд байгаа хүн, сураггүй алга болсон хүнийг эрж олох, нотлох баримт, алдагдсан нууц баримт бичиг, эд зүйл, галт хэрэгсэл, зэвсэг, тэсрэх болон хүчтэй хордуулах, цацраг идэвхит, мансууруулах бодис, түүх соёлын дурсгалт зүйл, нуугдмал эд хөрөнгийг эрж олох;, хорих байгууллагын хувьд оргосон ялтныг баривчлах зэрэг нь эрэн сурвалжлах ажил явуулах үндэслэл байх ёстой атал гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тогтоох ажиллагаа явуулах үндэслэлтэй хольж хутгасан байна. Ингэснээр аль тохиолдолд нь эрэн сурвалжлах ажил, аль тохиолдолд нь гүйцэтгэх ажил явуулах нь тодорхойгүй байдалд оржээ. Энэ мэтчилэн Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан олон зөрчил, дутагдалтай хэм хэмжээг дурдаж болно.

Энэ бүхний шалтгаан нь тус хуульд эрэн сурвалжлах ажлыг онолын үндэслэлгүй буюу оновчгүй тодорхойлсонтой шууд холбоотой.

Ийм учраас өнөөдөр бидэнд Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан эрэн сурвалжлах ажлын тухай хууль зүйн нэр томьёоны тодорхойлолтыг тухайн нэр томьёоны үндсэн агуулга,

гадаад орнуудын нийтлэг жишигт нийцүүлэн засаж залруулан хуульчлах, гүйцэтгэх байгууллага, ажилтнуудыг нэгдсэн ойлголттой болгох зайлшгүй шаардлагатай байна. Энэ шаардлагын дагуу хийсэн судалгаа, шинжилгээндээ тулгуурлан Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасан эрэн сурвалжлах ажлын тухай хууль зүйн нэр томьёоны тодорхойлолтыг **“мөрдөн шалгах байгууллага, прокурор, шүүхээс оргон зугтсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хорих байгууллагаас оргосон ялтан, сураггүй болсон болон бусад хуульд эрэн сурвалжлахаар заасан этгээд, түүнчлэн энэ хууль-д заасан баримт сэлт, бусад зүйлийг эрж олоход чиглэсэн гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ердийн ба тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглан явуулж байгаа үйл ажиллагааг хэлнэ”** хэмээн өөрчлөн хуульчлах санал дэвшүүлж байна.

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ЭРҮҮГИЙН ЯЛ БА ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГЫН БУСАД АРГА ХЭМЖЭЭ

(Шинэ, хуучин эрүүгийн хуулиудын харьцуулалтын жишээн дээр)



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч профессор Д.Баярсайхан (Ph.D)



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант Ц.Мэргэн

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРАЛЦАЛТЫН www.nli.gov.mn

1. Оршил

Монгол Улс төр ёс, хууль цаазын 800 гаруй жилийн арвин баялаг уламжлалтай (1206) боловч анхны эрүүгийн төрөлжсөн хуулийг 1926 онд гаргаж ирсэн түүхтэй. 1926 оны анхны эрүүгийн хуулиас хойш эдүгээ хүртэл нийт 8 удаа эрүүгийн хуулийг шинээр баталсан байдаг. (1926, 1934, 1942, 1960, 1987, 1994, 2002, 2016)

1990-ээд оноос хойш дэлхийн олон улс орон эрүүгийн эрх зүйн салбарт реформ хийж чадсан бөгөөд ялангуяа ялын бодлогод хүмүүнлэгийн хандлага хүчтэй илрэх болсон ба Олон улсын гэрээ, хэлэлцээр цөөнгүй гарсныг тэмдэглэх нь зүйтэй.

Пост-Комунист орнууд, тэр тусмаа Монгол Улсад ялыг төрийн бодлогын хүрээнд хэт явцуурууллан ойлгож түүний зорилгыг цээрлүүлэх болон дахин хүмүүжүүлэх гэсэн утгаар авч үзэж байсан нь ялын абсолют онолын туйлширсан догматик хандлага болж хэрэглэгдэж байв. Үүнээс үүдэн ялын үндсэн төрлийг хорих ялаар зонхилон төлөөлүүлж, ял эдэлсэн гэдгийг шоронд хоригдсон мэтээр төсөөлөн ойлгож байсан нь саяхан. Түүнчлэн Монгол Улсад хорих ялыг зөвхөн шоронгийн дэглэмд эдлүүлдэг байхаар олон жил хуульчилж ирсэн. Сүүлийн 30 шахам жилд шүүхийн тогтоолоор нийт эдлүүлсэн ялын дийлэнх хувь нь (75-85 хувь) шоронгийн дэглэмтэй хорих ял байдаг ба нээлттэй буюу хаалттай хорих байгууллагын тоттолцоо тус улсад бий болоогүй байна.

Орчин үеийн глобалчлалын нөхцөлд Монгол Улс шилжилтийн үеийн үр дагаврыг даван туулж байгаагаас эрх зүйн харилцааны орчин тогтворгүй (хуулиудын ихэнх нь богино хугацаанд олон удаа өөрчлөгддөг), социалист эрүүгийн эрх зүйн ялын бодлогын уламжлалыг хадгалсан хэвээр байгааг үгүйсгэх аргагүй.[1] Ялангуяа Монгол Улсад эдүгээ эрүүгийн эрх зүйн

[1] "Шүүх эрх мэдэл" сэтгүүл. 2015. №3. 136-р тал

салбарт реформ хийх шаардлага улам бүр нэмэгдэж, зарим нааштай өөрчлөлт гарч байгаа боловч зарим талаар төрийн бодлогын алдаа гаргах, хэт туйлширсан байдлаар асуудалд хандах, хүний эрхийг зөрчих, гаднын орны хууль, туршлагыг догматик байдлаар хуулбарлах, эсвэл үндэсний уламжлал, онцлогийг туйлшран үнэлж дэлхийн сонгодог зарчмуудыг үгүйсгэх зэрэг сөрөг хандлага нэгэнт бий болсныг анхаарах ёстой. Түүнчлэн нэг сонгуулиас нөгөө сонгуулийн хооронд Парламент, Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлэх 4 жилийн хугацаанд эрүүгийн эрх зүйн бодлого байнга өөрчлөгдөж ирсэн нь эрх зүйн орчин, нөхцөлийг хэвийн бус, тогтворгүй болгож, энэ салбарт гажуудал үүсгэх хүчин зүйл болж байна.

Монгол Улсад ял оногдуулж буй практик, түүний зарчим, үзэл баримтлалд хуучинсаг хандлага давамгайлж, байгаагаас ялын үр дүн хангалтгүй,[2] өнөөгийн Монголын эрүүгийн эрх зүй бүхэлдээ дэлхий нийтийн болон орчин үеийн шаардлагаас ихээхэн хоцрогдож байна.

Монгол Улсад хэвшиж тогтсон эрүүгийн ялын болон эрүүгийн хариуцлага, түүнийг оногдуулах бодлого, практик яг ямар түвшинд байна вэ?

Цаашдаа эрүүгийн ялын реформыг Монгол Улсад хэрхэн хэрэгжүүлэх вэ? Тулгамдсан ямар асуудал байгаа болон тэдгээрийг яаж шийдвэрлэх вэ? Энэ бүхнийг судалгаанд тулгуурлан бодиттойгоор авч үзэж, цаашдын чиг хандлагыг тодорхойлох нь чухал ач холбогдолтой юм.

2.2002 оны Эрүүгийн хууль дахь Эрүүгийн ял ба эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ:

Сургамж, тулгамдсан асуудал

2002 онд Эрүүгийн хуулийг баталснаас хойш цаг үеийн нөхцөл байдал, нийгмийн шаардлагаас шалтгаалан уг хуульд 10 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байдаг. Эдгээр нэмэлт өөрчлөлтүүд нь хохирлын хэмжээ болон гэмт хэрэгт тооцох нөхцөл байдлыг тодорхой болгох, шинэ гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хуульчлах, олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орох, бусад хуулиуд шинээр батлагдсан зэрэгтэй холбоотой.[3]

2002 оны Эрүүгийн хууль дахь Эрүүгийн ялын тогтолцоо, төрлүүд, ял оногдуулан зарчим журам, процедурыг бүхэлд нь дүгнэвэл, өмнөх үеийн Эрүүгийн хуулиудтай (1949, 1960, 1987) харьцуулахад социалист бус агуулгатайн дээр ялын бодлогын зарим уламжлалт шинжийг залгамжлан авсан ба хүнд, онц хүнд гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатган, ял оногдуулах нөхцөл, хэмжээг нэлээд тодорхой болгосон зэргийг дурдаж болно.

2002 оны Эрүүгийн хуулийн 46-р зүйлд зааснаар эрүүгийн ялын 6 үндсэн төрлийг хуульчилсан. Үүнд: 1) Торгох; 2) Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах; 3) Эд хөрөнгө хураах; 4) Албадан ажил хийлгэх; 5) Баривчлах (шинээр нэмсэн); 6)Цаазаар авах.

Торгох, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих, цаазаар авах ялыг үндсэн ялын чанартайгаар; Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасаг ялыг үндсэн ба нэмэгдэл ялын чанартайгаар; Эд хөрөнгө хураах ялыг зөвхөн нэмэгдэл ялын чанартайгаар тус тус хэрэглэхээр хуульчилсан. (ЭХ-ийн 46.2-р зүйл)

Торгох ялын үндсэн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг (240,000₮) 5-15 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тогтоосон байдаг.

Хорих ял нь 1 жилээс 25 жил

[2] Монгол Улсад 2000-2010 онд 4011 хүн шоронгоос суллагдсанаас 47 хувь нь дахин гэмт хэрэг үйлдэжээ. (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тайлан. 2011)

[3] Эрүүгийн хуулийн төсөл. Үзэл баримтлал. УБ., 2015. 5-р тал

ял эзэлдгээр илрэх бөгөөд харин Монгол Улсад сүүлийн 20 жилийн судалгаагаар нийт ялын 75-78 хувийг хорих ял эзэлж байна.[7]

Монгол Улсын Дээд шүүхийн 2015 оны тайлан, мэдээнээс үзэхэд Анхан шатны шүүх 2015 онд нийт 6756 эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэж 7696 хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж үзэж ял шийтгэл оногдуулжээ. Үүнээс 370 хүнийг торгох ялаар; 463 хүнийг албадан ажил хийлгэх ялаар; 957 хүнийг баривчлах ялаар; 5797 хүнийг хорих ялаар шийтгэжээ. Харин 2015 онд 1 хүнд цаазаар авах ял оноосон боловч уг ялыг 25 жилийн хорих ял болгон өөрчилжээ. Түүнчлэн 2015 онд 450 хүнд эд хөрөнгө хураах, 594 хүнд тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах, 87 хүнд тодорхой албан тушаал эрхлэх эрх хасах ял оноосон байна.

Эрүүгийн давж заалдах шатны шүүх 2015 онд эрүүгийн анхан шатны шүүхийн шийдсэн тогтоолын 57.9 хувийг хүчингүй болгох буюу өөрчлөлт оруулсан бол 42.1 хувийг нь хэвээр үлдээжээ.[8] Энэ нь Монгол Улсад хорих ялыг шударга ёсны болон бодит үнэний зарчимд нийцүүлж, оновчтой зөв оногдуулах явдал хангалтгүй байгааг харуулж байна.

2002 оны Эрүүгийн хуулийн 64-р зүйлд зааснаар эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ гэдэгт:

1) Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ

2)Хүмүүнлэгийн чанартай албадлагын арга хэмжээ гэж ангилдаг.

Сэтгэцийн хувьд хэрэг хариуцах чадваргүй үедээ гэмт хэрэг үйлдсэн болон архаг архичин, мансуурах донтой этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авдаг. Харин хөнгөн ба хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээдэд ял оногдуулах нь зохисгүй гэж үзвэл шүүх түүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг дараах байдлаар оногдуулдаг. Үүнд:

1) 6 сараас 1 жил хүртэл хугацаа тогтоож засарч хүмүүжихийг даалгах;

2) 16 насанд хүрсэн этгээд бие дааж орлого олдог бол хохирлыг өөрийн хөдөлмөрөөр арилгах үүрэг хүлээлгэх;

3) Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл садангийн хүний хяналтад өгөх;

4) Хамт олон буюу төрийн бус байгууллага, иргэний хяналтад байлгахаар шилжүүлэх г.м.

Ял бус эрүүгийн хариуцлагын арга хэмжээг нэлээд хязгаарлагдмал байдлаар хэрэглэж ирсэн бөгөөд энэ арга хэмжээг үр нөлөөтэй хэрэглэх эрх зүйн орчин хангалтгүй байна.

2002 оны эрүүгийн хуулийг хэрэгжүүлэх явцад эрүүгийн эрх зүйн хувьд анхаарал татсан дараах тулгамдсан асуудал бий болоод байна.

1)Эдүгээ хорих ял оногдуулж буй шүүхийн практик үр нөлөө муутай, хорих ялын доод хугацаа хэт өндөр гэмт хэргийн ангилал болон эрүүгийн хуулийн хатуу хязгаарт баригдан хорих ялыг нэн түгээмэл байдлаар хавтгайруулан оногдуулж ирсэн нь уг ялын 45-47 хувь нь үр дүнгүй болох нөхцөлийг бүрдүүлж өгчээ.

2)Хорихоос өөр төрлийн ялыг хэрэглэх боломж сонгох нөхцөл хязгаарлагдмал, торгох ялын хэрэгжилт туйлын хангалтгүй (хэрэгжилт 10 хувь)ба торгох ялаас зайлсхийсэн тохиолдолд түүний 40 хувь нь ял завшдаг байна. Торгох ял нийт ялын 15-18 хувийг эзэлж байгаа нь туйлын хангалтгүй үзүүлэлт юм.

3)Насанд хүрээгүй хүнд оноосон нийт ялын зонхилох хувийг хорих ял эзэлдэг ба тэдэнд хорих ялыг нэн түгээмэл хэрэглэж ирсэн нь анхаарал

[7] "NUMlaw Review."2016 №1 р 121

[8] Монгол Улсын Дээд шүүхийн 2015 оны тайлан УБ., 2016. 178-183-р тал

хүртэл хугацаатай байх бөгөөд онц аюултай гэмт хэрэг үйлдсэн этгээдэд 15 жилээс дээш хугацаагаар хорих ялтай.

Одоогоор Эрүүгийн хуулийн 53-р зүйлийн Цаазаар авах ял оноох заалт хүчингүй болоогүй бөгөөд 2011 оноос эхлэн Монгол Улс уг ялыг практикт хэрэглэхээс татгалзаад байгаа юм. (2-р нэмэлт протоколд нэгдэн орсонтой холбоотой)

Монгол Улсад нийт гэмт хэргийн 37.2 хувийг хөнгөн хэрэг, 62.8 хувийг хүндэвтэр, хүнд, онц хүнд хэрэг эзэлж байгааг авч үзвэл хорих ял шийтгүүлсэн нийт хүний 60 шахам хувийг шоронгийн дэглэмд эдлүүлдэг юм.[4]

Насанд хүрээгүй хүний үйлдсэн хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын асуудал Монгол Улсад дэлхий нийтийн хандлагаас ихээхэн зөрүүтэй бөгөөд Шүүхийн статистик тоо баримтаас үзэхэд шүүхээр хэргээ шийдүүлж буй насанд хүрээгүй хүний 80 гаруй хувьд хорих ял оногдуулдаг, оногдуулсан хорих ялынхаа 40 орчим хувийг шоронгийн дэглэмд биечлэн эдлүүлдэг. Ял бус эрүүгийн хариуцлагын төрөл дунджаар 0.7 орчим хувийг эзэлж байна.[5]

Сүүлийн жилүүдэд хөгжиж буй болон хөгжингүй орнуудад нэлээд хориглож, хязгаарлах болсон “Албадан ажил хийлгэх” ялыг (Hard labour) Монгол Улсад идэвхтэй хэрэглэсээр байна. Энэ ял нь 2002 оны Эрүүгийн хуулийн 50.2-р зүйлд зааснаар 100-500 цагийн хугацаатай байна.

Монгол Улсад тавин таван наснаас дээш насны эмэгтэй, жаран наснаас дээш насны эрэгтэйд 15 жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулдаггүйн дээр 3 хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэгт баривчлах болон албадан ажил хийлгэх ял оногдуулдаггүй.

Эрүүгийн хуулийн 49.1-р зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хөрөнгийн заримыг буюу бүгдийг албадан хурааж болохоор заасан байдаг. Энэ нь шүүхийн практикт хэрэгжихдээ гэр бүлийн гишүүдийн өмчлөх эрхийг хөндөх, ял халдаах нөхцөлийг бий болгосоор байгаа юм.

Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасаг ялыг 1-5 жил хүртэл хугацаагаар тогтоосон байдаг.

Энэ хууль анх батлагдах үедээ (2002) хорих ялын доод хэмжээг доош нь татаж, хөнгөрүүлэх боломжгүй байдлаар хуульчилсан боловч 2008 онд эрүүгийн хуулийн 55.1-р зүйлд өөрчлөлт оруулж, хорих ялын доод хэмжээг гуравны хоёроос хэтрэхгүй байх заалтыг нэмж тусгасан. Эрүүгийн хуулийн 55-р зүйлд ялын хөнгөрүүлэх нөхцөлд тохиолдлын шинжтэй анх удаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэргийн хохирлоо сайн дураар нөхөн төлсөн, хүчирхийлэл, заналхийлэлд автагдаж, эрхшээлд нь орж үйлдсэн, хохирогчийн хууль бус үйлдэл, сэтгэл санааны цочролоос болж үйлдсэн зэрэг хэд хэдэн нөхцөлийг заасан байна.

Харин уг хуулийн 56-р зүйлд ял оногдуулахад хүндрүүлэх нөхцөл гэдэгт гэмт хэрэг давтан үйлдсэн галт зэвсэг, галт хэрэгсэл ашигласан, нийтийн гамшигт байдал, эмх замбараагүй байдлыг ашиглаж үйлдсэн зэрэг 12 нөхцөлийг хуульчилсан юм.

Түүнчлэн 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийт хорих ялын доод, дээд хугацаа хэт ойр, өөр ялаар орлуулах буюу сонгон хэрэглэх боломж маш хязгаарлагдмал байсаар ирсэн.[6] (5-7, 3-5, 7-10 г.м)

Хөгжингүй орнуудад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд аль болох нийгмээс тусгаарлахгүйгээр хүмүүжүүлэх, нийгэмшүүлэхийг зорьдгийн илэрхийлэл нь нийт ялын 80 гаруй хувийг торгох ба хорихоос өөр төрлийн

[4] Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 2002.

[5] “Эрх Зүй” сэтгүүл. 2011. №1(20) 130-р тал

[6] МУИС-ийн Х.З.С Судалгааны тайлан. УБ., 2015.

татаж байна.

4) Ялтайд тооцох эрүүгийн эрх зүйн механизм нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйн дэх хүнлэг ёсны зарчимд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж байна.

5)Эрүүгийн ялыг оноох, хэрэглэх, чөлөөлөхөд тэгш эрхийн болон шударга ёсны зарчим алдагдах, ялын оновчтой, тогтвортой байдал хангалтгүй байна.

Дээр өгүүлсэн бүхий л хүчин зүйлүүд Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хуулийг бүхэлд нь өөрчилж, шинэ Эрүүгийн хууль төрөн гарах шаардлагыг бий болгосон билээ.

3.2015 оны шинэ Эрүүгийн хууль[9]:
Эрүүгийн ял ба эрүүгийн хариуцлагын шинэ журам, чиг хандлага

Энэ нийтлэлийн хоёр дахь хэсэгт дурдсан тулгамдсан асуудлыг даван туулж, оновчтой шийдвэрлэх зорилгоор Улсын Их Хурал 2015 оны 12-р сарын 3-ны өдөр шинэ Эрүүгийн хуулийг баталсан бөгөөд 2016 оны 9-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болж дагаж мөрдөхөөр тогтоосон билээ.[10]

Шинэ эрүүгийн хууль нь өмнөх эрүүгийн хуулиас нэлээд дэвшилттэй бөгөөд ялангуяа ялын бодлогод хүмүүнлэг ёсны хандлагыг тусгах, хорих ялын хэт түгээмэл хэрэглээг хязгаарлах, хорихоос өөр төрлийн ял болон эрүүгийн бусад хариуцлагын хүрээг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болсон юм.

Шинэ Эрүүгийн хуульд дурдсан өөрчлөлтүүд оржээ. Үүнд:

1)Хорих ялыг хугацаатай ба бүх насаар хорих гэсэн хэлбэртэйгээр, 7 хоногоос 20 жил хүртэл хугацаатай байна. Энэ нь нээлттэй ба хаалттай хорих байгууллагад эдлүүлэх нөхцөлтэйгөөр хэрэгжинэ.(ЭХ-ийн 56-р зүйл);

2)Баривчлах ялыг хүчингүй болгосон;

3)Торгох ялыг 100-40,000 нэгжтэй тэнцэх мөнгөн төлбөр оногдуулахаар тооцож нэг нэгж нь 2000 төг байхаар хуульчлав. (ЭХ-ийн 5.3-р зүйл)

4)Албадан ажил хийлгэх ялыг өөрчилж, Нийтэд тустай ажил хийлгэх ял (Compulsory labour) болгон өөрчилж өдөрт 4 цагаас дээшгүй, нийт 120-480 цагаар тогтоохоор боллоо. (ЭХ-ийн 5.4-р зүйл)

5)Зорчих эрхийг хязгаарлах ялыг шинээр нэмж, 1-5 жил хүртэл хугацаатай байхаар хуульчлав. (ЭХ-ийн 5.5-р зүйл)

6)Эрх хасах ялыг гэмт хэрэг үйлдсэн хүний нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, бусад тодорхой эрхийг 1-8 жил хугацаатай эдлүүлэхээр хуульчилсан байна.

7)Эрүүгийн хуулийн 5.1-р зүйлд ялын зорилгод цээрлүүлэхээс гадна хохирлыг нөхөн төлүүлэх, хүнийг дахин нийгэмшүүлэх явдлыг оруулжээ.

8)Ял оногдуулах насны доод хязгаарыг 16 нас байхаар тогтоосны дээр 14-16 насны хүнд оногдуулах зарим хүнд гэмт хэргийг хуульчилсан юм. (Дээрэм, хулгай, террор, хүнийг алах, хүнд хохирол учруулах г.м. 14 хэрэгт)

9)Эрүүгийн хуулийн 6.5-р зүйлд бусдын хүчирхийлэл, дарамтад өртсөний улмаас өөрийгөө хамгаалах зорилгоор үйлдсэн, тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас анх удаа үйлдсэн, хохирогчийн зүй бус үйлдлээс болж үйлдсэн зэрэг нөхцөл байдлыг шинээр нэмсэн байдаг.

10)Эрүүгийн хуулийн 6.7-р зүйлд Гэм буруугаа бүрэн хүлээн зөвшөөрсөн буюу гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн бол ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ авахаар хуульчилсан нь өмнө нь огт

[9] "Төрийн мэдээлэл" сэтгүүл. 2016. №07/916/

[10] Энэ хуулийг одоогийн УИХ, Засгийн газраас нэмэлт өөрчлөлт оруулж. 2017 оны 7-р сарын 1-ний өдрөөс мөрдөхөөр хойшлуулаад байна.

байгаагүй шинэ зүйл юм.

11) Эрүүгийн хуулийн 7.1-р зүйлд 5 жил хүртэл хорих ял оногдуулахаар заасан этгээд гэм буруугаа зөвшөөрч, хохирлоо төлсөн бол хорих ялыг биечлэн оногдуулахгүйгээр 5 жил хүртэл тэнсэж болохоор заасан байна.

12) Ял бус эрүүгийн хариуцлагын арга хэмжээ нь Эрүүгийн хуулийн 7.2-р зүйлд зааснаар:

1.Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах арга хэмжээ;

2.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ;

3.Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ гэсэн 3 үндсэн төрөлтэй байхаар хуульчлав.

Бүхэлд нь авч үзвэл эрүүгийн ял болон эрүүгийн хариуцлагын арга хэмжээг өмнөх хуулиас илүү тодорхой, оновчтой болгосноос гадна Олон улсын нийтлэг жишиг, ялын бодлогын орчин үеийн хандлагад илүү нийцүүлэхэд чиглүүлж чадсанаараа дэвшилттэй алхам болсон юм. Түүнчлэн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 46 төрлийн гэмт хэрэгт холбогдуулж, тэдгээрийг үйлдсэн хуулийн этгээдэд эрүүгийн ял оногдуулахаар хуульчилсан нь өмнө нь байгаагүй шинэ үзэгдэл юм.(ЭХ-ийн 9.2-р зүйл: Торгох, эрх хасах, татан буулгах ял)

2015 оны Эрүүгийн хуулийн 5.2-р зүйлд үйлдсэн 5 төрлийн ялыг (торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зөрчих эрхийг хязгаарлах, хорих, эрх хасах) хуульчлахдаа цаазаар авах ялыг оруулаагүй байна.

Харин шинэ Эрүүгийн хуульд ял хүлээх насны шалгуурыг 16 насаар тооцсон, хорих ялын хугацааг холдуулж, доод хязгаарыг багасгасан боловч тэдгээрийг хэрэглэх нөхцөл, журмыг төдийлөн оновчтой хуульчлаагүй зэрэг нь анхаарах асуудал юм.

4. Дүгнэлт

Монгол Улсын Эрүүгийн эрх зүй нь өөрийн уламжлал, үнэт зүйлсийг хадгалж, хөгжиж байгаа боловч, сүүлийн 10 жилд эрүүгийн ялын бодлого, тогтолцоо, практикт нь “шоронжсон” хэт чанга буюу хүний эрхийн Олон улсын шаардлага орчин үеийн нийтлэг зарчмаас хазайж, нэлээд гажуудалд орсныг хүлээн зөвшөөрөх ёстой. 2002 оны Эрүүгийн хуулийн хэрэгжилтээс үзэхэд ялын цээрлүүлэх зорилго нь илүү давамгайлж байгаагаас хорих ялын үр дүн хангалтгүйн дээр хорихоос өөр төрлийн ялыг ямар нэгэн сонголтгүйгээр хязгаарлагдмал байдлаар хэрэглэж ирсэнд дүгнэлт хийх ёстой.

Шинээр батлагдсан Эрүүгийн хууль нь гэмт хэрэгт оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын асуудлын хувьд зарчмын шинжтэй, томоохон өөрчлөлт орсон бөгөөд шоронд хорих ялыг биечлэн эдлэх явдлыг багасгахад анхаарч, хүмүүнлэг ёсны хандлагыг бий болгоход дорвитой алхам боллоо. Ял бус эрүүгийн албадлагын арга хэмжээг хэрэглэх нөхцөлийг шинээр бий болгож, ял тэнсэх, ял хойшлуулах, ялаас чөлөөлөх журмыг уян хатан байдлаар хуульчилсан нь чухал дэвшил юм.

Монгол Улс цаазаар авах ялыг халж, албадан ажил хийлгэх ялыг өөрчлөн ялын хэрэглээнд хорих ялын дээд, доод хугацааг уртасгаж, туйлын тодорхой санкцийг хуульчлахаас татгалзсан ба ялыг хойшлуулах, солих, өөрчлөх, боломжийг нэмэгдүүлсэн зэрэг нь онцгой ач холбогдолтой болж гэж үзэж байна.

Цаашдаа Монгол Улсын Эрүүгийн эрх зүйд эрүүгийн ялын болон эрүүгийн хариуцлагын зохистой журмыг нэвтрүүлэхэд чиглэгдсэн эрх зүйн шинэ орчин бий болж, ялын бодлого үр нөлөөтэй хэрэгжих түүхэн боломж бүрдэж байна.

---o0o---

-Нийгэм, экологийн сургаал (social ecology school) нь гэмт явдлын шалтгааныг нийгмийн орчин газарзүйн орчноос судалж байв. Shaw, McKay (1942) нар Чикаго хотод 1000 хүүхдүүдийн дунд явуулсан гэмт хэргийн тухай судалгаагаар дэлхий нийтэд танигдаж "Чикагогийн сургууль" хэмээн нэршсэн. Ийм үе шатаар 20 дугаар зууны сүүлчээр дээрх арга нь "environmental criminology" буюу "орчны гэмт явдал судлал" хэмээх шинэ криминологийн салбар болтлоо хөгжсөнийг бид мэдэх билээ.

Социалист эрх зүйн чиг баримжаагаар чиг баримжаагаар хөгжиж байсан ЗСБНХУ буюу ОХУ-ын судлаачид орчны криминологийг арай өөрөөр авч үзэж, "геокриминологи" хэмээн томьёолжээ.[6] Тэдний хувьд орчны гэмт явдал судлалыг криминологийн прогноз, төлөвлөлт хэмээх категорид хамааруулан авч үзэж, газарзүйн ухаан ухаан, криминологийн хосолсон чиглэлээр хэд хэдэн эрдэмтэн судлаачид төрөн гарчээ. Тухайлбал, ОХУ-ын эрдэмтэн Бадов Александр Даурбекович[7] "ОХУ-ын гэмт явдлын газрын зураглал: Зөвлөлт засгийн дараах үе" сэдвээр эрдмийн зэрэг хамгаалсан байна[8].

Дээрх аргыг 1982 онд Тифлис хотын жишээн дээр хэрэглэж, гэмт хэргийн газрын зураглал үйлдэж, түүнд дүн шинжилгээ хийх замаар криминологийн прогноз гаргаж, урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулжээ. "Гэмт явдлын газарзүйн зураглалын зарим асуудал"[9] сэдэвт уг судалгааны ажилд тухайн үеийн хотыг бүсчилж, гэмт явдлын төлөв байдлыг тодорхойлохдоо хронологийн аргыг ашигласан нь ихээхэн сонирхол татдаг.

Эл үетэй зэрэгцэн Баруунд орчны криминологийн онол боловсруулагдаж байснаас үзвэл, улс орнуудын эрх зүйн тогтолцооноос үл хамааран ижил түвшинд хөгжиж байсныг харуулж байна.



Зураг 1. Гэмт хэргээс сэргийлэх ухаалаг бүтэц : Ratcliffe, 2003.

Гэмт хэргийн газарзүйн зураглалын тогтолцоо бүрдүүлэх сургалтын онол, арга зүйг боловсруулсан судлаач Радклифф шийдвэр гаргагчдад нөлөөлөх бодлогын судалгаа, түүнийг хийх нэгжийн гол зорилгыг тайлбарлажээ. Ерөөс гэмт хэргийн орчны судалгаа хийх нэгж нь удирдах байгууллага албан тушаалтныг гэмт хэрэгтэй тэмцэх шийдлийг хурдан хугацаанд, үр дүнтэй, хүч хэрэглийг зөв хуваарилж явуулахад дэмжлэг үзүүлэхэд судалгааны зорилгоо чиглүүлсэн байх нь орчин цагт төрийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын голлох стратеги болж байна.[10]

Гэмт хэргийн зураглал үйлдэх аргачлал /crime mapping/

А/ Судалгаа хийх хүрээг гаргах:

Гэмт хэргийн зураглал үйлдэх аргын тухайд улс орны хэмжээнд хийгдэж байгаагаас авахуулаад нэгж тосгон, сум дүүрэг, тодорхой газар нутаг зэрэгт хийдэг өөр өөрийн онцлогтой. Гэмт хэрэг үйлдсэн цаг хугацаа, гэмт

[6] Аннотация:Опубликовано: Сибирский Юридический Вестник. 2001, №4 "География преступности: К вопросу понятии, предмете, методе." Шоткинов.С.А

[7] www.famous-sceintist.ru/list/1173 /last visited 2012.4.30/

[8] www.dissercat.com/content/geografiya-prestupnosti-v-rossii-v-postsovetskii-period /last visited 2012.4.25/

[9] "Некоторый вопросы географий преступности" По материалам Грузинской ССР, Авторы А.А.Габианы, Р.Г.Гачиладзе. Тифлис., 1982 . www.law.library.ru/idanie20743.html /last visited 2012.4.24/

[10] JERRY H. RATCLIFFE "CRIME MAPPING AND THE TRAINING NEEDS OF LAW ENFORCEMENT" European Journal on Criminal Policy and Research 10: 65–83, 2004. Kluwer Academic Publishers. Printed in the Netherlands.

ОРЧНЫ ГЭМТ ЯВДАЛ СУДЛАЛ



УЕПГ-ын хяналтын прокурор Г.Оюунболд

Түлхүүр үг: Environmentel criminology, гэмт явдлын урьдчилан харалт буюу криминологийн прогноз төлөвлөлт, гэмт хэргийн цахим газрын зураглал буюу crime mapping.

Abstract: Судлаач нь "Гэмт хэргийн төлөв байдлыг орчноос судлах нь" сэдвийн хүрээнд шинэ криминологийн арга болох гэмт хэргийн цахим газрын зураглалын системийг Монгол улсад нэвтрүүлэх талаар эрдэм шинжилгээний ажил хийж байгаа болно.

Урьд нийтлүүлсэн өгүүлэлд орчны криминологийн үүсэл хөгжил, аргуудын тухай товч дурдсан билээ[1]. Гаднын олон орон гэмт явдлын төлөв байдлыг орчноос судалж, урьдчилан харалтыг судалгааны үндэслэлтэй тодорхойлж, урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулан, цагдаагийн байгууллагын хүч хэрэгслийг оновчтой хуваарилж байгаад анхаарал хандуулж, туршлага судлах зайлшгүй шаардлага тулгарчээ. Бидний судалж үзсэнээр АНУ, Австрали, Англи, Солонгос, Япон зэрэг өндөр хөгжилтэй улсаас гадна Турк, Замби зэрэг хөгжиж буй орон ч энэхүү шинэ криминологийн аргыг хэрэглэж байгаа нь уг шинжлэх ухааны хөгжлөөс хоцрохгүй байх цаг үеийн хэрэгцээг харуулж байна.

Гэмт явдал судлаачид криминологийг үндсэн хоёр сургаалаас үүсэлтэй гэж үздэг. Үүнд: 1764 онд Ч.Беккариагийн бичсэн "Гэмт хэрэг ба ял шийтгэлийн тухай" бүтээлээс эхтэй[2] сонгодог сургаал, хоёрт, 1896-1897 онуудад бичигдсэн Ломборозын "Гэмт хэрэгтэн хүн" бүтээлээс эхтэй[3] позитивист сургаал юм. Түүхэнд криминологич Сатерленд, Кресси нар гэмт явдлыг орчноос судлах талаар анх удаа хөнджээ.[4] Гэмт явдлыг орчноос судлах тухай сургаал нь дараах байдлаар хөгжиж ирсэн. Үүнд:

-Франц Англи улсад гэмт явдлын төлөв байдлыг газарзүй, картын (cartographic & geographic school) аргыг 1830, 1880 онуудад тус тус хэрэглэсэн[5] юм. 1829 онд судлаач Adriano Balbi , Andre-Michel Guerry нар 1825-1827 гарсан гэмт хэргийн төлөв байдлыг орчны газарзүйн зураглалаар тодорхойлсон нь энэ салбар шинжлэх ухааны үүсэл, хөгжлийн эхэн үе байв.

-Байр зүйн арга ашиглах тухай сургаал (typological school) 20 дугаар зууны эхэн үүссэн ба байр зүйчид гэмт хэрэг гарсан газар орон, гэмт хэрэгтэн бие хүний сэтгэл зүйн харилцан нөлөөллөөс хайж байсан.

[1] "Гэмт явдалтай тэмцэх асуудал", сэтгүүл. 2011 оны ... дугаар. "Гэмт явдлын төлөв байдлыг тодорхойлоход хүрээлэн буй орчны зураглал үйлдэх аргыг ашиглах нь" эрдэм шинжилгээний өгүүлэл

[2] Чезар Бекариа "Гэмт хэрэг ба ял шийтгэл", Орчуулсан Г.Эрдэнэбат

[3] Cesare Lombroso "Criminal man", translated and new introduction by Mary Gibson and Nicole Hahn Rafter

[4] Sutherland.E.H, Cressey.D.R. Principles of Criminology, 7th edition, Philadelphia, New York, 1966, p 53-65.

[5] "Mapping Crime: Principle and Practice" Keith Harries, Ph.D, U.S. Department of Justice Office of Justice Programs, December 1999, NCJ 178919, page 3

www.nlc.gov.mn

холбоотой юм.[13]

Харин компьютерийн техник хангамжийн хувьд дэлхий дахины интернет, кибер хөгжлийн чиг хандлагаас хамааран өндөр хүчин чадалтай, хурдтай, онлайн хандалт хийж, шууд мэдээлэл оруулах боломжтой байхыг шаарддаг.

Цагдаагийн байгууллагад хэрэглэдэг техник хэрэгслийг гэмт хэргийн зураглал үйлдэхэд ашиглаж болох талтай. Хэдий тийм ч голлон хариуцаж байгаа ажилтнаас компъютерийн орчны нэмэлт мэдлэг зайлшгүй шаарддаг.

Үүнд:

-Гэмт хэргийн зураглал үйлдэхэд ашиглах том самбар, дэлгэц, онлайн системээр хянах боломж, техникийн ажилтан

-Тэмдэглэгээ хийх ашиглах эд зүйлс, өнгө, өнгийн хатгуур, бал, харандаа,фотошоп программ, гэмт хэргийн төрлийг хялбарчилсан байдлаар харуулсан жижиг зураг, ноорог газрын зураг

Ер нь гэмт хэргийн талаар тэмдэглэгдэх газрын зураг нь заавал хоёр хэлбэртэй байхыг шаарддаг.

-Биет буюу цаасан хэлбэртэй / бөх, бат/ хамгийн багадаа 1,5х1,5-ээс доошгүй, тэмдэглээ хийх боломжтой байна

-Цахим буюу дижитал хэлбэрт байгаагазарзүйнзурагтхийхтэмдэглэгээ нь оны эцэст криминологи судалгаа хүргүүлэх, удирдлагад танилцуулах зэрэгт зайлшгүй хэрэглэгддэг учраас дээрх хоёр хэлбэрийг хоёуланг нь ашиглаж байж үр дүнгээ өгдөг.

Г/Тэмдэглэгээ үйлдэх аргууд

1. Dot цэг, бөөрөнхий, дугуй, чагт

2. Line- холбосон хоёр цэгийн хоорондын хамаарал

3. Triangle –гурвалсан бүтэц / ажил-гэр-дэлгүүр г.м/

Юмс үзэгдлийн мөн чанарыг илэрхийлэх олон арга байдгийн нэг нь зураглал үйлдэх арга юм. Гэмт хэрэг гарсан цэгийн газарзүйн байршил, хугацаа, давтамж зэргийг жагсаан бичихэд data буюу мэдээлэл өгөхөд нилээдгүй бэрхшээл учирдаг.

-Мэдээллийг багтаан өгөхөд дүрс ашиглах. Хулгай, дээрэм гэх мэт хэргүүдийг дүрсээр илэрхийлэхэд тун хялбар байдаг, Тухайлбал дээрмийг хар багтай хүний дүрсээр төлөөлүүлж байхад хулгайг шуудайтай мөнгө, залиланг төгрөг гэх мэтээр илэрхийлж болно.

-Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг нэг бүрд тэмдэглээ өгөх боломжгүй үед нийтлэг үйлдэгддэг танхай, дээрэм булаалт, залилан, зам тээврийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, галдан шатаалт гэсэн хэргүүдийг дүрсээр харин бусад хэргүүдийг товчилсон үсгээр тэмдэглэж, дор нь тайлбар бичиж болно. Тухайлбал, дараах байдлаар дүрсэлнэ.[14] Үүнд:

- ЗОДОХ, ГЭМТЭЛ УЧРУУЛАХ
- ОХУЛГАЙ
- СОГТУУРАХ, МАНСУУРАХ
- ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ
- ХҮНИЙГ АЛАХ
- ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХУЛГАЙ
- ДЭЭРЭМ, БУЛААЛТ
- БЭЛЭГСИЙН ГЭМТ ХЭРЭГ
- ЗАЛИЛАН
- САРААЧИХ
- ГАЛТ ЗЭВСГЭЭР ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРЭГ

Газарзүйн зураглал тодорхойлох / geographic profiling/

Гэмт хэргийн зураглал үйлдэх аргыг хэрэглэсний дараа газар зүйн байрлалын хувьд үнэлгээ өгөх нь хамгийн чухал хэсэг бөгөөд энэ нутаг дэвсгэрийн хэмжээнд хаана, аль

[13] http://www.google.com/fusiontables/Home

[14] http://www.crimemapping.com/help/help.aspx-#crime-types /last visited 2012 5.1/

хэрэг үйлдэгчийн хүйс, нас гэх мэтчилэн нэг бүрээр тусгайлан авч үзэж зураглал үйлдэж болдог. Өөрөөр хэлбэл зөвхөн гэмт хэргийн төрлөөр зураглал үйлддэг гэж үзэх нь хэт өрөөсгөл. Юуны түрүүнд, удирдлагаас өгсөн чиглэлийн хүрээнд хэд хэдэн гэмт хэргийн төрлөөр гаргаж болно. Хэрэв тодорхой төрлийн гэмт хэргийн тухайд өгөгдөл өгөх, зураглал үйлдэж дүн шинжилгээ хийх хэрэг гарлаа гэж үзвэл аль нутаг дэвсгэрийн хүрээнд вэ, Харьцуулах үзүүлэлт юу байж болох вэ, тухайн хэргийн бусад өгөгдлөөр дүгнэлт хийх бололцоотой юу гэдгийг тодорхойлох хэрэгтэй.

Б/ Бэлтгэл ажил:

Нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэргийн зураглал үйлдэх нь ямар хэмжээнд, аль төрлийн гэмт хэргийг сонгон судалж байгаараа ялгаатай. Хүнийг алах, дээрэмдэх гэх мэт хүч хэрэглэсэн гэмт хэргийн зураглалыг гаргахад бэлгийн гэмт хэргийн талаарх зураглалаас илүү хялбар байх жишээтэй. Юуны түрүүнд нутаг дэвсгэрийн хэмжээнд зураглал үйлдэхэд дараах зүйлийг бэлтгэнэ. Үүнд:

1. Газарзүйн зураглал гаргах: Нутгийн захиргааны байгууллагатай урьдчилан ярилцаж, шийдвэрлэсний үндсэн дээр орон нутгийн үнэн зөв, бодит газрын зураг, түүнд орших обьектын талаарх мэдээллийг оруулсан байна.

2. Мэргэжлийн байгууллагуудтай холбогдох: Газрын болон геодези зураг зүйн газар, кадастрын алба, архитектурын алба гэхчлэн холбогдох нэгж байгууллагын мэргэжилтний туслалцааг авсан байна.

3. Хариуцсан ажилтныг томилох: Зураглал үйлдэх ажилтан нутаг дэвсгэрийн газар орны онцлогийг мэддэг байх, удаан хугацаанд тогтвортой ажиллаж, дүн шинжилгээг хийх чадвар, боломжтой байх шаардлагатай.

4. Гэмт хэргийн зураглалыг олон газар биш нэг газарт үйлдэхэд анхаарч, хүч тарамдуулахгүй, тодорхой гэмт хэрэг, зөрчлийг орхигдуулахгүй байхад анхаарал хандуулж, гэмт хэрэг бүртгэлийн системтэй уялдуулах

5. Нутаг дэвсгэрийн хэмжээнд гаргасан газрын зургийг цахим хэлбэрт шилжүүлж, шинэчлэлийг байнга хийж байх, тэмдэглэгээ хийх боломжийг бүрдүүлэх

Судалгаа хийх нэгж нь орон нутгийн захиргаатай энэ чиглэлийн судалгаа хийх гэж байгаагаа тайлбарлаж, энэ нь нутаг орны хэмжээнд ихээхэн ач холбогдолтой гэдгийг ойлгуулах хэрэгтэй.[11] Эхний байдлаар орон нутгийн алба хэлтэстэй хамтран гаргасан газар зүйн зураг хамтран тэмдэглэгээ, тодруулга хийж эцэслэн ахин хянана. Шинээр баригдсан байшин, булан тохой, орхигдсон обьект нэг бүрийг хэсгийн байцаагч нартай хамтран гаргаж болох бөгөөд хөдөө орон нутагт хэсгийн төлөөлөгч, нутгийн хашир туршлагатай малчдын туслалцааг авч болно.

В/Техник төхөөрөмж бэлтгэх, ашиглах:

Одоогийн байдлаар дэлхийн ихэнх оронд гэмт явдлын гаралтыг орчноос судлахдаа компьютерын программ хангамжийн хувьд газарзүй, топографын MapInfo, ArcView, ArcInfo программ болон тухайн орны өөрсдийнх нь боловсруулсан газарзүйн цахим зураглал /GIS/-ийн мэдээллийн системд тулгуурлан хэрэглэж байна.[12] Түүнчлэн “Google earth” газарзүйн хайлтын системийг ашиглан, дээрх аргыг хэрэглэж байгаа нь түгээмэл бөгөөд энэ нь тус программ дэлхийн газарзүйн байрлалыг хиймэл дагуулын тусламжтайгаар байнга шинэчилдэгтэй

[11] Монгол улсад газарзүйн нарийвчлалтай зургийг төрийн нууцын жагсаалтад оруулсан нь бэрхшээл учруулж болох талтай.

[12] The Use of Computerized Crime Mapping by Law Enforcement: Survey Results by Cynthia A. Mamalian, Nancy G. LaVigne, and the staff of the Crime Mapping Research Center

Гэмт хэрэг гарч байгаа шинж байдал нь газар орны онцлог, нуугдмал далд байршил, хүн амын шилжилт хөдөлгөөн, гэрэлтүүлэггүй гудамж, харанхуй мухар гудамж, хүнгүй зэлүүд газар гэхчлэн нийтлэг обьектод гардаг шинжийг харгалзан үзэх юм бол гэмт хэргийн давтамж тодорхой гарч ирдэг /Давтан гэмт хэрэгтэй хольж ойлгож болохгүй/. Энэ нь нийтийн эзэмшлийн талбай, анхаарал татсан обьектод ихэвчлэн аль төрлийн гэмт хэрэг гардаг, түүний цаг хугацаа, байршил, хохирогч зэрэг нь 6 сараас дээш хугацааны ажиглалтаар гарч ирнэ.

Б/ Хохирогч тодорхойлох

Хохирогчийн гэмт халдлагад өртсөн байдлыг түүний явдаг чиглэлээр, мөн халдлагад өртсөн өдөр гараг, цагаар гаргахдаа хатгаж, тэмдэглэж байгаа цэг бүр дээр нэмэлт мэдээл оруулах шаардлагатай. Хотын төвөөс захын хороолол руу эсвэл хотын захаас төв рүү гэх мэтчилэн гэмт хэргийн хохирогчийн байдал эрс ялгаатай байдаг бөгөөд үүнд аль төрлийн гэмт хэрэгт хохирогч хаана хамгийн өртөж байгааг тодорхойлох боломжтой.

Туршлага.

БНКазУ-ын УЕПГ-ын дэргэдэх Эрх зүйн мэдээлэл, статистикийн товчоо, БНКУ нь 2005 оноос Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийг тендер зарлаж, тусгай багаар гүйцэтгүүлэн Oracle Business Intelligence суурилсан программ хангамж, C-Sharp хэлэнд тулгуурлан сүүлийн найман жил тасралтгүй хөгжүүлж ирсэн байна. Тус товчоонд 120 алба хаагч ажилладаг ба аймаг, дүүрэг бүрт салбартай нийтдээ 380 орчим алба хаагчид үйл ажиллагаа явуулдаг юм байна. Ерөнхий хяналт гэсэн утгаараа УЕПГ-ын Эрх зүйн мэдээлэл, статистикийн товчоо нь гэмт хэрэг, зөрчил, иргэний нэгдсэн бүртгэл, мэргэжлийн хяналт, төрийн алба, шүүхийн шинжилгээ, гарын мөр судлалын папилон сан, иргэдээс төрийн байгууллагад хандаж гаргасан өргөдөл гомдол, мэдээллийг бүхэлд нь цахим байдлаар хянаж, гэмт хэрэг зөрчлийн нэгдсэн статистикийг гаргаж, гэмт хэргийн цахим газрын зураглалыг боловсруулан ажилладаг юм байна.

Энэ цахим систем нь удирдлага, хэрэглэгч болон иргэнд зориулсан гурван шатлалтай, ажилтан бүр өөр өөрийн нэвтрэх түлхүүр нууц үгээр орж мэдээллээ оруулж, боловсруулалт хийдэг. Харин анхан шатны нэгж хууль сахиулах байгууллагаас зөрчил, гэмт хэргийн мэдээллийг оруулж, түүний гүйцэтгэлд хяналт тавьж, өгөгдлийг хүссэн байдлаар гаргаж танилцан, дараагийн арга хэмжээгээ боловсруулдаг байна. Үүнийг дэлгэрэнгүй товч дурдвал:


- Иргэний өргөдөл гомдлын бүртгэл, лавлагаа, хяналтын сан
- Эрүүгийн хэргийн буюу гэмт хэргийн өргөдөл гомдол, эрүүгийн хэрэг үүсгэхээс авахуулаад таслан сэргийлэх арга хэмжээ, прокурор, шүүхийн шийдвэрлэлт, явц, хэн хэрхэн шийдвэрлэж байгаа тухай мэдээллийн сан
- Гэмт хэрэг, зөрчлийн нэгдсэн сан, статистик, шалтгаан нөхцлийн судалгаа, гэмт хэргийн цахим газрын зураглал
- Гэмт хэрэгт шалгагдсан хүн, яллагдагч, шүүхээр шийтгүүлсэн хүн, эрэн сурвалжлагдаж байгаа хүний нэгдсэн бүртгэл, лавлагааны сан
- Зам тээврийн салбарт гарсан хэрэг, зөрчлийн сан
- Хувь хүний бүртгэл- галт зэвсэг, зээл, нотариат, тэтгэвэр, лицен, гааль, татвар, эмнэлгийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлт, машин, санхүү гэх мэт

Системийн давуу тал: Нэг хүн-Нэг цахим систем, өргөдөл гомдлыг шийдвэрлэхэд хугацаа алдаж, цаас, албан бичиг, тоот гэдэггүй, хууль сахиулах байгууллагууд хоорондын удирдлагын шаталсан цахим дамжлага нь хурдан, өргөдлийг

газарт, хэнд, ямар хугацаанд чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг явуулах вэ? гэдгийг тодорхойлох ач холбогдолтой. Гэмт хэрэг гарч буй газар орны онцлог байдлыг ихэнх цагдаагийн ажилтнууд хэсэг хугацааны дараа мартдаг бөгөөд зураглал үйлдэх нь аливаа үйлдлийг эргэн сануулж байх, түүнд харьцуулсан оюуны дүгнэлт сайн зохион байгуулбал илүү амжилтад хүрнэ.

А/ Давтамж тодорхойлох:

Зураглал үйлдсэний дараа илэрч байгаа нөхцөл байдалд шууд яаран дүгнэлт өгөх нь эрсдэлтэй бөгөөд удаан хугацааны ажиглалт, уйгагүй, үнэн зөв тэмдэглэгээг хийсний үндсэн дээр судалгаа бодитой гардаг. Урьд танай



өгөхөд хэрэглэгдэнэ. Хэсгийн байцаагч, төлөөлөгчийн обьектын судалгаа үүнтэй төстэй боловч бүхэлд нь гэмт хэргийн талаар мэдээлэл авахад хэрэглэгддэггүй талтай. Ийм учраас зайлшгүй хийдэг обьектын судалгааг үр дүнтэй болгохын тулд нэгдсэн зохион байгуулалтад оруулж өөрсдөөр нь танилцуулга хийлгэж, үр дүнг нь нэгтгэж байвал зохино. Үүний өмнө алба, хэлтсийн дарга, дүн шинжилгээний байцаагч нарыг дээрх ажилд татан оролцуулахдаа үүрэгт ажилтай нь холбон өгч, дурдсан бэлтгэл ажлыг нутаг дэвсгэрт гарч байсан хэргүүдэд таны өгсөн үнэлгээ ихэнхдээ субьектив шинжтэй байсан бол та үүнийг илүү обьектив байдлаар тодорхойлох шаардлага гардаг. Тухайлбал ".. р хорооны тэр айлын урд талд байдаг жалганд өвөл хүмүүс их осгож нас бардаг, ... орчимд байнга танхай, дээрмийн хэрэг гардаг гэсэн төсөөлөл цагдаагийн байгууллагын анхан шатны нэгж ажилтан- хэсгийн байцаагчаас эхлээд гэмт хэргийн мэдээллийг байнга хүлээн авч танилцах үүрэгтэй удирдах албан тушаалтанд хүртэл байдаг.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

хэрхэн шийдвэрлэсэн талаар тавих хяналтыг бүрдүүлэхэд хүний нөөцийг хэмнэсэн, шуурхай, хамгийн гол нь иргэнд үйлчилж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг хянан шийдвэрлэх процесс ил тод, хяналттай явагдах нөхцөлийг бүрдүүлсэн. Шүүх, прокурор, хууль сахиулах байгууллага бүгд нэгдсэн нэг программ хангамж, платформд тулгуурлан өөр өөрийн үндсэн үүрэгт ажлаа харилцан нэгэндээ хүндрэл учруулахгүйгээр хийдэг байна.

Шийдэл: Шүүх эрх мэдлийн болон, хууль сахиулах байгууллагууд цахим системээр мэдээлэл солилцох тухай шийдвэр гаргалт, үр ашигтай харилцан ойлголцсон хамтын ажиллагаа, нэг цахим систем, уян хатан программ хангамж, урт хугацааны уйгагүй хөгжүүлэлт, төсөв санхүүг нэг зүгт чиглүүлсэн байдал.

Иргэнээс ирүүлсэн өргөдөл гомдолд бүртгэлийн ажилтан тусгай дугаар бүхий талон олгож, сканердан харьяа байгууллага руу илгээж, тухайн байгууллагаас хариу авах, иргэнд хариу өгөх зэрэг ажлыг 3-4 хүн гүйцэтгэж, цахим системээр дамжуулдаг. Хэрэв өргөдлийг шийдээгүй бол иргэн талоныхоо дугаараар цахим байдлаар www.service.pravastat.kz сайтаас хараад эргэж гомдол гаргаж болдог аж. Ийм байдлаар өргөдлийг шуурхай шийдвэрлэх ажиллагаа явагдаж, яам, прокурорын газарт мэргэжилтэн өргөдлийн ачаалалгүй, харин шийдээгүй өргөдөлд арга хэмжээ тооцож ажиллаж байгаа нь хэрэгжүүлж болох сайн туршлага байлаа. Хугацаа хэтэрсэн өргөдөл гомдлын талаар цахим систем өөрөө дохио өгдөг, цаасан хэлбэрээс татгалзсанаар шат шатандаа өргөдөл дамжуулах процесс багасаж, наад зах нь гэхэд 10-15 хоногт шийддэг байсан өргөдлийг 2-3 хоногт шийддэг болжээ.

Дүгнэлт.

Орчин үед гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чанар үр нөлөөг дээшлүүлэхэд судалгааны үндэслэлтэй арга барил шаардагдаж байгаа учраас гэмт явдал судлалын шинэлэг арга, техник, хэрэгслийг Монгол Улсад нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага тулгамдаж байна. Гэмт явдлыг орчноос судлах аргыг хэрэгжүүлэн, үр дүнд хүрсэн гаднын зарим орны туршлага судалж, инноваци буюу шинэ технологи нэвтрүүлэх талаар төрөөс баримталж буй бодлогод нийцүүлэн хэрэгжүүлэх боломжтой гэж үзлээ.

Санал

- Гэмт явдлыг орчноос судлах аргыг нь улс орнуудад янз бүрээр томьёолж байна. Environmental criminology-ийг орчны гэмт явдал судлал хэмээн томьёолох.

- Тодорхой төрлийн гэмт явдал, тэр дундаа орчин, нөхцөлөөс ихээхэн хамааралтай хүч хэрэглэсэн гэмт явдлын төлөв байдлыг энэхүү аргын үндсэн дээр тодорхойлж, бодит үр дүнг практикт нэвтрүүлэх талаар судалгааг чиглүүлэх

- Судалгаа явуулахдаа гэмт хэргийн газарзүйн зураглал боловсруулах программ хангамж болон техник хангамжийн асуудлыг судлан, хамтад нь шийдвэрлэж, Улаанбаатар хотын дүүрэг, хороодод хэрэгжүүлэх саналтай байна.

---o0o---

хууль.zүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН БАРЬЦААНЫ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАРЧ БУЙ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМЫН ТАЛААР



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш (LL.M) Н.Норовсамбуу

I.ОРШИЛ

Монгол улс нь 2002 онд батлагдсан Иргэний хуулиар барьцааны эрх зүйн суурь харилцааг зохицуулж байна. Энэ хуулиар барьцаалагч нь үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрхээ шүүхэд хандан хэрэгжүүлдэг байхаар хуульчилсан. Гэвч шүүхийн шатаар дамжих нь цаг хугацаа, их зардал шаарддаг тул үүнийг даван туулах арга замыг хууль тогтоогч хайсаар иржээ. Өөрөөр хэлбэл, барьцаалагч нь заавал шүүхэд хандалгүйгээр өөрийн үүргийн гүйцэтгэлээ хангуулах аргын тухай юм. Үүнд 2005.07.07-ны өдөр УИХ-аас баталсан "Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль", 2009.07.09-ний өдөр УИХ-аас баталсан "Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль" болон түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүд хамаарна. Эдгээр зохицуулалтууд нь барьцааны зүйлийг хурдан шуурхай байдлаар худалдан борлуулахыг зорьж байсан хэдий ч, тухай бүр Үндсэн хуулийн зөрчлийг бий болгож байсан.

Нөгөө талаас Иргэний хуулиар иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь хууль буюу гэрээнд заасан эрх үүргээ үнэнч шударгаар хэрэгжүүлэх ёстой. Өөрөөр хэлбэл үүрэг гүйцэтгэгч нь үүрэг зохих ёсоор гүйцэтгээгүй барьцаалагч, өмчлөгчөөс үүргийн гүйцэтгэлээ цаг тухайд шаардах нь зүй ёсны хэрэг юм.

Энд асуудлын гол оршиж байна гэж үзэн үүнийг хөндөж бичлээ. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн зөрчил болохооргүй түвшинд уг төрлийн зохицуулалтыг хэрхэн бий болгох вэ гэдэгт буй юм. Энэхүү илтгэлийн хүрээнд Иргэний эрх зүйн суурь зарчим, гадаад орны эрх зүйн зохицуулалттай харьцуулан судлах замаар уг асуудлын шийдлийг эрэлхийллээ.

II. ҮЛ МАРГАХ ЖУРАМ НЬ ШҮҮХЭД НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХГҮЙ

2016 оны 3-р сарын 16-ны өдөр Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, 53 дугаар зүйлийн 53.4, 53.5 дахь хэсэг нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх тухай №2 Үндсэн хуулийн цэцийн тогтоол гарсан.

Тус хуулийн 2015 оны 7-р сарын 2-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр барьцаалагч нь шаардлагаа үл маргах журмаар хангуулах талаар нотариатын мэдэгдэх хуудас дээр үндэслэн шүүхийн шийдвэр шаардлагагүйгээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах боломжтой зохицуулалт оруулсан.

ХУУЛЬ ЗҮЙН ТӨВ ГАЗАР www.lawcenter.mn

Харин үл маргах журмаар тодорхой үйл баримтыг хүлээн зөвшөөрсөн нь тогтоогдвол, шүүхээс ямар нэгэн маргаангүй нэгэнт хүлээн зөвшөөрсөн асуудал гэж үзээд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь зүйтэй.

Иймээс үл маргах журам нь хувийн эрх зүйн маргаанаас урьдчилсан сэргийлэх аргын нэг төрөл гэж үзэж болох бөгөөд үүрэг гүйцэтгэгч тодорхой үйл баримтыг хүлээн зөвшөөрсөн бол тухайн асуудлаар маргаан гарахгүй гэж итгэж буй үүрэг гүйцэтгүүлэгчийн итгэлийг хамгаалах, иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь "эрх, үүргээ үнэнч шударгаар хэрэгжүүлэх зарчим /bona fide/"-д нийцэхээс гадна, үл маргах журмыг тохиролцсон гэрээг баталгаажуулсан нотариатын мэдэгдэх хуудас нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл болдог. Энэ нь төрөөс хүний эрхийг хангах үүднээс бий болгосон нэг механизм учир хүн бүр ашиглах боломжтой байх ёстой. Хэрвээ уг тогтолцоог ашигласнаараа хувийн эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш байдал алдагдаж байвал уг тогтолцоог нь халах хэрэгтэй. Дүгнэвэл ИХШХШтХ-д тусгагдсан үл маргах журам нь шүүхэд нэхэмжлэл гаргах эрхээсээ татгалзаж буй явдал биш бөгөөд гэрээний аль нэг тал тодорхой үйл баримтыг хүлээн зөвшөөрч, эрх зүйн маргаан, тодорхойгүй байдлаас урьдчилан сэргийлж буй хэрэг юм.

III. ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ТОГТОЛЦОО

Одоо хэрэгжиж буй тогтоолцоо нь шүүхийн болон шүүхийн бус журмаар барьцааны эрхийг хэрэгжүүлэх боломжтой байхаар хуульчилсан. "Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль"-ийн 11-р зүйлийн 11.2-т "Хуульд заасан бөгөөд талууд гэрээгээр тохиролцсон бол барьцааны зүйлээс шаардлагыг шүүхээс гадуур хангаж болно" гэж шүүхийн бус журмыг хуульчилсан. Энд "барьцааны зүйлээс шаардлагыг шүүхээс гадуур хангаж болно" гэсэн нь барьцааны зүйлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дамжилгүйгээр худалдах агуулгатай байгаа. "Хуульд заасан бөгөөд талууд гэрээгээр тохиролцсон" бол барьцааны зүйлийг шууд худалдах, шүүхээс гадуур дуудлага худалдаагаар худалдах аргын аль нэгийг хэрэглэх боломжтой.

Энд маргаантай асуудал нь талууд гэрээндээ барьцааны зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах тухай тохиролцсоноор уг хууль үйлчлэх ба энэхүү тохиролцоо нь шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлаж байгаад оршино. Өөрөөр хэлбэл, шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг талуудын гэрээгээр хязгаарлаж болох уу?

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн талаас

Гэрээгээр тухайн эрх зүйн харилцаатай холбоотой бүхий л асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах боломжгүй болгох нь Монгол улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 14-т "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах,..." эрхийг бүрэн хязгаарлаж байна. Өөрөөр хэлбэл шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг талуудын гэрээгээр хязгаарлаж байгаа хэрэг юм. Гэтэл шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нь хувь этгээд болон төрийн хоорондын харилцаа ба иргэний эрх зүйн өөртөө туслахыг хориглох зарчмаас үүдэлтэйгээр хувь этгээд нь өөрт тулгарсан эрх зүйн маргааныг шийдвэрлэж өгөхийг төрөөс шаардах эрхтэй байхыг илэрхийлдэг. Иймд хувь этгээдүүдийн өөр хоороондоо байгуулсан гэрээний зүйл нь Үндсэн хуулийн уг заалт оршин байгаа цагт шүүхэд нэхэмжлэл гаргах эрх байж болохгүй юм.

Нөгөө талаас иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн суурь зарчим болох диспозитив

Харин Үндсэн хуулийн Цэцээс “Барьцаалуулагч болох өмчлөгч нь газраа барьцаалж гэрээ байгуулахдаа хожим нь түүний эрх зөрчигдөх эсэхийг урьдчилан мэдэх боломжгүй байхад барьцаалагчийн эрх, ашиг сонирхолд нийцүүлэн барьцааны зүйл болох газраа үл маргах журмаар дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрч Үндсэн хуулиар олгосон шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх үндсэн эрхээ хэрэгжүүлэхээс татгалзаж болохоор хуульчилснаараа гэрээний талуудын эрх тэгш байдал зөрчигдөх, барьцаалуулагчийн эрх илтэд дордож болох нөхцөл үүсгэхээр байна”[1] гэж үзжээ.

Эндээс авч үзвэл, Үндсэн хуулийн цэцээс “барьцаалуулагч болох өмчлөгч нь газраа барьцаалж гэрээ байгуулахдаа хожим нь түүний эрх зөрчигдөх эсэхийг урьдчилан мэдэх боломжгүй байхад” гэсэн дүгнэлт хийсэн байх ба “түүний эрх” гэдэгт ямар эрх хамаарах вэ? гэдгийг тодруулах шаардлагатай юм. Өөрөөр үл маргах журам нь шүүхэд нэхэмжлэл гаргах бүхий л талыг хязгаарладаг уу эсвэл тодорхой асуудал дээр хязгаарлалт бий болгодог уу? гэдгийг тодруулах хэрэгтэй.

Иймд анхаарал татаж буй зүйл нь ИХШХШтХ-д заасан үл маргах журам нь шүүхэд гомдол гаргах эрхээсээ татгалзсан асуудал мөн үү? гэдэгт байна. Юуны өмнө үл маргах журмын агуулгыг тодруулах шаардлагатай юм. Энэ нь Иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн суурь зарчим болох диспозитив зарчимтай холбогдож ирнэ. Хэрэг үүсгэсний дараа нэхэмжлэгч нь нэхэмжлэлээсээ татгалзах, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, зохигч эвлэрэн хэлэлцэх эрхтэй байдаг[2]. Угаас хувийн эрх зүйн маргааны онцлог нь шүүхийн оролцоогүйгээр талуудад маргаанаа бие даан шийдвэрлэх боломж нээлттэй бөгөөд төрийн зүгээс энэ байдлыг дэмжих үүднээс шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаа гэх мэт тогтолцоог бий болгож иржээ. Шүүхийн гол чиг үүрэг нь маргааныг шийдвэрлэх бөгөөд талууд эвлэрсэн, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн бол талуудын хоорондын маргаан үгүй болж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах шаардлагагүй болно.

Эндээс маргаан гарсны дараа хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрч болж байгаа учир, маргаан гаргахаас өмнө үүрэг гүйцэтгэгч нь тодорхой үйл баримтыг хүлээн зөвшөөрч байгаагаа үүрэг гүйцэтгүүлэгчтэй тохиролцож болно. Тухайлбал, зээлийн гэрээний хувьд зээлдэгч нь тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгө хүлээн авсан, тодорхой хугацааны дараа буцаан зээлдүүлэгчид өгөхөөр тохирсон гэдгээ хүлээн зөвшөөрч байгаагаа зээлдүүлэгчтэй тохиролцож байгаа нь үл маргаж журам юм. Ийнхүү хүлээн зөвшөөрч байгааг тодорхой болгох, хүний эрхийг хамгаалах үүднээс нотариатаар гэрчлүүлдэг. Түүнчлэн Нотариатын тухай хуулийн 45-р зүйлийн 45.1-т “Төлбөрийг нотолсон баримт бичгийг үндэслэн төлбөр төлөгчөөс мөнгө, эд хөрөнгийг гаргуулах болон үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс гаргуулахаар талууд харилцан тохиролцож байгуулсан гэрээг гэрчлэх....” гэсэн нь тодорхой үйл баримтын талаар тохиролцох тухай байх бөгөөд үл маргах журам нь үүрэгч гүйцэтгэгч шүүхэд нэхэмжлэл гаргах эрхээсээ татгалзаж буй асуудал огт биш бөгөөд тодорхой үйл баримтыг хүлээн зөвшөөрч буй явдал юм. Иймд үүрэг гүйцэтгэгч нь үл маргах журмаар ямар нэг үйл баримт хүлээн зөвшөөрсөн тохиролцоо хийгээгүй болоод өөр бусад асуудлаар шүүхэд хандах боломжтой.

[1] Төрийн мэдээлэл, 2016 оны 3 сарын 25, №12/921/

[2] Д.Хуяг “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн үндсэн болон тулгамдсан асуудлууд” Уб хот, 2013 он, 62 дахь тал

худалдаагаар худалдах ажиллагааг барьцаалагч, барьцаалуулагчийн харилцан тохиролцож сонгосон, ийнхүү тохиролцоогүй бол барьцаалагчийн сонгосон үл хөдлөх эд хөрөнгө худалдах асуудлаар мэргэшсэн, хөндлөнгийн хуулийн этгээд" гэсэн заалт байх ба барьцаалагчид давуу эрх олгосон заалт мөн оршиж байх бөгөөд талуудын тэгш эрхийн зарчим алдагдаж байна. Ер нь иргэний хуулиас салбарласан тусгай хууль баталж байгаа зорилго нь ерөнхий зарчмын хүрээнд тэгш бус байдал бий болж байгаа тохиолдолд тусгай хуулиар түүнийг арилгах зорилготой байдаг бол, энэ хууль үүний эсрэгээр байгаа байдал харагдаж байна.

IV. ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА

Энэ хэсэгт эрх зүйн өндөр хөгжилтэй орнууд болох Япон, Солонгос улсын эрх зүйн зохицуулалтыг авч үзнэ.

1.ЯПОН УЛС

Тус улсын иргэний хуульд хуульчлагдсан барьцааны эрхийг дараах байдлаар дөрөв ангилж байна. Барьцаалан зээлдэх эрх, Ипотек, Саатуулан барих эрх, Тэргүүн ээлжид шаардлага хангуулах тусгай эрх гэж ангилагдана. Барьцаалан зээлдэх эрх болон ипотек нь гэрээний дагуу үүсдэг бол саатуулан барих эрх болон тэргүүн ээлжид шаардах эрх нь хуульд заасны дагуу үүсдэг эрхүүд юм.

-Барьцааны эрхийг хэрэгжүүлэх суурь онол

Япон улсад эд юмсын эрхийг "Үндсэн эд юмсын эрх" болоод "Хязгаарлагдмал эд юмсын" гэж хуваадаг. Үндсэн эд юмсын эрхэд өмчлөх эрх, эзэмших эрх орох бол хязгаарлагдмал эд юмсын эрх нь дотроо барьцааны эрх болон ашиглах эрхэд хуваагддаг. Ашиглах эрхэд газар дээр барилга байгууламж барих эрх, сервитут гэх мэт хамаардаг.

Хязгаарлагдмал эд юмсын эрхийн шинж бол өмчлөх эрхийн тодорхой нэг хэсгийг(чиг үүргийг) авч өөрийн объект болгож буй явдал бөгөөд ашиглах эрхийн хувьд өмчлөх эрхийн эд зүйлийг ашиглаж үр шимийг хүртэх хэсгийг, барьцааны эрхийн хувьд өмчлөх эрхийн эд зүйлийн үнэ цэнийг олж авах(худалдах) хэсгийг тус тус объекттой болгож буй хэрэг юм[5]. Өөрөөр хэлбэл, барьцаалагчид тухайн барьцааны зүйлийн үнэ цэнийг олж авах буюу худалдан борлуулах эрх бий болсон гэж үзэж буй юм. Хэдийгээр барьцаалагч нь барьцааны зүйлийг мөнгөн хөрөнгөнд шилжүүлэх эрхтэй боловч, үүнийг төрийн албадлагыг хэрэглэхгүйгээр, бие даан хэрэгжүүлэх боломжгүй. Учир нь зөвхөн өмчлөгч л барьцааны зүйлийг бие даан захиран зарцуулах эрхтэй. Иймд барьцаалагч нь төрийн албадлага болох шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар дамжуулан барьцааны зүйлийг мөнгөн хөрөнгөнд шилжүүлэх эрхээ хэрэгжүүлэх шаардлагатай болно. Үүний тулд барьцаалагчид барьцааны эрх байгаа эсэх талаар тогтоох хэрэгтэй.

-Үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрхийн хэрэгжүүлэлт

Япон улсад 1979 онд батлагдсан Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль хэрэгжиж байна. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэл нь дотроо шүүхийн шийдвэр албадан гүйцэтгэх ажиллагаа, барьцааны эрхийн албадан хэрэгжүүлэх ажиллагаа, бусад гэж ангилагддаг. Тус улсад барьцааны эрхийг албадан хэрэгжүүлэх ажиллагаа нь шүүхийн шийдвэр албадан гүйцэтгэх ажиллагаанаас ангид бие даасан шийдвэр гүйцэтгэлийн төрөл болохыг харж болно.

Тус хуулийн 181[6]-р зүйлд зааснаар

[5] 内田貴『民法Ⅰ』(東京大学出版会、第4版、2012年) 350頁

[6] www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=2&id=70
(Commencement of Exercise of a Real Property Security Interest)
Article 181 Exercise of a real property security interest shall be commenced only when any of the following documents has been submitted:

зарчмын үүднээс материаллаг эрх буюу тодорхой нэг шаардах эрхээсээ татгалзах, хэрэгжүүлэхгүй байх эрх нь үүрэг гүйцэтгүүлэгчид байдаг. Нөгөө талаас иргэний эрх зүйн үүднээс "субъектив эрх бол субъектэд тодорхой хүсэл зоригийн эрх мэдлийг олгож буй бөгөөд, үүний хүрээнд субъектив эрхийг эдлэгч нь эрхийг хэрэгжүүлэх эсэх талаар өөрөө шийдвэр гаргах эрхтэй байна"[3] гэж үздэг. Иймд талууд материаллаг эрхээ хэрэгжүүлэхгүй байхаар гэрээндээ тохиролцож болно. Тухайлбал банк болон зээлдэгч хоорондын үүсэж буй харилцаан дээр авч үзвэл, банк гэрээний хугацаа дууссан ч, зээлээ төлөхийг зээлдэгчээс шаардахаа тодорхой хугацаанд хойшлуулах талаар зээлдэгчтэй дахин тохиролцож болох юм. Тухайн хугацаанаас өмнө зээлээ төлөхийг шаардвал шүүх хүлээж авахгүй.

Иймээс зөвхөн эрх бүхий этгээд нь эрхээ хэрэгжүүлэх эсэх талаар тохиролцож болох бағүрэггүйцэтгэгчийн хувьд эрхээ хэрэгжүүлэхгүй байх гэсэн асуудал яригдахгүй юм. Үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрх зүйн харилцаанд үүрэг гүйцэтгэгч болох барьцаалуулагч нь шүүхэд нэхэмжлэл гаргахгүй гэсэн нэмэлт үүрэг хүлээх ямар ч учир шалтгаан байхгүй юм. Хэрвээ өмчлөлийн зүйлээ борлуулан үүргээ гүйцэтгэхийг хүсвэл энэ нь түүний сайн дурын үндсэн дээр хэрэгжихэд л болох зүйл юм. Эндээс манай улсад үл хөдлөх барьцааны эрхийг хэрэгжүүлэх шүүхийн бус журмыг хуульчлан бий болгох боломжгүй гэж хэлэхэд хилсдэхгүй болов уу.

2.Шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйн талаас

Барьцааны зүйлийг шүүхээс гадуур худалдах нь гэрээний эрх зүйн харилцаан дээр үүсэж байгаа тул барьцаалуулагч нь шүүхээс гадуур худалдах гэрээний үүргээ биелүүлэхгүй тохиолдолд хэрхэх вэ? гэсэн асуулт гарч ирнэ. Өөрөөр хэлбэл, барьцаалагч нь барьцааны зүйлийг хураж авах, барьцаалуулагчийг албадах эрх барьцаалагчид байгаа юу? гэсэн үг юм. Уг тохиолдолд барьцаалагч нь ийм эрх эдлэхгүй бөгөөд албадлага хэрэгжүүлэх эрх нь төрийн монополь эрх юм. Гагцхүү төр албадлага хэрэглэх монополь эрхтэй тул нэхэмжлэгч нь хариуцагчид холбогдуулан албадлага хэрэглэх талаарх үндсэн хуулийн эрх зүйгээр хамгаалагдсан өөрийн шаардах эрхийг хэрэгжүүлэх боломжтой байдаг[4]. Иймд зөвхөн төрөөс албадлага хэрэглэхийг шаардах эрхтэй ба энэ нь мөн л нийтийн эрх зүйн харилцаа болно.

3.Өмчлөх эрхийн талаас

Барьцаалагчид өмчлөх эрх шилждэггүй буюу захиран зарцуулах эрх байхгүй юм. Харин Англи-Саксоны эрх зүйн тогтолцоотой орнуудад хөрөнгө итгэмжлэх, өмчлөх эрх шилжүүлэх гэх байдлаар шүүхийн шатаар дамжилгүй гуравдагч этгээд болон барьцаалагч нь худалдах эрхтэй байдаг боловч, энэ төрлийн зохицуулалт нь Иргэний хуульд заасан хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг барьцаалагчид шилжүүлдэг фидуцийг эс тооцвол манай орны эрх зүйн тогтолцоонд байхгүй юм. Тухайлбал Америкийн нэгдсэн улсын үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрх зүйд моргейж болон хөрөнгө итгэмжлэх гэрээ байгуулахдаа хэрвээ үүрэг гүйцэтгэгч нь үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй бол барьцаалагч болон хөрөнгө итгэмжлэгдсэн гуравдагч этгээдэд барьцааны зүйлийг худалдах эрхийг олгосон заалт(power of sale clause) оруулдаг ба энэ нь шүүхийн бус журмыг хэрэглэх гол үндэслэл болдог.

4.Тэгш эрхийн зарчмын талаас

Манай улсын Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хуульд "Барьцааны зүйлийг шүүхээс гадуур дуудлага

[3] Б.Тэмүүлэн нар "Иргэний эрх зүйн ерөнхий анги" 2 дахь хэвлэл, Уб хот, 2013 он, 257 дахь тал

[4] Д.Энхзул "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэн найруулах шаардлага" Хууль дээдлэх ёс, 2014 он, Цуврал 3 (49), 39 дэх тал

үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрхийг албадан хэрэгжүүлэх ажиллагааг эхлүүлэхийн тулд төлбөр авагч нь дараах баримт бичгийн аль нэгийг шийдвэр гүйцэтгэх байгууллагад гаргаж өгөх шаардлагатай. Үүнд:

• барьцааны эрхийг бий эсэхийг баталсан шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр,

• барьцааны эрх оршин байгааг баталсан нотариатчийн батламж,

• барьцааны эрхийн бүртгэлийн агуулгыг илтгэсэн улсын бүртгэлийн бичиг хамаардаг байна.

Эдгээрийн гол чиг үүрэг нь барьцаалагчид хүчин төгөлдөр барьцааны эрх байгаа эсэхийг тогтоох явдал юм. Өөрөөр хэлбэл, барьцааны зүйлийг худалдан борлуулахын тулд заавал шүүхийн шийдвэр шаардлагагүй бөгөөд үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийг үндэслэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагддаг.

2.СОЛОНГОС УЛС

Солонгос улсын одоо хэрэгжиж буй Шийдвэр гүйцэтгэх тухай хууль нь 2002 онд иргэний процессын хуулиасаа тусгаарлагдан хуульчлагдсан байна. Уг хуулийн 1-р зүйлд "тус хуулийн зорилго нь албадан гүйцэтгэх ажиллагааны журам, барьцааны эрхийг гүйцэтгэх дуудлага худалдаа, иргэний хууль, худалдааны хууль болон бусад хуульд тусгагдсан дуудлага худалдааг зохицуулахад оршино" гэж хуульчилжээ. Эндээс авч үзвэл, албадан гүйцэтгэх ажиллагаа болон барьцааны эрхийг албадан хэрэгжүүлэх нь бие даасан гүйцэтгэх ажиллагаанууд байна.

Барьцааны эрхийг албадан хэрэгжүүлэх ажиллагаа нь тус хуулийн 264-р зүйлд тусгагдсанаар "Үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрхийг албадан хэрэгжүүлэх дуудлага худалдааг үүсгэх хүсэлт гаргахдаа барьцааны эрхтэй болохоо харуулсан баримтаа гаргаж өгнө"[7] гэж хуульчилсан байна. Барьцааны эрхтэй болохыг нотолсон баримт нь улсын бүртгэл болох нь тус хуулийн 266[8] -р зүйлээс харагдаж байна. Үүнээс авч үзвэл Солонгос улсын эрх зүйн тогтолцоо нь Япон улсын эрх тогтолцоотой ижил байна.

V.ДҮГНЭЛТ

Одоо хэрэгжиж байгаа Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хууль нь өмнө авч үзсэнчлэн олон талаасаа учир дутагдалтай хууль болсон гэж үзэж болохоор байна. Япон, Солонгос улсад улсын бүртгэлд үндэслэн барьцааны эрхийг албадан хэрэгжүүлдэг байна. Энэ тохиолдолд барьцаалуулагчийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх хязгаарлагдахгүй, мөн барьцаалагч заавал шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх шатыг дамжилгүйгээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлүүлэх боломжтой болно. Иргэний хуулийн 175-р зүйлийн 175.1-т "...үүрэг гүйцэтгүүлэгчийн хүсэлтийг үндэслэн ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийг шүүхийн шийдвэрийн дагуу албадан худалдана" гэсэн зохицуулалтын дагуу барьцаалагч шаардлагаа хангуулахаар шүүхэд ханддаг байсан бол улсын бүртгэлд үндэслэн барьцааны эрхийг албадан хэрэгжүүлдэг болбол барьцааны эрх үүсээгүй талаар барьцаалуулагч түрүүлж шүүхэд ханддаг болох юм. Уг тохиолдолд барьцаалуулагч улсын тэмдэгтийн хураамж төлөх гэх мэт шүүхэд хандахад тодорхой саад үүсэх ба хариуцагчаар хэрэг хянан

[6] (i) A transcript of a final and binding judgment
(ii) A transcript of a notarial deed prepared by a notary, proving the existence of the security interest
(iii) A certificate of the registered matters concerning registration (excluding provisional registration) of the security interest

[7] http://www.moleg.go.kr/FileDownload.mo?flSeq=31345
(Article 264 (Request for Auction of Immovables)
(1) In filing a request for auction to execute a security right to immovables, the documents attesting the existence of such security right shall be submitted)

[8] Article 266 (Suspension of Auction Procedure)
(1) If the documents falling under any of the following subparagraphs are submitted to an auction court, it shall suspend the auction procedure:
1. A certified copy of the register, which states a cancellation of the registration of the security right;

шийдвэрлэх ажиллагаанд оролцдогтой адилаар шүүхэд чөлөөтэй нэвтрэн, цаг хугацаа хожих байдлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог байдал хязгаарлагдах боломжтой.

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

шийдвэрлэх ажиллагаанд оролцдогтой адилаар шүүхэд чөлөөтэй нэвтрэн, цаг хугацаа хожих байдлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог байдал хязгаарлагдах боломжтой.

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрхийг албадан хэрэгжүүлэх ажиллагааг эхлүүлэхийн тулд төлбөр авагч нь дараах баримт бичгийн аль нэгийг шийдвэр гүйцэтгэх байгууллагад гаргаж өгөх шаардлагатай. Үүнд:

- барьцааны эрхийг бий эсэхийг баталсан шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр,
- барьцааны эрх оршин байгааг баталсан нотариатчийн батламж,
- барьцааны эрхийн бүртгэлийн агуулгыг илтгэсэн улсын бүртгэлийн бичиг хамаардаг байна.

Эдгээрийн гол чиг үүрэг нь барьцаалагчид хүчин төгөлдөр барьцааны эрх байгаа эсэхийг тогтоох явдал юм. Өөрөөр хэлбэл, барьцааны зүйлийг худалдан борлуулахын тулд заавал шүүхийн шийдвэр шаардлагагүй бөгөөд үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийг үндэслэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагддаг.

2.СОЛОНГОС УЛС

Солонгос улсын одоо хэрэгжиж буй Шийдвэр гүйцэтгэх тухай хууль нь 2002 онд иргэний процессын хуулиасаа тусгаарлагдан хуульчлагдсан байна. Уг хуулийн 1-р зүйлд "тус хуулийн зорилго нь албадан гүйцэтгэх ажиллагааны журам, барьцааны эрхийг гүйцэтгэх дуудлага худалдаа, иргэний хууль, худалдааны хууль болон бусад хуульд тусгагдсан дуудлага худалдааг зохицуулахад оршино" гэж хуульчилжээ. Эндээс авч үзвэл, албадан гүйцэтгэх ажиллагаа болон барьцааны эрхийг албадан хэрэгжүүлэх нь бие даасан гүйцэтгэх ажиллагаанууд байна.

Барьцааны эрхийг албадан хэрэгжүүлэх ажиллагаа нь тус хуулийн 264-р зүйлд тусгагдсанаар "Үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрхийг албадан хэрэгжүүлэх дуудлага худалдааг үүсгэх хүсэлт гаргахдаа барьцааны эрхтэй болохоо харуулсан баримтаа гаргаж өгнө"[7] гэж хуульчилсан байна. Барьцааны эрхтэй болохыг нотолсон баримт нь улсын бүртгэл болох нь тус хуулийн 266[8] -р зүйлээс харагдаж байна. Үүнээс авч үзвэл Солонгос улсын эрх зүйн тогтолцоо нь Япон улсын эрх тогтолцоотой ижил байна.

V.ДҮГНЭЛТ

Одоо хэрэгжиж байгаа Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хууль нь өмнө авч үзсэнчлэн олон талаасаа учир дутагдалтай хууль болсон гэж үзэж болохоор байна. Япон, Солонгос улсад улсын бүртгэлд үндэслэн барьцааны эрхийг албадан хэрэгжүүлдэг байна. Энэ тохиолдолд барьцаалуулагчийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх хязгаарлагдахгүй, мөн барьцаалагч заавал шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх шатыг дамжилгүйгээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлүүлэх боломжтой болно. Иргэний хуулийн 175-р зүйлийн 175.1-т "...үүрэг гүйцэтгүүлэгчийн хүсэлтийг үндэслэн ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийг шүүхийн шийдвэрийн дагуу албадан худалдана" гэсэн зохицуулалтын дагуу барьцаалагч шаардлагаа хангуулахаар шүүхэд ханддаг байсан бол улсын бүртгэлд үндэслэн барьцааны эрхийг албадан хэрэгжүүлдэг болбол барьцааны эрх үүсээгүй талаар барьцаалуулагч түрүүлж шүүхэд ханддаг болох юм. Уг тохиолдолд барьцаалуулагч улсын тэмдэгтийн хураамж төлөх гэх мэт шүүхэд хандахад тодорхой саад үүсэх ба хариуцагчаар хэрэг хянан

[6] (i) A transcript of a final and binding judgment
(ii) A transcript of a notarial deed prepared by a notary, proving the existence of the security interest
(iii) A certificate of the registered matters concerning registration (excluding provisional registration) of the security interest

[7] http://www.moleg.go.kr/FileDownload.mo?flSeq=31345
(Article 264 (Request for Auction of Immovables)
(1) In filing a request for auction to execute a security right to immovables, the documents attesting the existence of such security right shall be submitted)

[8] Article 266 (Suspension of Auction Procedure)
(1) If the documents falling under any of the following subparagraphs are submitted to an auction court, it shall suspend the auction procedure:
1. A certified copy of the register, which states a cancellation of the registration of the security right;

криминологийн шинжлэх ухааны шинэ хандлага, төрлүүд бий болж хөгжиж байна. Тухайлбал, нийтийн криминологи (public criminology), хүн судлалын криминологи (biocriminology), хүрээлэн буй орчны криминологи (environment criminology) гэх мэтээр салбарлан хөгжиж байна.

Криминологийн шинжлэх ухааны судлах зүйлийн үндсэн хэсэг болох "гэмт явдал" нь нийгмийн сөрөг үзэгдэл бөгөөд тодорхой цаг хугацаанд улсын хэмжээнд болон тодорхой бүс нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нийлбэр цогц гэж ойлгож болно.

Гэмт явдал нь гэмт хэргээс илүү өргөн хүрээний ойлголт юм. "Гэмт явдал" (англиар criminality, оросоор преступность)ял оногдуулахаар Эрүүгийн хуульд заасан, эрх зүй зөрчсөн, бодитой үйлдэгдэн гарсан бүх гэмт хэргийн нийлбэр цогц, түүнчлэн тодорхой зүй тогтолтой тооны ба чанарын шинж бүхий нийгмийн эрх зүйн нийт сөрөг үзэгдлийг илэрхийлсэн криминологийн ухагдахуун.[3]

"Гэмт явдал нь нийгмийн хөгжлийн явцад улс төр, эдийн засаг, үзэл суртал, ёс суртахууны хүрээнд үүссэн элдэв гажуудал, зөрчил, сөрөг үзэгдлүүдийн шууд үр дагавар болж, тооны буюу чанарын үзүүлэлтээр илэрхийлэгддэг өөрийн зүй тогтолтой, нийгэм эрх зүйн үзэгдэл юм.

Гэмт явдал нь тодорхой гэмт хэргүүдийг өөртөө багтаасан цогц ойлголт юм"[4] гэж тус тус тодорхойлсон байна.

Монгол Улсын Эрүүгийн хуульд 16 дугаар зүйл 16.1-д "Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ"[5] гэж заасан. Судалгааны ажлын сэдвээ гэмт явдал бус зөвхөн гэмт хэргийн статистикийн хүрээнд хэмжээ хязгаарыг тогтоон судалж байгаа болно.

Орчин үед "гэмт хэрэгтэн бие хүн"-тэй зэрэгцүүлэн "хохирогч"-ийн талаарх мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэх нь урьдчилан сэргийлэх ажлын чиглэлийг оновчтой тодорхойлох, халдлагад өртөмтгий хүмүүсийн бүлэг, төрлийг олж тогтоон, тэдэнтэй ажиллахад хэрэгтэй байдаг.

Криминологийн шинжлэх ухааны судлах зүйлийн нэг нь гэмт хэргийн улмаас учирсан хор хохирол байдаг ба түүний мөн чанарыг танин мэдсэний үндсэн дээр урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулдаг онцлогтой.

Криминологийн шинжлэх ухаантай зэрэгцээд гэмт хэргийн хохирогч, түүний нийгэм, хүн ам зүйн шинж, гэмт хэргийн хохирогчийн хохирох зан байдал, гэмт хэрэгтэн ба хохирогчийн харилцан хамаарал, гэмт хэрэгт хохирох эрсдэл, хохирлын төрөл, түүний үр дагаврын талаар судалдаг виктимологийн шинжлэн ухаан хөгжиж байна.[6]

Өмнө нь гэмт хэргийн улмаас хохирсон хохирлын мэдээлэл гардаг байсны дээр цагдаагийн байгууллага 2007 оноос эхлэн гэмт хэргийн халдлагад өртөж хохирсон иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийн сан бүрдүүлж байна.

Гэмт явдлын тооны болон чанарын харилцааг гэмт явдлын түвшин, хөдөлгөөн, бүтэц гэсэн гурван үндсэн үзүүлэлтээр илэрхийлэн судалдаг.

Гэмт явдлын түвшин гэдэг нь түүний тоон үзүүлэлт бөгөөд өөрөөр хэлбэл тайлант хугацаанд тодорхой нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоон үзүүлэлт юм. Үүнд нуугдмал гэмт хэргийг авч үзэх нь зүйтэй. Өнөөдөр үйлдэгдээд хуулийн байгууллагад бүртгэгдсэн албан ёсны тоог авч үзэж байгаа ба гэмт явдлын

[3] Нарангэрэл.С, Эрх зүйн эх толь бичиг, 2008

[4] Жанцан.Н, Гэмт явдал судлал, УБ., 1995

[5] Монгол Улсын Үндсэн хууль,"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн, http://legalinfo.mn/law/details/50?lawid=50

[6] Нямсүрэн.Ч, Гэмт хэргийн виктимологи, УБ., 2005 он

МОНГОЛ УЛСЫН ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК: ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТҮҮНИЙГ САЙЖРУУЛАХ АСУУДАЛ



ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, математик, хууль зүйн ухааны магитстр, цагдаагийн хошууч Б.Мөнхдорж

Энэхүү өгүүллээр гэмт явдал, түүнийг судалдаг криминологийн шинжлэх ухаан, статистикийн шинжлэх ухаан, гэмт хэргийн статистикийн ойлголт, тогтолцоонд дүн шинжилгээ хийж, гэмт хэргийн статистикийн онол, арга зүйн зарим асуудлыг хөндөхийг зорилоо.

Судалгааны ажлыг явуулахад нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, баримт бичигт дүн шинжилгээ хийх, системийн дүн шинжилгээ хийх шинжлэх ухааны түгээмэл аргуудыг ашиглаж бичсэн ба Монгол Улсын гэмт хэргийн статистикийн өнөөгийн байдал, тогтолцоо, улмаар түүний онол, арга зүйг шинжлэх ухааны үндэслэлтэй судлан, онол, арга зүйг, практик хэрэглээг хөгжүүлэх асуудлыг авч үзсэн болно.

1.Криминологи, статистикийн шинжлэх ухааны уялдаа

Хүн төрөлхтөн гэмт явдлаас учрах аюул, аймшгийн өмнө амьдарч ирсэн, одоо ч амьдарсаар байна. Нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт явдлыг хүн төрөлхтөн эрт дээр үеэс таньж мэдэхийг оролдон, түүний шалтгаан нөхцөлийн талаар янз бүрийн онол, үзэл баримтлал боловсруулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх оновчтой арга замыг эрэлхийлсээр ирсэн билээ.[1]

Гэмт явдалтай тэмцэх арга замыг янз бүрийн түвшинд эрэлхийлж судалсаар шинжлэх ухаан болтлоо хөгжжээ. Криминологийн шинжлэх ухаан нь гэмт явдлын шалтгаан, нөхцөл, гэмт хэрэгтэн бие хүний онцлогийг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулдаг.[2]

Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлах асуудал онолын түвшинд баяжиж, улам боловсронгуй болж байгаа хэдий ч түүнийг практикт нэвтрүүлэх, үр дүнг ашиглах явдал хангалттай бус байна.

Криминологийн шинжлэх ухаан гэмт явдал, гэмт явдлын шалтгаан, нөхцөл, гэмт хэрэгтэн бие хүн, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ буюу бодлого, гэмт хэргээс учирсан хор хохирол зэргийг судалдаг.

Криминологи гэдэг нь латин гаралтай “Crimeni”- гэмт хэрэг, грек гаралтай “Logis”-судлал, сургаал гэсэн агуулгыг нэр томьёоны хувьд илэрхийлдэг. Дэлхийн улс оронд

[1] Болдбаатар.Ж, О.Нямдаваа, Криминологи, УБ., 2010, 5 дахь тал

[2] Жанцан.Н, Криминологи, УБ., 2004, 8 дах тал

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nlis.gov.mn

түвшинг авч үзэхэд нуугдмал гэмт хэргийг давхар тооцож үзэх нь нэн чухал. Энд хүн ам дахь гэмт хэргийн явдлын түвшинг мянга, арван мянган хүн амд ногдох коэффицентээр гаргадаг нь бусад бүс нутаг, улс оронтой харьцуулах боломжтой болгодог.

Гэмт явдлын хөдөлгөөн гэдэг нь гэмт хэрэг, зөрчлийн өсөлт, бууралтыг ойлгож болно. Тухайлбал, өмнөх онуудтай, эсвэл өмнөх оны мөн үеийн түвшинтэй, өмнөх саруудын түвшинтэй харьцуулах замаар гэмт хэрэг, зөрчлийн хөдөлгөөнийг илэрхийлж, өссөн, буурсан талаарх тоон үзүүлэлтийг гаргадаг.

Гэмт явдлын бүтэц гэдэг нь гэмт явдлын төрөл, ангилал, зарим онцлогийг хамруулан ойлгож болно. Тухайлбал гэмт хэргийн төрөл, үүнд хулгайлах, бусдын бие махбодид гэмтэл учруулах, танхайрах, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зэрэг гэмт хэргийн тоо, тэдгээрийн эзлэх хувийн жинг харуулдаг.

Гэмт хэрэг үйлдэгдсэн зарим онцлогийн тухайд насанд хүрээгүй болон эмэгтэй хүмүүс оролцсон, архидан согтуурсны болон гэр бүлийн хүчирхийлэл, маргааны улмаас, мөн бүлгээр, галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, тэдгээрийн хувийн жин, хөдөлгөөнийг харуулж болно.

Монгол Улсын Эрүүгийн хуульд зааснаар 223 гэмт хэргийг хуульчлан тогтоосон. Өнөөдөр гэмт хэрэг дотроос бусдын бие махбодид гэмтэл учруулах, хулгайлах, танхайрах, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг, булаах, дээлэмдэх, залилан мэхэлж авах, хүний амь насыг хохироох, амиа хорлох, хүчиндэх зэрэг тодорхой 8-9 төрлийн гэмт хэргүүд голлон үйлдэгдэж, эдгээр нь нийт гэмт хэргийн 80-90 орчим хувийг эзэлж байна.

Манай орны тухайд хулгайлах, бие биенээ зодох, гэмтэл учруулах хэрэг үйлдэгдэж байна.

Гэмт явдлыг судалж буй криминологи, бусад шинжлэх ухаантай математик, магадлал, статистик, социологи, мэдээллийн технологи зэрэг салбарын шинжлэх ухаан нягт уялдаатай байдаг.

Нийгэм, эдийн засгийн үзэгдлийн тоо мэдээллийг цуглуулах, боловсруулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх арга зүйн суурь шинжлэх ухааныг статистик хэмээх ойлголт түгээмэл болсон.**"Статистик"**[7] хэмээх нэр томъёо нь **"status"** гэсэн латин үгнээс гаралтай юмс үзэгдлийн төлөв байдал гэсэн утгатай үг. Орос хэлнээс **"статистик"** гэдэг нь "тоо бүртгэгч, статистикч", **"статистика"** гэдэг нь "тоо бүртгэлийн ухаан, статистик, тоо бүртгэл" гэж монгол хэл рүү орчуулжээ.[8]

Я.Цэвэлийн "Монгол хэлний товч тайлбар толь"[9] **"тооны бүртгэл"** гэдгийг "бүртгэл, тооцоо, тооллого, малын тоо бүртгэл, хүн амын бүртгэл", **"тоо бүртгэлийн судлал"** гэдгийг "нийгмийн хөгжил, ардын аж ахуй дахь тооны хуваарилалтыг судлах ухаан", **"тоо бүртгэгч"** гэдэг нь "тоо бүртгэл эрхэлсэн хүн", **"зүй"** гэдэг нь "...ямар нэгэн сургаал, онол, арга зүй, ..." гэж тус тус тайлбарлажээ. Статистик гэдэг үгийг хүмүүс хаа нэгтээ сонссон харсан байдаг ч яг юу гэдгийг нь тэр бүр мэддэггүй.

Статистикийн шинжлэх ухаан нь анх 1663 онд математикийн шинжлэх ухаанаас "өрх тусгаарлан" бие даасан шинжлэх ухаан болж хөгжих эхлэл тавигдсан гэж түүхийн эх сурвалжуудад бичигдсэн байдаг талаар Английн хүн ам зүйч Жон Граунт өөрийн бүтээлдээ дурдсан байдаг. Тэрээр статистикийн зарчмууд нь 17-р зууны эхнээс өргөжин

[7] Эрдэнэсувд.Л, Бизнесийн статистик,УБ., 2004, 6 дахь тал

[8] Кручкин.Ю, Орос-Монгол-Монгол-Орос орчин үеийн хэлний дэлгэрэнгүй толь бичиг, Москва хот., 2006, 496 дах тал

[9] БНМАУ-ын Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэн, Я.Цэвэл., Монгол хэлний товч тайлбар толь, УБ., 1966, 541 дэх тал

хөгжсөн гэж тэмдэглэжээ. 17-р зуунд Францын математикч, физикч, шашны гүн ухааныч Блэйс Паскал, хуульч, математикч Пиерр де Фермат нарын боловсруулсан магадлалын онолыг статистикийн онолын гол суурь болсон онол гэж үздэг.

Энэ онол нь Германы математикч, физикч Карл Фриедрих Гауссын 1794 онд боловсруулсан "Хамгийн бага квадратын арга"-ыг араасаа дагуулсан юм. Энэ мэтчилэн статистикийн шинжлэх ухаан нь үе үеийн эрдэмтдийн боловсруулсан онолоор баяжигдан өнөөг хүрсэн түүхтэй.

Олон улсын хэмжээнд нийтлэг мөрддөг тодорхойлолтоор "Статистик нь нийгэм, эдийн засгийн тоон мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, үр дүнг тайлбарлах, танилцуулахтай холбоотой шинжлэх ухаан юм" гэж тодорхойлсон байдаг.[10] Монгол Улсын хувьд "Статистик нь нийгэм, эдийн засгийн юмс үзэгдлийн тоон илрэлийг чанартай нь холбон тэдгээрийн хөгжлийн зүй тогтлыг тодорхой орон зай, цаг хугацаанд судалдаг шинжлэх ухаан юм" гэж ойлгож болно.

Нийгэм, эдийн засгийн үзэгдэл, процессын тоо мэдээллийг шинжлэх ухааны үндэстэйгээр цуглуулж, боловсруулан шинжилгээ хийж, түүний зүй тогтол, харилцан хамаарлыг тооны аргаар нээж үнэлэлт, дүгнэлт гаргадаг шинжлэх ухааныг статистик[11] гэнэ.

Хүн төрөлхтөн хийж бүтээсэн баялаг, өмч хөрөнгө, мал, хэрэглэж буй эд зүйлээ бүртгэн тооцоолох зайлшгүй шаардлагаар амьдрал дээр статсистик МЭӨ 2200-аад оны үед эртний Вавилон, Египед, Римд үүссэн байдаг. Практик статистик 4000 гаруй жилийн түүхтэй байхад онолын статистик сүүлийн 300 гаруй жилийн хугацаанд үүсэн эрчимтэй хөгжиж байна.

Монгол Ардын Намын III их хурал, Улсын Анхдугаар Их Хурлаас тоо бүртгэлийн албыг бий болгож хүн ам, өрх, мал, эд хөрөнгийг үнэн зөв тодорхой тоо баримттай болохын чухлыг зааж, энэ үндсэн дээр 1924 онд тоо бүртгэлийн хэлтсийг байгуулан улсын тоо бүртгэлийн ажлыг эрхлэх үүргийг хариуцуулсан үеэс эхлэн Монгол Улсын Үндэсний статистикийн алба хөгжих үндэс суурийг тавьжээ. 2016 оноос Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар болж, дараа нь Үндэсний статистикийн хороо нэрээр үйл ажиллагаа явуулж байна.

Статистик шинжлэх ухаан нь бүтцийн хувьд:

1. Статистикийн ерөнхий онол;

-статистик судалгаа, шинжилгээний ерөнхий онол, арга зүй, аргачлал, зарчим, статистикийн ерөнхий үзүүлэлтүүдийг боловсруулдаг.

2. Эдийн засгийн статистик;

-улс орны эдийн засгийн байдлыг тусгаж байгаа үзүүлэлтийг боловсруулан шинэчлэх, салбар хоорондын харилцан хамаарал, үйлдвэрлэл, материал, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн бэлэн байгаа нөөц, зарцуулалт, ашиглалтын байдал, үр дүнг судалдаг.

3. Салбарын статистик гэж хуваагдана.

-нийгмийн статистик болон салбарын статистикт тээвэр, холбоо, хүн ам, соёл, боловсрол, эрүүл мэнд, шүүх, гэмт хэргийн статистик гэх зэрэг орно.

Статистикийн шинжлэх ухааны судлах зүйл нь нийгэм, эдийн засгийн юмс, үзэгдлийн тоо мэдээллийг чанарын агуулгатай нь нягт холбоотойгоор тодорхой орон зай (улс орны, тодорхой бүс нутаг), цаг хугацаанд судлах явдал байдаг. Статистикийн юмс, үзэгдлүүд нь статистикийн хэмжигдэхүүнээр тодорхойлогддог. **Статистикийн хэмжигдэхүүн** гэдэг нь судлагдаж буй юмс, үзэгдлийн шинж чанарын

[10] http://chandra_b.blog.gogo.mn/read/entry434220

[11] Эрдэнэсувд Л. Бизнесийн статистик,УБ., 2004, 9-р тал

хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр Төр, засаг, шүүх болон хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл өгөх, ажлын үр дүнд үнэлгээ өгч, тодорхой санал дүгнэлт боловсруулах явдал юм.

Хууль зүй, криминологи, математик, статистикийн шинжлэх ухаантай уялдаатайгаар "гэмт хэргийн статистик" нь хавсарга шинжлэх ухаан байдлаар боловсронгуй болгон судлах боломжтой гэж үзэж байна. Санамсаргүй буюу болгоомжгүй, тохиолдлын байдлаар илэрч байгаа нэгжүүдээс бүрдэх адил чанарын юмс, үзэгдлийн нийлбэр хэмжээг статистик олонлог гэнэ.

Тэгвэл санаатай болон болгоомжгүй үйлдэгдсэн гэмт хэргүүдийн нийлбэр хэмжээ нь гэмт явдлын олонлог болох юм. Олонлогийн аль нэг тогтвортой байдлаар илрэх шинж байдал буюу мөн чанарыг статистикийн зүй тогтол гэнэ.

Статистикийн олонлогийг бүрдүүлж байгаа нэгж бүр тодорхой агуулга бүхий мөн чанартай, төрх байдлыг харуулсан нийтлэг үзүүлэлтүүдийг статистикийн онолд **шинж тэмдэг** гэж нэрлэдэг. Бүх төрлийн шинж тэмдгүүдийг **тооны болон чанарын шинж тэмдэг** гэж нэрлэдэг. Шинжлэх ухааны үндэслэлтэй урьдчилан төлөвлөсөн тодорхой программын үндсэн дээр зохион байгуулалттайгаар тоо мэдээллийг цуглуулах ажлыг **статистик ажиглалт** гэнэ.

Гэмт хэргийн байдлыг статистикийн аргаар судлан боловсруулахын тулд урьдчилан төлөвлөсөн тодорхой программын дагуу зохион байгуулалттайгаар гэмт хэргийн талаарх тоо мэдээллийг цуглуулах үйл ажиллагааг **статистик ажиглалт** гэж ойлгож болно. Статистик ажиглалт явуулан гэмт хэргийн тоо мэдээллийг цуглуулах 4 үндсэн арга хэрэглэдэг. Энэ нь шууд биечлэн бүртгэх, баримтын арга, асуулгын арга, анкетын арга гэж хуваана.

1.Шууд биечлэн бүртгэх арга. Энэ нь гэмт хэргийн талаарх тоо мэдээллийг бүртгэхдээ ажиглалт хийж байгаа хүн өөрөө биечлэн тооцоолох, хэмжих, жигнэх зэрэг найдвартай тоо мэдээллийг олж авах явдал юм. Энэхүү аргаар ажиглалт явуулахад нэлээд хөдөлмөр зарцуулдаг.

2.Баримтын арга. Албан ёсны бичиг баримт, материалаас мэдээллийг бүртгэн авахыг хэлнэ.

3.Асуулгын арга. Нэлээд түгээмэл дэлгэрсэн ажиглалт юм. Гэмт хэргийн талаар судлаачаас хүмүүстэй харилцан ярилцах, асуух замаар бүртгэхийг хэлнэ. Асуулга нь нийгэм, эдийн засгийн үзэгдэл, процессуудын талаарх үнэн зөв шуурхай мэдээллийг авахад бусад аргуудыг бодвол илүү давуутай байдаг.

4.Анкетын арга. Тусгайлан боловсруулсан хүснэгтийн дагуу тоо баримтыг нөхүүлэн бичүүлж авах арга. Тухайлбал: Гэмт хэргийн бүртгэлийн маягт нөхөж бичихэд дээрх аргуудыг хэрэглэж байгаа ба дараа нь цуглуулсан эдгээр мэдээллийг боловсруулалт хийх ажлыг программ хангамжийн ашиглан хийж байна.

Гэмт явдлын нөхцөл байдал, төлөв, чиг хандлага, шалтгаан нөхцөл, мөн гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн этгээд, гэмт хэргийн халдлагад өртсөн этгээдийн болон захиргааны зөрчлийн талаарх мэдээллийг статистикийн шинжлэх ухааны арга зүйд тулгуурлан оновчтой цуглуулж, боловсруулж, дүн шинжилгээ хийн, түүний үр дүнг криминологи, виктимологи, эрүү, эрүүгийн процессын эрх зүйн шинжлэх ухаантай уялдуулан судалж, гэмт явдалтай үр дүнтэй тэмцэх зорилт тавигдана.

"Гэмт хэргийн статистик" гэдэгт гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийн сангаас статистик мэдээллийг боловсруулан гаргах, түүнд

тоон үнэлгээ юм. Статистикийн шинжлэх ухааны аргуудыг гүйцэтгэх үүргийг нь харгалзан **боловсруулалт, шинжилгээний** гэсэн хоёр бүлэгт хуваадаг.

Боловсруулалтын бүлэгт:

-Тоо мэдээллийг бүлэглэлт, товчоололт хийх;

-Тархалтын цуваа байгуулах;

-Статистик хүснэгт зохиох;

-График дүрслэлээр илэрхийлэх;

-Үзүүлэлтүүдийг харьцуулах, зэрэгцүүлэх;

-Дундажлах, нийлбэрийг тооцох;

-Үзүүлэлтүүдийн хэлбэлзлийг тооцох зэрэг аргуудыг хамруулна.

Шинжилгээний бүлэгт:

-Динамик эгнээний шинжилгээ;

-Нөлөөлж буй хүчин зүйлсийн корреляцийн шинжилгээ;

-Регрессийн шинжилгээ;

-Түүвэр судалгааны арга;

-Дисперси;

-Индекс;

-Магадал таамаглал дэвшүүлэх зэрэг аргууд багтана.

Статистик нь задлан шинжлэх (анализ), нэгтгэн дүгнэх (синтез), хийсвэрлэх (абстракт), түүхчлэх, ерөнхийгөөс тодорхой, тодорхойгоос ерөнхийд хандах зэрэг шинжлэх ухааны түгээмэл аргуудыг шууд баримтална. Статистикийн арга зүй гэдэг нь нийгэм, эдийн засгийн бүтэц, динамик болон хамаарлын зүй тогтлыг судлахад чиглэгдсэн арга, аргачлалын тогтолцоо юм. Энд математик статистикийн шинжлэх ухааныг дурьдахад санамсаргүй үзэгдлийг ажиглах явцад гарган авсан туршилтын статистик тоон мэдээллийг бүртгэх, цуглуулах, судлах, шинжилгээ хийх аргыг боловсруулдаг шинжлэх ухааныг **математик статистик гэнэ.**[12]

[12] Энхбат.Р, Магадлалын онол, математик статистикийн гарын авлага, УБ., 2002

2. Монгол Улс дахь гэмт хэргийн статистикийн тухай ойлголт:

Нийгмийн сөрөг үзэгдэл гэмт хэрэг нь гаралт, хөдөлгөөн, тархалт, бүтцийн хувьд байнга хувьсан өөрчлөгдөж байдаг. Олон улсын практикаас судалж үзэхэд хууль зүйн статистикийг эрүүгийн, шүүхийн, **иргэний, захиргааны эрх зүйн статистик** гэх мэт ангилдаг байна.

Тэгэхээр манай улсад хууль зүйн статистикийн илүү өргөн хүрээнд судлан үзэх шаардлага улам бүр нэмэгдэж байгаа ба *эрүүгийн буюу гэмт хэргийн статистикийг* нарийвчлан авч үзэх нь зүйтэй.

Гэмт хэргийн талаарх статистик ажиглалт хийж мэдээллийг цуглуулах, боловсруулах, түүнд судалгаа, шинжилгээ хийж, цагдаагийн байгууллагын албадын ажлыг дүгнэх, удирдлагыг мэдээллээр хангах, гэмт хэргийн байдал, шалтгаан нөхцөлийг тодорхойлоход зайлшгүй статистикийн шинжлэх ухааны арга, аргачлал, арга зүйг байнга үйл ажиллагааны бүх шатанд ашиглаж байна.

Иймээс гэмт хэргийн статистикийг онол, арга зүйн талаас судалж, түүнийг боловсронгуй болгох, өргөн цар хүрээг хамарсан дүн шинжилгээ хийх шаардлага аливаа улс орны хөгжлийн чиг хандлагыг даган бий болж байна.

Гэмт хэргийн статистик *нь шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулсан програмаар, гэмт хэргийн талаарх тоо бүртгэл хөтлөх, цуглуулах, боловсруулах, түүнд судалгаа, шинжилгээ хийж гэмт хэргийн тоон мэдээллийг шалтгаан нөхцөл, шинж чанартай нь уялдуулан тодорхой зай, цаг хугацаанд судалдаг салбарын статистик юм.*

Гэмт хэргийн статистикийн судлах үндсэн зүйл нь гэмт хэргийн гаралт, тархалт, бүтэц, хөдөлгөөн, гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, сэжигтэн, яллагдагч, хохирогч иргэн, байгууллага, нийгэм, эрх зүйн хор хохирол, үр дагавар, гэмт

www.mjsoft.mn

гэмт хэрэг, зөрчлийн тоо бүртгэл, арга зүй уялдаагүй, гэмт хэрэг, зөрчлийн тоо бүртгэлийн аргачлал, статистик мэдээний нэгдмэл байдал хангагдахгүй, гэмт явдлын тоо бүртгэл бодитой бус байгаа нь төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх бодлогод үр дүнтэйгээр нөлөөлж чадахгүй.

Түүнчлэн, гэмт хэргийн статистикийн онол, арга зүйн талаарх эрдэм шинжилгээний бүтээл хомс байна. Гадаад, дотоодын эх сурвалж, бүтээл, практикийг харьцуулан судлах замаар "Гэмт хэргийн статистик зүй" хэмээх судлагдахуун, эсхүл хавсарга дундын шинжлэх ухаан хэмээн үзэж, түүний онол, арга зүй, практикийг хөгжүүлэх шаардлагатай байна.

Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Хууль зүйн яамны 2012-2016 хүртэлх үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд цахим мэдээллийн тогтолцоог төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, хүнд суртал, өргөдөл гомдолыг шийдвэрлэх олон шат дамжлагыг багасгах талаар тодорхой заалтууд туссан.

Үүнийг хэрэгжүүлэхээр Хууль зүйн яамны дэргэд мэргэжилтнүүдээс бүрдсэн төслийн баг 2013 оноос байгуулагдан хууль сахиулах байгууллагуудын цахим мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхээр ажиллаж байна. Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Захиргааны болон эрүүгийн зөрчлийг бүртгэх нэгдсэн сан бий болгож, эрсдэлийн удирдлагын менежментийг нэвтрүүлэх..." гэж заасан.

Үүний дагуу хууль зүйн цахим мэдээллийн тогтолцоог шүүх эрх мэдлийн байгууллага болон хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаагаар бий болгож, түүнийг хөгжүүлэх хүлээлт байна.

Түүнчлэн, хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн гэмт хэргийн статистикийн мэдээллийг шинжлэх ухааны үндэслэлтэй бодитой гаргаснаар гэмт хэрэгтэй тэмцэх талаар төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагаа оновчтой, үр дүн хэрэгжих нөхцөл бүрдэж, ард иргэдийн аюулгүй, амар тайван орчинд амьдрах нөхцөл, хүний эрх, эрх чөлөө хангагдах юм.

Хууль зүйн салбарын шинэтгэлийн хүрээнд батлагдан гарч буй Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийг 2016 оны 09 дүгээр сарын 01-нээс мөрдөж эхлэхтэй холбогдон гэмт хэргийн бүртгэлийн болон мэдээний маягтуудыг шинэчлэх шаардлага бий болох бөгөөд эдгээрийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах хэрэгцээ байна.

Мөн Хууль зүйн яамнаас боловсруулагдаж буй Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөлд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн бодлого боловсруулах, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн давхардлыг арилгах, иргэдэд шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилгоор хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагууд хамтран нэгдсэн мэдээлийн сан бүрдүүлж, ашиглах заалт тусгагдаад явж байгаа учир мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээлэл эрхлэн гаргах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсронгуй болгох шаардлага байна.

Иймд Монгол Улсын гэмт хэргийн статистикийн талаар онолын судалгаа хийж, судалгааны үндсэн дээр онолын үндэслэл боловсруулах, эрдэм шинжилгээний бүтээл ном эрхлэн гаргах, өгүүлэл ний лүүлэх, цагдаа, авлигатай тэмцэх, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын гэмт хэргийн бүртгэлийн болон статистикийн мэдээний маягтыг шинэчлэх, програм хангамж, мэдээллийн системийг нь боловсронгуй болгох санал боловсруулах, холбогдох хууль, журамд нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

www.nibeg.mn

дүн шинжилгээ, анализыг практиктай уялдуулан үр дүнтэй хийж, үр дүнд бодлого, үйл ажиллагаандаа ашиглах үйл ажиллагаа хамаарагдана. Гэмт хэргийн статистик гээд бичихэд Монгол Улсын хэмжээнд үйлдэгдсэн бүх гэмт хэргийг хамруулах зорилт тавигддаг. Мөн хуульд заасан харьяаллын дагуу хуулийн байгууллагуудын бүртгэж, шалгаж буй гэмт хэргийг бүгдийг хамруулах зорилт тавигдах учиртай. Эндээсургаадгэмтхэргийнстатистикийг боловсронгуй болгох асуудал нь хууль сахиулах, хамгаалах, хэрэгжүүлэх байгууллагуудын мэдээллийн нэгдсэн тогтолцоог оновчтой бүрдүүлэх, үйл ажиллагааг нь жигдрүүлэх, давхардлыг арилгах явдал.

Гэмт хэргийн статистикийн эцсийн үр дүн бол Монгол Улсын хэмжээнд үйлдэгдсэн бүх гэмт хэргийг зөв арга зүйгээр бүртгэдэг, цуглуулдаг, нийтэд мэдээлдэг, Монгол Улсын төр засаг, иргэд, олон түмэн гэмт хэргийн бодит нөхцөл байдлыг мэдэрч, түүнтэй тэмцэх төрийн бодлого, иргэдийн тэмцэл үр дүнд хүрэхэд оршино гэж дүгнэж болохоор байна.

Гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох асуудлыг судлахад математик, эдийн засаг, статистик, криминологи, виктимологийн шинжлэх ухаанаас гадна эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын эрх зүй, социологи, цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх гэх мэт олон салбар шинжлэх ухаануудтай уялдаатайгаар судлах ёстой.

3. Монгол Улсад гэмт хэргийн статистикийг судалсан байдал

Гэмт хэргийн статистикийн онол, арга зүйг дэлхий нийтэд хөгжиж байгаа боловч Монгол Улсад 1988 онд Я.Баатар, Д.Тархаашин "Гэмт хэрэг судлах статистик арга зүй", 2007 онд П.Ихзаяа, С.Жанцан, Б.Мөнхдорж "Гэмт хэргийн статистик" нэг сэдэвт бүтээлээс дагнан судалсан эрдэм шинжилгээний бүтээл хомс байгаа нь гэмт хэргийн статистикийн онол, арга зүйг тодорхойлсон бүтээл зайлшгүй үгүйлэгдэж байна. С.Жанцан, Н.Жанцан, Ж.Болдбаатар, О.Нямдаваа, Б.Батзориг нарын эрдэмтэн, судлаачдын бүтээлд гэмт хэргийг судлахад статистикийн арга зүйг ашиглах талаар дурдсан байдаг.

Энэ чиглэлээр дагнасан иж бүрэн судалгааны ажил үгүйлэгдэж байна. Цаашид ч уг асуудлыг магистр, докторын шатанд судлах үзэх зайлшгүй шаардлага байгааг эрдэмтэн, судлаачид дурьддаг.

Гадаад улсын хувьд ОХУ-ын эрдэмтэн Ю.Д.Блувштейн математик ба криминилоги, АНУ-ын DavidGreenberg зэрэг эрдэмтэн математик, магадлал, статистикийн шинжлэх ухааны арга, арга зүйг гэмт хэргийг судлах, криминологийн шинжлэх ухаанд ашиглах талаар эрдэм шинжилгээний ажил хийсэн байдгийг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлага бий.

Гадаадын зарим улсын туршлагаас үзэхэд *Crime statisticis,Mathematics, statistics and the Law, Criminal Justice statistics, Crime and mathematics, Quantitative Criminology, Statistics for Criminology and Criminal Justice, Уголовны статистика, Юридическая статистика, Правовая статистика, Субодная статистика* гэх нэр томьёоны хүрээнд судлагдаж, боловсронгуй болж байна.

Япон улсад гэмт хэргийн статистикийн хэрэглээ боловсронгуй болон хөгжсөн нь жил бүр эрхлэн гаргадаг гэмт хэргийн цагаан номноос харагддаг. (White paper on crime)[13]


4.Монгол Улсад гэмт хэргийн статистикийг онол, арга зүйгсудлах шаардлага:

Монгол Улсад гэмт хэргийн статистикийн тогтолцоо оновчтой бус, цагдаа, авлига, шүүхийн шийдвэр, прокурор, шүүхийн байгууллагын

[13] http://hakusyo1.moj.go.jp/en/nendo_nfm.html

5. Монгол Улс дахь гэмт хэргийн статистикийн тогтолцоо, өнөөгийн байдал:

Монгол Улсад гэмт хэргийн статистикийн мэдээг Шүүх, Прокурор, цагдаа, авлигатай тэмцэх, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас эрхлэн гаргаж, Үндэсний статистикийн хороонд нэгтгэж, улсын хэмжээний нийгэм, эдийн засгийн мэдээнд тусч байна. Эдгээр байгууллагууд мөн тус тус үйл ажиллагааны хүрээнд статистик мэдээллийг нийтийн хүртээл болгож, үйл ажиллагаанд ашиглаж байна.Дээрх хуулийн зарим байгууллагуудын аймаг, нийслэл, дүүрэг, сум дахь нэгжийн гэмт хэргийн статистик мэдээ нь тухай нутаг дэвсгэрийн төрийн захиргааны статистикийн нэгжийн эрхлэн гаргаж буй статистикийн мэдээнд тусч байдаг.



Монгол Улсад гэмт хэргийн статистикийн мэдээлэл эрхлэн гардаг тогтолцоо бол зохих түвшинд бүрдсэн.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, прокурорын байгууллага чиг үүргийн хүрээнд хяналт тавьсан эрүүгийн хэрэг, шүүхийн байгууллагад шүүхээр шийдвэрлэгдсэн, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн статистикийн мэдээлэл гардаг. Эдгээр статистик мэдээллийн анхан шатны бүртгэл болох бүртгэлийн маягт нь харилцан адилгүй байдаг.

Тагнуулын байгууллагын хувьд хуулиар харьяалуулсан гэмт хэрэг шалгадаг боловч улсын хэмжээний гэмт хэргийн статистикийн мэдээнд тэр бүр тусгадаггүй. Авлигатай тэмцэх газар мөн хуулиар харьяалуулсан гэмт хэргийг бүртгэж, илрүүлж шалгадаг ба шалгаж гэмт хэргийн талаарх мэдээллийг цагдаагийн байгууллагын мэдээллийн санд бүртгүүлж, улсын хэмжээний мэдээнд тусгагдаг ч албаны нууцлал гэх үүднээс гэмт хэрэг бүрийг бүрэн мэдээллийн санд оруулдаггүй, статистикийн мэдээнд тусгахгүй явдал байна.

Сүүлийн 10 жилийн байдлаар Монгол Улсад жилд дунджаар 22 мянган гэмт хэрэг бүртгэгдэж байгаа боловч эрдэмтэн, судлаачдын судалгаа, таамаглалаар нуугдмал гэмт хэргийн түвшин өндөр байгааг дурдсан байдаг. Дэлхийн улс оронд нуугдмал гэмт хэргийн түвшинг хэд дахин өндөр байдгийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлан гаргасан байдаг.

Өнөөгийн байдлаар Цагдаагийн байгууллагад гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, гэмт хэрэгт холбогдсон этгээд, хохирсон иргэн, байгууллага, хохирол, захиргааны зөрчил, түүнийг үйлдсэн этгээдийн талаарх мэдээллийн сан улсын хэмжээнд онлайнаар бүрдэж, түүнээс статистикийн мэдээлэл боловсруулагдаж гарч байна.

Харин Шүүх, прокурорын байгууллагын хувьд мэдээллийн сан бүрдүүлэх системээ хөгжүүлж эхэлж байгаа бөгөөд статистик мэдээлэл эрхлэн гаргах үйл явц боловсронгуй бус байна.

Үндэсний статистикийн хорооны Хүн ам, Нийгмийн статистикийн газарт цагдаа, прокурор, шүүх, шүүхийн

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

шийдвэр гүйцэтгэх байгууллагын гэмт хэргийн талаарх статистик мэдээлэл нэгтгэн гарч, улсын хэмжээний нийгэм, эдийн засгийн байдалд тусч, улмаар төр засгийн холбогдох байгууллага, албан тушаалтнуудын түвшинд танилцуулагдаж, НҮБ-ын статитикийн төв байгууллала зэрэг олон улсын байгууллагад хүргэгддэг.

6. Монгол Улс дахь гэмт хэргийн статистикийн эрх зүйн зохицуулалт

Гэмт хэргийн статистик мэдээлэл эрхлэн гаргаж буй эрх зүйнзохицуулалт нь Статистикийн тухай, Цагдаагийн албаны тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Прокурорын байгууллагын тухай, Шүүхийн тухай, Шүүхийн захиргааны тухай хууль болон цагдаагийн байгууллагын хэмжээнд Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх журам,[14] Прокурорын байгууллагын мэдээлэл, мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангах журам,[15] Гэмт хэргийн тоо бүртгэлийн маягтыг нөхөх, мэдээллийн санд төвлөрүүлэх журам,[16] Шүүхийн статистикийн мэдээлэл, тайлан гаргах журам[17] зэрэг эрх зүйн зохицуулалтын хүрээнд зохицуулагдаж байна.

Мөн Хууль зүйн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/48 тоот тушаалаар батлагдсан "Салбарын статистик мэдээллийн сан бүрдүүлэх, эрхлэн хөтлөх" журам мөрдөгдөж байна.

Дүгнэлт

Энэхүү илтгэлийн төгсгөлд дүгнэхэд хууль зүй, криминологи, математик,магадлал, математик статистик, статистик, виктомологийн зэрэг гэмт явдалтай тэмцэх онол, арга зүйн үндсийг тодорхойлсон шинжлэх ухаантай уялдаатайгаар "Гэмт хэргийн статистик зүй" хавсарга шинжлэх ухаан, эсхүл бие даасан судлагдахуун байж болох юм.

Гэмт хэргийн статистик зүйн онол, арга зүйг гадаад, дотоодын эх сурвалжид тулгуурлан гүнзгийүүлэн судлах шаардлага байна.

Гэмт хэргийн статистик зүйг боловсронгуй болгох замаар Монгол Улсын гэмт хэргийн статистикийн тогтолцоо, онол, арга зүйг судлан онолын үндэслэл боловсруулах; Цагдаа, авлига, шүүхийн шийдвэр, прокурор, шүүхийн байгууллагуудын гэмт хэргийн статистикийн бүртгэлийн болон мэдээний маягтууд болон мэдээллийн систем, програм хангамжийг шинэчлэхсанал боловсруулах;Монгол Улсын гэмт хэргийн статистикийн арга зүйг журамласан журмын төсөл, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох, энэ төрлийн ажлыг хариуцсан мэргэжилтэн бэлтгэх, судлаачдыг мэргэшүүлэх шаардлага урган гарч байна.

Цаашилбал гэмт хэргийн статистик зүйг хавсарга дундын салбар шинжлэх ухааны онол, арга зүйг хөгжүүлсэнээр цагдаа, авлига, шүүхийн шийдвэр, прокурор, шүүхийн байгууллагын гэмт хэргийн маягт, арга зүйг боловсронгуй болгож, хууль зүйн салбарын гэмт хэргийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болно.

Улмаар гэмт хэргийн талаарх статистикийн мэдээллийн нэгдмэл байдал, уялдаа холбоо хангагдаж, үнэн бодиттой статистик мэдээллийн үндсэн дээр гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх төрийн бодлого оновчтой хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

Түүнчлэн, Монгол Улс дахь эрүүгийн нөхцөл байдлыг тоон үзүүлэлтээр үнэн зөв, бодитой илэрхийлэн гаргаж, дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх ажлын үр дүн дээшлэх нөхцөл бүрдэхийн зэрэгцээ

[14] ЦЕГ-ын даргын 2015 оны А/21 дүгээр тушаалаар батлагдсан.

[15] Монгол УлсынЕрөнхий Прокурорын 2014 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан.

[16] АТГ, ТЕГ, ЦЕГ, УЕПДэргэдэх МБА-ын даргын хамтарсан 2010 оны 43/182/223/21 тоот тушаалаар батлагдсан.

[17] Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2006.04.25-ны 17 дугаар тогтоолоор батлагдсан.

гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг оновчтой тодорхойлж, түүний эсрэг тохирсон арга замыг хэрэгжүүлж, улмаар гэмт хэргийн статистик зүйн ойлголт, арга зүй, хэрэглээ төлөвшиж, цаашид улам боловсронгуй болон төлөвшихөд ач холбогдолтой билээ.

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ АЖИЛЛАГААНД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГА, АРГА ЗАМ

МУИС-ын Хууль зүйн сургуулийн магистрант Ж.Болормаа

Товч агуулга: Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих арга хэмжээ авах онцгой эрх бүхий субьект болох шүүхийн үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт, мониторингийн тогтолцоо байснаар хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээхтэй холбогдсон бүх талын арга хэмжээг авах боломжтой юм.

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч баривчлагдах, цагдан хоригдох үеийн эрхийн хамгаалалтын талаар олон улсын хэм хэмжээгээр баталгаажсан боловч дотоодын хууль тогтоомжоор зохицуулагдаагүй зарим асуудал практикт тулгарсан тохиолдолд шийдвэр гаргах гол субьект нь шүүгч болж байна.

Шүүхийн эрх хэмжээний асуудал болох баривчлах, цагдан хорих ажиллагаанд шүүхийн зүгээс шуурхай, хараат бус, хөндлөнгийн хяналтыг зайлшгүй тавьж, тайлан, мэдээний үзүүлэлтэд дүгнэлт хийж ажилладаг байх нь сэжигтэн, яллагдагчийн эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэйгээр авах, зөрчигдсөн тохиолдолд цаг алдалгүй хамгаалах, цаашилбал, шүүн таслах ажиллагааны үр нөлөөг үр дүнтэй байлгах, хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чухал нөлөө үзүүлэх ач холбогдолтой юм.

Түлхүүр үг: Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, баривчлах, цагдан хорих, хүний эрх, шүүгч, шүүх, хяналт, мониторинг

Demand and way of implementation of court monitoring on taking of arrest and detention measure

Abstract: In case of having effective control or monitoring on the court activity related to taking measure of arrest and detention, possibility of preventing from and recovery human rights violence would be increased. At the same time, court itself is a singular subject to take those measures during criminal procedure.

Although right protection issue of suspect, defendant and accused during arrest and detention is fully guaranteed by international law, still there are challenges in practice that related to aspects which are not regulated yet in domestic legislations. Again, judge is a main subject to make any decision obviously in that case.

Prompt, independent, and sideway monitoring and making an analysis on court report and data is considered as necessary for court activity of taking arrest and detention measure. Also, it will be a basement of taking fruitful measures for preventing from infringement of suspect, defendant and accused rights and freedoms and recovery of human right violence. Further, monitoring and analysis helps to keep effectiveness or result of judicial review and to develop related legislations.

Key words: Suspect, defendant, accused, arrest, detain, human rights, judge, court, control, monitoring.

Хууль зүйн үндэсний их сургууль www.num.edu.mn

хэмжээ хууль ёсны эсэх талаар болон зүй бус харьцаа, орчин нөхцөлийн эсрэг шүүхэд гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх зэрэг эрхийг тайлбарласан байдлыг Хүний эрхийн комисс судлан үзэхэд, өмгөөлөгчтэй 529 хоригдогчдын 40 шахам хувьд нь баривчлагдах үед өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, шүүхэд гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг сануулаагүй буюу хууль зүйн туслалцааг бүрэн авч чадахгүй нөхцөл байдлыг үүсгэжээ.[4] Өөрөөр хэлбэл, хуульд заасан үндэслэл, журам зөрчигдсөн байхад хүний эрхийг хязгаарлахыг шүүхээс зөвшөөрсөн байгаа нь анхаарал татаж байна.

Түүнчлэн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс 2015 оны 01 дүгээр сарын 02-оос 09 дүгээр сарын 30-ныг хүртэлх хугацааг хамруулан хийсэн судалгаагаар Нийслэл дэх Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд 4378 шүүх хуралдаан товлосноос 45.7 хувийг нь буюу 2 хүрлын нэгийг хойшлуулжээ. Хойшлогдсон нийт шүүх хуралдааныг өмгөөлөгч өвчтэй, эсхүл өмгөөлөгч авах хүсэлт гаргасан, мөн өмгөөлөгчийн бусад хурал давхацсан гэх зэрэг шалтгаанаар хойшлуулсан байх ба“шүүх хуралдаанд өмгөөлөгч ирээгүйн улмаас таны таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж, цагдан хорьсон уу” гэсэн асуултад 15% нь буюу 79 хүн “тийм” гэж хариулсан[5] нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заагаагүй үндэслэлээр хүний эрхийг мөн л хязгаарласан хууль бус ажиллагаа болжээ.

“Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 9 дүгээр зүйлийн 3-д заасны дагуу баривчлагдсан буюу эрүүгийн хэрэгт буруутгагдсан аль ч хүнийг шүүгч буюу хуулийн дагуу шүүн таслах эрх хэмжээ олгогдсон бусад албан тушаалтанд даруй шилжүүлэх бөгөөд хүн хэргээ боломжийн богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх буюу суллагдах эрхтэй. Иймээс шүүх хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хойшлуулах нь эрүүгийн хэрэгт буруутгагдаж, баривчлагдан, цагдан хоригдсон аливаа этгээдийн аль болох богино хугацаанд хэргээ шийдвэрлүүлэх эрх зөрчигдөх нэг нөхцөл болох бөгөөд ялангуяа өмгөөлөгч, улсын яллагч хэд хэдэн хэрэгт давхар ажиллаж байгаа тохиолдолд шүүх хуралдааны товыг давхардуулахгүй байх үүднээс бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, шүүхийн зүгээс тодорхой хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй өмгөөлөгчид хариуцлага тооцох саналыг Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороонд тавьж шийдвэрлүүлдэг байх шаардлагатай болохыг Хүний эрхийн комисс илтгэлдээ анхааруулсан байна.[6]

НҮБ-аас 1966 онд батлан гаргасан “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 9 дүгээр зүйлийн 1-д ‘Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасаж болохгүй”[7] гэж заасныг Монгол улс НҮБ-ын гишүүн орон болохын хувьд ч, тэдгээр эрх, эрх чөлөөг өөрийн Үндсэн хуулиараа баталгаажуулсан [8] орны хувьд ч олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө болон өөрийн орны ард түмний өмнө заавал биелүүлэх үүрэг хүлээдэг.

Тиймээс энэхүү нийтлэлийн

[4] “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл, Хүний эрхийн Үндэсний комисс, хуудас 55.

[5] Мөн тэнд, хуудас 119.

[6] Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл, Хүний эрхийн Үндэсний комисс, хуудас 82.

[7] Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1966, file:///C:/Users/Altankhuyag/Downloads/irgenii-bolon-uls-turiin-erhiin-tuhai-olon-ulsiin-fact.pdf

[8] Монгол улсын Үндсэн хууль, 1992 http://mongolianlaws.com/index.php?lid=LW1992011300&action=show

Оршлын оронд

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрх, ялангуяа сэжигтэн, яллагдагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар прокурорын хяналтаас гадна шүүх тодорхой үүрэг, хариуцлага хүлээдэг. Тодруулбал, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих арга хэмжээ авах онцгой эрх бүхий субьект болох шүүхийн үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт, мониторингийн тогтолцоо байснаар хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээхтэй холбогдсон бүх талын арга хэмжээг авах боломжтой юм.

Эрүүгийн хэргийн сэжигтэн, яллагдагчийн эрх, ашиг сонирхлыг үр дүнтэйгээр хамгаалах асуудал нь эрх зүйн орчноос гадна түүнийг хэрэгжүүлэх хуулийн байгууллагын ажилтан, ялангуяа бие даасан, төвийг сахисан шүүх хяналт, мониторингтой эсэхээс шууд хамааралтай. Тухайлбал, шүүх эрх мэдлийн хяналт нь сэжигтэн, яллагдагчтай зүй бусаар харилцах, эрүүдэн шүүх явдалтай тэмцэхэд чухал үүрэгтэй болохыг хүний эрхийн судлаачид тэмдэглэсэн байдаг.[1] Ялангуяа баривчлах, цагдан хорих арга хэмжээ авагдах гэж буй сэжигтэн, яллагдагч өөрийн биеэр шүүх хуралдаанд оролцох нь тийнхүү зүй бус харьцаанд өртсөн хүний хувьд гомдол гаргах боломжтой туйлын чухал мөч байдаг. Гомдол гаргаагүй ч баривчлагдах, цагдан хоригдох явцад эрүүдэн шүүх болон зүй бусаар харьцах явдал гарсан байж болзошгүй бол шүүх, эсхүл эрх бүхий шүүхийн албан тушаалтан зохих арга хэмжээ авах үүрэгтэй.[2]

Монгол улсын Хүний эрхийн комиссын хийсэн судалгаанаас[3] үзэхэд, сүүлийн 3 жилийн байдлаар буюу 2012-2015 онд нийт 2036 гомдол хүлээн авч ажиллагаа хийснээс шүүхийн өмнөх шатанд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээр татагдан цагдан хоригдож буй хүмүүсийн өмгөөлөгч авах эрх, хэргийнхээ талаар хангалттай хууль зүйн туслалцаа авах эрх зөрчигдөж байгаа тухай 286 гомдол хүлээн авч шийдвэрлэсэн нь нийт гомдлын 14%-ийг эзэлсэн байна. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэхдээ цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа дуусаж байгаа тохиолдолд заавал шийдвэрлэх, хорьж мөрдөх хугацааг сунгахдаа Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 69 дүгээр зүйлийн 69.9 дэх хэсэгт заасан журмын дагуу ерөнхий шүүгчийн захирамжаар шийдвэрлэх журам зөрчигдөн практикт яллагдагчийг шүүхэд шилжүүлснээс хойш таслан сэргийлэх арга хэмжээг тухай бүр шийдвэрлэдэггүйн улмаас шүүгдэгч хууль бусаар цагдан хоригдож байгааг Хүний эрхийн Үндэсний Комисс тэмдэглээд, цагдан хоригдож буй яллагдагч, шүүгдэгчийг шүүхийн шатанд удаан хугацаагаар хорьдог, уг хоригдсон хугацааг Монгол Улсын Дээд Шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн шүүгчийн албан бичгийг үндэслэн цагдан хоригдсон хугацаанд оруулан тооцохгүй байгаа нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон дотоодын хууль тогтоомжийг ноцтой зөрчиж байгааг цохон анхааруулсан.

Мөн олон улсын хэм хэмжээ болон үндэсний хууль тогтоомжоор баталгаажсан эрх болох аливаа этгээдийг баривчлах үед гуравдагч этгээдэд мэдээлэх, хууль зүйн болон эрүүл мэндийн туслалцаа авах, өөрийгөө өмгөөлөх эрхтэй болох, түүнчлэн баривчлах, цагдан хорих арга

[1] "Эрүүгийн эрх зүй дэх хүний эрх", судалгааны илтгэл, 2009, хуудас 33.

[2] Мөн тэнд.

[3] "Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл, Хүний эрхийн Үндэсний комисс, хуудас 55.

хуульзүйн үндэсний хүрээлэн www.legal.mn

үйлдэх талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа" зэрэг үндэслэлүүдийг тус тус шинээр оруулж өгсөн. Хамгийн чухал нь тэдгээр "үндэслэл"-үүдийг баримтлан шийдвэр гаргах шүүгчийн хувьд субьектив байдлаар хандах бус ямар шалгууруар яаж тогтоох вэ гэдэг нарийвчилсан аргачлал байх шаардлагатай.

Мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан шүүгдэгчийн цагдан хорих хугацааг олон улсын хэм хэмжээгээр тогтоогдсон хүний эрхийн зарчимд нийцүүлэн багасгаж өөрчлөх талаарх зөвлөмжийг Хүний эрхийн комиссоос Улсын их хуралд 2015 онд өргөн барьсан "Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл"-дээ тусгасан[11] байгааг шүүх эрх мэдлийн байгууллага ч анхааралдаа авч ажиллах нь зүйтэй.

Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хувьд шүүхээс баривчлах, цагдан хорихдоо сэжигтэн, яллагдагчийн насыг тодорхойлох төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэхийн хуулбар, иргэний бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас зохих лавлагаа, тодорхойлолт авахаас гадна түүний хувийн байдлыг буюу байнгын эсхүл түр оршин суугаа газрын хаяг, амьдралын нөхцөл байдал, гэр бүлийн байдал, өсөж хүмүүжсэн орчин, сургуулийн тодорхойлолт, хувийн хэргийн хуулбар, өмнө нь хэрэг, зөрчилд холбогдож байсан эсэх зэрэг баримтуудыг холбогдох этгээдээс авч, ухаан санааны ерөнхий хөгжил, өөрийн үйлдлийн учир холбогдлын талаар шинжээчийн дүгнэлтийг гаргуулсан байвал зохино.[12]

Одоогийн шүүхийн практикт сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээр цагдан хоригдвол зохих нийт хугацаа нь тухайн төрлийн гэмт хэргийн цагдан хорих хугацааны дээд хэмжээнээс хэтрэх ёсгүй атал сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн цагдан хоригдсон хугацааг тус тусдаа байх мэтээр ойлгон, нийт цагдан хоригдсон хоногийг буруу тооцсоны улмаас цагдан хорих хугацааг хэтрүүлэх асуудал гарсаар байна.[13]

Мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 366 дугаар зүйлийн 366.4 дэх хэсэгт насанд хүрээгүй этгээдийг цагдан хорьж, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах үндсэн хугацааг 1 сараар тогтоож, гэмт хэргийн төрлөөс хамаарсан хугацааг тогтоосон байдаг. Гэтэл шүүхийн шатанд энэ хугацаа хэтэрсэн тохиолдолд хэрхэн ямар хугацаагаар сунгах, эсвэл ямар ажиллагаа хийлгэх талаар хуулийн зохицуулалт бүрхэг байна. Жишээлбэл, тухайн насанд хүрээгүй этгээд орон гэргүй, асран хамгаалах харгалзан дэмжих хүн, байгууллага байхгүй, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн бөгөөд нийт 8 сар цагдан хоригдож, яг энэ хугацаандаа шүүхэд хэрэг нь шилжин ирсэн бол шүүх хугацааг нь сунгах хууль зүйн үндэслэлгүй байна. Практикт, хүнээ суллаад оргуулах уу, эзэнгүй түдгэлзүүлсэн хэрэгтэй үлдэх үү, эсхүл гэдэг асуудал байнга тавигдаж байдаг.

Түүнчлэн одоогийн мөрдөгдөж буй Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 408 дугаар зүйлд "гэмт этгээдийг шилжүүлэн өгөх зорилгоор цагдан хорих" асуудлыг тусгасан. 408 дугаар зүйлийн 408.1-д "Гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг хангаж гэмт этгээдийг шилжүүлэн өгөх хууль зүйн үндэслэл байвал түүнийг баривчилж шилжүүлж өгөх хүртэл цагдан хорьж прокурор хүсэлт тавьсан байгууллагад шилжүүлэн өгөх цаг хугацаа, газрыг нэн даруй мэдэгдэнэ", 408.2-д "Энэ хуулийн 408.1-д заасны дагуу цагдан хоригдсон этгээдийг 30 хоногийн дотор

[11] Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл. Хүний эрхийн Үндэсний комисс, 2015. file:///C:/Users/Altankhuyag/Downloads/report_15.pdf

[12] Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ: шүүхийн практик, анхаарах зарим асуудал. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шүүгч Л.Оюунчимэг. http://www.judcouncil.mn/inder/print:page,1,1506--.html

[13] Мөн тэнд

зорилго нь Монгол улсын хувьд баривчлах, цагдан хорих арга хэмжээ авах сэжигтэн, яллагдагчийн эрх, ашиг сонирхлыг үр дүнтэйгээр хамгаалахад шүүх тодорхой үүрэг гүйцэтгэн мониторинг хийж ажиллах бодит хэрэгцээ, шаардлага байгааг дүгнэж, практик болон хууль, эрх зүйн орчинд тулгуурлан санал гарган хэлэлцүүлэхэд оршино.

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг баривчлах, цагдан хорих үндэслэлийн талаар:

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад сэжигтэн, яллагдагчид баривчлах, цагдан хорих арга хэмжээ авах нь тэдний хувь хүний халдашгүй, эрх чөлөөтэй байх үндсэн эрхийг хөнддөг онцгой ажиллагаа байдаг тул шүүх эрх мэдлийн байгууллага нь тухайн арга хэмжээг хуульд заасан үндэслэл, журмын дагуу авахад хяналтаа чиглүүлэхээс гадна хараат бус, бодитой, шударгаар ажиллахад анхаарах учиртай.

Мөн баривчлах, цагдан хорих арга хэмжээ авагдсан этгээдийн гомдол гаргах эрхийг хангах, цагдан хорих арга хэмжээ авахтай холбогдсон шүүх хуралдаанд сэжигтэн, яллагдагч, түүний өмгөөлөгчийг биечлэн байлцуулах замаар мэтгэлцээн бодитой явагдах нөхцөлийг хангаж ажиллах нь практик ач холбогдолтой болохыг хүний эрхийн байгууллагууд тэмдэглэсээр байна.[9]

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу сэжигтэн, яллагдагчийг хойшлуулшгүй тохиолдолд баривчлах болон цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл нь оргон зугтахыг завдсан, эсхүл хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдэх хангалттай баримт байгаа, түүнчлэн удаа дараа ял шийтгэгдэж байсан этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэгт сэрдэгдсэн бол түүнийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлах, хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулах, гэмт хэрэг дахин үйлдэхээс сэрэмжлэх зорилгоор цагдан хорьж болно. Мөн хүндэвтэр гэмт хэргийн сэжигтэн, яллагдагчийг өмнө нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас оргон зайлж болзошгүй, эсхүл оргон зайлсан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дахин гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжтой.[10]

Түүнчлэн 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон 2016 онд батлагдсан Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлах үндэслэлийн нэг нь "гэрч, хохирогчоос сэжигтэн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн болохыг шууд заасан" гэж заасан. Мөн 2016 оны 05 дугаар сард батлагдсан Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн "Сэжигтнийг баривчлах" тухай үндэслэлд 30.6 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт "...хохирогч, гэрч, хамтран гэмт хэрэг үйлдсэн хүнийг дарамтлах, сүрдүүлэх, амь нас, эрүүл мэндэд нь халдах үндэслэл байгаа бол", 1.4 дэх хэсэгт "дахин гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргээ төгсгөх үндэслэл байгаа бол", 1.5-д "...гэрч, хохирогч, хамтран гэмт хэрэг үйлдсэн хүнд хууль бусаар нөлөөлөх үндэслэл илэрсэн бол", 13.10 дугаар зүйлд "цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл"-д "...хохирогч, гэрч, шинжээч, шүүгч, прокурор, мөрдөгч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, эсхүл тэдгээрийн болон өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа", "гэмт хэрэг дахин

[9] Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл, Хүний эрхийн Үндэсний комисс, хуудас 6, 2015. file:///C:/Users/Altankhuyag/Downloads/report_15.pdf

[10] Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002, http://www.legalinfo.mn/law/details/59

шилжүүлж аваагүй бол прокурорын тогтоолоор суллана", 408.3-д "Энэ хуулийн 408.2-т заасны дагуу сулласан этгээдийг шинээр хүсэлт тавьсан тохиолдолд дахин цагдан хорьж болно" гэж тус тус заасан боловч цагдан хорих хугацааг ямар үндэслэлээр ямар хугацаагаар сунгах боломжтой болох нь тодорхойгүй байна. Хэрэв хүсэлт гаргагч гадаад улсын эрх бүхий байгууллагын зүгээс нэмэлт материал ирүүлж байгаа талаар мэдээлэл ирсэн бол Монголын тал цагдан хоригдож байгаа хүнийг нь суллаж явуулах бус харин үргэлжлүүлэн хорих нь зайлшгүй юм. Нөгөө талаас, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 408 дугаар зүйлийн 408.2 дахь хэсгийн заалт нь өөрөө энэ хуулийн үзэл баримтлалыг зөрчсөн заалт буюу шүүгчийн захирамжаар хоригдсон этгээдийг прокурорын тогтоолоор суллах тухай асуудал байна.

Монгол улсын Засгийн газраас гадаадын зарим орны Засгийн газартай эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээнд цагдан хоригдсон этгээдийг 30 хоногийн дотор шилжүүлж аваагүй бол Монголын тал нэг удаа 15 хоногоор сунгаж болох тухай заалт байдаг.[14] Гэтэл Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар шууд прокурорын тогтоолоор суллах тухай ярьж байгаа нь "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ" гэж заасан Үндсэн хуулийн болон Монгол улсын Олон улсын гэрээний тухай хуулийн заалтыг зөрчсөн буюу үндэсний хууль тогтоомж нь олон улсын гэрээний заалтыг зөрчсөн агуулгатай байна.

Иймд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг баривчлах, цагдан хорихтой холбогдсон Монгол улсын эрх зүйн орчинг улам боловсронгуй болгон, олон улсын хэм хэмжээ зарчимд нийцүүлэх бодит шаардлага байсаар байна.

Дүгнэлт, санал

Дэлхийн улс орнуудад сэжигтэн, яллагдагчид баривчлах, цагдан хорих асуудлыг шийдвэрлэдэг тусгайлсан шүүх, хариуцсан шүүгч ажилладаг практик байна.[15] Зарим оронд гэмт этгээд нь сургалт, эмчилгээ болон бусад тусгай хөтөлбөрт хамрагдах талаар шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд түүний биелэлтэд хяналт, мониторинг хийх үүрэг бүхий тусгай бүтэц нь дагнасан шүүхийнхээ дэргэд ажиллаж байна.[16]

Тийнхүү баривчлах, цагдан хорих асуудлыг тусгайлан хариуцсан, дагнасан шүүгчтэй байх нь уг арга хэмжээ авагдаж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хуулиар баталгаажуулсан эрхийг хамгаалах, эдлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх ажиллагаанд чанарын ахиц гаргах үр нөлөөтэй арга замын нэг болно.

Нөгөө талаар, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч баривчлагдах, цагдан хоригдох үеийн эрхийн хамгаалалтын талаар олон улсын хэм хэмжээгээр баталгаажсан боловч дотоодын хууль тогтоомжоор зохицуулагдаагүй зарим асуудал практикт тулгарсан тохиолдолд шийдвэр гаргах гол субьект нь шүүгч болж байна. Тухайлбал, олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчмаар онцгой тохиолдолд буюу дэг журам, аюулгүй байдлыг хангах зорилгоор зайлшгүй нөхцөлдхойшлуулшгүйгээр баривчлагдсан этгээдийн өмгөөлөгч авах эрхийг хойшлуулах, хязгаарлахыг зөвшөөрөх шийдвэрийг шүүхээс эсвэл бусад эрх бүхий байгууллагаас гаргадаг бөгөөд энэ тохиолдолд ч

[14] Бүгд Найрамдах Казахстан Улстай байгуулсан иргэний ба гэр бүл,эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ, http://prokuror.mn/index.php?newsid=114

[15] https://en.wikipedia.org/wiki/Arrest_warrant

[16] Testing the Effectivenessof Batterer Programs andJudicial MonitoringResults from a Randomized Trial at the Bronx-Misdemeanor Domestic Violence Court, p1,http://www.courtinnovation.org/sites/default/files/battererprogramseffectiveness.pdf

гэсэн баривчилж, хорьсноос хойш 48 цагаас илүүгүй хугацаанд өмгөөлөгч авах эрхийг нээх ёстой байдаг байна.[17] Тодруулбал, Хүний эрхийн хорооны 32 дугаар Ерөнхий тайлбар, 32 дугаар зүйл, Хуульчдын Гүйцэтгэх Үүргийн Үндсэн Зарчмуудын 7 дугаар зарчим, "Аливаа хэлбэрээр хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмууд"-ын цогцын 15 дугаар зарчимд "Зарчмуудад... зааснаар онцгойлсон боловч саатуулагдсан болон хоригдсон этгээдэд гадаад орчинтой тухайлбал гэр бүл, өмгөөлөгчтэй холбоо тогтоохыг хэдхэн хоногоос хэтрэхгүй хугацаагаар татгалзаж болно", 18 дугаар зарчмын 3-т "Саатуулагдсан болон хоригдсон этгээдийг нэн даруй, хяналт шалгалтгүй, бусдыг байлцуулахгүйгээр өмгөөлөгчтэйгөө уулзах, зөвлөлдөх, холбоо барих эрхийг шүүхийн болон бусад байгууллагын үзэж байгаагаар аюулгүй байдал дэг журмыг хангахад зайлшгүй онцгой нөхцөл байдал бий болсноос бусад тохиолдолд түр зуур хүчингүй болгож хязгаарлаж болохгүй" гэж тус тус заасан байдаг.

"Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмууд" болон Хүний эрхийн хорооны 32 дугаар Ерөнхий зөвлөмжид "Бүх талуудад процессын тэгш эрхийг хангах ёстой бөгөөд хэрэв хуульд тодорхой нэг ялгааны талаар заасан бол тэр нь тодорхой үндэслэлтэй, бодит шалтгаанаар тогтоогдсон байх ёстой ба өмгөөлөх талд ямар нэгэн сул тал бий болгосон шударга бус бүхий л нөхцөл байдлыг тогтоосон шинжтэй байж болохгүй" гэж заасан. Энэхүү заалт нь Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт "Шүүн таслах ажиллагаа нь эрх тэгш бүхий яллах, өмгөөлөх талын мэтгэлцээний үндсэн дээр явагдах ёстой" гэж зааснаар баталгаажсан байдаг. Одоогийн практикт, ялангуяа сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорихтой холбогдсон шүүх хуралдаанд өмгөөлөгчийг тухай бүр оролцуулж, талууд мэтгэлцэх боломжийг хангах асуудал чухал байна.

Дүгнэхэд, шүүхийн эрх хэмжээний асуудал болох баривчлах, цагдан хорих ажиллагаанд шүүхийн зүгээс шуурхай, хараат бус, хөндлөнгийн хяналтыг зайлшгүй тавьж, тайлан, мэдээний үзүүлэлтэд дүгнэлт хийж ажилладаг байх нь сэжигтэн, яллагдагчийн эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэйгээр авах, зөрчигдсөн тохиолдолд цаг алдалгүй хамгаалах, цаашилбал, шүүн таслах ажиллагааны үр нөлөөг үр дүнтэй байлгах, хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чухал нөлөө үзүүлэх ач холбогдолтой юм. Үүнтэй уялдуулан дараах арга замуудыг санал болгож байна. Үүнд,

1/Тодорхой төрлийн хэрэг тус бүрд сэжигтэн, яллагдагчид баривчлах, цагдан хорих арга хэмжээ авахад шүүхийн зүгээс анхаарах асуудлын талаар тайлбар, аргачлалтай байх нь зүйтэй. Тухайлбал, зөвхөн хүчирхийллийн гэмт хэрэгт холбогдсон этгээдийг баривчлах, цагдан хориход анхаарах асуудал гэх мэт.

2/Шүүх, хуулийн байгууллагуудын хэмжээнд эрүүгийн хэргийн сэжигтэн, яллагдагчтай холбоотой мэдээллийн нэгдсэн цахим сан ажиллуулах, түүнд суурилан судалгаа, анализ хийх боломжтой байх. Одоогийн практикт баривчлах, цагдан хорих арга хэмжээтэй холбоотой мэдээ тайланг зөвхөн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч гэсэн ангиллаар гаргадаг бөгөөд үүний үзүүлэлт, асуултуудыг илүү уялдаа холбоотой, нарийн боловсронгуй болгох, түүндээ хяналт мониторингийг хийх замаар хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх.

3/Цагдан хорих арга хэмжээ авахтай холбогдсон процессын тодорхойгүй байдлыг сайжруулах. Цагдан хорих арга хэмжээг хэрэгжүүлж

[17] Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл, Хүний эрхийн Үндэсний комисс. хуудас 95

ЗАХИРГААНЫ АКТЫН БИЕЛЭЛТИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ АСУУДАЛ: ШҮҮХИЙН ПРАКТИКТ ТУЛГУУРЛАСАН ШИНЖИЛГЭЭ



Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Ц.Цогт



Говьсүмбэр аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч З.Ганзориг

ХУНЛЭЭСНИЙ ҮНДЭСНИЙ ХУРЛЫН ЭРХ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЛЫН www.nli.gov.mn

Оршил

"Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх" харилцааг тодорхойлсон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /цаашид "ЗХШХШтХ" гэх/-ийн 61, 62 дугаар зүйл дэх зохицуулалт[1] бол иргэн, хуулийн этгээдийн хувьд захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо хуулиар тусгайлан олгосон эрхтэй захиргааны байгууллага, албан тушаалтан буюу хариуцагчтай шүүхийн өмнө эрх тэгш байх, мэтгэлцэх зэргээр Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан "... шүүхэд мэдүүлэх эрх"-ээ эдлэх боломжийг бүрдүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны суурь зарчмуудыг хангах, шүүхээс хүн ба хуулийн этгээдэд "хойшлуулшгүй эрхийн хамгаалалт" тогтоох зэргийн ач холбогдлыг; нөгөөтэйгүүр захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгыг илэрхийлсэн хэм хэмжээ юм.

"Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх" асуудлыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх эцэслэн шийдвэрлэхээр хуульд[2] зохицуулсан байдагтай холбогдуулан 2011.04.01-ний өдрөөс 2016.10.20-ны өдрийн хооронд энэ асуудлаар гаргасан тус шүүхийн тогтоолуудыг судалж үзсэн. Давж заалдах шатны шүүхийн тогтоолуудад 1/ шүүх хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүргээ гүйцэтгээгүй, 2/ хүсэлтийг хэргийн оролцогчид танилцуулж, тайлбар, нотлох баримт гаргах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэгш эрхтэй оролцох боломжийг олгоогүй, 3/ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн

[1] Энэ харилцааг өмнө нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцогдсон)-ийн 45, 46 дугаар зүйлээр зохицуулж байсан.

[2] Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль/ хүчингүй болсонд тооцогдсон/-ийн 90 дүгээр зүйлийн 90.1, 90.3, ЗХШХШтХ-ийн 122 дугаар зүйлийн 122.1, 122.7 дахь хэсэгт

буй өнөөгийн практикийг боловсронгуй болгохын тулд нэн тэргүүнд авах ёстой арга хэмжээ нь хууль эрх зүйн орчинг шинэчлэх буюу цагдан хорих арга хэмжээний процессын тодорхойгүй байдлыг сайжруулах шаардлагатай болох нь судалгаагаар тогтоогдсон.[18] Ялангуяа насанд хүрээгүй этгээдийг болон гадаад улсад шилжүүлэн өгөхөөр баривчлах, цагдан хорих, цагдан хорих хугацааг сунгах талаар нарийвчлагдсан зохицуулалт шаардлагатай байна.

4/Аль ч эрх зүйн бүлд хамаарагддаг орны шүүхийн тогтолцоонд хэрэглэгдэж байгаа, цагдан хорих арга хэмжээ, батлан даалт, үзлэг, нэгжлэг хийх зөвшөөрөл олгох, сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгох зэргээр эрүүгийн процесс ажиллагаанд хяналт тавин ажилладаг "Зөвшөөрлийн шүүх"[19] -ийн тогтолцоог Монгол улсад судалж, нэвтрүүлэх.

5/Баривчлах, цагдан хорих асуудлыг тусгайлан хариуцсан шүүгчийг мэргэшүүлэх, байнгын үргэжилсэн сургалтад хамруулдаг байх.

6/Баривчлах, цагдан хорих талаарх шүүх хуралдааныг мэтгэлцэх зарчим бүрэн хэрэгжих боломжтойгоор яллах, өмгөөлөх талуудын адил тэгш оролцоог хангаж явуулдаг байхад анхаарах.

7/Шүүх хуралдааныг нээсний дараа өмгөөлөгч, улсын яллагчийн зүгээс шүүх хуралдааныг хойшлуулах тухай гаргаж байгаа хүсэлтийг хүлээн авахгүй байх нь ялангуяа цагдан хоригдсон этгээдэд холбогдсон хүний хэргийг шийдвэрлэх шүүн таслах ажиллагааны шуурхай байдлыг хангахад чухал ач холбогдолтой байх юм.

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ САН www.nli.gov.mn

[18] Судалгааны тайлангийн эмхтгэл, хуудас 19, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Шүүхийн судалгаа, Мэдээлэл, сургалтын хүрээлэн, 2014.

[19] https://en.wikipedia.org/wiki/Magistrate, Судалгааны тайлангийн эмхтгэл, хуудас 34, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Шүүхийн судалгаа, Мэдээлэл, сургалтын хүрээлэн, 2014

зохицуулсан байсан бөгөөд шүүхэд гомдол (нэхэмжлэгч биш) гаргагчид түдгэлзүүлэх талаар хүсэлт гаргах эрх тухайлан заагдаж олгогдоогүй, хэрэг үүсгэсэн тохиолдолд шүүх түдгэлзүүлж "болох" –оор зохицуулсан зэргээс тухайн үеийн захиргааны эрх зүйн ойлголт, хандлага нь иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах, сэргээх талаар төдийлөн тууштай зорьсон байж чадаагүйг харж болох юм.

Харин 2002 онд батлагдсан Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2004 оноос хэрэгжиж эхэлсэнээс хойш эрс өөрчлөлт хийгдэж, захиргааны хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго нь хууль эрх зүйн хувьд цоо шинэ гэж хэлж болохуйц үзэл баримтлал буюу "захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас хүний эрх зөрчигдөхөөс сэргийлэх, иргэний зөрчигдсөн эрхийг сэргээн, тогтоох" зорилготой болсон билээ. Үүнтэй уялдуулан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар зүйлд *"энэ хуулийн 46 дугаар зүйлд болон өөр хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүгч захирамж гаргаж, маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлнэ"* гэж заасан нь харьцангуй дэвшилттэй зохицуулалт болж чадсан. Энэхүү зохицуулалтаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж буй шүүгч хуульд заасан үндэслэл байхгүй тохиолдолд актын биелэлтийг шууд түдгэлзүүлэхээр агуулгатай байсан. Энэ нь нэхэмжлэл гаргагчийн эрх зүйн байдлын хувьд чухал дэвшилттэй зохицуулалт бөгөөд нэхэмжлэгчийн эрхэд нэн даруй шүүхээс хамгаалалт хийх эрх олгосон зохицуулалт байсан юм.

Хэдийгээр хуульчдын дунд энэхүү зохицуулалтыг "үндэслэлгүй нэхэмжлэл гаргаж, захиргааны зүй ёсны үйл ажиллагааг саатуулах, гуравдагч этгээдийн захиргааны шийдвэрээр олж авсан эрхийн хэрэгжилтийг үндэслэлгүйгээр зогсоох" зорилгоор ашиглагдах боломжтой гэсэн сэрэмжлэл байдаг боловч тэдгээр нь хуулийн *"энэ хуулийн 46 дугаар зүйлд болон өөр хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд"* гэсэн нөхцөлийн дагуу шалгагдаж, тогтоогдсон байх учиртай.

Нэхэмжлэгчийн нөхөн сэргээгдэхгүй, мөнгөөр илэрхийлэгдэхгүй эрхийн зөрчил, эсхүл түүнд зайлбаргүй тулгамдсан бөгөөд засагдахгүй хор хохирлын хувьд захиргааны хэрэг үүсгэснээр маргаж буй актын биелэлтийг даруй зогсоож эрхийн яаралтай хамгаалалт тогтоох, харин мөнгөөр илэрхийлэн хөрвүүлж болох эрхийн зөрчлийн тухайд, нийтийн эрх ашигт сөрөг нөлөөтэй гэх мэт тодорхой тохиолдолд актыг түдгэлзүүлэхгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжүүлээд эцэст нь нэхэмжлэл хангагдсан тохиолдолд зөрчигдсөн эрхийг өөр бусад байдлаар сэргээх боломжтой байдлаар зохицуулах нь "хүний эрхийг захиргааны үйл ажиллагаанаас хамгаалах" захиргааны процессын эрх зүйн зорилгод нийцсэн хандлага юм. Харин 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинээр хэрэгжиж буй шүүхийн процессын хувьд зөвхөн нэхэмжлэгч (бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд) -ийн хүсэлтийг үндэслэж шийдвэрлэхээр зохицуулсан байгаа.

ЗХШХШтХ-ийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх *"Энэ хуулийн 62 дугаар зүйл, эсхүл хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүгч хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлнэ"* гэсэн заалт бол захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгчээс нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлд зааснаар тодорхойлон маргаж буй захиргааны

[3] 46 дугаар зүйл болон бусад хуульд тусгайлан заасан нөхцөлийг шалгаагүй гэх зэрэг (а) материаллаг хууль хэрэглээ болон (б) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, журамтай холбоотой үндэслэлүүд зонхилж байна.

Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлтийг шийдвэрлэх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бие даасан, чухал үе шат учир; дээрх хугацаанд давж заалдах шатны шүүхээр хянагдсан анхан шатны шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийн 47 хувь нь өөрчлөгдөж, хүчингүй болсон үзүүлэлт гарсан[4]; зэрэг нь энэхүү нийтлэлийг бичих үндэслэл боллоо.

Ингэхдээ дээрх судалгаанд тулгуурлан захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх энэхүү хууль зүйн ойлголтын эрх зүйн онолын үндэслэл, өмнөх ба шинэ хуулийн зохицуулалтыг харьцуулж, шүүхээс хуулийг тайлбарлан хэрэглэх асуудлыг хөндөж, тодорхой санал дэвшүүлэхийг зорьлоо.

I. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх асуудлын ерөнхий ойлголт

Захиргааны эрх зүйн онолын үүднээс авч үзвэл, захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх асуудал хэрхэн зохицуулагдаж байгаагаар тухайн улсын захиргааны эрх зүйн хөгжлийн төвшин ямар нэгэн байдлаар илэрхийлэгддэг гэж үзэж болно.

Актын биелэлтийг түдгэлзүүлэх зарчим, зохицуулалт нь захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго хэрхэн тодорхойлогдсоноос шууд хамааралтай байдаг. Тухайлбал 1990 он, бүр бодит байдлаар 2004 оноос өмнөх шүүхийн процессын зорилго нь шүүхэд мэдүүлсэн, хандсан иргэн, хуулийн этгээдийн эрхийг хамгаалж, сэргээх гэхээс урьтаж захиргааны үйл ажиллагаан дахь хуулийн зөрчлийг илрүүлж, залруулах явдал байсан билээ.

Монгол Улсын хувьд 1967 оны Иргэний байцаан шийтгэх хуулиар цөөн тооны захиргааны шийдвэрийг иргэний журмаар шүүхэд хандаж шийдвэрлүүлэх эрхийг тухайлан зөвшөөрч, хуульчилсан бөгөөд уг хэргүүдэд буюу "торгууль, төлбөр оногдуулсан" актын /захиргааны шийтгэл/ биелэлтийг түдгэлзүүлэх асуудлыг "БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх тухай хуулийн 200 дугаар зүйлийн 5-ын 3-т зааснаар шүүхээс шийдвэр гартал зогсоохыг шүүгчийн тогтоолоор эрх бүхий албан тушаалтанд яаралтай мэдэгдэнэ"[5] хэмээн зохицуулж ирсэн байдаг.

Мөн 1990 оны "Монгол Улсын иргэний эрхийг хохироосон төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах журмын тухай хууль"–ийн зорилго нь тухайн үеийн улс, төр, нийгмийн өөрчлөн байгуулалтын нөлөөнөөс хамааран захиргааны хууль бус үйл ажиллагаанаас иргэний эрхийг хамгаалахаар тодорхойлогдсон боловч практикт төдийлөн хангалттай хэрэгжиж чадаагүй. Энэхүү хуулийн 6 дугаар зүйлд *"Байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа нь илт хууль бус байвал шүүх гомдлыг хянан шийдвэрлэхийн өмнө уг үйл ажиллагааг түдгэлзүүлэх тухай магадлал гаргаж болох бөгөөд энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэнэ"* хэмээн

[3] Судалгаанд ашигласан шүүхийн тогтоолууд нь 2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль / цаашид "ЗХХШтХ" гэх/ хүчин төгөлдөр үйлчилж байсан цаг хугацаанд хамаарах тул энэ нийтлэлийн I-III хэсэгт уг хуулийн нэр, зүйл заалтыг голчлон хэрэглэсэн болно.

[4] Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн тогтоолуудыг судалж үзэхэд 2011.04.01-2016.10.20-ны өдрийн хооронд тус шүүх "Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх" тухай хүсэлт шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн 226 шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол / хамтад нь "шийдвэр" гэх/ хянаснаас 106 шийдвэр буюу 47 хувийг нь; үүнээс 2015.01.01-2016.10.20-ны өдрийн хооронд 155 шийдвэр хянаснаас 79 шийдвэр буюу 51 хувийг нь; тус тус хүчингүй болгож, өөрчилж шийдвэрлэсэн байна.

[5] БНМАУ-ын иргэний байцаан шийтгэх хуулийн тайлбар. Редактор Д.Зундуй, Н.Чинбат. 1984 он. 227 дахь талд.

акт, захиргааны хэм хэмжээний актыг бүх талаас нь, бүрэн хэмжээгээр судалж шийдвэрлэхийн ач холбогдлыг илэрхийлэхээс гадна захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд "хүний эрх, эрх чөлөөг хамгаалж, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох" шүүхийн зорилго хэлбэржсэний илрэл юм.

Тодруулбал, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь өөрөө хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагааны улмаас зөрчигдөхөөс сэргийлэх, таслан зогсоох, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтооход чиглэгддэг ба нэхэмжлэгчийн тодорхойлсон сэргээгдэх /мөнгөөр илэрхийлэгдэн хөрвөх/ болон сэргэх боломжгүй эрхүүдийг хамгаалах нь шүүхийн зорилго байдаг.

Маргаж буй захиргааны актыг шүүхээс түдгэлзүүлээгүй ба уг акт нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад биелэгдэх зэргээр үр дагаваргүй болсон тохиолдолд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа өөрөө ач холбогдолгүй, зорилгоо биелүүлэх боломжгүй болох тул ялангуяа сэргэх боломжгүй эрх *(тухайлбал, сонгуульд нэр дэвших эрх тодорхой тэрхэн хугацаанд нээгдэх бөгөөд нэр дэвшигчээр бүртгээгүй, сонгууль явагдаад өнгөрсөн тохиолдолд уг эрх сэргээгдэх магадлал маш бага, бараг боломжгүй байдаг)* -ийн хувьд захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэхэд үндэслэлтэйгээр хандах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулж буй шүүгчээс хуульд заасан шүүхийн зорилго, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чухал нөлөөтэй.

Хуулийн дээрх зохицуулалтын агуулга нь ЗХШХШтХ-ийн 62 дугаар зүйл болон өөр хуульд тусгайлан заасан тохиолдолд захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхгүй; бусад тохиолдолд түдгэлзүүлнэ; гэж тайлбарлагдаж, хэрэглэгдэх бөгөөд энэ нь дээрх зорилгоос гадна "маргаан хөөн хэлэлцэх хугацааны дотор үүсээд түдгэлзүүлж болохгүй үндэслэл байхгүй л бол тухайн захиргааны актын биелэлт түдгэлзэж байж хэрэг хянан шийдвэрлэгдэх" процессын суурь зарчмаас үүдэлтэй.

Нэхэмжлэлтэй хамт, хэрэг үүсгэсэн даруйд, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад үед ирүүлсэн актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлтийг хэргийн бусад оролцогчид танилцуулалгүй тэр дор нь, нэг бол тэдний тайлбар, нотлох баримт гаргаж өгөх эрх боломжийг хангалгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд талууд тэгш эрхтэй байх зарчмыг хэрэгжүүлэлгүйгээр, хүсэлтийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль үе шатанд ирснээс үл хамааран өөр өөр ажиллагаа (процесс)[6] -аар шийдвэрлэж буй явдал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулж буй шүүгч юуны өмнө ямар тохиолдолд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль үед буюу хэзээ нь, хэний санаачилгаар актын биелэлтийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэх нь зохилтой вэ гэдгийг анзаарч, түүнд ач холбогдол өгөх шаардлагатай болохыг харуулна.

Учир нь захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны туршид буюу бүхий л үе шатанд хэрэгжиж байх учиртай шүүхийн өмнө эрх тэгш байх, мөрдөх шалгах *(нотлох үүрэг)*, мэтгэлцэх зэрэг үндсэн ба тусгай зарчмуудын агуулгыг уялдуулан авч үзвэл, захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлтийг бусад хэргийн оролцогчид танилцуулах, тайлбар,

[6] Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс 2011.04.01-2016.10.20-ны хооронд гаргасан шүүхийн тогтоолоос үзэхэд (шинэ хууль хэрэгжихээс өмнө) зарим анхан шатны шүүх хүсэлтийг шүүхэд гаргасан даруйд шийдвэрлэж байхад зарим нь хүсэлтийг бусад хэргийн оролцогчид танилцуулж, тайлбар авч шийдвэрлэж байсан байна. Мөн хэргийн оролцогчдоос тайлбар авч, нотлох баримт цуглуулсны дараа шүүх хуралдааны танхимд хүсэлт хэлэлцэх ажиллагаа хийж шийдвэрлэдэг ч тохиолдол байна.

нотлох баримт гаргаж өгөх боломжит хугацаа олгож, тайлбарын үндэслэл, түүнд хамаарах нотлох баримтыг харьцуулан судалсны үндсэн дээр **(дараа)**, өөрөөр хэлбэл захиргааны актыг бодитойгоор судалж шийдвэрлэх нь зайлшгүй шаардлага юм.

Дээр дурдсан шүүхийн чиг үүрэг, ЗХШХШтХ-д заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, нөгөө талаас шүүх захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэхдээ заавал хэргийн оролцогч, ялангуяа нэхэмжлэгч хүсэлт гаргасан байхыг шаардахгүй байхаар ЗХХШтХ-ийн 45 дугаар зүйл болон бусад хэсэгт зохицуулж байсан зэргээс дүгнэхэд хэргийн оролцогчийн хүсэлтэд үндэслэхээс гадна өөрийн санаачилгаар захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх эрх шүүхэд байсан байна.

Гадаад орнуудын иргэний болон захиргааны хэрэг шүүхээр хэлэлцэх процесст *stay of execution of administrative act, injunction, interim order, temporary restraining order* зэрэг ойлголтуудаар илэрхийлэгддэг захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх ажиллагааг, ялангуяа жишгийн эрх зүйн тогтолцоотой улсуудад түр буюу *temporary injunction,* урьдчилсан буюу *preliminary injunction,* шүүхийн шийдвэрийг дагаж гардаг байнгын үйлчлэл бүхий түдгэлзүүлэх ажиллагаа буюу *permanent injunction* гэсэн үндсэн 3 төрөлд хуваж үздэг байна. Үүнд, түр түдгэлзүүлэх ажиллагаа нь нэхэмжлэл гаргахтай зэрэгцэн зайлшгүй яаралтай түдгэлзүүлэх шаардлагатай тохиолдолд хариуцагчид шүүхээс шууд түдгэлзүүлсэн *(энэ нь Германы хуулийн нэхэмжлэл гаргаснаар маргаж буй актын үйлчлэл автоматаар зогсох зохицуулалттай төстэй)* шийдвэр гаргах бөгөөд энэхүү шийдвэр нь хэргийн оролцогчид бүрэн татагдан орж, тайлбар мэдүүлгээ гаргах хүртэлх хугацаанд хүчинтэй байх бөгөөд үүний дараа захиргааны актын биелэлтийг шүүхийн шийдвэр гартал түдгэлзүүлэх *(preliminary injunction)* эсэх ажиллагааг талуудыг бүрэн оролцуулан, тайлбар мэдүүлгийг нь авсны үндсэн дээр хийдэг байна. Харин захиргааны тодорхой үйл ажиллагаа нэхэмжлэгчийн эрхийг зөрчсөн хууль бус болохыг тогтоож шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дагуу, тухайн хууль бус үйл ажиллагааг дахин явуулахгүй байхыг бүрмөсөн даалгах, хориглох агуулга бүхий шийдвэр нь байнгын үйлчлэл бүхий түдгэлзүүлэх шийдвэр *(permanent injunction)* юм. Энэхүү байнгын үйлчлэл бүхий актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлт нь нэхэмжлэлийн нэмэлт шаардлага байдлаар шийдвэрлэгддэг тохиолдол байна.

ХБНГУ-ын Захиргааны хэргийн шүүхийн процессын хууль (цаашид германы хууль гэнэ)[7]-ийн зохицуулалтын талаар товчхон дурдахад: Германы хуулийн 111 дүгээр зүйлд **түр шийдвэр**-ийн төрөл, тодорхойлолт, 47 дугаар зүйлийн (6)–д захиргааны хэм хэмжээний шийдвэрийг **түр хориглох** шүүхийн эрх хэмжээний талаар зохицуулалт байх бөгөөд харин 80, 80a, 80b дугаар зүйлүүдэд дээд шатны байгууллагад урьдчилан шийдвэрлүүлэх гомдол эсхүл шүүхэд нэхэмжлэл гаргаснаар актын **үйлчлэл зогсох үр дагавар**, 123 дугаар зүйлд шүүхийн **захирамжаар актын биелэлт, гүйцэтгэлийг түдгэлзүүлэх** зэргийг ялгамжтайгаар заасан байна. Мөн хуулийн 42 дугаар зүйл дэх "хүчингүй болгуулах" нэхэмжлэлийг шүүхэд гаргасан тохиолдолд эсхүл захиргааны актын эсрэг дээд шатны захиргааны байгууллагад гомдол гаргасан нь тухайн актын үйлчлэлийг автоматаар зогсоох үйлчлэлтэй байх талаар 80

[7] Code of Administrative Court Procedure in the version of the promulgation of 19 March 1991 (Federal Law Gazette I page 686), most recently amended by Article 5 of the Act of 10 October 2013 (Federal Law Gazette I page 3786) http://www.gesetze-im-internet.de/englisch_vwgo/englisch_vwgo.html

илтэд байгаа (урьдчилан дүгнэлт хийхгүй байх зарчимтай зөрчилдөхгүй хэмжээнд) тохиолдолд уг актыг шүүх хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл түдгэлзүүлэх нь илүү ойлгомжтой, зүй ёсны шийдэл болно.

Дашрамд дурдахад, илт хууль бус актын тухайд бусад нэхэмжлэлийн шаардлагаас тусдаа онцлог зохицуулалтууд дагалддаг, жишээлбэл, уг төрлийн нэхэмжлэлийн шаардлага гаргаж буй тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэхгүй байх гэх мэт. Хэдий ийм боловч, энэ нь хөөн хэлэлцэх хугацаа гэх мэт шаардлагаас зайлсхийх зорилгоор акт бүрийг "илт хууль бусад тооцуулахаар" нэхэмжлэлийн шаардлагыг сонгох боломж олгож байна гэсэн үг биш. Шүүх илт хууль бусад тооцуулахыг хүссэн акт болон нэхэмжлэл гаргаж буй этгээдийн зөрчигдсөн гэх эрхийн хоорондын үйлчлэлийг шалгаж хэрэг үүсгэхээс гадна, эцэст нь акт илт хууль бус биш л бол нэхэмжлэлийг хэрэгсэхгүй[14] болгож шийдвэрлэх тул нэхэмжлэлийн шаардлагыг хуульчид эхнээс нь зайлшгүй зөв сонгох шаардлагатай болно.

Монгол хэлний "түдгэлзүүлэх" гэдэг нэр томьёогоор илэрхийлэхээр зөвхөн захиргааны актын үйлчлэлийг "зогсоох" гэсэн агуулгаар хязгаарлагдаж ойлгогдоход хүрээд байдаг. Гэтэл үүнд мөн адил тодорхой шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулахыг "даалгах"[15] эсхүл нэхэмжлэгчид сөрөг үйлчлэлтэй тодорхой шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулахыг "урьдчилан хориглох"[16] гэсэн агуулгаар бусад төрлийн нэхэмжлэлийн шаардлагатай холбогдуулан түдгэлзүүлэх ажиллагаа хийгдэх боломжтой. Ялангуяа, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар тодорхой тохиолдлуудад эрх, хууль ёсны ашиг сонирхол нь "зөрчигдөж болзошгүй" асуудлаар нэхэмжлэл гаргах эрхийг хуульчлан зөвшөөрсөн үед уг нэхэмжлэлийн шаардлагатай холбогдуулан захиргааг тодорхой шийдвэр гаргахыг хориглохыг "актын биелэлтийг түдгэлзүүлэх" ажиллагааны хүрээнд шийдвэрлэх боломжтой. Тухайлбал, ирээдүйд хийгдэх нь тодорхой байгаа сөрөг үйлдлийг зогсоох, хориглосон байдлаар нэхэмжлэлийн шаардлагаа тодорхойлж байгаа бол түүнтэй уялдуулан тийм шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулахыг шүүх хэргийг шийдвэрлэтэл хориглосон агуулгаар актын биелэлтийг түдгэлзүүлж болно.

Дээрхээс дүгнэвэл, нэхэмжлэлийн шаардлагын бүхий л төрөлд хуульд зааснаар **хориглосноос бусад тохиолдолд** захиргааны актын биелэлт түдгэлзэх нь ЗХШХШтХ-ийн үзэл баримтлалд нийцсэн, түүнд тулгуурласан суурь зохицуулалт гэж тодорхойлж болно.

II. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй тусгай нөхцөл

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 45.2-т зааснаас үзэхэд захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй тусгай нөхцөлийг нэгд ЗХХШтХ-д тусгайлан заасан; хоёрт бусад хуульд заасан; гуравд захиргааны хэм хэмжээний актыг хуульд зааснаас өөр үндэслэлээр түдгэлзүүлэхгүй; гэсэн 3 агуулгаар авч үзэж болно. Энэ хэсэгт эдгээр тусгай нөхцөлүүдийг тус бүрт нь шинжлэн судлахыг зорьё.

Нэг. ЗХХШтХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан тохиолдлууд:

(а) ЗХХШтХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх *"Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх*

[14] Практикт нэхэмжлэгчийн сонгож гаргасан төрөл (жишээ нь акт хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлага) -ийг шүүх хэргийг шийдвэрлэх үедээ өөрчлөн (актыг илт хууль бус болохыг тогтоож) шийдвэрлэх тохиолдол байдгийг цаашид хуулиар хориглон зохицуулах шаардлагатай болов уу.

[15] Хэргийн оролцогчийг тодорхой шийдвэр, үйл ажиллагаа хийхийг даалгах (Mandatory Injunction)

[16] Хэргийн оролцогчийг тодорхой шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулахыг хориглох (Prohibitory Injunction)

дугаар зүйлд заасан байх бөгөөд энэ нь "эрх зүйг хэлбэржүүлэх"[8] (constitutive administrative act) болон эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоосон актад ч адил хамаарахаар зохицуулсан байна.

Актын биелэлтийг түдгэлзүүлэх ба нэхэмжлэлийн шаардлагын төрлийн харилцан хамаарал

Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх зохицуулалт нэхэмжлэлийн шаардлагын төрөл бүрт хэрэглэгдэх эсэх нь энэ сэдвийн хүрээнд багагүй маргаантай[9] асуудал. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай ЗХШХШтХ-ийн зохицуулалт нь хүн, хуулийн этгээдийн гаргасан нэхэмжлэлийн төрлөөс үл хамааран Монгол Улсын Үндсэн хуульд заасан "... шүүхэд мэдүүлэх эрх"-д тогтоож буй эрх зүйн урьдчилсан хамгаалалт байдаг тул "маргаан бүхий захиргааны актыг хүчингүй болгуулах" нэхэмжлэлээс гадна илт хууль бусад тооцуулах г.м бусад төрлийн нэхэмжлэлийн шаардлагад мөн адил хэрэглэгдэх нь зүйн хэрэг. Харин "актын биелэлтийг түдгэлзүүлэх" ойлголтын агуулга нь захиргааны актын "эрх зүйн үйлчлэл үргэлжилж байх" нөхцөлөөр тодорхойлогддог тул үйлчлэл нь дуусгавар болсон актын[10] хувьд "түдгэлзүүлэх" ойлголт хамаарахгүй.[11]

Захиргааны актыг "хүчингүй болгуулах" нэхэмжлэл гаргасан тохиолдолд л түүний үйлчлэлийг зогсоохоор биелэлтийг түдгэлзүүлнэ, харин даалгах, илт хууль бусад тооцуулах шаардлагын хувьд энэ зохицуулалтыг хэрэглэхгүй[12] гэж тайлбарлах тохиолдол хуульчдын дунд байдаг хэдий ч Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлал, зарчим болоод шүүхийн зорилго, чиг үүргийн агуулгатай уялдуулан тайлбарлаж үзвэл өөр дүр зураг харагдана.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болоод шүүхийн процессын шинэ хуулиар "захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх" тухай зохицуулсан. Харин "захиргааны акт" гэдгийг 2002 оны хууль болон Захиргааны ерөнхий хуульд онцын зөрүүгүйгээр тодорхойлсон байдаг. Үүнд: нэг удаагийн тохиолдлыг зохицуулсан, эрх зүйн шууд үр дагавар бүхий захирамжилсан үйлдэл, эс үйлдэхүйг хамааруулж ойлгоно. Үүнээс үзвэл, нэхэмжлэлийн шаардлага нь (1) эс үйлдэхүйг тогтоолгох, эсхүл (2) ямар нэгэн тодорхой шийдвэр гаргахыг даалгах, мөн түүнчлэн (3) тодорхой шийдвэр гаргахыг хориглох тухай байгаа эсэхээс үл хамааран, бүгд л захиргааны актад хамаарах тул үйлчлэлийг нь түдгэлзүүлэх тухай хөндөгдөх боломжтой байна. Нөгөөтэйгүүр, захиргааны актыг "илт хууль бусад тооцуулах" нэхэмжлэлийн шаардлага нь хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагатай харьцуулбал хангагдахад шаардагдах нөхцөл өндөр, бодит байдалд зөрчилтэй захиргааны актаас (буюу хүчингүй болгохоос) харьцангуй цөөн байх хэдий ч, хэрэв "илт"[13] хууль бус буюу нэхэмжлэгчийн эрхэд халдсан байдал болоод уг актын хуульд нийцээгүй байдал нь

[8] Д.Сүнжид доктор (Dr.jur)-ын орчуулсанаар "эрх зүйг хэлбэржүүлэх" акт (Rechtsgestaltenden Verwaltungsakt).

[9] Тухайлбал, энэ нь зөвхөн "актыг хүчингүй болгуулах" нэхэмжлэлийн шаардлагад хэрэглэгдэх боломжтой хэмээн Д.Сүнжид докторын саяхны нэг өгүүлэлд бичигдсэн байна. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх. Д.Сүнжид, Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2015 оны №3 (53) –с дэлгэрүүлэн үзнэ үү.

[10] ЗХШХШтХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.3

[11] Гэвч зарим улсын хувьд тухайлбал, ХБНГУ-ын Захиргааны хэргийн шүүхийн процессын хуулийн 80 дугаар зүйлийн (5)-д нэгэнт хэрэгжсэн захиргааны актын биелэлтийг ч цуцлах боломжтой байхаар зохицуулсан байна.

[12] Жишээлбэл, Ө.Баянмөнх, Д.Баярмаа нарын нэхэмжлэлтэй Хөдөлмөрийн сайдад холбогдох захиргааны хэргийн тохиолдолд өмгөөлөгч актын биелэлтийг түдгэлзүүлсэн захирамжийг эс зөвшөөрсөн гомдолдоо ЗХХШтХ-д зөвхөн "маргаан бүхий захиргааны акт (10-р зүйлд заасан акт)-ыг" түдгэлзүүлэх тухай зохицуулсан тул "илт хууль бус акт (9-р зүйлд заасан акт)-ыг" түдгэлзүүлэх зохицуулалтгүй хэмээн маргааны үндэслэлээ тодорхойлсон байдаг.

[13] "Ил бүхий, юмны тодорхой, нууц биш" Монгол хэлний их тайлбар толь.

нь бусдын амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой, хуулийн этгээдэд илт хохирол учруулахаар бол;" гэсэн заалтын агуулгаас үзэхэд *амь бие, эрүүл мэнд; эд хөрөнгө* гэсэн хоёр нөхцөлийг, ноцтой; илт гэсэн хохирлын тохиолдыг тодорхойлсон ба харин **"бусдын"** гэдэгт зөвхөн хэргийн оролцогчид байх уу, эсхүл хэргийн оролцогч биш өөр бусад хэн ч байж болох уу гэдгийг энд ялгамжтай зааж өгөөгүй нь анзаарагдана.

"Бусад" гэдгийг хэргийн оролцогчоор хязгаарлах[17] нь хуулийн уг зохицуулалтын үйлчлэлийг явцууруулах төдийгүй өмнө тодорхойлсон хуулийн үзэл баримтлал болоод шүүхийн зорилго, чиг үүрэгт нийцэхгүй юм.

Жишээлбэл: "Ай ви ко" ХХК нь Эрүүл мэндийн яамнаас зарласан Гемодиализын тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмж нийлүүлэгч шалгаруулах шийдвэрийг хүчингүй болгуулахаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасантай холбогдуулан маргаан бүхий актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлт гаргасныг давж заалдах шатны шүүхээс *"энэ тохиолдолд маргаан бүхий актыг түдгэлзүүлснээр өвчтөнүүдийн амь бие, эрүүл мэндэд хохирол учирч болзошгүй байгаа тул ТБОНӨХБАҮХАЖтХ-ийн 55 дугаар зүйлийн 55.4.3-д заасан нөхцөл байдал үүсэхээр байна"* гэж дүгнэн хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Дээрхээс үзвэл, тендер шалгаруулалт нь төрийн эрх бүхий байгууллага, захиалагч, эсхүл тендерт оролцогчдоос (хэргийн оролцогч) гадна төрийн үйлчилгээ хүртэх бусад этгээдийн амь бие, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулахаар байвал захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхгүй байх боломжтой юм.

Харин "илт хохирол учруулах" гэдгийг хохирол бодитоор учирсан, эсхүл хохирол учруулахуйц нөхцөл нүүрлэсэн, зайлбаргүй бүрдсэн байх гэсэн 2 агуулгаар илэрхийлж байгаа бөгөөд үүнтэй холбоотой тодорхой жишээг энэ өгүүллийн III бүлгийн 6 –р хэсэгт тайлбарласан болно.

(б) ЗХХШтХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.2 дахь хэсэгт *"Иргэн, хуулийн этгээдээс албан татвар, төлбөр, хураамж гаргуулах тухай акт бол"* гэж зааснаас үзэхэд захиргааны эрх зүйн харилцаан дахь *"албан татвар, төлбөр, хураамж"* гэх ойлголтыг Татварын хууль тогтоомжид заасан[18] *"улс, орон нутгийн төсөв, тусгай зориулалтын санд төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгө"* гэдэг утгаар тайлбарлан хэрэглэх нь зүйтэй байна.

Учир нь хуулийн энэ заалтыг татварын хууль тогтоомжид тусгасан "татварын орлогыг тасралтгүй бүрдүүлэх" зарчимд нийцүүлэн, түүний хамгаалалт болгож, "татварын орлого бүрдүүлэх харилцааг шүүх ажиллагаанаас шалтгаалан тасалдуулахгүй байх"-д чиглэсэн агуулга бүхий зохицуулалт гэж ойлгож болно.

Энэ хэсэг дэх албан татвар, төлбөр, хураамж гэдэгт юу хамрах талаар дараах жишээн дээр тулгуурлан авч үзье: "Хунлиан" ХХК-иас "мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн "ажилтанд нэмэгдэл хөлс нөхөн олгуулах" актыг хүчингүй болгуулах" тухай шаардлага бүхий нэхэмжлэлийн хамт уг актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлт шүүхэд гаргажээ. Давж заалдах шатны шүүхээс маргаан бүхий захиргааны акт нь хөдөлмөрийн

[17] Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн "Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" 37 дугаар тогтоолын 16-д "Хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 43 дугаар зүйлийн 43.3-д заасан "... бусад этгээд..." гэдэгт тухайн хэргийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөж болохоор байгаа, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие даасан шаардлагатайгаар оролцуулах нь зүйтэй гэж үзсэн гуравдагч этгээдийг хэлнэ" гэж тайлбарласан байдаг.

[18] Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "албан татвар", 5.6-д "хураамж", 5.7-д "төлбөр" гэдгийг тодорхойлсон.

хяналтын улсын байцаагчийн "нэмэгдэл хөлс нөхөн олгуулах" акт байх ба ажил олгогчоос ажилтанд олгох нэмэгдэл хөлс нь Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д зааснаар цалингийн бүрдүүлбэрийн нэг төрөл учраас ЗХХШтХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.2-т заасан "албан татвар, төлбөр, хураамж" гэдэгт хамаарахгүй гэж шийдвэрлэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, энэ хуулийн 46.1.2-д заасан зохицуулалтыг иргэн, хуулийн этгээдийн хоорондын "цалин хөлс, хохирол нөхөн төлүүлэх" харилцаанд хэрэглэхгүй. Тиймээс хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийн "ажилтанд учруулсан хохирол /нэмэгдэл хөлс/ нөхөн төлүүлэхийг ажил олгогчид даалгасан" актыг иргэн, хуулийн этгээдээс албан татвар, төлбөр, хураамж гаргуулах акттай адилтган үзэхгүй гэж дүгнэсэн байх жишээтэй.

Түүнчлэн, Ховд аймгийн үйлдвэрчний эвлэлийн холбооноос "аймгийн Засаг даргын захирамжийг хүчингүй болгуулах" тухай шаардлага бүхий нэхэмжлэлтэйгээ холбогдуулан маргаан бүхий актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлт гаргасан. Шүүх Ховд аймгийн Засаг даргын маргаан бүхий захирамж нь төрийн албан хаагчдын цалингаас холбогдох хууль тогтоомжийн дагуу нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хүм амын орлогын албан татвараас бусад төрийн бус байгууллагын гишүүнчлэлийн татвар, төлбөр хураамж авахыг зогсоох тухай шийдвэр байх тул "иргэн, хуулийн этгээдээс албан татвар, төлбөр, хураамж гаргуулах тухай акт" буюу ЗХХШтХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.2-т хамаарахгүй гэж дүгнэжээ.

Харин Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1-д "Үйлдвэрчний эвлэлүүд нь өөрөө санхүүжих зарчмаар ажиллана", 2-т "Үйлдвэрчний эвлэлүүдийн эд хөрөнгө нь гишүүдийн татвар, хандив, үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах бусад эд юмсаас бүрдэнэ" гэж заасныг үндэслэн маргаан бүхий захиргааны актын улмаас нэхэмжлэгч байгууллага өөрийгөө санхүүжүүлэн үйл ажиллагаа явуулах баталгаа хязгаарлагдаж, гишүүдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах боломжгүй байдалд хүрч болзошгүй байгааг харгалзах шаардлагатай гэж дүгнэн ЗХХШтХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.1-д зааснаар захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлжээ.

(в) ЗХХШтХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д заасан *"Захиргааны журам зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэсэн болон уг зөрчлийг таслан зогсоох тухай захиргааны хяналтын байгууллага, албан тушаалтны шийдвэр бол"* гэсэн зохицуулалтыг агуулга нь "захиргааны журам зөрчих", "хяналтын байгууллага, албан тушаалтны шийдвэр" гэх ойлголтын тайлбараас хамаарна.

Захиргааны хариуцлагын тухай хуулийн 3 дугаар зүйл, 41 дүгээр зүйлийн 1-д зааснаас үзэхэд Монгол улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр, тус хууль болон бусад хуулиар тогтоосон захиргааны журмыг санаатай буюу болгоомжгүй зөрчсөн, үйлдэл, эс үйлдэхүйг захиргааны зөрчил гэж ойлгох бөгөөд ЗХХШТХ-д зааснаар уг зөрчилд *хариуцлага хүлээлгэх; зөрчлийг таслан зогсоох* гэсэн 2 төрлийн актыг илэрхийлжээ.

Эдгээрийг ялгаж ойлгохгүй бол улсын байцаагчийн хувьд л гэхэд түүний үйлдсэн акт, дүгнэлт, албан шаардлага бүрийг хариуцлага хүлээлгэсэн актад хамааруулахгүй. Хэдийгээр Захиргааны хариуцлагын тухай хуулиас гадна бусад хуульд тодорхой үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэвэл зохицуулсан боловч тэдгээрээс *торгох, тусгайлан олгосон эрх хасах, хууль бусаар олсон орлого буюу эд зүйлийг хураах, баривчлах* зэрэг Захиргааны хариуцлагын тухай

хуулиуд[19] нь захиргааны хэргийн шүүхэд хэрэглэгдэх эсэх нь тухайн маргааны төрөл, үйл баримтаас хамаарна.

Жишээ нь: "Номин холдинг" ХХК-иас "Төрийн өмчийн хорооны 2014.03.20-ны өдрийн "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг цуцлах тухай" 143 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах"-аар шүүхэд гаргасан нэхэмжлэлтэйгээ холбогдуулан актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлт гаргахдаа үндэслэлийг "Гэрээг цуцалсан тохиолдолд манай компани хөрөнгө оруулалтаараа хохирох, 25 ажилчин ажилгүй болох, тус байранд амьдарч байгаа 15 айлтай байгуулсан түрээсийн гэрээ цуцлагдсанаар нөхөн төлбөрийг компани төлөх үүрэг хүлээнэ" гэж тайлбарладаг бол, хариуцагч "нэхэмжлэгч нь төрийн тусгай хамгаалалтын газарт (Их тэнгэр) байрлах тус обьектыг эзэмших болсноор төрийн дээд өндөр хэмжээний айлчлалын зочид байрлах боломжгүй болсон, мөн төсөвт хохирол учрахаас гадна зочид төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангахад эрсдэл үүсгэж байна. Нэхэмжлэгч нь тус обьектыг гадаад дотоодын иргэдэд хөлслүүлэх болсноор тэдгээр иргэд нь төрийн тусгай хамгаалалтын бүс рүү хяналтгүй нэвтэрч орох, төрийн хамгаалалтад байх хүмүүсийн аюулгүй байдалд аюул учруулж болох нөхцөл байдал үүсээд байна" гэж маргасан байдаг.

Шүүх маргаан бүхий захиргааны актыг түдгэлзүүлснээр Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 3, 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 болон 5 дахь заалт, 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 3 дахь заалтын дагуу төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, албан тушаалтан, гадаад орны өндөр албан тушаалтан зэрэг хуулиар тогтоосон төрийн тусгай хамгаалалтын хүрээ горим зөрчигдөж болзошгүй байгаа нь ЗХХШтХ-ийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийн "өөр хуульд тусгайлан заасан тохиолдолд", 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх хэсгийн "бусдын амь бие, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулахаар бол", 46.1.4 дэх хэсгийн "хууль тогтоомжид заасан тохиолдолд үл маргах журмаар биелүүлэх бол" түдгэлзүүлж болохгүй гэсэн зохицуулалтад хамаарч байна" гэж дүгнэн, нэхэмжлэгчийн хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байдаг. Ингэхдээ актын биелэлтийг түдгэлзүүлэх нь гадаадын төрийн өндөр албан тушаалтны айлчлал, хуулиар хамгаалалтыг нь тогтоосон, дотоодын төрийн өндөр албан тушаалтны амь биед ноцтой эрсдэл үүсэх нөхцөлийг хамгаалах төрийн хамгаалалтын горим нь "хуульд зааснаар үл маргах журмаар" зохицуулалтад хамаарна гэсэн агуулгаар шийдвэрлэсэн байна.

Хоёр. Өөр хуульд тусгайлан заасан тохиолдол

ЗХХШтХ-ийн 45 дугаар зүйлийн 45.1-д *"...өөр хуульд тусгайлан зааснаас..."* гэж томьёолж байсан бол ЗХШТШтХ-ийн 61 дүгээр зүйлийн 61.1-д "..., эсхүл хуульд тусгайлан зааснаас..." гэж тусгажээ.

Энэ нь хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хуульд тухайн захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхийг хориглосон хэм хэмжээг тусгасан тохиолдлыг илэрхийлж байх бөгөөд ийм зохицуулалт бүхий хууль цөөнгүй бий:

Цөмийн энергийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6-д *"Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 26.5-д заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргах эрхтэй бөгөөд шүүх тухайн шийдвэрийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн*

[19] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.10, Банкны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь заалт болон Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийг энд дурдаж болно.

хуулиар тодорхойлон заасан шийтгэл ногдуулсан шийдвэрийг л “хариуцлага хүлээлгэсэн акт” гэдэгт хамааруулж ойлгоно.

Харин зөрчлийг таслан зогсоох шийдвэр гэдэгт үйл ажиллагаа зогсоох, битүүмжлэх, хураах г.м Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.7, 10.9.8-д заасан үйл ажиллагаа болон бусад салбарын хууль дахь ийм төрлийн зохицуулалтыг дурдаж болно.

Тухайлбал, Амьтны тухай хууль зөрчиж зөвшөөрөлгүй ан амьтан агнасан этгээдэд улсын байцаагчийн шийтгэврээр торгууль ногдуулахаас гадна актаар нөхөн төлбөр ногдуулах тохиолдол түгээмэл байдаг. Энэ тохиолдолд шийтгэвэр нь хариуцлага хүлээлгэсэн шийдвэр тул түүний биелэлтийг түдгэлзүүлж болохгүй. Харин нөхөн төлбөр тогтоосон акт нь амьтны аймагт учруулсан хохирол төлүүлэх шийдвэр тул хариуцлага хүлээлгэсэн буюу таслах зогсоох тухай шийдвэр гэж үзэхгүй.

Хяналтын байгууллага, албан тушаалтан гэдэгт Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг, улсын байцаагчийн эрхтэй, хуулиар эрх олгогдсон аливаа этгээдийг ойлгохоор байна.

Жишээ нь: “Шунхлай трейдинг” ХХК зэрэг нэр бүхий компаниудаас Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчдын 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 5/125 дугаар албан шаардлага болон шийтгэврийг хүчингүй болгуулах нэхэмжлэлтэйгээ холбогдуулан актын биелэлтийг түдгэлзүүлэхээр гаргасан хүсэлтийг шүүх ЗХХШтХ-ийн 45 дугаар зүйлийн 45.1, 46 дугаар зүйлийн 46.1.3-д заасныг баримтлан хэрэгсэхгүй болгожээ.

Ингэхдээ Захиргааны хариуцлагын тухай хуулийн 3 дугаар зүйл болон Өрсөлдөөний тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасан захиргааны журам зөрчсөн гэж нэхэмжлэгч компаниудад Өрсөлдөөний тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3-д заасныг үндэслэн захиргааны шийтгэл ногдуулсан улсын байцаагчийн шийдвэр нь ЗХХШтХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д заасан актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй үндэслэлд хамаарч байна. Учир нь Өрсөлдөөний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч, орон нутагт улсын байцаагч ажиллана” гэж заасан ба тэдгээр байцаагчид нь Захиргааны хариуцлагын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан захиргааны хариуцлага хүлээлгэх эрхтэй албан тушаалтан мөн гэж дүгнэсэн.

(г) ЗХХШтХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.4-д зааснаар *“хууль тогтоомжид заасан тохиолдолд үл маргах журмаар биелүүлэх бол”* шүүх захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхгүй.

Хууль тогтоомжид зарим асуудлаар гарсан шийдвэрийг үл маргах журмаар биелэгддэг байхаар зохицуулсан байх нь бий. Үүний учир нь тухайн асуудлаар гарч болох үр дагаврыг тухайн харилцааны оролцогчид урьдчилан сайтар хэлэлцсэн, мэдэгдсэн, танилцсан, зөвшөөрсөн байхаар зохицуулж, үүний дагуу шийдвэрийг үл маргах журмаар хэрэгжүүлэхээр зохицуулсан байдаг.

Тухайлбал, Векселийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1-д "Вексель" гэж төлбөр хариуцагчаас тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг тогтоосон хугацаанд ямар нэгэн нөхцөл болзолгүйгээр үл маргалдах журмаар вексель эзэмшигчид төлөхийг харилцан тохиролцож баталсан төлбөрийн баримтыг хэлнэ” гэж заасан ба эдгээр

www.nlis.gov.mn хууль зүйн үндэсний хүрээлэн

хэмжээний акт нь эрэмбийн хувьд хуулиас доогуур хүчин чадалтай ч захиргааны байгууллагын "хууль хэрэгжүүлэх" үндсэн чиг үүргийг илэрхийлсэн үйл ажиллагаа байдаг, үр дагаврын хувьд ижил төрлийн олон тохиолдолыг давтан зохицуулах үүрэгтэй гэдэг утгаараа "... зөвхөн хуульд заасан үндэслэлээр түдгэлзүүлж болно" гэсэн агуулгаар хуульчлагджээ. Өөрөөр хэлбэл, нэг удаагийн тохиолдол, нэг этгээдийн нэхэмжлэлээр тухайн харилцааг зохицуулж буй хэм хэмжээг түдгэлзүүлснээр уг хэм хэмжээгээр зохицуулагдаж байгаа харилцаа бүхэлдээ зохицуулалтгүй үлдэх эрсдэлтэй зэрэг нөхцөлтэй уялдсан байх магадлалтай.

Жишээ: [1] Н.Ариунболд нь шүүхэд гаргасан "Үндэсний архивын газар болон Сонгуулийн ерөнхий хорооны хамтран батлсан 2008.05.09-ний өдрийн 22/69 тоот тушаалын 6.2, 6.4.4 дэх заалтыг хүчингүй болгуулах" шаардлага бүхий нэхэмжлэлтэйгээ холбогдуулан маргаан бүхий актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлт гаргасныг шүүх Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль[23], Сонгуулийн төв байгууллагын тухай хууль, Архивын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд түдгэлзүүлж болох талаар зохицуулалт байхгүй тул хэм хэмжээ тогтоосон маргаан бүхий актыг түдгэлзүүлж болохгүй гэж дүгнэн, хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон.

[2] "МДТОФ" ХХК-иас Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар болон Стандартчилал, хэмжил зүйн газарт холбогдуулан гаргасан "... улсын байцаагчийн 2014 оны 00001969 тоот шийтгэврийг бүхэлд нь хүчингүй болгох, MNS 6058-2009 стандартад өөрчлөлт оруулахгүй байгаа эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоож, уг стандартын хэрэглэх хүрээг тодорхойлж уг стандартад өөрчлөлт оруулахыг даалгах" тухайн шаардлага бүхий нэхэмжлэлтэйгээ холбогдуулан маргаж буй "Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал" MNS 6058-2009 стандартын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлт гаргасныг Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүх /тухайн үеийн нэрээр/-ийн шүүгчийн 2015 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 2750 дугаар захирамжаар хэрэгсэхгүй болгосныг давж заалдах шатны шүүх хэвээр үлдээжээ.

Ингэхдээ шүүх "Засгийн газрын тохируулагч агентлаг болох Стандартчилал, хэмжил зүйн газар нь нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах эрхтэй байгууллага бөгөөд Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор батлсан "Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам"-ын 1.6.1, 1.6.3-т зааснаар стандартыг хэм хэмжээ тогтоосон акт гэж үзнэ" хэмээн дүгнэж байжээ.

2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж буй Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т "Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 3.1.2-т заасан баримт бичиг энэ журамд хамаарахгүй" гэж зохицуулснаар Монгол улсын стандарт нь захиргааны хэм хэмжээний акт "болохгүй" тул цаашид MNS стандартыг захиргааны хэм хэмжээний акттай адилтган үзэж, ЗХШХШтХ-ийн 61 дүгээр зүйлийн 61.2-т заасан зохицуулалтыг түүнд хэрэглэхгүй нь.

Захиргааны хэм хэмжээ тогтоосон актын биелэлтийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэсэн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн тогтоолуудыг тоймлоход "захиргааны хэм хэмжээний актаар маргаж буй тохиолдолд анхан шатны шүүхээс түүний үндсэн шинж хийгээд хүчин төгөлдөр байдлыг шалган тогтоолгүй, зөвхөн түдгэлзүүлэхийг зөвшөөрсөн хуулийн зохицуулалт бий эсэхийг

[23] Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар энэ хуулийг хүчингүй болсонд тооцсон.

62.1.3-т заасны дагуу түдгэлзүүлж болохгүй".

Ашигт малтмалын тухай хуулийн 56.5-д *"Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 56.4-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцалсан шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргах эрхтэй бөгөөд шүүх тухайн шийдвэрийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62.1.3-т заасны дагуу түдгэлзүүлэхгүй",*

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан журмын авах тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-д *"Тендер шалгаруулалттай холбогдох гомдлыг хүлээн авсан шүүх энэ хуулийн 55.4.1 -55.4.3-д зааснаас бусад тохиолдолд төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийг түдгэлзүүлэхийг хориглоно"*, 55 дугаар зүйлийн 55.4.1 "тендерт оролцогчийн гомдлыг хангах нь илүү үндэслэлтэй байгаа бол;", 55.4.2 "түдгэлзүүлээгүй тохиолдолд тендерт оролцогчид их хэмжээний хохирол учрахаар бол;", 55.4.3 "түдгэлзүүлэх нь төрийн эрх бүхий байгууллага, эсхүл захиалагч болон бусад тендерт оролцогчдод илтэд хохиролтой биш бол" гэх мэтчилэн зохицуулалтууд байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-д *"Энэ хуулийн 15.1, 15.2-т зааснаас бусад үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэхийг хориглоно"* гэж тус тус заасан нь хэдийгээр хуульд тусгайлан түдгэлзүүлж болохгүйгээр заасан зохицуулалт мөн боловч энэхүү маргаан нь харьяалалын хувьд захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдэхгүй, харин Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.2 –т "зохицуулах хорооны шийдвэрийг давж заалдсан нь хариуцлага хүлээлгэх шийдвэрийг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй" гэсэн зохицуулалт нь захиргааны журмаар хэлэлцэгдэж буй хэрэг маргааны хувьд актын биелэлтийг түдгэлзүүлэх харилцаанд хэрэглэгдэх юм.

Гурав. Захиргааны хэм хэмжээний актын биелэлтийг түдгэлзүүлэх тухайд

Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д "Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно" гэж заасан ба Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т "Засгийн газар нь Улсын Их Хурлаас хуулиар тусгайлан эрх олгосон нөхцөлд хуульд нийцүүлэн бүрэн эрхийнхээ хүрээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрхийн акт гаргаж болно...", Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 119 дүгээр тогтоолоор баталсан "Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам"[20] -ын 1.3-д "Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг эрх бүхий этгээд нь зөвхөн хуулиар тусгайлан эрх олгосон тохиолдолд гаргана" гэж тус тус зохицуулснаас үзэхэд хуулиар тусгайлан эрх олгосон нөхцөлд; Засгийн газраас гадна захиргааны байгууллагын бүх түвшинд[21]; нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг ЗХШХШтХ-ийн 61 дүгээр зүйлийн 61.2-т заасан "захиргааны хэм хэмжээний акт"[22] гэдэгт хамааруулж ойлгохоор байна.

Хэдийгээр захиргааны хэм

[20] Энэ журмыг Засгийн газрын 2016 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 86 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон.

[21] яам, агентлаг, Засаг дарга болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурал г.м

[22] ЗХХШтХ-ийн 45 дугаар зүйлийн 45.2-т "хэм хэмжээ тогтоосон захиргааны акт" гэж томьёолж байсан бол ЗХШХШТХ-д "захиргааны хэм хэмжээний акт" гэж тусгасан. Энэ ойлголтыг ямар нэршлээр илэрхийлэх нь зохимжтой талаар П.Одгэрэл, "Хэм хэмжээний акт" гарын авлага, УБ 2009 он, 15 дахь талаас дэлгэрэнгүй үзэж болно.

л хянах замаар актын биелэлтийг түдгэлзүүлэх шийдвэр гаргаж болохгүй" гэсэн дүгнэлт зонхилжээ.

Тэгэхлээр "захиргааны хэм хэмжээ тогтоосон актын биелэлтийг зөвхөн хуульд заасан үндэслэлээр түдгэлзүүлж болно" гэсэн хуулийн зохицуулалтыг хэрэглэхийн өмнө тухайн акт нь *захиргааны хэм хэмжээний актын шинжийг агуулах эсэх, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдэж албан ёсоор хэвлэгдсэн эсэх, хуульд түдгэлзүүлж болох талаар зохицуулалт байгаа* эсэхийг зайлшгүй шалгах шаардлагатай болохыг эндээс харж болохоор байна.

III. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхэд маргааны төрлийг харгалзах нь

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээр 2011.04.01-ний өдрөөс 2016.10.20-ны өдрийн хооронд хянагдсан анхан шатны шүүхийн "Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлт" шийдвэрлэсэн тухай 226 шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж /цаашид "шийдвэр" гэх/-ийг маргааны төрлөөр ангилж, захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэхдээ тэдгээр төрөл бүрт шүүхээс өгч буй дүгнэлтийг тоймолбол:

1. **Тендерийн маргаан**тай холбоотой 31 шийдвэр хянагдсанаас 10 нь хэвээр үлдэж, 21 нь хүчингүй болж, өөрчлөгдсөн. Хүчингүй болсон 21 шийдвэрийн 13 нь актын биелэлтийг түдгэлзүүлж, 8 нь хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Захиргааны хэргийн шүүхээс тендерийн хэргийн маргаан бүхий актын биелэлтийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэхдээ ЗХХШтХ-ийн 45 дугаар зүйлийн 45.1, 46 дугаар зүйлийн 46.1.1, ялангуяа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын тухай хууль /цаашид "ТБОНӨХБАҮХАЖТХ/-ийн 56 дугаар зүйлийн 56.3, 55 дугаар зүйлийн 55.4.1-55.4.3 болон тухайн тендер шалгаруулалтад хамаарах бусад салбарын хуулийг хэрхэн тайлбарлаж хэрэглэсэн, ямар нөхцөл байдлуудад ач холбогдол өгч шалгасныг жишээгээр харуулбал:

- "Аствишн" ХХК нь Мэдээлэл, шуудан, харилцаа, холбоо, технологийн газраас зарласан "Нийтийн түлхүүрийн дэд бүтэц, гэрчилгээжүүлэх тогтолцоог бий болгох" тендерт "Инэкст" ХХК-ийг шалгаруулсан шийдвэрийг хүчингүй болгуулахаар нэхэмжилж, актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлт гаргасныг анхан шатны шүүхээс хангаж шийдвэрлэснийг давж заалдах шатны шүүхээс хэвээр үлдээжээ.

Шүүхийн дүгнэлтээс харахад ЗХХШтХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.1-д заасан үндэслэл тогтоогдохгүй, шүүхээс уг маргааныг эцэслэн шийдвэрлээгүй, хэрхэн шийдвэрлэгдэх нь тодорхойгүй байхад Нийтийн түлхүүрийн дэд бүтэц, гэрчилгээжүүлэх ажлыг бэлэн болгох захиалагчийн үйл ажиллагаа зогсоход хүрч, хэвийн үйл ажиллагаанд илтэд хохирол учирсан, Дэлхийн банкнаас санхүүжүүлж байгаа төлбөр цуцлагдахад хүрч, улсын төсөвт 400.000 ам.долларын хохирол учруулахуйц нөхцөл байдал үүссэн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй бөгөөд захиалагчтай нэгэнт гэрээ байгуулагдсан нь хариуцагч болон гуравдагч этгээд, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагаанд илтэд хохирол учруулсан гэж үзэхгүй гэжээ.

- "Амин хүч" ББН өрхийн эмнэлгийн дарга нь Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2010 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн "Өрхийн эмч нарын багийг сонгон шалгаруулах тухай" 1/70 тоот тушаалыг хүчингүй болгуулахаар захиргааны хэргийн шүүхэд гаргасан нэхэмжлэлтэйгээ холбогдуулан маргаан бүхий актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлт гаргасан ба шүүхээс ЗХХШтХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.1 болон Эрүүл мэндийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.1 дэх хэсгийг баримтлан

хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Ингэхдээ өрхийн эмнэлэг нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа, мөн энэ асуудал маргаантай учраас тухайн нутаг дэвсгэрт тендер шалгаруулалт явуулаагүй тул актын биелэлтийг түдгэлзүүлэх нь ямар нэг эрх зүйн үр дагавар үүсгэхгүй гэж дүгнэжээ.

Шүүх хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахаар байна гэсэн тохиолдол бүрт актын биелэлтийг түдгэлзүүлэхгүй орхиж шийдвэрлэдэггүй бөгөөд маргаан бүхий захиргааны актаас үл хамааран тухайн үйл ажиллагаа хэвийн явагдах эсэх нь төрийн байгууллага, албан тушаалтны хүлээсэн үүргээс хамааралтай байвал ЗХХШтХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.1-д заасан үндэслэл үүсээгүй гэж үзэн, актын биелэлтийг түдгэлзүүлж шийдвэрлэдэг байна.

Жишээлбэл: "Бодь профертийз" ХХК нь шүүхэд "Эрүүл мэндийн яамны БУА 13-01-07 дугаар бүхий Гэмтэл согог судлалын төвийн харьяа Түлэнхийн төвийн барилгын ажил гүйцэтгэх тендер шалгаруулах үнэлгээний хорооны шийдвэрийг хүчингүй болгуулах" тухай шаардлага бүхий нэхэмжлэл гаргасантай холбогдуулан маргаан бүхий актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлт гаргасны дагуу шүүх актын биелэлтийг түдгэлзүүлж шийдвэрлэхдээ *"Түлэнхийн төвийн барилгын ажлыг хойшлуулбал цаана нь хүний амь нас, эрүүл мэндийн эрх ашиг хөндөгдөж байгаа гэх боловч иргэдийн уг эрхийг хангах нь төрийн байгууллагын үүрэг бөгөөд барилгын ажлаас үл хамааран энэ үйл ажиллагаа тасралтгүй явагдах ёстой тул үүнээс үүдэн нийтийн эрх ашигт шууд хохирол учрах нөхцөл байдал тулгарсан гэж үзэх боломжгүй"* гэж дүгнэснийг дурдаж болно.

Мөн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс ЗХХШтХ болон ТБОНӨХБАҮХАЖтХ-ийн зохих заалтыг баримтлан шийдвэрлэхдээ *дээрх хуульд заасан үндэслэлүүдийг шалгасан эсэх, хариуцагч болон гуравдагч этгээдэд илтэд хохирол учруулахааргүй байх нөхцөл байдлууд нь бариматаар хэрхэн тогтоосон зэрэг нь тодорхойгүй, ийм нөхцөл байгаа эсэхийг асууж тодруулалгүй, хуулийн шаардлага хангаагүй нотлох бариматыг үндэслэн маргааны үйл бариматад дүгнэлт хийсэн* тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг хангуулсны дараа анхан шатны шүүхийн актын биелэлтийг түдгэлзүүлэх шийдвэрийн агуулгад дүгнэлт өгөх шаардлагатай гэж дүгнэн[24] дахин шийдвэрлүүлэхээр буцаасан байна.

Энэ нь мэтгэлцэх, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд үйлчлэх хуулийн шаардлагыг захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхэд ч баримтална гэсэн суурь ойлголтоос үүдэлтэй.

2. Төрийн албаны маргаантай холбоотой 53 шийдвэр хянагдсанаас 27 нь хэвээр үлдэж, 26 нь хүчингүй болсон. Хүчингүй болсон 26 шийдвэрийн 20 нь актын биелэлтийг түдгэлзүүлж, 6 нь хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Эдгээр актууд нь иргэнийг төрийн албанаас чөлөөлж, томилсон тушаал; албан тушаалаас чөлөөлж, шилжүүлэн ажиллуулах тухай тушаал; сахилгын шийтгэл ногдуулж, ажлаас чөлөөлөх тухай тушаал; төрийн албан хаагчийг түр томилох тухай; бөгөөд энэ судалгааны дүнгээс үзвэл төрийн албаны маргааныг шийдвэрлэхдээ захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхгүй байх нь давамгай байна.

Энэ төрлийн захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн анхан

[24] Энэ тохиолдолд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс ЗХХШТХ-ийн 90 дүгээр зүйлийн 90.2.2-т зааснаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хүсэлтийг дахин шийдвэрлүүлэхээр буцаах практик тогтоожээ.

шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн гол үндэслэлийг *“шүүхийн шийдвэрээр маргаан бүхий захиргааны акт хууль зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд эрхэлж байсан ажил, албан тушаалд эгүүлэн тогтоолгож, ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг гаргуулах зэргээр нэхэмжлэгчээс зөрчигдсөн гэж тодорхойлсон эрх, хууль ёсны ашиг сонирхол нь “нөхөн сэргээгдэх” боломжтой””* гэж тайлбарлаж болно.

Нэхэмжлэгчийн хувьд “захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхэд ЗХХШтХ-ийн 46 дугаар зүйлд заасан түдгэлзүүлж болохгүй нөхцөл байдал тогтоогдохгүй байна” гэсэн бол хариуцагчийн зүгээс зөвшөөрөхгүй байгаа үндэслэлээ:

-актын биелэлтийг түдгэлзүүлэх нь иргэн, хуулийн этгээдэд илтэд хохирол учруулахаар;

-төрийн ажил цалгардаж, төсвийг зүй зохисгүй зарцуулах зэрэг асуудал хүндэрч ноцтой байдалд хүргэж болзошгүй;

-улс орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэх, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих ажлыг хариуцаж ажилладаг хяналт шалгалтын болон татвар хураалтын тасгийн дарга нарын хэвийн ажил үргэлжлэхэд хүндрэл гарч, байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна;

-актыг түдгэлзүүлснээр төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдаж, үүнээс үүдэн тухайн байгууллагын иргэдэд үзүүлэх үйлчилгээнд сөргөөр нөлөөлж болзошгүй;

-актыг түдгэлзүүлснээр багш ажилчдын болон хүүхдүүдийн эрүүл аюулгүй орчинд сурч боловсрох эрх ашигт илт хохирол учруулахаар байна; зэргээр тодорхойлдог ажээ.

Шүүхээс дээрх нөхцөл байдлуудад дүгнэлт өгч шийдвэрлэсэн байдлыг авч үзвэл:

“Хуулийн этгээдэд илтэд хохирол учруулахаар, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдахаар” гэсэн үндэслэлүүд болон хуульд заасан түдгэлзүүлж болохгүй нөхцөл байдал тогтоогдохгүй ба баримтаар нотлогдохгүй байх тохиолдолд актын биелэлтийг түдгэлзүүлсэн.

Жишээ нь: нэхэмжлэгчээс гаргасан “Төрийн албан хаагчийг ажлаас чөлөөлөх тухай” тушаалыг маргааныг шүүхээр эцэслэн шийдвэрлэх хүртэлх хугацаанд түдгэлзүүлэх хүсэлтийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс ЗХХШтХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.1-д заасан үндэслэл тогтоогдохгүй бөгөөд хариуцагчийн гаргасан “газрын харилцаатай холбоотой бүх үйлчилгээнд саад болж иргэн, хуулийн этгээдэд илт хохирол учруулж байна” гэсэн үндэслэл нь хуулийн дээрх зохицуулалтад хамаарахгүй гэж дүгнэжээ.

Харин дараах тохиолдолд хариуцагчийн гомдлыг хангаж, актын биелэлтийг түдгэлзүүлэхээс татгалзжээ:

Маргаан бүхий актыг түдгэлзүүлснээр нэхэмжлэгчийн эрх зүйн байдалд өөрчлөлт орохооргүй, *“ажлаас чөлөөлөгдсөн, эсхүл шинээр томилогдсон албан хаагчдын хэн нь уг албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэх нь тодорхойгүй болж”* төрийн байгууллагын хэвийн, тасралтгүй үйл ажиллагаа алдагдаж, үүнээс үүдэн тухайн байгууллагын иргэдэд үзүүлэх үйлчилгээнд сөргөөр нөлөөлж болзошгүй, мөн тухайн маргаан бүхий захиргааны актад тусгагдсан нэхэмжлэгчийн эрх ашгийг хөндсөн хэсэгт өөрчлөлт орсноор тухай захиргааны актыг түдгэлзүүлэх нь ямар нэг эрх зүйн үр дагавар үүсгэхээргүй, түдгэлзүүлэхийг хүссэн захиргааны акт хэрэгжээд дууссан, нэгэнт хэрэгжсэн захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх боломжгүй гэсэн үндэслэлүүдээр актын биелэлтийг

хууль зүйн үндэсний хүрээлэн www.nlc.gov.mn

түдгэлзүүлэх хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Жишээ нь: Гэмтэл согог судлалын үндэсний төвийн захирлын албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулсан тогтоолын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлтийг шүүхээс хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Ингэхдээ (1) тус сонгон шалгаруулалт нь 2013 оны 12 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, 2014 оны 2 дугаар сарын 17-ны өдөр тогтоол гарснаар дууссан бөгөөд нэхэмжлэгч уг шалгаруулалтад оролцсон болох нь нотлогдсон. Иймд нэхэмжлэгчийн түдгэлзүүлэхийг хүссэн захиргааны акт нь хэрэгжээд дууссан тул нэгэнт хэрэгжсэн захиргааны актыг түдгэлзүүлэх боломжгүй. (2) Төрийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-т зааснаар Гэмтэл согог судлалын үндэсний төвийн захирлын албан тушаал нь төрийн үйлчилгээний албан тушаалтан ба уг хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д зааснаар төрийн албаны сонгон шалгаруулалт явагдаж томилогдох ёстой. Гэтэл нэхэмжлэгч төрийн албаны шалгалт өгөлгүй уг албан тушаалд томилогдсон байх тул сонгон шалгаруулалтад орж томилогдоогүй этгээдийн нэхэмжлэлээр төрийн албаны сонгон шалгаруулалтыг түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж шүүх дүгнэжээ.

3. Газрын маргаантай холбоотой 35 шийдвэр хянагдсанаас 22 нь хэвээр үлдэж, 13 нь хүчингүй болсон. Хүчингүй болсон 13 шийдвэрийн 9 нь актын биелэлтийг түдгэлзүүлж, 4 нь хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхээс газрын маргаантай хэргийн хувьд маргаан бүхий актын биелэлтийг түдгэлзүүлж шийдвэрлэх болон анхан шатны шүүхийн түдгэлзүүлсэн захирамжийг хэвээр үлдээхдээ ЗХХШтХ-ийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийг баримталж байгаа ба харин 46 дугаар зүйлийн 46.1-д заасан нөхцөл байдал тогтоогдсон тохиолдолд түдгэлзүүлэх хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэдэг бөгөөд ингэхдээ дараах нөхцөл байдлыг харгалзан үзэж байна.

Тухайлбал: актын биелэлтийг түдгэлзүүлсэн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжид гуравдагч этгээдээс давж заалдах гомдол гаргасныг давж заалдах шатны шүүхээс гомдолд дурдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан дүгнэлт, хөрөнгө оруулсан тухай нотлох баримтууд хэрэгт авагдаагүй, 46.1.1-д заасан актыг түдгэлзүүлж болохгүй нөхцөл байдал баримтаар тогтоогдохгүй ба хэргийн оролцогчдын аль нэгний эрх ашигт сөргөөр нөлөөлж хохирол учруулахааргүй байвал хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж байна.

Хэргийн оролцогчдын зүгээс ЗХХШтХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.1-д зааснаар “түдгэлзүүлэх нь илтэд хохирол учруулж байна” гэсэн гомдлыг шүүхэд ирүүлдэг бөгөөд дараах үндэслэлээр гомдлыг хүлээн авалгүй, маргаан бүхий актыг түдгэлзүүлэн шийдвэрлэжээ:

- гуравдагч этгээдэд газар эзэмших эрх олгосон захиргааны актын хууль зүйн үндэслэлийн талаар маргаантай байгаа бөгөөд шүүх маргааныг эцэслэн шийдвэрлээгүй байгаа учир хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гуравдагч этгээдийг маргаан бүхий газар дээр үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөх үндэслэлгүй. Актын биелэлтийг түдгэлзүүлсэн тохиолдолд ЗХХШтХ-ийн 46.1-д заасан нөхцөл байдал үүсэхгүй.

- Гуравдагч этгээдийн гомдолд “маргаан бүхий газарт уринш хийхээр мөнгө зарцуулсан бөгөөд энэ маргааны улмаас хийх боломжгүй болж их хэмжээний орлогоо алдаж, үүний улмаас банкны зээл төлөгдөхгүйд хүрч, барьцаа хөрөнгөө банкинд алдаж их хэмжээний хохирол учирна” гэж дурдсан нь үндэслэлгүй. Учир нь 2013.09.23-

Жишээ нь: Дорнод аймгийн Ардчилсан намаас захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхэд гаргасан "аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн бүрэн эрхийг баталгаажуулсан 01 тоот тогтоолын биелэлтийг түдгэлзүүлэх" хүсэлтийг анхан шатны шүүх хэрэгсэхгүй болгож шийдвэрлэснийг давж заалдах шатны шүүхээс буруу гэж үзсэн байна.

Учир нь Улсын Дээд шүүхийн 2013 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 171 дүгээр тогтоолоор тус хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан ба үүнд гуравдагч этгээд УДШ-ийн Ерөнхий шүүгчид гомдол гаргаснаар хэрэг УДШ-д шилжсэн учир анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдах боломжгүй байхад түдгэлзүүлэх хүсэлтийг шийдвэрлэсэн байна гэжээ.

Түүнчлэн анхан шатны шүүх сонгуулийн маргаантай холбоотой актыг түдгэлзүүлэх хүсэлтийг шийдвэрлэхдээ хэргийн оролцогчид маргаан бүхий актын аль хэсгийг нь түдгэлзүүлэх хүсэл сонирхол, шаардлага байгааг тогтоох, тогтоогдож байгаа тэрхүү бодит нөхцөл байдал нь үнэхээр нийтийн ашиг сонирхол хөндөгдөхүйц байгаа эсэхийг нухацтай авч үзээгүйгээс дээрх алдаанууд давтагдсан тохиолдол байна.

ЗХХШтХ-ийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх "хуульд өөрөөр заасан" тохиолдлуудыг сонгуулийн хууль тогтоомжид харилцан адилгүй тогтоож байсан.

Тухайлбал: Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль /хүчин болсонд тооцогдсон/-ийн 59 дүгээр зүйлийн 59.8-д "Шүүх сонгуулийн хорооны шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэхийг хориглоно" гэсэн заалт байсан боловч 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан Сонгуулийн тухай хуульд ийм зохицуулалт ороогүй бөгөөд Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд баг, хороодын иргэдийн Нийтийн хурлын дарга, Тэргүүлэгчдийг сонгох сонгуульт ажиллагааны талаар тусгайлсан зохицуулалт мөн байхгүй байна.

Жишээ: Дундговь аймгийн Ардчилсан намаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад "Аймгийн ИТХ-ын 2012.12.10-ны өдрийн 1 дүгээр тогтоолын 2 дугаарт байгаа Б.Доржсүмбэр, 15 дугаарт байгаа Ж.Мөнхчулуун, 16-д байгаа С.Буджав, 17-д байгаа Д.Чандмань нарт холбогдох хэсгийг түдгэлзүүлэх" хүсэлт гаргасныг анхан шатны шүүхээс хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Харин давж заалдах шатны шүүхээс "... түдгэлзүүлэхийг хүссэн акт нь сонгуулийн хорооны шийдвэр бус ИТХ-ын тогтоол байх бөгөөд Сонгуулийн хорооны 25 дугаар тогтоол нь 2012.12.20-нд буюу маргаан бүхий акт гарснаас хойш үйлдэгдсэн байх тул ИТХ-ын тогтоолыг Сонгуулийн хорооны шийдвэртэй адилтган үзэж, Аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль /хүчин болсон/-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь заалтыг баримтлан актын биелэлтийг түдгэлзүүлэх үндэслэлгүй" гэж дүгнэн анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон ажээ.

Сонгуулийн тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.8, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.4-д зааснаар УИХ болон орон нутгийн сонгуулийн маргааны хувьд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзахаас бусад шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргахгүй болсон тул энэ төрлийн хэргийн хувьд актын биелэлтийг түдгэлзүүлсэн анхан шатны шүүхийн шийдвэр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээр хянагдахгүй болжээ.

5. Тусгай зөвшөөрөлтэй

ны өдөр захиргааны акт гарснаар гуравдагч этгээдэд газар эзэмших эрх үүссэн бөгөөд түүнээс хойш 8 хоногийн дараа актын биелэлтийг түдгэлзүүлэх шийдвэр гарсан байхад "уринш хийхээр бэлдэж, их хэмжээний хохирол учирсан" гэх байдал тогтоогдохгүй. Хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд маргаж буй газар дээр ямар нэгэн үйл ажиллагаа явуулахгүй байх нь хуульд нийцнэ гэж дүгнэсэн байдаг.

- Гуравдагч этгээдийн "Оршин суугчдын эсэргүүцлийн улмаас маргаан бүхий газарт хийх барилга угсралтын ажил хойшлогдож бусад хуулийн этгээдэд гэрээний дагуу торгууль төлсөн ба барилга угсралтын ажлыг хойшлуулсан зэрэг нь манай компанийн бодит хохирол боллоо" гэх үндэслэл тогтоогдохгүй. Учир нь гуравдагч этгээдээс бусад хуулийн этгээдтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний торгуулийн баримтыг хохирол хэмээн шүүхэд гаргаж өгсөн нь "илтэд хохирол учрах" гэсэн хуулийн шаардлагыг хангахгүй байна. Харин актын биелэлтийг түдгэлзүүлэх нь өөр бусад эрсдэлээс сэргийлнэ.

-Хэргийн оролцогчдоос түдгэлзүүлэх тухай хүсэлтдээ үндэслэлээ тодорхой заах ёстой байтал "... нэхэмжлэлд захиргааны хэрэг үүсгэсэн бол шууд түдгэлзүүлэх ёстой" гэж тайлбар гарган маргаж байгаа нь үндэслэлгүй бөгөөд ЗХХШтХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан үндэслэл тогтоогдсон, маргаан бүхий актыг түдгэлзүүлэх боломжгүй гэж дүгнэжээ.

Түүнчлэн судалгаанд хамрагдсан тогтоолуудад хийгдсэн хууль зүйн дүгнэлтээс онцлоход, шүүх аливаа маргааны төрлөөс үл хамааран *"бусдаас авсан зээл, зээлийн хүү, гэрээгээр хүлээх алданги, торгууль"* хариуцлагыг ЗХХШтХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.1-д засан "илт хохирол учруулах нөхцөл" гэдэгт хамаарахгүй гэж дүгнэсэн нь нийтлэг байна.

4.Сонгуулийн маргаантай холбоотой 6 шийдвэр хянагдсаны 5 нь хүчингүй болж, 1 нь хэвээр үлдсэн. Хүчингүй болсон 5 шийдвэрийн 2 нь актын биелэлтийг түдгэлзүүлж, 3 нь хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Хэргийн оролцогчдоос ихэвчлэн *санал хураалтыг албажуулсан тогтоолыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулахаар шийдвэрлэсэн Сонгуулийн тойргийн хорооны тогтоол; Баг хорооны иргэдийн Нийтийн хурлаас хурлын дарга, Тэргүүлэгчдийг сонгосон иргэдийн Нийтийн Хурлын тогтоол;* иргэдийн хурлын Төлөөлөгчийн бүрэн эрхийг баталгаажуулсан ИТХ-ын тогтоол; зэрэг шийдвэрүүдийн биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлт гаргажээ.

Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх болсон үндсэн шалтгаан нь маргаж буй тухайн актын үйлчлэлийг зогсооход чиглэгддэг бөгөөд харин энэ төрлийн маргааны хувьд хэргийн оролцогчдоос маргаан бүхий актыг түдгэлзүүлж болохгүй нөхцөл байдал гэдгийг "дахин санал хураалт явуулахыг түдгэлзүүлэх нь уг ажиллагаатай холбоотой улсын төсөвт хор хохирол учруулна; нийт сонгогчдын өөрийн төлөөллөө сонгох улс төрийн эрх зөрчигдөнө" гэж тайлбарладаг.

Түдгэлзүүлж болохгүй нөхцөл байдал байгаа эсэхийг шалгаж тогтоогоогүй, холбогдох баримтыг цуглуулаагүй, хэргийг оролцогчдод мэдэгдээгүй, энэ асуудлаар тайлбар нотлох баримт гаргах эрхийг эдлүүлээгүй зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн; нэхэмжлэлийн шаардлагад тодорхойлсноос өөр захиргааны акт түдгэлзүүлсэн тохиолдолд тухайн актын түдгэлзүүлсэн анхан шатны шүүхийн шийдвэрийн агуулгад дүгнэлт өгөх боломжгүй гэж давж заалдах шатны шүүхээс уг шийдвэрийг хүчингүй болгодог байна.

хууль зүйн шинжлэх ухаан www.nli.gov.mn

холбоотой 39 шийдвэр хянагдсанаас 22 нь хэвээр үлдэж, 17 нь өөрчлөгдөж, хүчингүй болсон. Хүчингүй болж, өөрчлөгдсөн шийдвэрээс 8 нь актын биелэлтийг түдгэлзүүлж, 9 нь хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Эдгээр актууд нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл, архитектур төлөвлөлтийн даалгавар байх бөгөөд түдгэлзүүлэх хүсэлтийн үндэслэлийг "нэхэмжлэгчийн эрх, ашиг сонирхлыг зөрчсөн, холбогдох хууль, норм дүрэмд нийцээгүй, хуульд заасан түдгэлзүүлэхгүй байх үндэслэл тогтоогдохгүй" зэргээр тодорхойлжээ.

Шүүх "маргаан бүхий захиргааны акт болох архитектур төлөвлөлтийн даалгавар нь хууль дүрэм, норм стандарт зөрчсөн эсэхийг хянаж байгаа тул түдгэлзүүлэх шаардлагатай" гэсэн үндэслэлээр актын биелэлтийг түдгэлзүүлсэн нь ЗХХШтХ-д нийцэх ба энэ тохиолдолд тус хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1-д заасан түдгэлзүүлж болохгүй нөхцөл байдал тогтоогдохгүй гэж дүгнэж, актын биелэлтийг түдгэлзүүлсэн.

Жишээ: С.Гантогоо нь НМХГ-ын улсын байцаагчийн 2012.06.27-ны өдрийн Барилга угсралтын ажил эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагатайгаа холбогдуулан уг актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлт гаргасан ба шүүх "хариуцагч болон гуравдагч этгээд актын биелэлтийг түдгэлзүүлснээр барилгын ажил зогсож, их хэмжээний хохирол учирна гэж тайлбарлах боловч энэ үндэслэл нь баримтаар тогтоогдоогүй. Мөн барилгын ажлыг зогсоосноор банкны зээлийн хүүгийн төлбөрт унах үр дагаврыг үүсгэж байна гэх боловч өвлийн улирал эхэлсэнтэй холбогдуулан жил бүрийн 10 сарын 01-ний өдрөөс эхлэн барилгын ажил зогсох тул цаг хугацааны хувьд ч гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөхгүй" гэж дүгнэн, маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн байна.

Харин шүүхээс хүсэлтиийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхдээ актын үйлчлэл нь даруй хэрэгжиж дуусгавар болсон, нэгэнт хэрэгжсэн актын биелэлтийг түдгэлзүүлснээр аливаа этгээдийн эрх зөрчигдөхөөс сэргийлэх урьдчилсан хамгаалалт үр нөлөөгүй болно гэсэн үндэслэлүүдийг заажээ.

6. Улсын бүртгэлийн маргаантай холбоотой 26 шийдвэр зөвхөн 2016 онд хянагдсан ба дээрх бүх тохиолдолд захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлжээ. Эдгээр шийдвэрээс 15 нь хэвээр үлдэж, 13 нь өөрчлөгдөж, 2 нь хүчингүй болсон байна.

Эдгээрийн дийлэнх нь өөрийн өмчийг бусдын барьцаанд бүртгэсэн улсын бүртгэлтэй холбоотой маргаан бөгөөд нэхэмжлэгчийн маргаж буй захиргааны акт болох улсын бүртгэл, түүнийг үндэслэж олгогдсон эрхийн гэрчилгээ нь нэхэмжлэгчийн эрхийг зөрчсөн эсэхийг шалгаж, дүгнэлт өгөх шаардлагатай тул улсын бүртгэлд хөдөлгөөн, өөрчлөлт оруулахгүй байх нь хуульд нийцнэ гэж шүүх дүгнэн, актын биелэлтийг түдгэлзүүлжээ. Ингэхдээ барьцааны гэрээ, түүнийг бүртгэсэн улсын бүртгэлийн үндсэн дээр гуравдагч этгээдэд (дийлэнх тохиолдолд банк оролцсон) үүссэн эрх нь хууль ёсны эсэх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар тогтоогдох тул улсын бүртгэлийг түдгэлзүүлэх нь түүнд илт хохирол учруулах нөхцөл болохгүй гэсэн дүгнэлт зонхилжээ.

Харин давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн зарим шийдвэрийг өөрчилж, хүчингүй болгосон үндэслэлээ "хэргийн оролцогчийн эрхийг хангаагүй зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн, актын биелэлтийг түдгэлзүүлэх шийдвэрийн агуулга нь нэхэмжлэлийн шаардлагаар

хязгаарлагдах байтал нэхэмжлэлийн шаардлагад хамаахгүй асуудлаар шийдвэр гаргасан" гэж тайлбарласан байна.

ЗХХШтХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.1-д заасан түдгэлзүүлж болохгүй гэж үзсэн нөхцөл байдлыг бодит жишээгээр тайлбарлавал: нэхэмжлэгч "Монос фарм" ХХК нь "Н.Амбага, Б.Саранцэцэг нар дээр Нефромон, Салимон гэсэн эмнүүдийн "Барааны тэмдэгтийн гэрчилгээ" олгогдсоноор "Тавин ус" ХХК нь тухайн эмнүүдийг үйлдвэрлэх болсон. Ингэснээр тус эмнүүдийг зах зээлд анхлан үйлдвэрлэж нийлүүлж байсан манай компанийн эрх ашиг хөндөгдөж, зээлийн төлөлт болон борлуулалтын алдагдал хүлээх болсноор манай компанид илт хохирол учрах боллоо" гэж маргадаг ба шүүх дүгнэхдээ маргаан бүхий захиргааны актыг түдгэлзүүлснээр гуравдагч этгээд Н.Амбага, Б.Саранцэцэг нар болон тэдгээртэй хамтран ажиллаж буй "Тавин ус" ХХК-д учирч болох нотлогдож байгаа хохирлоос илүүтэй хохирол учрахуйц нөхцөл байдал нэхэмжлэгч "Монос фарм" ХХК-д үүссэн гэдэг нь баримтаар тогтоогдохгүй байна гэж дүгнэн хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

7. Өрсөлдөөний маргаантай хэргийн актын биелэлтийг түдгэлзүүлсэн 4 шийдвэр хянагдсанаас 3 нь хэвээр үлдэж, 1 нь хүчингүй болжээ.

Энэ тохиолдолд анхан болон давж заалдах шатны шүүхээс актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон үндэслэлээ "ШӨХТГ-ын улсын байцаагчаас Өрсөлдөөний тухай хуулийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэсэн захиргааны акт нь ЗХХШтХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д хамаарна" гэж тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, захиргааны журам зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэсэн болон уг зөрчлийг таслан зогсоох тухай захиргааны хяналтын байгууллага, албан тушаалтны шийдвэр гэдэгт хамааруулж үзсэн хэрэг юм.

Хүчингүй болсон шийдвэрийн тухайд хэргийн оролцогчдын маргаж буй ЗХШХШТХ-ийн 62 дугаар зүйлийн 62.1.1-д заасан үндэслэл нотлох баримтаар тогтоогдоогүй гэж шүүх дүгнэжээ.

8. Бусад /концесс, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, шүүгчийн сонгон шалгаруулалт, өмч, татвар г.м/ төрлийн маргаантай холбоотой 13 шийдвэр хянагдсанаас 10 нь хэвээр үлдсэн. Хүчингүй болсон 3 шийдвэрийн 2 нь актын биелэлтийг түдгэлзүүлж, 1 нь хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн ба шийдвэрт тусгасан хууль хэрэглээний болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой үндэслэлүүд нь агуулгын хувьд бусад төрлийн маргаанд дурдсантай адил байна.

IV. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх харилцааг зохицуулсан нь

Өмнөх бүлгүүдэд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс 2011.04.01-ний өдрөөс 2016.10.20-ны өдрийн хооронд гаргасан тогтоолуудад дүн шинжилгээ хийх замаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дахь "захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх" зохицуулалтыг шүүхээс хэрхэн тайлбарлан хэрэглэж байсан талаар өгүүлсэн.

2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж буй Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль дахь "захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх" зохицуулалтын онцлог хийгээд өмнөх хуулиас ялгаатай талыг энд авч үзье.

1.ЗХХШтХ дахь онцлог буюу дэвшилтэт зохицуулалт бол "шүүгч өөрийн санаачилгаар актын биелэлтийг

түдгэлзүүлэх" гэдгийг шүүхийн зорилго, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчимтай уялдуулан өмнө нь тодорхой дурдсан.

ЗХШТШтХ-ийн 61.1-д "... шүүгч хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн **хүсэлтээр** захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлнэ" гэж зааснаас дүгнэхэд шүүх маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх асуудлыг зөвхөн хэргийн оролцогч, түүнийг төлөөлж өмгөөлж буй этгээд хүсэлт гаргасан тохиолдолд шийдвэрлэх ба өөрийн санаачилгаар түдгэлзүүлэх шийдвэр гаргах эрхгүй болж байна.

2.Захиргааны хэм хэмжээний актын хувьд өмнөх хуулийн үндсэн агуулга, зарчим өөрчлөгдөөгүй ба Захиргааны ерөнхий хуулийн зохицуулалттай уялдан "Монгол улсын стандарт"-ыг захиргааны хэм хэмжээний актад хамааруулахгүй гэдгийг өмнө онцолсон. ЗХШХШтХ-ийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасан "захиргааны акт"-ын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй үндэслэлүүд "захиргааны хэм хэмжээний акт"-д хамаарахгүй гэдгийг мөн дурдах хэрэгтэй.

3.ЗХШХШтХ-ийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалтыг ЗХХШТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалттай харьцуулбал "нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулах" гэсэн агуулга бүхий нөхцөл нэмэгдсэн ба үүнийг ЗХШХШтХ-д нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргах тодорхой тохиолдлыг хуульчилсантай холбон тайлбарлаж болно.

4.ЗХШХШтХ-ийн 62 дугаар зүйлийн 62.1.2-т "... гаргуулах тухай **шийдвэр** бол" гэж заасан нь ЗХХШТХ-д үүнийг "акт" гэж бичсэнээс болж улсын байцаагчаас хуулиар олгосон эрхийнхээ дагуу гаргаж болох шийдвэрийн олон төрлөөс зөвхөн "акт"-ыг л түдгэлзүүлж болохгүй гэж маргах явдал цаашид гаргахгүй байхад чиглэсэн зохицуулалт юм.

5. ЗХШХШтХ-ийн 62 дугаар зүйлийн 62.1.3-д *"захиргааны журам зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэсэн бол*[25] *уг зөрчлийг таслан зогсоох тухай захиргааны хяналтын байгууллага, албан тушаалтны шийдвэр бол"* гэж заасан.

ЗХХШТХ-д "зөрчилд хариуцлага хүлээлгэх", "зөрчлийг таслан зогсоох" гэж тусгасныг хоёр өөр агуулга бүхий, тус тусдаа гарсан шийдвэр болох талаар өмнөх хэсэгт тодорхой жишээгээр тайлбарласан.

6. ЗХХШТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.4-д заасан "хууль тогтоомжид заасан тохиолдол" гэдгийг ЗХШХШтХ-ийн 62 дугаар зүйлийн 62.1.4-д зөвхөн "хуульд" гэсэн агуулгаар өөрчилжээ.

Өмнө нь хууль болон УИХ-ын тогтоолыг "хууль тогтоомж" гэж тайлбарлан хэрэглэж байсан ба Хууль тогтоомжийн тухай хуулийн[26] 1 дүгээр зүйлийн 1.1-д "... хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр /цаашид "хууль тогтоомж" гэх/..." гэж заасан нь ч энэ ойлголтын агуулга, хүрээг улам тодорхой болгосон зохицуулалт болсон. Тэгэхээр шинэ процессын хуулийн үйлчлэлээс хойш үл маргалдах журмаар биелүүлэхийг зөвхөн хуульд заасан тохиолдолд л түдгэлзүүлэх ба ийм зохицуулалт бүхий тодорхой хуулиудыг ч дээр дурдсан билээ.

7. Мөн ЗХШХШтХ-ийн 70 дугаар зүйлийн 70.1, 70.1.2, 70.7-д захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлт шийдвэрлэх процессын хуульчилсан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эерэг нөлөө үзүүлэх нь дамжиггүй. Учир нь давж заалдах шатны шүүхээс хэрэг

[25] Энэ хэсэгт өмнөх хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д заасан зохицуулалтыг ямар нэг утга агуулгын өөрчлөлтгүйгээр тусгасан байгаа боловч энэ заалт дах эхний "бол" гэсэн үг нь "болон" гэсэн үг бичвэрийн алдаатайгаар тусгагдсан байж болохоор байгааг анхаарах шаардлагатай.

[26] Улсын Их Хурлаас 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар баталж, 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулснаар энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим болоод хэргийн оролцогчийн эрхийг хангаагүй гэх үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хүсэлтийг дахин шийдвэрлүүлэхээр буцааж буй нөхцөл байдлаас дүгнэхэд энэхүү сөрөг байдлыг арилгахад чиглэсэн зохицуулалт болжээ.

V. Дүгнэлт

Эцэст нь, шүүхийн практик судалгаанаас дүгнэвэл захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны нэгээхэн чухал үе шат болох "актын биелэлтийг түдгэлзүүлэх" хуулийн зохицуулалтыг хэрэглэх тодорхой практик тогтож буйг харж болохоор байна. Тухайлбал, актын биелэлтийг түдгэлзүүлэх асуудлыг эцэслэн шийдвэрлэж буй давж заалдах шатны шүүхийн шийдвэрт хийгдэж буй үндэслэл, гаргалгаанаас үзвэл хуулийн тодорхой зохицуулалтыг тайлбарлаж хэрэглэх зарим шалгуур тогтсон байна. Үүнд: актын биелэлтийг түдгэлзүүлснээр нэхэмжлэгчид учирч болох сөрөг үр дагавар болон түдгэлзүүлэхгүй байснаас өөр бусад этгээдэд, түүний дотор гуравдагч этгээдэд учирч болох эрсдэлийг харьцуулан дүгнэх аргачлал, актын биелэлтийг түдгэлзүүлэхгүйгээс нэхэмжлэгчид учирч болох эрхийн зөрчлийн шинж байдал тухайлбал, уг эрх нь нөхөн сэргээгдэхгүй эрх, эсхүл мөнгөөр илэрхийлэгдэн нөхөгдөж болох зэргээс хамаарсан аргачлал зэргийг дурдаж болно.

Түүнчлэн, актын биелэлтийг түдгэлзүүлэх асуудалд маргааны төрөл, нэхэмжлэлийн шаардлагын төрөл, актын төрөл зэргээс шалтгаалсан онцлог шинжүүд нөлөөлж байгааг харж болохоор байна.

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ISSN 2226-9185

Хаяг: Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Бага тойруу /15160/. Хуульчидын гудамж 1.
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн байр
Утас: 315735
Факс: 315735
Цахим хуудас: www.legalinstitute.mn
Цахим хаяг: lawjournal@legalinstitute.mn